ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 10

ХЯТАДЫН ЭРТНИЙ
ҮЛГЭР ДОМОГ ДАХЬ
СҮНСЛЭГ АГУУЛГА

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 10

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР

ХЯТАДЫН ЭРТНИЙ ҮЛГЭР ДОМОГ ДАХЬ СҮНСЛЭГ АГУУЛГА

Аравдугаар боть

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг

ГАРЧИГ

Намтрын өмнөх үг 4

Товч илгээлт 5

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар.....6

Өмнөх үг.....11

1 дүгээр бүлэг. Арьяабалын аргаар бясалгаж байсан Найман арш...12
2 дугаар бүлэг. Нүйва чулуу хайлуулж, тэнгэрийг нөхсөн нь.....29
3 дугаар бүлэг. Ан Зи-гийн билиг ухаан.....42
4 дүгээр бүлэг. "Баруун этгээдэд зорчсон нь" зохиолын дүрүүд.....57
5 дугаар бүлэг. Бясалгал бүтээлийн зам дахь ад чөтгөрүүдээс болгоомжил.....64
6 дугаар бүлэг. Ид шид ба их билиг ухаан.....67
7 дугаар бүлэг. Цаг хугацаа, орон зайнаас хэтийдсэн түшмэл.....89
8 дугаар бүлэг. Их Багш "Усан хөвөөний шасдир"-ын тухай.....104
9 дүгээр бүлэг. Түүхээр багшлуулахуй.....124
10 дугаар бүлэг. Хатуу, зөөлнийг хослуулж чадвал төгс төгөлдөр мөн - Күнз болон түүний шавь нарын түүх.....141
11 дүгээр бүлэг. Бао Шуяа, Гуанжун хоёрын зөв намба төрх, сүр жавхлан.....152
12 дугаар бүлэг. Төрөө төвшитгөж, тэнгэрийн дор амар амгаланг тогтоох нь бясалгал мөн.....168
13 дугаар бүлэг. Гэгээнтний өвчин.....179
14 дүгээр бүлэг. Гэгээнтэн хийгээд эгэл хүний ялгаа "Жуанз"-Тэжээхүй ухаан бүлгийн тайлбар.....187

Эх зохиол, эх сурвалжийн жагсаалт.....194

Дэлгэрүүлэн унших.....198

Авшиг хүртэхүй-Арьяабалын бясалгалын арга 208

Таван сахил.....211

Төгс Гэгээрсэн Их багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт.....212

Бидэнтэй хэрхэн холбогдох вэ?..... 216

НАМТРЫН ӨМНӨХ ҮГ

Машид гэгээрсэн Их Багшийн дэсийг эгэл хүний чадвар, энэ ертөнцийн үгээр илэрхийлэх боломжгүй. Түүний бүхий л амьдрал, үзэл санааг хичнээн тодорхой хичээнгүйлэн дүрсэлсэн ч бүрэн дүүрэн өгүүлж чадахгүй. Эрт цагт Энэтхэгийн нэг бясалгагчид өөрийн Багшийн намтар түүхийг бичих үүрэг оногджээ. Хэдэн сарын дараа бичиж дууссан эсэхийг асуухад дуусаагүй гэжээ. Дахиад хэсэг хугацааны дараа асуухад: “Их Багштай ижил дэсэд хүрч, түүний үзэгдэх, үзэгдэхгүй төвшний ажлыг жинхэнэ үнэн зөвөөр ойлгохоос нааш би энэ ажлыг хэзээ ч дуусгаж чадахгүй. Учир нь миний багш эгэл ертөнцөөс хэтийдсэн төрөлтөн билээ” гэж хариулсан гэдэг.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн өмнөх амьдралын талаар дурдсан нь тун бага. Харин Багшийн намтрыг ихэд сонирхсон газар газрын шавь нарынхаа тавьсан олон янзын асуултад хариулахаас өөр аргагүй болдог. Энэ товч намтарт Их Багшийн амьдралын замналыг эмхтгэж, найруулан бичжээ. Иймээс бүрэн төгс болоогүй тал мэдэгдэж бий.

ТОВЧ ИЛГЭЭЛТ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай нь уран бүтээлч, оюун санааны агуу хөтөчийн хувьд сүнслэг гоо сайхныг илэрхийлэх бүхий л хэлбэрт дуртай. Тэрээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. “Ау Лак” нь Вьетнамын эртний нэр, амар амгалан амьдрах гэсэн утгатай. Харин “Формоса” (үзэсгэлэнтэй сайхан) гэдэг нэр энэ эрдэнийн арал, ард түмнийх нь гоо сайхныг бүрэн дүүрэн илэрхийлнэ. Эдгээр нэрийг хэрэглэх нь тухайн улс орон, зон олонд сүнслэг дэвшил, буян хишгийг авчирна гэж Их Багш үздэг юм.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР

ХАЙР ЭНЭРЛИЙН ЗАМ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхий дахинд алдар суу нь түгсэн оюун санааны их удирдагч, уран бүтээлч, хүмүүнлэгийн үйлстэн билээ. Их Багшийн хайр энэрэл хүн төрөлхтний соёл, ёс заншлын хил хязгаарыг давж, дэлхий даяар түгж байдаг.

Төгс Гэгээрсэн Их Багш Ау Лак(Вьетнам)-ын төв нутагт мэндэлж, Европт суралцсан бөгөөд Улаан загалмайн нийгэмлэгт ажиллаж байжээ. Тэр энэ хугацаанд дэлхий дахин зовлон шаналлаар дүүрэн байдгийг хараад үүнээс ангижрах арга замыг хайхаар даруй шийдсэн нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болсон юм.

Тэрбээр тухайн үед нэгэн герман эмчтэй гэр бүл болж, жаргалтай сайхан амьдарч байсан ч өөр өөрийн зам мөрөөр явах амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө чин сэтгэлийн ерөөлийг өвөрлөөд зорилгоо биелүүлэх их аянд

морджээ. Ингэж Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай үнэнийг эрж хайх сүнслэг гэгээрлийн зам мөрөөр замнажээ. Эцэст нь Энэтхэгийн Хималайн уулнаа Төгс Гэгээрсэн нэгэн Их Багш түүнд дотоодын Гэрэл, Аялгууг ажих “Арьяабалын бясалгалын арга”-ыг уламжилсан байна. Ингээд Тэр хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Төгс Гэгээрэлд хүрсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаал номлолыг удирдлага болгосон Олон улсын нийгэмлэг 1980 онд байгуулагдсан. Хүмүүсийн чин сэтгэлийн хүсэлтээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг уламжилж, өөрийн дотоодын бурхан чанарыг нээн илрүүлэхэд тэднийг дэмжин зоригжуулж эхэлжээ. Удалгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк таван тив, Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайд ном айлдахыг хүсэж, урин залах болжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэрэл нигүүлслэлийн сэтгэлээр зовж зүдэрсэн олонд бүх талаар хайр энэрэл, тус дэмжлэг үзүүлдэг бөгөөд Түүний хүмүүнлэгийн ажил нь бүхий л хориг саадыг даван туулж, дэлхийн өнцөг булан бүрийн орон гэргүй ядуучууд, ядуу буурай амьдралтай өндөр настнууд, шоронд хоригдож буй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй, оюуны чадамжгүй иргэд, дүрвэгсэд, Америкийн ахмад дайчид зэрэг маш олон хүнд хүрсэн юм.

Дулаарлаас үүдсэн олон хямрал дэлхий дахинд нүүрлэсэн өнөө үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өгөөмөр сэтгэлээр олон сая долларын хүмүүнлэгийн тусламжийг үзүүлж буй бөгөөд байгалийн гамшигт нэрвэгдэгсдэд туслахаар нийгэмлэгийн гишүүдээ дэлхийн олон оронд илгээж байна. Үүнээс гадна Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бидэнтэй зэрэгцэн орших эрхэм ариун амьтад, хүрээлэн буй орчны асуудалд ихэд санаа тавьдаг юм.

Их Багшийн энэрэл хайр, асрал нигүүлсэл олон сая хүний сэтгэлийг хөдөлгөж, бусдын төлөөх харамгүй сайхан сэтгэл нь тэдний даган дуурайх үлгэр жишээ болдог билээ. Их Багш өөрийн уран зураг, дэнлүүн чимэглэл, хувцас загвар, үнэт эрдэнийн гоёл зэрэг өөрийн урлагийн бүтээлүүдийн орлогоор тусламж хэрэгтэй Эзэн Бурханы үр хүүхдүүдийг дэмжин тэтгэсээр байдаг .

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн жилүүдэд бичсэн “Шувууд миний амьдралд”, “Ноход миний амьдралд”, “Эрхэм ариун амьтад” гурван ном нь дэлхийн хамгийн их борлуулалттай номоор шалгарч, олон хэлээр орчуулагдсан байна. Их Багш телепат холбоо, сүнслэг ажиглалтаараа эрхэм ариун амьтдын сэтгэл хөдлөл, бодол санааг гүн гүнзгий ойлгож, тэдний эрхэм дээд санаа зориг, хэзээ ч хариу үл нэхэх өгөөмөр хайрыг эдгээр бүтээлдээ тод томруун тусган харуулжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш хүмүүст үлгэр дуурайл болох зөв ёс зүйтэй сайн үйлсийг урамшуулан сайшааж 2006 оны 3 сард “Дэлхийн Гэрэлт манлайллын шагнал”, мөн удалгүй “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт Нигүүлсэнгүй үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт шударга үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт Зохион Бүтээгчийн шагнал” зэрэг олон цол шагналыг бий болгосон юм.

Эдгээр нэр төртэй шагналыг хувь хүн, албан байгууллага, улс орнуудад олгодог бөгөөд тэдний үлгэр дуурайлалтай ажил үйлс нь манай гарагийг улам гоо үзэсгэлэнтэй, эв зохиролтой болгож, дэлхийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Словени Улсын хоёр дахь Ерөнхийлөгч доктор Жанез Дрновшек, АНУ-ын 45 дахь Дэд ерөнхийлөгч, 2007 оны Нобелийн Энх тайвны шагналт, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны гишүүн Аль Гор, НҮБ-ын Уур Амьсгалын

Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны тэргүүн, Энэтхэг улсын Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн (TERI)-гийн тэргүүн, НҮБ-ын Хүний суурьшлын хөтөлбөрийн 2010 оны шагналт, доктор Ражендра К.Пачаури, АНУ-ын Сансар Судлалын Үндэсний Төвийн (НАСА) тэргүүн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналт, доктор Жэймс Е.Хансен, Английн нэрт доктор, бичний овгийн хөхтөн амьтан судлаач Жэйн Гуудал нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амь биеэ үл хайрлан аюул эрсдэлийг сөрж, бусдын амь насыг аварсан бидний эрхэм анд нөхөр амьтдын баатарлаг үйлсийг сайшаан “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт оюун ухааны шагнал”-ыг олгож, үүгээр амьтдын баатарлаг зориг, сэргэлэн ухаан, хайрын сэтгэлийг илчлэн харуулдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн хөгжил дэвшилд оруулсан сүнслэг болон материаллаг асар их хувь нэмрийг олон орны төр засгийн газар, хувийн байгууллагууд өндрөөр үнэлэн шагнаж хүндэтгэлээ илэрхийлсэн байна. Тухайлбал: Гуси Энх Тайвны шагнал (2006 он), Телли-гийн 27 дахь жилийн шалгаруулалтын Мөнгөн Эрдэнийн тэргүүн шагнал (2006 он), Лос Анжелесын Хөгжмийн Долоо хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002 он), Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн шагнал (1994 он), Дэлхийн Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал (1994) зэргийг дурдаж болно. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 2 дугаар сарын 22 болон 10 дугаар сарын 25-ны өдрийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” болгон тэмдэглэж байхаар зарласан юм. Их Багшийн дэлхийд өргөсөн тусламж, түүний бие, сэтгэлийн харамгүй их үйлсийг олон орны төрийн тэргүүн, ард иргэд өндөр үнэлэн талархлаа илэрхийлсээр байдаг.

Их Багш Чин Хай бол өөрийн билиг ухаан, баатар зоригоор цаг уурын өөрчлөлтийн сэдвийг зоригтой хөндөж

тавьсан өнөө үеийн хүрээлэн буй орчныг хамгаалагчдын манлайлагч мөн. Үнэндээ хориод жилийн өмнөөс хүрээлэн буй орчныг хамгаалахыг уриалж байсан бөгөөд “Та ийм амьдралыг сонгож болно”, “SOS - дэлхийн дулаарлыг зогсоох нь” зэрэг үйл ажиллагааг санаачлан эхлүүлжээ. Түүнчлэн дэлхийн цаг уурын өөрчлөлтийн хуралд зочин илтгэгчээр оролцож, дэлхий ертөнц дээр өнөө үед тасралтгүй гарсаар байгаа байгалийн гамшгийн үндсэн шалтгаан, түүнийг шийдвэрлэх гол арга болох нигүүлсэнгүй веган амьдралын хэв маягийг сонгоход олны анхаарлыг хандуулж байна.

Олон нийтэд хэдийнээ танил болсон “Веган болж, энх тайвныг цогцлооё” хэмээх уриаг Их Багш Чин Хай дэвшүүлсэн юм. Хоол хүнсний сонголт нь цаг уурын өөрчлөлтөд асар их нөлөөтэйг үндэслэн энэрэнгүй, тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход хүмүүст туслахын тулд “Loving Hut” веган хоолны сүлжээ ресторанууд Их Багш Чин Хайн урамшуулал дэмжлэгээр амжилттай өргөжин тэлсээр байна. Олны таашаалыг хүлээсэн энэ хоолны газрууд дэлхий даяар тархаж, олон төрлийн эрүүл, тэжээллэг, хямд үнэтэй, амтлаг веган хоолоор үйлчилдэг. Гараг ертөнц, түүний оршин суугчид, зэрэгцэн оршигч төрөлтнүүд болоод бидний үр хойчийг дэлхийн дулаарлаас үүдсэн сүйтгэгч нөлөөнөөс аврахын тулд үүний эсрэг хамгийн үр дүнтэй арга болох эрүүл, энэрэнгүй хоол хүнсийг дэлгэрүүлж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүн төрөлхтөнд хосгүй гайхамшигт энэ гараг дэлхийд гэрэлт ирээдүйгээ цогцлоох үйлсэд нь амь биеэ огоорон эцэс цуцалтгүйгээр тусалсаар байна.

ӨМНӨХ ҮГ

Их Багш Чин Хай гүн утгатай, ойлгоход хэцүү үг хэллэг хэрэглэхээс ямагт зайлсхийж, хамгийн ойлгомжтой ярианы хэлбэрээр ном тайлдаг. Түүний ном хэвлэлүүд нь уран яруу илэрхийллийг бус, уншихад хялбар ойлгомжтой байхыг урьтал болгодог.

Их Багшийн адислалын хүчийг бууруулахаас эмээж, түүний шавь нар эгэл хүний ухаанаар номын агуулгыг өөрчилдөггүй.

Нэгдүгээр бүлэг

АРЬЯАБАЛЫН АРГААР БЯСАЛГАЖ БАЙСАН НАЙМАН АРШ

Төгс Гэгээрсэн Их багш Чин Хайн айлдвар
Формоса,Тайбэй хот. 1988 оны 4 дүгээр сарын 8
(Эх нь хятад хэлээр)

Шар тогорууны нуруунаа тонгоруу сууж, лимбийн аялгууг сонордмуу

Өнөөдөр энэтхэг, ау лакын түүх биш, харин хятадын түүхээс ярья. Зарим хүн надаас: “Багш аа, Та Арьяабалын бясалгалын дотоодын дуу аялгуу үнэхээр гайхамшигтай гэдэг. Манай хятадын үе үеийн Их Багш нар, эрхэм дээд хуврагууд яагаад энэ талаар ер дурдаагүй юм бол?” гэж асуудаг.

Бодьдармаа, зургадугаар үеийн Их Багш Хүй Нэн бүгд Арьяабалын бясалгалын аргын тухай ярьсныг Багш нь номдоо дурдсан. Хятадад их бясалгагч тун олон байсан.

Зөвхөн Хуанпи, Байжан, Хүй Нэн, тавдугаар үеийн их багш Хун Рэн нараар тогтохгүй, Найман их арш ч их бясалгагчид байсан. Тэдний бичсэн шүлгийг уншвал мэдэж болно. Жишээ нь, Лиу Донбин шүлэгтээ:

Би угаас күнзийн шүтлэгтэн бөлгөө,
Ерөөс түшмэлийн жинс өмсөхүйеэ нүсэр
Бядуу ардын борог хувцас эвтэйхэн
Ертөнцийн хүмүүс нэр алдрын төлөө тэмцэлдмүү.
Харин би ертөнцийн явдлыг огоорч
Хурмастын хаанд бараалхахыг хүснэм

гэж шүлэглэжээ.

Тэрээр баян тансагийг огоорч, зөвхөн гэгээрэлд тэмүүлэх зориг санааны тухай бичсэн ажээ. Багшийнх нь хятад хэл сайнгүй ч Хэ Сиенгү–ийн өөр нэг шүлгийг орчуулахыг хичээе. Хэрвээ Хэ Сиенгү энд байвал эхлээд түүнээс өршөөл эрье. Багшид бүү уурлаарай (Багш болоод бүх хүн инээлдэв)

Шүлгийн гол санаа нь тогоруу хөлөглөн саранд хүрч, лимбэний аялгуу сонссон тухай.

Энэ л хорвоогийн хуран үймээнд автан сууна уу хэмээн Магу намайг зэмлэхүйд
Эгэл хийгээд эгэл бусын замын аль алиныг агшнаа алсруулаад
Шалавхан, гэгээн даяанчийн газар нисэн хүрч, тэргэл сарыг тольдон
Шар тогорууны нуруунаа тонгоруу сууж, лимбийн аялгууг сонордмуу.

-Хэ Сиенгү-ийн “Магу оргил”-оос

Хэрвээ Хэ Сиенгү эгэл хүн байсан бол хэрхэн тогоруу унаад саран дээр очиж, лимбэний аялгуу сонсох вэ? Тогорууны бие өчүүхэн жижиг, Хэ Сиенгү хэдий бие багатай ч сүнсэн биеэрээ л яваагүй бол тогоруунаас унах нь

тодорхой. Харин сүнсэн биеэрээ шувуу хөлөглөн үүлнээс дээгүүр нисжээ. Хэ Сиенгү өөр нэгэн шүлэгтээ:

Талст чулуу, уулын горхины үзэмж хослон асрын дээвэрт хүрэхүйд
Тоорын цэцэг дэлгэрэн хаврын модод нахиалмуй.
Шар луугийн агуйд хаш бишгүүрийн аялгуу сонсогдохуйд
Шадар тогоруухай хүзүү сунган чимээгүйхэн орж ирнэ гэжээ.

Тэр бас бишгүүрийн аялгуу сонссон гэжээ. Та нар ийм аялгуу сонссон уу? Арьяабалын аргаар бясалгадаг хүмүүс л түүний яриаг ойлгоно. Арьяабалын аргаар бясалгаагүй бол хэдэн зуун мянга дахин уншаад ч ойлгохгүй. Уншаад л өнгөрнө. Гайхамшиг нь хаана байгааг, маш дээд гүн нарийн нь хаана байгааг үл ойлгоно. Хэ Сиенгү бишгүүрийн аялгуу сонссон бодит явдлыг харахад түүний дэс маш өндөр байжээ.

Өөрийн дотоодын бишгүүрийн аялгууг сонсож чаддаг хүн хязгааргүй их хайрын хүчтэй байдаг бөгөөд үй олон төрөлхтнийг өөртөө татах увдистай байдгийг Багш нь ч хэлсэн, ислам, хиндийн шашинд ч дурддаг. Энэтхэгийн Кришна бурхан ч үүний нэг жишээ юм. (эрхлэн гаргагчаас: Rama Krishna, ихэнхдээ Krishna гэж нэрлэнэ. Энэтхэгийн "Бхагавадгита"–д түүний тухай өгүүлдэг. Түүний бишгүүр үлээж буй зураг байдаг.)

Хүмүүс эртний хятадын олон сайхан түүх, үлгэр домгийг өнгөцхөн уншаад сонирхолгүй гэж боддог. Үнэндээ маш гүн утга агуулгатай. Арьяабалын аргаар бясалгасны дараа эхнээс нь дахин уншвал эртнээс нааш өнөөг хүртэл их бясалгагч хүмүүс байсныг мэдэх болно. Хэрвээ бидний өмнө машид гэгээрсэн нэгэн их бясалгагч ирвэл хэн болохыг нь бид танихгүй байж магадгүй. Их бясалгагч хүмүүс аль

ч цаг үед байсан, найман их арш бол тэдний нэг төлөөлөл. Тэдний бясалгалын дэс маш өндөр байжээ.

Хүний ертөнцийг огоорч, номын баясалд цэнгэнэ

Уг зохиолд Лан Цайхэг их танхай, зоргоороо, өдөржин согтуу мэт байдаг тул архи уудаг хэмээн бодно гэжээ. (эмхтгэгчээс: "Зүүн этгээдэд зорчсон нь" зохиолоос дэлгэрүүлэн уншиж болно) Багшийнх нь бодлоор тэр, диваажингийн рашаан хүртэснээс тийм байдалтай байжээ. Бясалгагч хүн самади агуулсан үедээ яг согтсон мэт байдаг. Хүн сайн хэлбэл: За сайн!, муулвал бас "jiujia" (формоса аялгаар маш сайн гэсэн утгатай), яасан ч яахав ээ гэнэ.

Учир нь бясалгагч хүнд энэ дэлхийн явдал чухал биш. Хачин этгээд хүн гэж хэлүүлнэ, диваажингийн рашаан хүртэснийг архинд согтсон гэж ойлгоно. Номын баяслын сайхан нь үгээр илэрхийлшгүй байдгийг ертөнцийн хүмүүс ойлгохгүй тул түүнийг согтжээ гэцгээдэг. Күнз, Чи улсад байхдаа шаолэ аялгуу сонсон гурван сар автан жаргажээ. Энэ шаолэ аялгуу нь дотоодын аялгуу болно. Лан Цайхэ-гийн шүлэгт юун тухай өгүүлдэг вэ? Тэрээр:

Энэ хорвоод хавар, намар, өвөл, зун ээлжлэн цаг хугацаа харвасан сум мэт өнгөрнө.
Эртний хүмүүсийн зам мөрийг эрээд ч олохуйяа бэрх болмуй.
Энэ цагийн хүмүүс алдар нэр, ашиг хонжоо хөөцөлдөн өчүүхэн ч чөлөө завгүй,
Эргэлтгүй цаг хугацаа нисэн одож, түмэн бодис нэгэн агшнаа элэн замхарч болзошгүйг ер үл анзаарна.

Энэ бол Лан Цайхэ-гийн дуулсан дуу. Тэр өөр олон дуу дуулсан гэж сонссон. Энд ердөө цөөн хэдэн дээж нь байна. Нэг дуунд нь өглөө эрт хангарьд шувуу хөлөглөн хөх тэнгэрт дүүлэн ниснэ, үдшийн бүрийд буцан ирж, хөх далай

мэт цэлийх ялмын талбайг харахыг хүснэ гэж гардаг. Үүлэн дээр тоосгоор бус, алт, мөнгөөр бүтсэн маш үнэтэй асар том орд харш бий. Эх зохиолд:

Цайхэ би дуулъя, энэ хорвоо ер юусан билээ?
Цэл залуу насны гоо үзэсгэлэн ч цагийн аясаар хаврын мод намар хагдрах мэт арилж элмүй.
Эртний хүмүүс усны урсгал шиг холдон одоод эргэж үл ирнэм.
Энэ цагийн хүмүүс харин уван цуван ирж, учралдан золголдмуй.
Үүр цүүрээр Цайхэ би хангарьд хүлэглэн диваажинд зорчоод
Үдэш буцан ирэхүйд ялмын талбай цайвалзан угтнам.
Үүлэн чанадын огторгуйд үзэмжит гэрэл гийгүүлэн
Үнэлж баршгүй алтан, мөнгөн орд сүндэрлэх ажаам”

гэж шүлэглэжээ.

Лан Цайхэ-гийн дүрслэн өгүүлсэн энэ төвшин буддын шашны ариун оронтой тун төстэй, Баруун зүгийн Төгс баясгалант орны газрыг алтаар бүрж, орд харшийг алт, лиули, мана, шүр, хясаа долоон эрдэнээр бүтээжээ. Баруун зүгийн Төгс баясгалант орны тухай Шагжамуни Будда айлдсан төдийгүй, хятадууд ч бас “gankuang” (формоса аялгаар нэгэн ижил гэсэн утга) гэх зүйлийг ярьсан байдаг .

Багш нь бас Хэ Сиенгү-тэй ижил зүйлийг ярина. Арьяабалын аргаар бясалгавал дотоодын аялгууг сонсоно. Хэ Сиенгү шиг бишгүүрийн аялгуу сонсоно. “Богдосын ном цагаан лянхуа судар”-т дотоодын аялгуунд хонхны дуу, цангийн дуу, бөмбөрийн дуу, аянгын дуу, арслангийн хүрхрэх дуун бий гэж тодорхой бичжээ. Гадна талын дуу аялгуу биш. Дуу аялгуу зөвхөн гадна талд байдаг бол Шагжамуни Будда “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг айлдахад тийм их цаг гаргахгүй байсан.

Библийн сударт Эзэн Бурханы ярих нь аянгын дуу мэт, илрэн гарах нь асах гал мэт маш их гэрэл гэгээтэй гэжээ. Энэ бол гэрэлтэй, аялгуутай дотоодын ахуй ойлголт мөн. Дорнын сургаал, өрнийн сургаал бүгд ижил. Дорно дахинд л сурч чадна, өрнөдөд сурч чадахгүй гэсэн ялгаа байхгүй. Бас дорнын сургаал гайхамшигтай, өрнийн сургаал шальгүй гэсэн хэрэг бас огт биш.

Бид өөр өөр сургаал номлол, өөр өөр шашин шүтлэгийг цогцоор нь сайтар судлаагүйгээс маш амархан буруу ойлгодог. Нэгэн шашин ч олон урсгалд хуваагдаж, өөр хоорондоо тэмцэлдэж, маргалдаж байхад шашнуудын хооронд ч аргагүй юм. Зарим хүн католик шашин, христийн шашин бол гаднын шашин гэзд хүлээж авдаггүй. Эсвэл Багш нь Ау Лак хүн бол олон хүн түүнийг даган суралцах дургүй. Үүнийг Багш нь ойлгож байна. Гэхдээ Шагжамуни Будда энэтхэг хүн байсныг та нар мартаа юу?

Энэ дэлхий дээр маш олон улс орон бий. Бурхан төрөл тутамд зөвхөн нэг л улсад төрөөд байхгүй. Бурханд тийм алагчлах үзэл байхгүй. Нэгэн улсын хувь заяа дээшилж, доошилно. Хэсэг хугацаанд дарагдаж, газартай тэгшлэгдэн доройтовч зуун жил, мянган жилийн дараа сэргэн мандаж, хүчирхэг баян болно.

Хятадын өмнөх үеийн хаант улсуудын мөхөл ч адилхан. Мөхөж сэхэх нь аль ч улсад тохиолддог. Тиймээс Бурхан аль улсад мэндлэх нь тухайн ард түмний буян хишгээс хамаардаг. Харин хэзээ ч өөрийн дуртай, дургүйд дулдуйдан төрөх газраа сонгохгүй.

Заримдаа төрж мэндэлсэн тэр нутагтаа амьдран сууж болдоггүй. Жишээ нь, Шагжамуни Будда Капилавастуд (одоогийн Балба улсад) төрсөн ч тэнд амьдраагүй. Тэр дөрвөн зүг, найман зовхист аялан явж, сургаал номоо айлдсан. Есүс Христ ч бас адил, тэрээр Бетлехемд төрсөн

ч тэнд амьдраагүй. Энэтхэг, Төвөдөд очиж, дээдийн номонд суралцсан юм. Дараа нь буцаж очоод үнэн ёсыг дэлгэрүүлжээ. Бас л газар сайгүй явж, ном дэлгэрүүлж байв. Тиймээс их бясалгагч хүний хаана төрсөн нь тийм ч чухал биш. Харин Түүнтэй уулзаж чадах нь бидэнд хамгийн чухал.

Эртнээс нааш жинхэнэ мөрийг олж гэгээрсэн хүн хэд байна вэ?

Зуун бүрийн төгсгөлд Их Багш нар, гэгээнтнүүд, их бясалгагч хүмүүс хамаг төрөлтөнд өндөр дэсийн сургаал ном айлдаж, энэ дэлхийд чанагуух ертөнцийн гэрэл гэгээг түгээхийг хичээдэг. Тиймээс нэгэн зууны сүүлийн хагаст маш олон Их Багш ном дэлгэрүүлэхээр гарч ирдэг байна. Энэ үе бол нэгэн зууны төгсгөл юм. Тиймээс маш олон хүн ном дэлгэрүүлж байгаа тухай радио, зурагт, сонин, хэвлэлээс бид уншиж байна.

Зарим хүн надаас: "Хүн бүхэн өөрийгөө Их Багш гэнэ, хэнээс суралцах нь зөв бэ?" гэж асуудаг. Багш нь тэдэнд: "Баяр хүргэе! Та бүхэнд. Ийм олон Их Багшаас сонгох боломжтой байгаад тань. Сонгох хүнгүй бол хамгийн хэцүү, тиймээс бүү гомдолло. Өөртөө тохирох багшийг сонгож, шийдвэр гаргавал түүнийгээ бүхий л сэтгэл зүрхээрээ дага. Боломжийг алдвал хожим харамсана! Нас барсны тань дараа зууны төгсгөл үе улиран одож, тэр үед ном дэлгэрүүлэх гэгээрсэн их багшгүй бол яах билээ" гэж хэлдэг.

Дэлхийн өнцөг булан бүрд Их Багш бий. Бид л бясалгах хүсэлгүй учраас уулзаж чадахгүй байна. Чин сэтгэлгүй бол Төгс Гэгээрсэн Их Багштай уулзаж чадахгүй. Төгс Гэгээрсэн Их Багш өмнө чинь ирсэн ч зугтаж одно. Шагжамуни Буддаг заларч байх тэр үед түүнтэй уулзах барилдлага олон

хүнд байсан, гэвч тэд бурхан гэдэгт нь итгээгүй. Нэгэн эмэгтэй бие давхар мэт харагдахаар гэдсэндээ түмпэн зүүж, Буддагийн ном айлдаж буй газарт очиж, түүнийг худал хуурмагаар ялласан байна. (дэлгэрэнгүйг "Бурхан Багшийн айлдсан брахман бүсгүй Гоша, Буддаг гүтгэсэн үйлийн үрийн барилдлага"-ын тухай судрын 8 дугаар бүлгээс уншиж болно) Эцэст нь тэнгэр, луу тэргүүтэн хүмүүн бус найман аймгийн төрөлтнүүд бүсгүйн хувцасыг ярж, нуусан түмпэнг нь ил гаргажээ. Энэтхэгт байдал ийм байхад өөр бусад оронд ном дэлгэрүүлэх бүр ч хэцүү.

Тиймээс та бүхэн эртнээс нааш төрөл тутамд бурхан бодьсадва, ихэд гэгээрсэн хүмүүс энэ дэлхийд заларсан байтал яагаад ийм цөөн хүн чөлөөлөгдсөн юм бол гэж гайхах хэрэггүй. Лиу Донбины багш Жун Личүан нэгэн шүлэгтээ:

Хөөр баяр, хөгжүүн ярианд автахаас чимээгүйхэн залхнам.
Хуран үймээнээс дайжин хөсөр суун бодол цэгцрэхүйд сүнс шаналнам,
Гэгээн амгаланг олсон хүмүүн хэд хичнээн билээ хэмээн дэмий л
Гар хуруугаа даран даран тоолон тоолон суунам, би

гэжээ. Энэ шүлэгт чөлөөлөгдсөн хүн хуруу дарам цөөн байдгийг маш тодорхой бичжээ. Эртний хүмүүс сайхан сэтгэлтэй, бясалгах цаг ихтэй байсан. Гэвч маш цөөн хүн чөлөөлөгдсөн байна. Одоо хүмүүсийн амьдрал дэндүү тухтай, бидний анхаарал сонирхлыг татах зүйл хэтэрхий их болсон тул чөлөөлөгдөх хүн бүр ч цөөн. Эд өлөгийн соёл нь аж амьдралыг тав тухтай, амар хялбар болгодог. Харин бид ийм тав тухтай амьдрахын төлөө цаг завгүй болчихжээ.

Өмнө нь үзэх зурагт байсангүй, шинэ мэдээ дамжуулахдаа удаан байлаа. Хэн нь хэнийг хөнөөсөн, дэлхий яаж үймж буйг бид ер мэдэхгүй байжээ. Одоо зурагттай

болж, нэвтрүүлэг бүхнийг алгасалгүй үзээд унтраахаа ч мартдаг. Зурагт хэтэрхий их үзсэнээс цаг тун хомс болжээ.

Өчигдөр нэг хүн Багшаас нь: Өдөрт тавхан цаг унтаж, үргэлж нойр дутуу явах болов, одоо яах вэ? гэж асуусан. Үнэндээ түүний цаг хүрэлцэхгүй биш, зурагт, киног хэт их үзэж, дуу хөгжим сонсож, сонин сэтгүүл уншиж, бүжиглэж, караоке-д дуулаад завгүй болсон хэрэг. Орчин үед хоол хийх хүртэл дэндүү нарийн төвгөтэй болсон. Дээр үеийнх шиг энгийн биш. Дээр үед бол хоолны орц ховор байсан. Миний санахаар, урьд Ау Лакт онцгой үйл явдал, эсвэл баяр ёслолын үеэр махан хоолоор дайлдаг байсан. Одоо өдөр бүр маш их мах идэж байна. Тав тухтай байлгах олон төхөөрөмж бий болж, энэ бүхнийг худалдан авахын төлөө завгүй ажиллаж, мөнгө олох хэрэгтэй болжээ.

Хөршийнд байгаа бүхэн манайд байх ёстой, хэрвээ байхгүй бол нэг л эвгүй, хоцрогдсон мэт санагдана. Багшийнх нь амьдарч байсан газарт орчин үеийн эд бараа гэхээр юм байгаагүй. Бидэнд тог цахилгаан, ярих утас ч байгаагүй тул цагаа хэмнээд олон цаг бясалгана, хамаг төрөлтөнд тустай ажил хийж чаддаг байжээ.

Утастай болсноор хүмүүстэй харилцахад амар болсон ч бас муу талтай. Хэрэг гарвал ганцхан залгаад амжуулна, гэвч бие биетэйгээ уулзах нь багасч, ах дүү, найз нөхдийн харилцаа өмнөх шиг дотно биш, нилээд хөндий болсон байна.

Тэгэхээр сайн зүйлийг ч зөв зүйлд ашиглахгүй бол бясалгалд ч тусгүй, амьдралд ч нэмэргүй. Заримдаа соёлжингуй эд зүйлс ч эсрэгээрээ биднийг хүлээсэлж, төвөг удаж, цаг зав их гарзддаг. Тэгэхээр сайнтай, муутай байдаг хэрэг.

Эртний хүмүүс бясалгалд нь нөлөөлөх олон янзын

харилцаа холбооны хэрэгсэл байгаагүй гэсэн ч бясалгах хүн их цөөхөн байжээ. Орчин үеийн амьдралын хэмнэл ийм хурдассан тул бясалгах хүн бүр цөөрсөн нь мэдээж. Энэ нь зүй ёсны хэрэг. Хүмүүс шинэ машин, загварлаг хувцас, зурагт авах гээд дэндүү завгүй болжээ.

Харин Формосагийн хүмүүсийн хувьд асуудал нилээд бага, гадаад явах нь цөөн тул мөнгөө дотооддоо зарцуулна. Хүмүүс нийтээрээ тав тухтай амьдарна. Аль ч аялал жуулчлалын газар очсон жуулчид ихтэй. Өөр очихоор газар хомс учир өмнөд нутгийн хүмүүс хойшоо, хойд нутгийнхан нь урагшаа аялна. Би олон оронд очиж байсан. Формоса бол нилээд үзэсгэлэнтэй газрын нэгэнд орно. Гэвч газар нь бага, хүн нь олон. Арлууд нь жижигхэн, уул ус, дурсгалт газрууд нь үнэхээр сүрлэг сайхан тул хүмүүс очих дуртай. Тиймээс хаана ч очсон хүн ихтэй.

Миний бодлоор энэ нь тун сайн, манай энд нилээд цэвэр ариун, элдэв муу нөлөө багатай. Гадаадад очвол олон зүйлийг сурах нь мэдээж, гэхдээ дэлхийн юмсын ихэнх нь муу нөлөөтэй байдаг. Лууз хэлэхдээ: “Гэгээнтэн хүн гэрээс гаралгүй дэлхийн байдлыг бүгдийг мэдэж болно” гэжээ. Бид Луузтай ижилхэн болбол тун сайнсан.

Их Найман аршийн түүхээс тэд үнэхээр үхэлгүй мөнхийн хутагт хүрснийг нь мэдэж болно. Хэ Сиегү-ийн хойд эх нь түүнд их л хатуурхдаг байсан ч урьдын адил ээждээ маш их ачлалтай байдаг нь Лиу Донбины сэтгэлийг ихэд хөдөлгөжээ. Тэгээд түүнд нэгэн увдист тоор бэлэглэсэн байна. Увдист тоорыг идээд Хэ Сиенгү-ийн билиг ухаан маш ихэд нээгдэж, үхэлгүй мөнхийн хутгийг олжээ.

Их Найман арш бол бүгд үхэлгүй мөнхөрсөн бодгалиуд. Гэтэл үхэлгүй мөнхөрсөн тэд яагаад одоо бидэндтэй тааралдахгүй байна вэ? Тэд бүгдээрээ хятад хүмүүс, тэгэхээр хаа нэгтээ заавал илрэн гарах ёстой!

Үхэлгүй мөнхрөх гэдэг нь махан бие нь үхэлгүй мөнхөрсөн бус, харин сүнсэн бие нь үхэж, төрөхийн сансрын хүрднээс чөлөөлөгдөж, үүрд мөнх үхэхгүй, төрөхгүй болж, үнэхээр илтэд төгс туулсан бодь хутагт хүрч, үхэлгүй мөнхрөх хутагтын сууринд хүрч, Бурхан Буддатай ижилхэн болсон гэсэн үг.

Лиу Донбины хэлсэн үхэлгүй мөнхөрсөн хувилгаан гэдэг нь Буддатай ижил болж, Будда шиг Бурханы хутагт хүрсэн гэсэн үг. Гэсэн ч тэр өөрийгөө Будда гэж хэлж зүрхлээгүй. Хүмүүст гадаад номтон гэж хэлүүлэх, дайрч доромжлуулахаас айсан тул Будда шиг гэсэн байна. Ингэсэн нь илүү даруухан, бас аюул осол багатай байжээ.

Будда ч үхэлгүй мөнхөрч, үхэж, төрөхийн сансрын хүрднээс чөлөөлөгдсөн. Бид үргэлж Будда илрэн гарч, бидэнд харагдаасай гэж хүсдэг, гэвч Буддаг ирэхэд бид тэнгэрийн нүдгүй, бурханы мэлмийгүй бол харж чадахгүй.

Манай авшигтнуудын дунд бурхан бодьсадва, арш хувилгаадыг хардаг хүн цөөнгүй, та нар итгэж байна уу? (Итгэж байна гэж зарим нь хариулав) Би өмнө нь Каошиунд очиж, ном айлдах үедээ найман аршийн сүмийг зээлж суусан юм. Тэдний дотроос нэгэн шавь, Лиу Донбин ирж, Багштай нь мэндэлж, Багшид нь мөргөж байхыг бясалгалаараа харжээ. Үүнийг миний шавь ярьсан. Тэр үед бас олон хүн сонссон шүү. Удалгүй намайг бүү буруутгаарай даа, Багш өөрийгөө ингэж ярьсан гээд. (бүгд алга ташив)

“Найман арш далай тэнгисийг гаталсан нь” киног бид үзсэн. Энэ кинонд их найман арш Луузыг бишрэн угтаж байгаа тухай гардаг. Та нарт санаанд оромгүй санагдаж, найман арш Луузтай ямар холбоотой билээ гэж бодож байгаа байх. Холбоотой. Учир нь сайн бясалгалтай хүн өнгөрсөн, одоо, ирээдүйн олон их багштай уулзаж чаддаг.

Тиймээс Багш нь ямар ч шашинд итгэсэн, өнгөрсөн үеийн ямар ч их багшийг шүтсэн ялгаагүй бүгд сайн. Тэднийгээ үргэлжлүүлэн шүтэж болно, гэхдээ Арьяабалын аргаар заавал бясалгах хэрэгтэй. Тэгвэл та нар багш нартайгаа уулзаж чадна гэж олон удаа ярьсан билээ.

Каошиунд, Лиу Донбиныг харсан тэр шавь их найман аршийг шүтдэггүй, нэрийг нь ч бүрэн тогтоогоогүй хүн байсан. Харин тэр, миний ээж их найман аршийг хамгийн их шүтдэг, шүтээн болсон их найман аршаараа дамжуулан Их Багшид мөргөж байдаг. Хамгийн их шүтдэг нь Лиу Донбин гэж ярьсан.

Шагжамуни Будда: “Төрөлтөн бүхэн бурхан чанартай” гэж айлдсан. Есүс Христ: “Бид бүгдээрээ Эзэн Бурханы хүүхэд мөн” гэжээ. Бид ямар ч шашин шүтэж болно, гэхдээ заавал дотоодын ахуй ойлголттой байвал сая зөвдөнө. Ингэж л бид төгс төгөлдөр Католик шашинтан, төгс төгөлдөр Буддын шашинтан, төгс төгөлдөр Игуандао шүтлэгтэн, Луузын шүтлэгтэн, Күнзийн сургаалтан болно. Багшийнхаа санааг ойлгов уу?

Миний америк шавь Луузыг харжээ. Лууз гэж хэн болохыг тэр мэдэхгүй, хожим нь түүний хөргийг хараад мэддэг болсон. Заримдаа бид итгэж сүсэглэдэггүй ч бас хардаг. Бясалгаж байхдаа бидний сүнс тэдний орноор дайран өнгөрвөл тэдэнтэй заавал уулзана. Тиймээс их найман арш Луузтай хамт байсан нь үнэн бодитой явдал.

Бид Буддагийн дэсэд хүрээгүй байгаа ч Бурхан бодьсадва, гэгээнтнүүдтэй уулзах завшаан олддог. Тиймээс бид тийм ч өнчин ганцаардмал биш. Гэвч бид их өнчирдөг, учир нь бясалгалын зам мөр юу ч шаардахгүй, зөвхөн биднээс огоорч орхихыг шаардана, эгэл хүний тогтсон үзэл бодлыг орхиж, бүхий л үзэл ойлголтыг хаяж, өөрийн сэтгэлийг бүрэн хоосолбол сая мөрийг олж гэгээрнэ.

Мөрийг олж гэгээрэхэд бидний хичнээн их ном сударт нэвтэрсэн, эсвэл хаанахын ямар сургууль төгссөн, том, жижиг дарга байхтай ямар ч хамаагүй. Өчигдөр бясалгалын сэтгэгдлээ хуваалцсан номын ах бол таксины жолооч. Өнөөдөр тайзан дээр гарч ахуй ойлголтоо ярьсан хүн бол сургуулийн багш. Ажил мэргэжил нь өөр ч тэр хоёрын ахуй ойлголт тун сайн байна.

Тиймээс хүн бүхэнд найдвар бий. Бясалгал баян, ядуугаар ялгаварлахгүй, харин жинхэнэ чин сэтгэл байна уу, үгүй гэдгийг л харна. Бид энэ ертөнцөөс сэтгэлийн гүнээс уйссан, үхэж, төрөхийн хүрднээс ангижрахыг үнэхээр их хүссэн, их билгүүн ухааныг олж хүртэхийг жинхэнээсээ эрмэлзсэн, баруун зүгийн Төгс баясгалант орон луу буцах үнэн сэтгэлийн хүсэлтэй байх хэрэгтэй.

Бурхны шашны ариун орны шүтлэгт баруун зүгийн ариун оронд очихыг сэтгэлийн гүнээс маш хүчтэй хүсэх нь нь тун чухал гэж онцолдог. (Ариун орны шүтлэг нь итгэл, сэтгэл, явдал мөрөө баруун зүгийн ариун оронд төрөх нөхцөл болгоно. Хамгийн гол нь баруун зүгийн Төгс баясгалант орон үнэхээр оршин байдагт итгэсэн итгэл байх ёстой) Жинхэнэ ариун орны шүтлэг бол ийм байдаг. Тэрнээс өдөр бүр бурхныг дурсахыг дадал болгож, амандаа тарни уншивч сэтгэлдээ захаас ногоо авах тухай бодох, эсвэл зарим нь тасралтгүй эрих эргүүлэх боловч хүүхэд үймүүлбэл эрих гүйлгэхээ зогсож: Чамд юу хэрэгтэй вэ? гэж төвөгшөөх явдал биш юм. (Бүгд инээв.)

Эрих гүйлгэхийн хэрэг нь юу вэ? гэж нэг хүн Багшаас нь өчигдөр асуусан. Эрихээр хүүхдээ л зодох байх даа гэж би хариулсан. (Бүгд инээв.) Багшийнх нь зүүсэн эрихэнд онцгой утга учир байхгүй. Шавь маань сэтгэлээсээ өгсөн болохоор л зүүж явдаг. Эрих бол номын багшийн хэрэгсэл. Номын хэрэгсэл зүүвэл харахад сүрлэг эрхэмсэг, хүмүүсийн нүдэнд таатай. Та бүхэн ийм ганган хувцаслаад Багштайгаа

уулзахаар ирдэг. Тэгвэл Багш нь бас арай аятайхан хувцаслаад бурхад та нарыгаа угтах хэрэгтэй.

Та нар бүгд бурхад шүү дээ! (Бүгд алга ташив.)

“Богдосын ном цагаан лянхуа судар”-т бичсэнээр: Баршгүй саналт бодьсадва Арьяабал бодьсадвад эрдэнийн чулуун зүүлт өргөжээ. Арьяавал бодьсадва уг нь авахыг хүсээгүй ч Шагжамуни Будда оролцож: “Хамаг төрөлтөнийг буян хишигтэй болгохын тухайтад та хүлээн авах ёстой” гэв. Тэр үед Арьяабал бодьсадва хамаг төрөлхтний өмнөөс бодоод хүлээн авчээ. Тэрээр эрдэнийн зүүлтийг хоёр хувааж, нэг хэсгийг Шагжамуни Буддад, нөгөөг нь Олон эрдэнийн бурханы суварганд өргөв”.

“Богдосын ном цагаан лянхуа судар”-т бясалгагч хүний дотоодын ахуй ойлголтыг бичсэн. Тэд бясалгах үедээ болон авшиг хүртэхдээ өндөр дээд төвшинд хүрч, Арьяабал бодьсадваг Шагжамуни Будда болон Олон эрдэнийн бурхантай уулзан ярилцаж байгааг харжээ. Ийм гайхамшигтай ахуй ойлголтыг тэнд байсан хүн бүхэн үзэхгүй. Ойлгов уу? Ойлгохгүй байна уу? За, тэгвэл би илүү дэлгэрэнгүй тайлбарлая.

Өчигдөр ном айлдах үеэр энд байсан зарим хүн Багшаас нь гэрэл цацрахыг харжээ. Гэрэл тэдэн рүү туссан байна. Зарим нь Багшийн бие биндэрьяа болор бие болон хувирахыг харжээ. Цөөн хэдхэн хүн харсан. Та нар бүгд хараагүй. Харин хариу мэдрэх зөнтэй хүмүүсийн харахад Багш нь өөр өөрөөр илэрсэн байна.

Бурханы хутагт хүрэх нь шинжлэх ухаанд нийцнэ

Үүнээс гадна, зарим хүн Багшаас нь та бидэнд хүчээ

үзүүлж болох уу гэж асуудаг. Бодит байдал дээр зарим нь Багшийн хүчийг зөн совингоороо хариу мэдэрнэ. Гэхдээ хүмүүсийн ихэнх нь харж чадаагүй байдаг. Харин харсан хүний асуух асуулт нь өөр болдог. Зарим нь: “Багш аа! Та Арьяавал бодьсадва мөн үү?”, зарим нь: “Багш аа, та Газрын зүрхэн бодьсадва мөн үү” гэж асуудаг.

Учир нь тэдний харсан Багш бүгд өөр өөр байжээ. Тиймээс Багш яг хэн болохыг нотлохыг хүсвэл тэд бүгд Багш нь мөн. Гэхдээ бас биш. Учир нь дүрс хоосноос ялгаагүй. Хэрвээ би мөн гэвэл бас биш. Хэрвээ биш гэвэл бас буруу. Учир нь угаасаа мөн. (Бүгд алга ташив.)

Ханьцашгүй үнэхээр илтэд туулсан Бурханы бодь хутагт хүрвэл бид юм бүхэн мөн. Бас бид юм бүхэн биш. Учир нь бид “Мөр”-ийг олвол “Мөр”-ийг олсноо өөрөө мэдрэхгүй. Энэ “Мөр” үнэхээр сэтгэгдэшгүй, өгүүлшгүй, тиймээс “Мөр гэмээ нь мөр биш” гэж ярьдаг байна.

Зарим хүн машид их гэгээрсэн мэт харагдавч тийм сайн гэгээрээгүй байдаг. Зарим хүн мөрийг бүтээгээгүй, гэгээрээгүй мэт харагдавч машид их гэгээрсэн байдаг. Гэгээрэл бол үнэхээр тонгоруу явдал юм. Тиймээс Багш нь шавь нартаа: “Хэрвээ биднийг хүн загнавал талархах хэрэгтэй. Хүн биднийг магтан сайшаавал сэрэмжтэй байх ёстой. Учир нь бидний би гэх үзэл оволзон гарах болно” гэж байнга захидаг.

Биднийг загнах үедээ тэр хүн бидний үйлийн үрээс хуваалцаж, бидний би гэх үзлийг цэвэрлэж, биднийг нилээд ариусгаж, бодол санааг хянамгай болгож, алдаа оноогоо дүгнэж, хаана ямар алдаа гаргаснаа эргэцүүлдэг болгоно. Бардамнах юм өөрт үнэндээ байхгүйг ухаарч, илүү номхон даруу болно. Тиймээс үйлийн үрийг угаах гэжээ. Ер бусын юм энд ер байхгүй, тун шинжлэх ухаанч явдал юм. Үйлийн үр, нүгэл хилэнц, буян хишиг, ач буян энэ бүхнийг шинжлэх

ухааны өнцгөөс тайлбарлаж болно.

Бясалгал ч бас шинжлэх ухаантай ижил, жишээ нь, эрдэмтэн хүн усыг хэрхэн мөс болгохыг мэднэ. Жирийн хүн сурвал бас усыг мөс болгож чадна. Тийм биз? Дээр үед зарим бясалгагч буурцаг цацаад цэрэг болгодог шидтэй байжээ. Өнөөдөр ч бид бас архийг мөс болгон хувиргана. Ийм нэгэн чадвар дээр үед ид шидэд тооцогдож байсан бол одоо энгийн нэг химийн урвал болохыг хүн бүхэн мэднэ. Аргыг нь мэдвэл бид ч бас усыг мөс болгоно.

Жишээ нь, биохими судалдаг хүн өөр өөр химийн элементийн нэгдлээр харилцан адилгүй үйлдэлтэй олон эм, хортой бодис, сайн эм, саар эмийг гарган авдаг. Хүмүүсийн ихэнх нь харин энэ ертөнцийн ид шидийг л сурахыг хүсдэг. Харин Бурхны ид шидийг сурах дуртай хүн байхгүй. Үл мэдэгч хүн л бясалгагч хүн этгээд сонин, ер бусын гэж боддог.

Багшийн номд ихэнхдээ ер бусын зүйлс, олон янзын дэс төвшин, бясалгалын хүчний талаар өгүүлдэг гэж зарим хүн хэлдэг. Үнэндээ Багш нь заавал хүч гэхгүй урлаг гэж бас ярьж болно. Билиг бясалгалын аргыг бясалгал талаас нь биш, өөр нэг өнцгөөс орон зайн шинжлэх ухааны урлаг гэж ярьж бас болно.

Ертөнцийн шинжлэх ухааны аргаар усыг мөс, мөсийг ус болгож болно. Олон материаллаг зүйлийг өөр нэгэн материаллаг зүйл болгон хувиргаж болно. Орон зайн шинжлэх ухааны урлагийн тухайд бол хүнийг бурхан болгон хувиргана. Бидний мунхаг харанхуй, бядуу дорой оюун ухааныг их билгүүн ухаан болгон хувиргадаг ажээ.

Тиймээс бясалгал бол ер бусын нууцлаг зүйл биш. Орчлон хорвоогийн юм бүхнийг сурч эзэмшиж болно. Заримдаа бид зөвхөн нэг хэсгийг, заримдаа хоёр зүйл,

заримдаа гурван зүйлийг сурдаг. Заримдаа бид бүгдийг буюу зуун хувь сурдаг. Бүгдийг амжилттай сурч, юм бүхэнд нэвтэрч чадсан хүн бол Будда юм. Анагаахын шинжлэх ухаанд суралцсан хүнийг эмч гэнэ. Хууль зүйг тусгайлан судалж, суралцсан хүнийг хуульч гэнэ. Хэрвээ бид будда болохыг хүсвэл Бурханы хутагт хүргэдэг шинжлэх ухааны урлагийг судлах хэрэгтэй. Арьяабалын бясалгалын арга бол нэг төрлийн шинжлэх ухааны урлаг бөгөөд түүнийг сурч төгссөн хүн... хутагт хүрнэ ээ. (Бурханы гэж нэгэн хүн хариулав) Тийм ээ! Баярлалаа!

Хоёрдугаар бүлэг

НҮЙВА[1] ЧУЛУУ ХАЙЛУУЛЖ, ТЭНГЭРИЙГ НӨХСӨН НЬ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Каошиун хот.1988 оны 5 дугаар сарын 11
(Эх нь хятад хэлээр)

“Чулууны бичээс” дэх билиг бясалгалын тухай далд утга

“Улаан асрын зүүд” зохиолд Нүйва чулуу хайлуулж, тэнгэрийг нөхсөн түүх гардаг. Нүйва тэнгэрийг нөхөж дуусахад ганц чулуу үлджээ. Нүйва тэр чулууг илбэсэнд чулуу их зөн билигтэй, олон зүйлийг ойлгох чадвартай болсон гэнэ. Үүнийг уншсан эгэл хүн наадам наргиа хийж байна гэж бодон хүүхдийн уншдаг үлгэр домог болгоно.

Гэвч энэ нь үлгэр домог биш. Арьяабалын аргаар

1 Нүйва -Хятадын уламжлалт 女媧дасгал 女娲 пиньинь Nǚwā) нь хүн төрөлхтнийг бүтээгч, дэлхийг үерээс аврагч, нөхөрлөл, гэрлэлтийн бурхан болсон Хятадын (Даоист) сүм хийдийн агуу Дара эх, охин тэнгэрийн нэг юм. Википеди толь.

бясалгадаг хүн бол ямар ч ном уншсан түүний жинхэнэ утгыг ойлгоно. Хүүхдийн уншдаг ном ч цаанаа билиг бясалгалын гүн утга агуулж болно. Учир нь бурхны хүч, их зам мөрийн хүч сэтгэгдэшгүй их. Түүнээс өчүүхэн багыг хүртвэл асар их шидийг олж, дэлхий дахины түмэн зовлонг арилгаж чадна. Тэгвэл зам мөрийг бүрэн төгс бүтээж чадвал юу болох вэ? Тийм учраас бид эртнээс нааш Бурхадыг, Төгс Гэгээрсэн Их Багш нарыг магтан сайшаасаар ирсэн хэрэг. Учир нь тэд энэ их хүчийг хэдийнээ төгс олж хүртсэн байдаг.

Чулуу зөн билигтэй болсон түүхийг энгийн хүн яавч билиг бясалгалтай холбож ойлгохгүй. Гэвч зохиолч өөрөө бясалгалтай хүн байсан учраас ийм ёс учрыг ойлгодог байжээ. Тэрээр зарим нэг зүйрлэлийн аргыг ашиглан бясалгалын хүчийг илэрхийлсэн байна.

Нэгэн Гэгээрсэн Их Багш бол их хүч, Эзэн Бурхан, их билиг ухааныг төлөөлнө. Тиймээс түүний хүч чадал сэтгэгдэшгүй их. Нийт орчлонгийн хүч Түүний дотор байгаа. Тэр хүссэн бүхнээ хийнэ. Үйлийн үрийг эвдэе гэвэл эвдэнэ, тамаас хүссэн төрөлтнөө аварна. Бүгд асуудалгүй. Тиймээс их бясалгагчийн хувьд бол түүнийг даган суралцсан бидний таван үе, есөн үеийг гэтэлгэх нь тун энгийн явдал. Өчүүхэн ч асуудалгүй. Өвгө дээдэс маань бидэнтэй цусан төрлийн холбоотой учраас их бясалгагч багш тэдэнд тусалдаг юм.

Чулуог алт болгох ер бусын хүч

Яагаад Нүйва–гийн хүрсэн чулуу билиг ухаантай болсон бэ? Учир нь түүнд сэтгэгдэшгүй их хүч чадал байдаг тул түүний хүрсэн бүхэн өргөгдөж, сүнслэг болж хувирна.

Миний өвгө Багш амьд сэрүүндээ нэг удаа манай Багштай уулзахаар очжээ. Багш өөрийн гэсэн тусгай даяаны

өрөөтэй. Өвгө Багшийг залрахад даяаны өрөөндөө түүнийг суулгасан аж. Өвгө Багшийг буцсаны дараа тэр өрөө нь өдөржингөө хорин дөрвөн цаг аялгуутай байх болсон байна. Өмнө нь тийм байгаагүй. Өвгө Багшийг ирж сууснаас хойш өөр болсон байна. Өвгө Багш тэнд байгаа эд зүйлсийг адисалж, амьтай, сүнслэг болгосон байжээ. Тиймээс чулууг сүнслэг амьд төрөлтөн болгох сэтгэгдэшгүй их хүч зөвхөн Нүйвад байсан биш, Төгс Гэгээрсэн Их Багш бүхэнд ийм төрлийн хүч байдаг байна.

Түүнээс хойш Багшийн даяаны өрөөг цоожлох болж, хэнийг ч оруулахгүй, зөвхөн Багш өөрөө л тэр газрын гайхамшгийг эдлэн баясдаг болжээ. Хүмүүсийн зарим нь их бүдүүлэг байдаг тул ариун дагшин газар сэвтэх вий гэж Багш их эмээдэг байсан.

Энэ дэлхийн зарим хүнд бодьсадвагийн чанар давамгай, зарим хүнд эгэл ертөнцийн бүдүүлэг чанар их байдгийг бид мэднэ. Тийм биз? Ариун гэгээн хүмүүс харахад нүдэнд дулаахан, сэтгэлд их тааламжтай. Энэ нь эгэл ертөнцийн тааламжтай сайхан бус, харин туйлын эрхэм дээд, машид гэгээрсэн тааламжит байдал юм. Сэтгэл зүрх нэгэн зүйлийн баяр баяслаар бялхаж, бясалгал хийж, гэгээрэх сэтгэл төрж, өөртөө эрхэм дээд хүсэл мөрөөдөл байгааг мэдэрнэ.

Зарим хүнээс, эсвэл зарим нэг газарт орохын зуурт л нэг тийм таагүй бодол халдварладаг. Гэнэт л энэ ертөнцийн эд юмсыг хүсэж, сэтгэл санаа тогтворгүй болдог, тийм биз? Энэ нь хүн бүрийн ялгаатай хэлбэлзлээс болдог. Их бясалгагч хүний хэлбэлзэл маш цэвэр ариун, тайван тогтуун байдаг. Тэдэнтэй уулзвал бид зөв сайн ойлголттой болж, бясалган чөлөөгдөхийг хүсэж, эрхэм дээд үйл хэрэг бүтээхийг эрмэлзэнэ. Эд баялгийн талаар огтхон ч бодохгүй. Маш хүнд үйлийн үртэй л биш бол зууны ерэн есөн хувь нь эрхэм дээд үйл хэргийн тухай л боддог. Бусармаг мууг

бодох нь тун ховор.

Шагжамуни Будда маш олон хүнд гэгээрэх сэтгэл үүсэхэд зоригжуулж, олон арван мянган хүн түүнийг даган гэрээс гаран бясалгажээ. Гэвч ганц хоёр эмэгтэй арай өөр бодолтой байсан. Жишээ нь, Модэнжиа бүсгүй Шагжамуни Буддагийн шавь Анандад сэтгэлтэй болсон. Уг нь бид гэрээс гарсан хүнийг хараад ихэд хүндэлж, бясалгах сэтгэл төрдөг. Гэвч Модэнжиа бүсгүй Анандыг хараад бясалгах сэтгэл төрөөгүй, харин Анандын сэтгэлийг татах тарни уншжээ. Тиймээс түүний гаргасан энэ байдал арай ангид явдал юм.

Анандыг харсан эмэгтэй хүн бүхэн ийм биш, гэхдээ Ананд үнэхээр сайхан залуу байжээ. Тиймээс Шагжамуни Будда түүнийг биеэ ил гаргасан хувцас өмсөхийг хориглосон байна. Тэр үед энэтхэгийн гэрээс гарагсад бүгд гар, бугуйгаа ил гаргасан хувцас өмсдөг байв. Харин Ананд тэгж хувцаслаж болохгүй. Учир нь Шагжамуни Будда, бүсгүйчүүдийн сэтгэл хөдлөхөөс эмээсэн байна.

Бурханы ийм их ивээл хамгаалалтын дор байсан ч Модэнжиа бүсгүйн сэтгэлийг хөдөлгөсөн аж. Сэтгэлийн хөдлөл ч яахав, тэр бүсгүй харин удалгүй ирж, Шагжамуни Буддаг даган гэрээс гарсан байна. Шагжамуни Буддад ч ер хохирол болсонгүй. Анандыг алдаагүй төдийгүй, нэмээд нэг гэрээс гарагчтай болжээ.

Модэнжиа бүсгүй гэрээс гарсны дараа Анандаас ч хурдан бясалгасан байна. Учир нь тэр ихэд хичээж, хатуужилтай бясалган Анандаас бүр өмнө гэгээрсэн гэдэг. Харин Ананд Шагжамуни Буддаг их нирваанд орсны дараа жинхэнэ гэгээрэлд хүрсэн юм.

Энэ хүч зөвхөн Буддад л байдаг биш, эгэл хүнд ч бас бий. Ямар ч зэрлэг араатан, хорон санаатныг уяраана. Гэтэл бид гэгээрээгүй, бурхан чанараа хөгжүүлээгүй учраас хүч

чадалгүй байна. Гэгээрвэл яг Будда шиг болно. Тиймээс “Мөн чанараа үзэж, будда болно” гэж ярьдаг.

Гэгээрэх мөч

Будда болох нь маш амархан, тун энгийн, маш аядуу зөөлөн, Будда болсон шинж тэмдэг огт мэдэгдэхгүй. Гэгээрэхэд заавал газар, тэнгэр донсолж, тэнгэр, газар нээгдэх шиг болохгүй. (Багш болон нийтээр инээлдэв) Гэгээрэх нь тун энгийн, маш хялбар явдал. Нойрондоо, зүүдэндээ, бясалгах үедээ, хооллох үедээ, эсвэл бие засах өрөөнд ч гэгээрч болно. Та нарын дотор бие засах өрөөнд гэгээрсэн хүн байна уу? Мэдээж байгаа. Хүмүүс эрхэмсэг бус гэхээс эмээж, хэлж зүрхлэхгүй байна. Гэвч Бурхан хаана ч оршин байдаг. Яагаад бие засах газарт гэгээрч болохгүй байх вэ?

Багш нь анх Формосад ирэхэд хүмүүс намайг Арьяабалын аргаар бясалгадаг гэж мэдэхгүй, би ч мэдүүлэхийг хүсээгүй, тиймээс бие засах газарт нуугдан бясалгадаг байсан. Тэнд нэг л дутагдал байдаг нь байнга хаалга тогшино. Тогшвол гарч, өөр нэг бие засах өрөөнд орж бясалгана. (Багш болон хүмүүс инээлдэв) Төд удалгүй дахиад хүн ирж, тогшино. За, за за! гээд дахин гарч, өөр газар хайна. Зарим үед агуулахад бясалгаж болдог. Лекцийн танхим, сүм болгон агуулахтай. Тэнд бясалгалын олбог, сандал байдаг. Би тэнд нуугдаад бөөн олбог сандалтай хамт бясалгадаг байв. Та нар олбог дээр суугаад бясалгадаг бол би олбогнуудтай хамт бясалгадаг байлаа. Агуулах, бие засах газар аль аль нь албан ёсны бясалгалын сүм биш. Би бас бурхны тахилын ширээний өмнө бясалгаагүй, гэсэн ч гэгээрсэн. Ихэд гэгээрэх үеийг онцгойлон ярих хүсэлгүй. Учир нь гэгээрэх агшин тун энгийн, сүртэй юмгүй, заавал хэлж ярих, эсвэл хавь ойрыг доргион тунхаглаж, ёслон

тэмдэглэх хэрэггүй.

Багшийнх нь нилээд хэдэн гэгээрлийн туршлага сүм хийдэд биш, харин агуулах, бие засах газар, далайн эрэг, голын хөвөө, майхан гэх мэт маш энгийн газарт тохиолдсон. Эсрэгээрээ хөл хөдөлгөөнтэй, эсвэл тийм ч сүр жавхлантай биш газруудад Багш нь дао - гэгээрлийн сэтгэгдэшгүй их хүчийг мэдэрсэн билээ. Магадгүй тийм сүр жавхлантай газарт гэгээрэх учиргүй нь миний хувь тавилан байх.

Үнэндээ бясалгалын сүм хаа сайгүй, газар бүхэн сүр жавхлантай. Харин хүмүүсийн хэрэгцээ л өөр өөр. Зарим хүн заавал сүрлэг ариун газарт байвал сэтгэл нь төвлөрч, гэгээрч чаддаг. Зарим хүн Их Багш нартай хамт маш удаан амьдрах шаардлагатай. Тэгж байж дараа нь гэгээрдэг. Зарим хүн Их Багшийг хармагц гэгээрдэг.

Өчигдөр зарим хүн гэртээ хариад л гэгээрлийн ахуй ойлголттой болсон байна. Тэр өдөр Багш нь тэдэнд юу ч заагаагүй, тэд харин хариад унтаж байхдаа гэрэл харж, гэгээрлийн төвшнийг үзсэн байна. Энэ бол гэгээрсэн байдал болно. Гэгээрэл тийм зөөлөн аядуу, тийм хялбар байдаг.

Хялбар мэт харагдана, гэвч хялбар биш. Яагаад вэ? Учир нь бид тэр зөөлөн аядуу гэрэл, дэс төвшнийг харсны дараа хүн нь өөрчлөгддөг. Өөрчлөгдсөнөө бид мэдэхгүй байсан ч өөрчлөлт болсон байдаг. Бидний бясалгалын дэс маш их дээшилнэ. Хэрвээ Их Багшийн удирдлагагүй, эсвэл өөрөө дурааараа бясалгавал хэдэн арван жил бясалгаж байж, сая нэг өчүүхэн гэрэл харна, эсвэл жаахан дотоодын аялгуу сонсоно.

Бид даяаны түүх уншвал урьд цагт даяаныг бясалгадаг хүмүүс маш урт удаан хугацаанд бясалгаж бясалгаж, гэнэт нэг өдөр бишгүүрийн дуу, хонхны дуу, аянгын дуу сонсоно. Тэд хачин их баярлаж, Багшдаа илтгэж,

гэгээрснээ илэрхийлнэ. Маш удаан бясалгасны эцэст л олж хүртдэг байжээ. Харин манай авшигтнууд бол тэр дороо олж хүртдэг. Авшиг аваагүй ч бас ахуй ойлголт хүртэж магадгүй. Заримдаа их бясалгагч хүнийг харахын төдийд л бид гэгээрлийн ахуй ойлголттой болдог.

Тийм учраас хүмүүс нэгэн Их Багшийг, нэгэн жинхэнэ Их Багшийг бахдан магтдаг ажээ. Учир нь түүний хүч чадал сэтгэшгүй их. Яг л Нүйва шиг, тэрээр чулууг адисалж, билиг ухаантай, бодож сэтгэдэг, олон зүйлийг ойлгодог болгосон. Хожим нь дэвшээд хүн болно. Гэхдээ чулуу хүн болон төрөл дээшилсэн ч нэгэн нэн агуу бодгаль болон хувирахгүй нь тодорхой.

Тиймээс, “Улаан асрын зүүд” зохиолын Жа Баоүй тийм олноос онцгой түмнээс төгөлдөр биш, тэр бясалгалтай, ахуй ойлголттой, зөн мэдрэмжтэй хэдий ч тийм агуу мундаг байгаагүйг бид мэднэ. Тэр дахин нилээд хэдэн удаа төрөл авч, үргэлжлүүлэн бясалгаж, өөрийгөө хөгжүүлвэл сая жинхэнэ мөрийг бүтээж, Бурханы хутагт хүрээд төгс төгөлдөр төрөлтөн болно. Эс бөгөөс жаахан хүч чадалтай болохоос цаашгүй.

Жаахан хүч чадалтай болсон тэр хүмүүс Бурханы хутагт хүрэхгүй ч байж мэднэ. Магадгүй ид шид, зөн билигтэн, эсвэл хар домч болох байх. Энэ бүхнийг чадагч их хүчийг бүрэн төгс олж хүртвэл сая Бурханы хутагт хүрнэ. Бурханы хутагт хүрсний дараа ямар ч төрөлтнийг аварч болно. Харин нэг жаахан хүч чадал олвол өөрийгөө ч аварч чадахгүй байж магадгүй юм.

Учир нь бясалгал маш олон дэстэй. Зарим хүн нэгдүгээр дэсэд хүрч нэгдүгээр ертөнцөд байна. Зарим хүн хоёрдугаар дэсэд хүрч хоёрдугаар ертөнцөд байна. Зарим хүн бясалгаад гурван ертөнцийн чанадад гарна.

Зарим ертөнцөд хүрвэл маш их хүчтэй болдог. Бид үүнийг хамгийн төгс дээд нь хэмээн андуурдаг. Үнэндээ, хамгийн төгс дээдэд хүрсэн ч бидэнд ямар ч онцгой зүйл мэдрэхгүй. Тиймээс сударт Шагжамуни Будда айлдахдаа: “Гэгээрэх нь миний хувьд зүүдлэхтэй ижил. Бурханы хутагт хүрэх нь надад агаарт буй цэцэг шиг” гэжээ. Санаа нь, түүний хувьд Бурханы хутагт хүрэх нь тийм сүртэй биш, маш энгийн, тун жирийн явдал ажээ.

Ялааны дотоодод ч бас зам мөр буй

Та нар, Багш өдөржингөө нүдээ аниад эсвэл хагас аниад яг л Бодьдармаа шиг сүрлэг эрхэмсэг бясалгаж суудаг. Хэн нэг хүн ойртон ирвэл нүдээ том нээн эгцлэн ширтэхэд өнөөх хүн ихэд айн холдон одно гэж боддог. Үгүй дээ, бясалгахаас гадна заримдаа би ном уншдаг. Уйдвал ялаа ажигладаг. (Багш инээв)

Өнөөдөр би нааш, цааш нисэх ганц, хоёр ялааг хэсэг зуур ажиглаад тэд бидэнтэй адилхан болохыг жинхэнээсээ ойлголоо. Тэд үнэндээ ялаа биш юм. Энэ дэлхийн үг хэл хязгаарлагдмал тул тэднийг ялаа гэж нэрлэжээ. Тэр уг нь ялаа биш, зөвхөн гаднах төрх нь ялаа болохоос дотоод хөдөлгөх хүч нь ижилхэн байна. Ижилхэн хүч түүнийг захирч, түүнийг нисгэж, түүнийг хөдөлгөж, түүнийг хооллож, ийш нь тийш нь явуулж байна.

Хүмүүс бид ч бас адил. Чи, би, тэр бүгд адилхан. Дотоод нь ижилхэн. Зөвхөн гаднах өмссөн “хувцас” нь өөр. Чи сайн хүн, би муу хүн, эсвэл би сайн хүн, чи муу хүн байсан ч дотоод тал нь бүгд ижил. Сайн муу бол ердөө л гадна талын адил бус үйлдэл төдий.

Бид ялгахын тулд л “сайн”, “муу” гэж хэлдэг. Хэрвээ бид сайн, муу гэж ялгадаггүй бол энэ дэлхий сонирхолгүй

болно. Тиймээс бид ялгах болсон. Яг нэг задгай тайзан дээр жүжиг үзэх шиг. Жүжиг эхлэхээс өмнө жүжигчид бүгдээрээ эгэл жирийн нэгэн гэр бүлийн гишүүд, эхнэр, нөхөр, хүүхдүүд байдаг. Гэрээрээ нийлээд нэгэн тоглолтын баг бүрдүүлжээ.

Удалгүй тайзан дээр гарвал бүгд өөрчлөгдөж, аав нь харгис хэрцгий хаан, ээж нь зовлонд өртсөн өрөвдөлтэй хүн, хүүхэд нь аавынхаа дайсан болон хувираад хувьсгал хийж, харгис эзнийг хаан суудлаас түлхэн унагаана. Тайзан дээр хүн бүхэн өөрт оногдсон дүрдээ орно. Удалгүй гэртээ хариад нүүрээ угааж, будгаа арилган хувцсаа соливол угаасаа нэг гэр бүл тул хамтдаа хооллож, ярьж хөөрч, ажиллаж хөдөлмөрлөнө.

Гэгээрлийн ахуй ойлголтууд бидний сэтгэлийг их хөнгөн амар болгодог. Хүний сайн, мууг нэг их тоохгүй, энэ дэлхийн хөгжих дэвших эсэхийг тов тодорхой харна. Энэ дэлхий яг л театр шиг, хүн бүхэн жүжиглэж байдаг. Гэхдээ энэ бас сонирхолтой! Хэрвээ ийм тоглолтгүй бол өөр юу хийх вэ? Олон хүн Баруун зүгийн Төгс баясгалант оронд очоод энэ дэлхийд дахин төрж, хамаг төрөлхтнийг гэтэлгэе гэж тангарагладаг. Магадгүй баруун зүгийн Төгс баясгалант орон дэндүү уйтгартай байх, би мэдэхгүй юм. (Багш инээв.)

Та нар баруун зүгийн Төгс баясгалант оронд очиж байсан уу? Ариун орон дэндүү баяр жаргалтай болохоор уйдахгүй. Гэхдээ хэсэг хугацааны дараа уйдах байх, ер нь ямар ч зүйлд хэв дундыг барих нь зөв.

Хэтэрхий арга, хэтэрхий билиг байх аль аль нь сайнгүй. Зарим үед бид арга, билгийг тохируулах хэрэгтэй. Ингэвэл амьдрал сонирхолтой, уйдахгүй болно.

Сударт номд бичсэнээр: Арьяабал бодьсадва бол нэн

эртний Бурхан юм, Вималакирти Их Багш ч бас эртний Бурхан, Шагжамуни Будда ч мөн тоолшгүй олон галавын өмнө Бурханы хутагт хүрсэн ажээ. “Богдосын ном цагаан лянхуа судар”-т Шагжамуни Будда айлдахдаа, тоост хорвоогийн маш олон төрөлхтөн, мөн газраас ундрах үй түмэн бодьсадваг бас гэтэлгэв гэжээ.

Газрын зүрхэн бодьсадва ч мөн нэн эртний Будда. Тэрээр үй олон хүмүүн төрөлхтөн, лус савдаг, ад чөтгөр, бодьсадваг гэтэлгэсэн. Гэвч “Газрын зүрхэн судар”-т тэмдэглэснээр тэр одоо болтол Будда болоогүй байгаа нь төрөлхтөнүүд бид түүнийг хохироож байгаагаас болжээ. Учир нь хамаг төрөлтөн тамд очих дуртай байдаг нь түүнийг дэндүү завгүй болгосон байна.

Бидний билиг ухаан хязгаарлагдмал тул судар уншсан ч олон зүйлийг чухам яаж тайлбарлахаа мэдэхгүй. Ойлгож чадвал тэр, ойлгохгүй бол бас яахав. Учир нь бурхны хүч сэтгэгдэшгүй их, тиймээс бид хэмжээ хязгаартай оюун ухаан, ертөнцийн үг хэлээр тайлбарлаж чадахгүй. Бидний ууараг тархи бол маш сайн компьютер. Гэвч ердөө л компьютер л төдий. Мэдэх зүйл нь хязгаартай. Бид энэ компьютерээр ертөнцөөс хэтийдсэн зүйлийг дүгнэж чадахгүй.

Миний таамгаар тэр эртний бурхад уйдаад ирэхээрээ энэ дэлхийд ирж шалган явж, бас жүжиг үздэг байж магадгүй. Бид гэртээ нөхөртэй, эхнэртэй, аавтай, ээжтэй, үртэй хүүхэдтэй. Амьдрал баяр хөөр, жаргал зовлонгоор дүүрэн. Бид ч хангалттай эдэлдэг. Гэсэн ч бид хааяа театрт очиж, кино үзэн бусдын жаргал зовлон, баяр гунигийг харах дуртай. Тийм биш үү?

Кино одоо ч хүмүүсийн сонирхлыг татсан хэвээр байна. Кино театр үргэлж дүүрэн хүнтэй байдаг. Бурхан бодьсадва хэдийгээр ариун оронд баяр баясалтай байдаг ч заримдаа бас баяр гуниг, жаргал зовлонг түр зуурхан амсаж

эдэлж болно.

Хэрвээ та нар надаас энэ дэлхийн төрөлтнүүдийг гэтэлгээд дуусах уу? гэж асуувал, гэтэлгэж барагдахгүй гэж Багш нь хариулна. Учир нь бүгдийг гэтэлгэчихвэл уйтгартай. Хааны ордон гайхалтай сүрлэг сайхан байдаг. Тэд бол хамгийн баян, хамгийн их эрх мэдэлтэй хүмүүс. Гэвч заримдаа тэд уйдаж, өөр тийш загасчилж, амрахаар явна, эсвэл энгийн ардуудын дунд орж, тэдний наадам зугааг сонирхоно. Учир нь тэд тайвширч, амьдралын өөр нэгэн хэв маягийг амсаж эдлэхийг хүсдэг.

Харин эгэл жирийн ардууд хаан болох их дуртай. Учир нь тэдний бодлоор хаан бол хамгийн сайхан ажил. Харин хаанд бол маш уйтгартай санагдаж, заримдаа энэ ажлаа солихыг хүснэ. Найралт төв хаан уйдвал энгийн ардын хувцас өмсөөд бяцхан аялал хийж, ард олны аж амьдралыг тандан явж, санаа бодлыг нь сонсдог байжээ.

Энэ нь улс орны байдлыг ойлгож мэдэхээс гадна энэ завшаанаар ордны гаднах баяр жаргалыг эдэлнэ. Учир нь хааны ордны амьдрал өдөр тутмын тогтсон хэмнэлтэй. Хэзээ босох, хэзээ ажиллах нь бүгд төлөвлөгдөнө. Түшмэдийн ээлж дараалан өргөх айлтгалыг хүлээн авч, дайн дажин, өлсгөлөн, бослого үймээн, хар шуурга, газар хөдлөлт гэх мэт улс орны их ажил хэргийн толгой өвтгөм мэдээллүүдийг сонсоно.

Тиймээс заримдаа хүнд ажлаас хэсэг зуур амсхийн холдож, энгийн ардын маягаар хувцаслаад уул, усаар аялдаг байжээ. Гэхдээ түүхийн номуудад түүнийг зугаа цэнгэл хөөцөлдөж явсан гэж огт бичээгүй. Харин ард түмний амьжиргааны бэрх хэцүүг ойлгож мэдэхээр явсан тухай тэмдэглэсэн байдаг. Зүгээр, энэ нь арай сонсоход сайхан аж, эдгээр түүхийг уншаад бид Найралт төв хаан бичил аялал хийж, ардын амьжиргааг тандан мэдэхээс гадна энэ

ертөнцийн баяр цэнгэлийг ч бас эдэлж явсныг олж мэдэв.

Будда болсон ч хооллож ундлана, амарч унтана

Намайг сая ингэж хэлэхээр, Будда болохыг хүсэх хүнгүй болчихов уу даа. Бас Будда болмоор байна уу? Уйдахаас айхгүй байна уу? Орчлонгийн хууль ийм байдаг. Хүн Бурханы хутагт хүрвэл хамаг төрөлтнийг гэтэлгэхээр бууж ирнэ. Энд хэтэрхий удвал бас уйдаж дахин нирваанд орно. Ингэж хүний хорвоо, диваажингийн хооронд ирж буцсаар байдаг.

Гэхдээ Будда болоод энэ дэлхийд үлдсэн ч эгэл хүний мэдрэмжээс өөр мэдрэмжтэй байдаг. Тиймээс бид хурдхан бясалгаж чөлөөгдөөд үхэж, төрөхийн сансрын хүрднээс мултарч, эрх чөлөөтэй болох хэрэгтэй. Өчнөөн зуун мянга, түмэн жилээр сансрын хүрдэнд ахин дахин эргэлдэн төрөл авч, мунхаг харанхуй явах хэрэггүй.

Нэгэн хүн Будда болсон ч мөн адил хооллоно, унтана. Гэхдээ эгэл хүний хооллох унтахтай адилгүй. Гаднаасаа ижил харагдах хэдий ч үнэндээ огт өөр. Бурхан, эгэл хүний үй олон ажлыг хийж, эгэл хүн мэт харагдавч түүний ажил үйл бүхэн хамаг амьтны тусын тулд байна. Бусдыг гэгээрүүлж, хамаг төрөлтний үйлийн үрийг угаан ариусгана. Түүний ажил харахад эгэл хүнийхтэй ижил ч үнэндээ огт өөр.

Зарим нэгэн номын багшийн ном айлдах нь бусад номын багшийн ном айлдахаас өөр байдаг. Ихэнх номын багш зөвхөн үг хэлээр ном айлдахаас хэтрэхгүй, хамаг төрөлтөнд ямар ч хүч өгч чадахгүй. Учир нь тэр өөрөө хүчгүй юм. Гэвч зарим номын багш ном айлдахгүй ч хамаг төрөлтөнд асар их тустай байдаг. Тиймээс үйлдэл нь ижил ч ач тус нь огт өөр.

Бид яагаад заавал Будда болох ёстой вэ? Хамаг төрөлхтөнд ач тустай байхын төлөө юм. Бид Будда болсны дараа юу ч хийсэн ачтай тустай. Юуг ч харсан ойлгоно. Цэцэг харвал гэгээрнэ. Оддыг ажвал, сарыг харвал бас гэгээрнэ. Хүнийг харсан ч гэгээрнэ. Хүн бүхнийг бурхан хэмээн харна. Маш их баяр жаргалтай, зүрх сэтгэл эрх чөлөөтэй, өөрийгөө хүлээслэхгүй болж, уурламаар зүйлгүй, атаархах сэтгэлгүй, бусдад гомдохгүй, надад яагаад ингэж хандана вэ, гэж бусдыг хардахгүй болно, ойлгов уу?

Тиймээс Есүс Христ: “Хүн бидний баруун хацрыг алгадвал бид зүүн хацраа тавьж өгнө” гэжээ. Учир нь түүний хувьд яасан ч адилхан, бүхий л үйлдэл бүгд ижил болохыг мэдэж болно, Түүнд ялгаварлах сэтгэл өчүүхэн ч байхгүй. Будда болсны дараа л бүхнийг ингэж тов тодорхой хардаг. Хэрвээ бид Будда болоогүй бол шунал хүсэл, уур хилэн, мунхагийн харанхуйдаа баригдаад хөдлөх аргагүй болтол баглагдсан байдаг. Тиймээс зарим хүн уурлавал гэдэс нь өвдөнө, атаархвал сэтгэл нь үзэн ядалтаар дүүрч, улмаар хавдар болдог. Эсвэл уур, шунал, мунхагаас болж, амиа хорлохыг хүснэ.

Зөвхөн бясалгаж чөлөөлөгдвөл бусад хүнийг чөлөөлөлтөнд дагуулж чадна. Хэрвээ чөлөөлөгдөх хүсэлгүй хүн байвал хамаагүй. Хүчлэх хэрэггүй. Харин чөлөөлөгдөхийг хүссэн хүнд бид даруй туслах болно.

Гуравдугаар бүлэг

АН ЗИ-ГИЙН БИЛИГ УХААН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Пиндүн.1988 оны 5 дугаар сарын 19
(Эх нь хятад хэлээр)

Бусдыг хүндэлсэн хүн үүрд хүндлэгдэнэ

Та нар бүгд Ан Зи-г мэдэх үү? Тэр бол Чи улсын хамгийн сайн гадаад хэргийн түшмэл. Нэгэн удаа тэрээр Чу улсад төрийн хэрэг хэлэлцэхээр очжээ. Чу улсын хаан, Ан Зи тун намхан биетэйг мэдэх тул энэ далимаар түүнийг тохуурхаж, Ан Зи-г нүүргүй болгоё гэж бодоод туслахуудаараа хотын хаалганы орчим нэгэн жижиг нүх ухуулжээ. Ан Зи-г ирэхэд хотын их хаалгыг нээж угталгүй, харин түүнийг ухсан нүхээр шурган орж ирээрэй гэв.

Ан Зи нохойн нүхээр орохгүй нь мэдээж. (Багш болон хүмүүс инээлдэв.) Чу улсын хаан элч илгээж, яагаад хэмээн асуулгажээ. Ан Зи: “Би хүмүүний улс гүрэнд айлчилж,

хүний сайнтай уулзахаар ирсэн. Нохойн улс оронд, нохойны хаантай уулзахаар ирээгүй тул нохойн хаалгаар орж чадахгүй” гэжээ. Ингээд Чу улсын хаан ичгэвтэр байдалд оров. Уг нь Ан Зи-г ичээхийг санаархсан ч өөрөө Ан Зи-д чадуулжээ. Чу улсын хаан туслахуудаа дуудан их хаалгаа нээж, Ан Зи-г оруулахыг тушаав. Хүн гэдгээ батлахын тулд тэд бүгдээрээ Ан Зи-д тун ч хүндэтгэлтэй хандаж гэнэ. (Багш болоод хүмүүс инээлдэв.)

Тэр улсын хаан уг нь анх хорон санаа өвөрлөөгүй, харин дэргэд нь зааж зөвлөх эрдэмтэй, үнэнч сайн түшмэд, зөв санаа хэлэх сайн санаатан дутсанаас ийм явдал болсон байна. Эртнээс нааш нэгэн улсын хааны эд баялаг их бага, улс орон нь том жижиг ямар ч байсан дэргэдийн их түшмэл нь билгүүн ухаантай бол тэр хаан агуу удирдагч болж, улсаа төвхнүүлж, ардаа жаргааж, түүхэнд нэрээ мөнхөлдөгийг түүх батална. Ертөнцийн явдалд ч цэцэн мэргэн, билиг ухаантны оролцоо, сайтар сэхээрсэн хүний тус дэм маш чухал. Бидний бясалгагч хүмүүсийн тусыг бол бүр яриад яахав. За одоо өмнөх яриагаа үргэлжлүүлье. Ан Зи-г Чу улсын хаанд бараалхахад тэр хаан дахиад түүнийг тохуурхахыг санаархав. Гэхдээ энэ нь түүний ноёдын санаа байжээ. Нэгэн ялтан хүнийг оруулж ирээд хаан түшмэдээсээ: “Энэ хүн ямар хэрэг хийсэн бэ? Аль улсын иргэн буй” гэж асуув. Түшмэд нь: “Энэ хүн Чи улсын иргэн болой. Хулгай хийсэн” гэж хариулав. Дараа нь Чу улсын хаан Ан Зи-д хандаж: “Танай Чи улсын иргэд зөвхөн хулгай л хийдэг хүмүүс үү?” гэв. Энэ нь Ан Зи-г нүүргүй болгох санаа байсан ч харин тэр: “Манай Чи улсын иргэд хулгай хийдэггүй. Яг л, жүрж өмнөд нутагт ургавал чихэрлэг сайхан амттай, харин хойд нутагт ургавал исгэлэн гашуун болдог нь газар нутаг, уул устай нь холбоотойн адил. Энэ Чи улсын иргэн Чи улсдаа бол хулгай үл хийнэ. Харин Чу улсад ирээд ийн үйлджээ!” гэж хариулав. (Багш болоод нийтээр инээлдэв.)

Дараа нь бүр илүү сонирхолтой түүх өрнөжээ. Чу улсын хаан нүүрээ барж дууссан ч бууж өгсөнгүй. Ан Зи-д их хүмүүний сүрлэг том бие байхгүй, тэр намхан нуруутай туранхай хүн байв. Хятад хүмүүс өндөр том, махлаг биетэй, сүрлэг төрхтэй хүнийг ухаантай, буянтай гэж үздэг. Харин туранхай намхан хүнийг буянгүй гэнэ.

Ан Зи тун намхан нуруутай, тиймээс Чу улсын хүмүүс түүнийг нохойн хаалгаар оруулахыг оролдсон. Одоо хаан нь түүнийг бас тийм нүдээр харж байна. Энэ бол хүнийг дорд үзсэн харц, хөлөөс толгой хүртэл гүйлгэн хараад дахин толгойнооос хөл хүртэл нь ажаад үл тоомсорлосон өнгөөр: “Хөөе, Чи улс хүнгүй болоо юу, тийм үү?” гэхэд Ан Зи: “Яагаад хүнгүй болох билээ? Манай улс хүн ихтэй, асар майхан баривал гишгэх зайгүй болдог. Бид дээл хувцсаа нийлүүлвэл тэнгэр газрыг ч бүрхэнэ! Манай Чи улсын хүн ам ийм их, яагаад хүнгүй байх вэ?” гэхэд Чу улсын хаан дахин: “Хэрвээ тийм их хүнтэй бол сайн хүн байхгүй гэж үү? Яагаад чам шиг ийм хүнийг нааш илгээв?” гэж асуужээ.

Ан Зи: “Манай улс гадагш элч илгээхдээ тухайн улсад нь тааруулж илгээдэг юм. Хэрвээ сайн улс бол сайн хүнээ илгээнэ. Хамгийн шилдэг улс оронд хамгийн шилдэг сайн хүнээ томилно. Харин доогуур дэсийн улс руу дорд дэсийн түшмэл илгээхэд л болно. Манай улсад сайн түшмэд тун олон. Тэднийг өндөр зэргийн, хөгжин цэцэглэсэн соёлтой улс орнууд руу илгээчихсэн. Хамгийн сүүлд үлдэж хоцорсон ганц хүн нь би. Наашаа явах хүн ч олдохгүй байв, тэгээд л намайг нааш нь илгээв” гэжээ. (Багш болоод хүмүүс бүгд инээлдэв.)

Бусдыг хүндлэх нь өөрийгөө ч хүндэлж буй хэрэг. Хүнийг ичээж зовоовол өөрөө ч бас ичиж зовно, өөрийгөө хорлоно. Хүн хийсэн бүхнээ амсаж эдэлдэг. Эртнээс нааших маш олон түүх нь ёс суртахууны тухай санааг агуулсан байдаг. Хятад хүмүүс энэ талаар маш сайн мэддэг. Учир

нь хятад орон бол эртний соёлтой, олон мянган жилийн түүхтэй, олон зуун жил үе дамжин ирсэн түүхэн сайн сурвалж бичгүүдтэй. Хятадын гүн ухаантнууд, бясалгагчид, жишээ нь, Лууз, Жуанз, Мози, Күнз гэх мэт. Тэднийг дэлхий даяараа мэднэ. Тиймээс бид эртний хүмүүсээс суралцах хэрэгтэй. Та нар хар л даа, Ан Зи ганцаархнаа, гэтэл бүхэл бүтэн Чу улсыг ичээж байна. Чу улсын хаан уг нь Чи улс болоод Ан Зи-г гутаахыг санаархсан ч эцэст нь Ан Зи мэхийг мэхээр хариулж, Чу улсын хааныг ичгэвтэр байдалд оруулжээ.

Нэгэн хүн хэрвээ их билгүүн ухаантай, авьяас чадвар төгөлдөр, өөрийн гэсэн өнгө төрхтэй бол эцэг өвгөдийнхөө яруу алдрыг дуурсгаж, үр хойчдоо буян хишиг дуудна. Түүний амьдрал, дүр байдал, ёс зүй нь олон түмэнд үлгэр дуурайлал болж, өөрийн гэр бүл, хот тосгон, улс орныхоо алдар сууг бадрааж, дэлхий ертөнцийг улам гэрэл гэгээтэй болгодог. Ан Зи ганцаархнаа өөрийн Чи улсыг бүхэлд нь дээш дэвшлүүлж чадсан юм. Хэрвээ бид муу үйл хийж, явдал мөр сайнгүй явбал эх орондоо тун ч таагүй нөлөө үзүүлнэ, тийм биз? Мэдээж тийм.

Ягчис ба “Баруун этгээдэд зорчсон нь” тэмдэглэл

Бид сайхан энергитэй газар амьдарвал эерэг сайн нөлөө хүртдэг. Харин нилээд харгис муу газар амьдарвал харгис догшин эрчим нь бидэнд бас халдана. “Баатар явагч их хөлгөн судар”-т Шагжамуни Будда айлдахдаа: “Хэрвээ тухайн газар оронд амьтны амийг маш ихээр хөнөөсөн бол амь хөнөөсөн маш хүнд үйлийн үр үүсэж, тэнд алж хөнөөх эрчмийн орон зай бий болно. Эрчмийн ийм орон зай нь үй олон ягчис, чөтгөрийг бий болгодог. Тэр ягчис чөтгөрүүд зөвхөн хүний мах л иднэ” гэжээ. Тиймээс үйлийн үр бол маш аймшигтай явдал.

“Баатар явагч их хөлгөн судар”-ын сүүлийн хэсэгт маш олон түүх бий. Энд аллагын талаар тусгайлан тэмдэглэж, мах идэхээс үүдэлтэй муу нөлөөллүүдийг дурдсан. Аллага нь орчныг бүхэлд нь сэвтээж харлуулна. Гэвч бидний махан нүдэнд үл үзэгдэнэ. Тэнгэрийн нүдэнд бол тов тодорхой. Бидний махан нүдний харах зүйл хязгаартай, бодьсадва заларсан ч танихгүй, чөтгөр ирсэн ч ялгахгүй.

Тансан лам бол алдар хүндтэй номын багш, одоо ч алдартай хэвээр байгаа. Тэр маш чухал хувь заяаны үүрэгтэй байжээ. Түүний ачлалд бид одоо ч талархах ёстой. Гэхдээ тэрээр ном залахаар явах үедээ эгэл хүн байсан юм. Тиймээс чөтгөрийг хараад мэдэхгүй, бурхан бодьсадва ирэхэд танихгүй байжээ. Тиймээс “Баруун этгээдэд зорчсон нь” зохиолд гарах маш олон түүхэнд бичсэнээр бол нүдний нь өмнө бурхан бодьсадвагийн хувилгаан бие заларсан ч танихгүй. Ямар нэгэн цагаан араг ясан чөтгөр, үнэгэн шулам үзэсгэлэнт хүний дүрд хувилан ирж саад тотгор хийвэл Тансан лам бас ялгахгүй байдаг. Харин ч тэдний амь насыг хөнөөлөө хэмээн Сүн Y күнийг зэмэлдэг.

Сүн Y күн хэдийгээр түүний шавь боловч тэнгэрийн мэлмий нь хэт нээгдсэн учир хэн нь бурхан, хэн нь чөтгөр шуламс болохыг харж чадна. Тэрээр баруун орноос дээдийн номыг залж, дэлгэрүүлэхийн төлөө чөтгөр шуламсуудыг хөнөөн устгадаг. Эцэст нь Тансан ламд зэмлүүлж загнуулаад хөөгддөг. Учир нь тэр үед Тансан лам их хөлгөний номыг хүртэж, Арьяабалын бясалгалын аргыг сураагүй байсан учраас тодорхой сайн харж чаддаггүй байжээ.

Энэтхэгт хүрч, Арьябалын бясалгалын аргыг сурсны дараа Тансан ламын цадиг хэсэгт тэрээр Shabd Vigya–г сурсан тухайгаа бичсэн байдаг. Shabd Vigya гэдэг нь аялгууны арга гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл Арьяабалын бясалгалын арга юм. Тансан лам үүний дараа л арай илүү сайжирч, олон зүйлийг ойлгож, илүү ихийг мэдэх болсон

байдаг.

Арьяабалын аргыг сурахаас өмнө бол Тансан лам хүч муутай, юм бүхэнд Бурхан бодьсадвагаас тусламж гуйдаг, асуудал үүсэх бүрт Арьяавал бодьсадва, Амитава Бурханаас тусламж хүснэ. Түүнд зөвхөн ийм л эрдэнэс байсан. Юу ч болсон шууд л Амитава Бурханы тарнийг маш хурдан уншина. Сүн Y күн байгаагүй бол Тансан лам баруун оронд хүрч чадахгүй байсан.

Тэр хоёрын нэг нь тэнгэрийн нүдтэй харж чаддаг, нөгөө нь “сохор” байснаас тун олон төвөгтэй байдал үүссэн билээ. Хэрвээ бид хараахан мэдэхгүй бол хэдийнээ мэдэж ойлгосон нэгэн хүнийг түшиж, түүний зааврыг дагах нь зөв. Хэрвээ бидэнд билиг ухаан байхгүй бол хэн билиг ухаантай байна, түүнийг хайж олоод түүнээс суралцах хэрэгтэй. Тэгвэл аажимдаа түүнтэй ижил болно.

Тиймээс “Богдосын ном цагаан лянхуа судар”-т Шагжамуни Будда айлдахдаа: “Будда тоост хорвоод мэндэлсэн нь Бурханы билгийг эгэл хүмүүст ойлгуулахын төлөө юм. (Бурхан бүхэн нэг л шалтгаанаар энэ дэлхийд заларсан, энэ нь бүхий л төрөлтөнд бурханы мэдлэгийг гэгээрэн ойлгуулахын төлөө)” гэж айлджээ. Бурханы билгийг ойлгох гэдэг нь гэгээрч, Бурханы хутагт хүрэх гэсэн утгатай. Учир нь Шагжамуни Будда: “Зөвхөн Будда л Буддаг ойлгоно” гэж айлдсан билээ.

Анхдугаар газрын бодьсадва, наймдугаар газрын бодьсадва аль аль нь Бурханы билгийг ойлгохгүй. Тэгэхээр эгэл хүмүүс бид бол бүр ч ойлгохгүй.

Тэгэхээр нэгэн сайтар сэхээрч гэгээрсэн хүнд хандах сайн, муу хандлага нь бидний билиг ухаанаас хамаарна. Хэрвээ бид нэгэн сайтар сэхээрсэн хүнд итгэж, түүнийг хүндлэн дээдэлж байхыг харвал бясалгалтай хүн: “Энэ

хүний дэс тун дажгүй юм” гэж бодно. Харин сайтар сэхээрсэн хүнд таагүй хандаж, хүчирхийлэгч, дорд хүний муу авир гаргавал биднийг тун доогуур дэстэй төрөлтөн болохыг хүмүүс мэдчихнэ. Энэ бол жам ёсны хэрэг. Тийм биз, үгүй юү? (Тийм гэж нийтээрээ хариулаад алга ташив.)

Өөрөө өөрийгөө гутаах мунхаг үйлдэл

Ан Зи-гийн түүхтэй ижил, хүн байгаа газар ирвэл мэдээж хүний зан төрхөөр, хүнийг хүндлэх ёсоор зочноо угтана. Харин нохойн ёсоор зочноо угтвал нохойноос л ийм үйлдэл гарна. Ан Зи-гийн ирсэн зорилго нь энх тайванч үүргээр, хоёр орны амар амгалангийн төлөө байв. Тэр ямар ч муу үйл хийхийг бодоогүй, гэвч зарим нэг хар санаатан түүнийг доромжлон гутаах бодолтой байжээ. Эцэстээ Ан Зи-гийн гэрэл гэгээтэй, бадрангуй байдлаас тэд өөрсдөө гутамшигт байдалд орсон байна.

Шагжамуни Буддаг ном дэлгэрүүлж байх үед зарим хүн эсэргүүцэж байсан. Тэр хүмүүс гадаад номтнууд байсан гэж сонссон. Тэд ид шидээр Шагжамуни Буддаг хорлохыг оролдож, муу сэдлээр хилс хэрэгт буруутгаж, нэр хүндийг нь унагахыг санаархаж байсан ч аль аль нь бүтээгүй. Тэд бас эмэгтэй хүнийг зорилгодоо ашиглаж, гэдсэнд нь түмпэн уяад жирэмсэн мэт болгож, хүүхдийг нь Шагжамуни Буддагийн хүүхэд гэцгээсэн. Эцэст нь луугийн биет ном хамгаалагч сахиусан хүүхний гэдсийг алгадаж, түмпэнг нь газарт унагаажээ. Үүнийг бүгд харж, тэр дороо бөөн инээдэм болжээ.

Бас нэг өдөр нэгэн хүн ирж, Шагжамуни Буддатай ном хаялцав. Шагжамуни Будда түүнээс гурав дараалан асуулт асуухад тэр ер хариулсангүй. Шагжамуни Буддаг дорд үзэж буй мэт байжээ. Гурав дахь удаа нь очирт ном хамгаалагч

түүнийг очирт ташуураар ороолгож үнс болгожээ. Учир нь түүний үйл нүгэл туйлын хүнд болсон байна. Хэрвээ тэр хүн тэнгэрийн мэлмийтэй, бясалгалтай байсан бол ийм муу үр дүн амсахгүй байсан.

Тэр өөрөө эгэл жирийн гаралтай гэдгээ мэдэхгүй, юм ойлгохгүй, мөн амьд сэрүүн заларч буй Буддаг гүтгэн доромжилсон байна. Тиймээс очирт ном хамгаалагч түүнийг жанчин хөнөөжээ. Шагжамуни Будда тэр очирт ном хамгаалагчаар үйлдүүлсэн бус, харин номоо хамгаалах нь очирт ном хамгаалагчийн үүрэг мөн юм.

Хэн нэгэн хүн Бурхан бодьсадвад хүндэтгэлгүй хандвал тэд ажил үүргээ заавал гүйцэтгэх ёстой.

Тэр хүн мунхаг учраас Шагжамуни Буддад хүндэтгэлгүй хандсан юм. Тэрнээс биш санаатай, эсвэл Шагжамуни Буддаг бурхан гэдгийг мэдсээр байж, түүний асуусан асуултанд хариулаагүй биш. Гэхдээ л тэр дэндүү мунхаг, дэндүү билиг ухаангүй байжээ. Будда Бурхан өмнө нь заларч байхад танихгүй. Бурхан Буддагийн өмнө нь суугаад Бурхан Буддагийн айлдсан номын айлдварыг сонссон ч номын учир шалтгаант агуулгыг ойлгохгүй, Бурханы өндөр дэсийн билиг ухааныг хүртэж чадахгүй, тиймээс Бурхан Багшид эргэлзэн үл итгэсэн төдийгүй Түүнийг гүтгэн буруутгажээ.

Үйлийн үрийг давах зам

Хүй Кэ-гийн хараахан гэгээрч амжаагүй байх үеийн түүх ч бас үүнтэй ижил. Хүй Кэ тэр үед эгэл хүн байв. Бодьдармаа бол гэгээнтэн хүн, энэ дэлхийд залран буй бодьсадва гэдгийг тэр мэдээгүй. Тиймээс Бодьдармааг эрихээр ороолгож, хоёр шүдийг нь унагажээ. Хэдийгээр мунхагийн эрхээр үйлдсэн ч хийсэн нүгэл нь байсаар байдаг.

Ойлгож мэдэхгүй бол юу дуртайгаа хийж болно гэсэн үг биш юм. Бурхан бодьсадва хэдийнээ гурван ертөнцөөс хэтийдэж, үйлийн үрийг давсан байдаг. Харин бид гурван ертөнцийг ч давж чадаагүй. Тиймээс гурван ертөнцийн дотор бидний хийсэн, үйлдсэн бүхэн гурван ертөнцийн эзэн, тэнгэрийн хаанд тов тодорхой бүртгэгдэнэ. Дараа нь бидний буян, нүглийг дэнслээд шагнана, эсвэл шийтгэнэ.

Хэрвээ үйлийн үрийн өр төлөөс байдаггүй бол Их Багш, бусад Бурхан бодьсадва нар залран ирэхийг хүлээх хэрэггүй. Ганц Шагжамуни Будда залрахад л хангалттай. Хүмүүс Түүнийг хараад шууд таньж, тэр бол Будда байна гэж мэдээд дагах юм. Тэгвэл бидний өвгө дээдэс аль эрт бүгд гэтлээд энд хэн ч үлдэж гэрлэхгүй, хүүхэд төрүүлэхгүй байсан. Бид ч өнөөдрийг хүртэл үхэж, төрөхийн хүрдэнд эргэлдэхгүй байв.

Тиймээс эгэл хүмүүс бид тун сэрэмжтэй байж, төрөлтөн бүхнийг Бурхан бодьсадва хэмээн үзэх ёстой. Гэвч ингэхэд бас тийм ч амар биш, гэгээрээгүй бол харж чадахгүй. Зөвхөн хүмүүсийн: "Төрөлхтөн бүхэн Бурхан бодьсадва мөн" гэж ярихыг сонсохоос цаашгүй, жинхэнээсээ ойлгох аргагүй юм. Тиймээс бид заавал бясалгах хэрэгтэй. Арьяабалын аргаар бясалгавал нэгэн өдөр хамаг амьтан бүгд бурхан чанартай болохыг жинхэнээсээ ойлгож чадна.

Одоо та бүхэн надаас бас: "Багш аа! Хүн бүхэн бурхан чанартай, хүн бүхэн Бурхан бодьсадва мөн. Гэтэл муу хэрэг үйлдэж буй хүн ч бас Бурхан бодьсадва бус уу" гэж асууж болно. Тэд бас Бурхан бодьсадва мөн, гэхдээ тэд өөрийн сайн чанарыг хараахан хөгжүүлээгүй, сайн багаж болж чадаагүй байгаа учраас Бурхан бодьсадва тэднээр сайн үйл хийлгэж болохгүй байна. Тиймээс тэднээр муу үйл л хийлгэнэ. Та бүхэн бас: "Бурхан бодьсадва тэднээр муу үйл үйлдүүлж байгаа бол үүрэг хариуцлагыг нь бас Бурхан бодьсадва үүрэх ёстой. Гэтэл яагаад муу үйл үйлдсэн тэр хүмүүсийг

шийтгэнэ вэ? Тэд бол мунхагийн харанхуйд төөрөгсөд юм" гэж асууж мэднэ. Яагаад гэдгийг Багш нь тайлбарлаж өгье. Энэ бүхэн бүгд үйлийн үрээс болдог. Бурхан бодьсадва биднээр муу үйл хийлгэсэн ч энэ нь орчлонгийн их хүчний орчил хөдөлгөөний төлөө юм. Энэ их хүч хүний хорвоод ч адилхан үйлчилж байдаг, тиймээс зарим хүн сайн үйл хийж, зарим хүн муу үйл үйлдэж байдаг. Гэвч муу үйл үйлдсэн хүн үйлийн үрээ заавал эдэлнэ. Учир нь үйлийн үрийн хууль маш нарийн бөгөөд тодорхой. Бид жүрж таривал жүрж хурааж авна, алим таривал алим хураана. Үүнээс өөр үр дүн байхгүй. Тэгэхээр бид хэтийдсэн номын аргаар бясалгаж, хэтийдсэн зам мөрөөр замнавал л үйлийн үрийн энэ хуулиас хэтийдэж чадна.

Их хөлгөний номын ёс

"Баруун этгээдэд зорчсон нь" зохиолд Арьяабал бодьсадва Тансан ламд хандан: "Их хөлгөний номын ёс төрөл төрөлд хураасан үйлийн үрийг угаан цэвэрлэнэ. Гамшиг бүхнээс гэтэлгэнэ. Өвчин болгоныг эмнэнэ" хэмээн айлджээ. Арьяабалын бясалгалын арга бол их хөлгөний номын ёс мөн. Яагаад Арьяабалын бясалгалын аргыг их хөлгөний номын ёс хэмээн нэрлэсэн бэ? Учир нь Тэр бол их зам мөртэй холбоотой. Арьяабалын бясалгалын аргаар бясалгавал сая тэр их зам мөрийг олно. Тиймээс түүнийг их хөлгөний ном гэдэг. Арьяабалын бясалгалын аргатай холбоотой, Арьяабалын аргаар бясалгахыг хөхиүлэн дэмжсэн аливаа судар бүхэн их хөлгөний судар мөн. Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийн айлдсан айлдвар бүхэн мөн их хөлгөний судар юм.

Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш их хөлгөний номыг уламжлах төдийгүй, их хөлгөний судрыг ч айлдана. Төгс Гэгээрсэн Их Багш ертөнцөд ном дэлгэрүүлж, хамаг

төрөлтний тусыг бүтээнэ. Харин Түүнийг их нирваанд орсоны дараа түүний ач буян, буян хишиг таван зуун жил хадгалагддаг байна. Таван зуун жилийн дараа Төгс Гэгээрсэн Их Багшийн эрчмийн талбай энэ дэлхийд оршихоо болино. Тиймээс энэ дэлхийгээс яваад нэн удсан Их Багш нарт бид залбирч даатгавал тийм ч их сүнслэг мэдрэмж төрөхгүй юм.

Өчигдөр та бүхэн Багшаасаа: "Есүс Христэд итгэхэд л хангалттай биш үү? Яагаад заавал Арьяабалын аргаар бясалгах ёстой вэ?" гэж асуусан. Есүс аль хэдийнээ буцчихсан. Одоо өөр нэгэн Христ ирсэн байна. Тиймээс бид энэ цаг үед залран ирсэн Христийг хайж олох хэрэгтэй. Христ гэдэг нь нэгэн номын ёс болно. Бурхны номын ёс, Их Багшийн номын ёстой яг ижил. Энэ номын ёсны хүч нь Арьяабалын бясалгалын аргын хүчтэй мөн ижилхэн. Есүс бол хүн. Христ бол нэрийдэл, Есүс энэ дэлхийд заларч байхдаа Христийн хүчтэй, Христийн номын ёстой байжээ. Тиймээс бид түүнийг Есүс Христ гэж нэрлэсэн юм.

Гэвч Христ хэн нэгний өмч биш, бас зөвхөн энэ цаг үед л байгаад дараагийн үед үгүй болохгүй. Христ бол номын ёстой адил олон үеийг туулж, олон улс оронд ээлжлэн байдаг. Зөвхөн Еврей үндэстэнд байсан биш. Багш нь энэ тухай олон удаа ярьсан. Одоо ч дахин хэлье.

Жишээ нь, нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш Формосад ном дэлгэрүүлвэл маш олон Формоса хүн түүний шавь болох нь гарцаагүй. Тэгээд олны дунд ихэд алдаршвал тун олон гадаадын хүн ирж, түүний шавь болно. Тэр гадаадын шавь нар эх орондоо буцаж очоод хичээнгүйлэн сайтар бясалгажээ. Эсвэл Формосагийн шавь нараас гадаад оронд очиж бясалгасан байна. Хожим Их Багш таалал болоход Формосад өндөр дээд дэстэй, хүч чадалтай гарамгай сайн шавь үгүй бол түүнийг залгамжилж, Түүний өмнөөс ном дэлгэрүүлэх хүнгүй болно. Тэгвэл Формосад тэр Их Багшийн номын ёс тасарна. Хэдэн зуун жилийн дараа Формоса

хүмүүс зөвхөн гэгээрсэн Их Багшийн хөргийг гэртээ залж шүтэхээс биш, жинхэнэ номын ёсоор хэрхэн яаж бясалгахыг мэдэхгүй болно. Ингээд шүтлэг нь яваандаа гаднах зүйлсэд дулдуйдсан нэгэн урсгал төдий болж хувирна.

Харин тэр гадаадын шавь нар, эсвэл Формосагаас гадаадад очиж бясалгасан шавь нар удаан хугацааны дараа бясалгаад гэгээрэлд хүрч, тухайн оронд үргэлжүүлэн ном уламжилна, эсвэл Формосад буцаж ирээд ном дэлгэрүүлнэ. Зарим нь Формосад буцаж ирэхгүй, зөвхөн гадаад оронд ном дэлгэрүүлж болно.

Эдгээр шавь, шавийн шавь нар Формосад эргэж ирээд ном дэлгэрүүлэхэд Формоса хүмүүс, тэр дундаа Төгс Гэгээрсэн Их Багшийн урьдын шавь нар харин ч бүр их эргэлзэнэ. Хэзээ ч Арьяабалын бясалгалын аргын тухай сонсож байгаагүй, Формосагийн эрхэм дээд ёс суртахуунтай олон мундаг лам хувраг, ийм олон их бясалгаач яагаад нэг нь ч Арьяабалын бясалгалын аргыг уламжлахгүй байна вэ? Энэ гадаад хүн энд ирж, юу хийгээд байна вэ? Эсвэл гадаадад амьдардаг хятадын харьяат хүн та юу яриад байна вэ? Бид чамд итгэхгүй байна гэцгээнэ.

Тиймээс номын ёс уламжлагдах эсэх нь хамаг төрөлтний билиг бясалгалын хүчээс бас хамаардаг. Харин нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш тухайн газар оронд ном дэлгэрүүлсэн, эсвэл түүний шавь нараас нь тухайн оронд үлдсэн, эсвэл шавийн шавь нар, тэдний шавь нар яг тэр газарт төрлөөс төрөлд ном дэлгэрүүлж байсан зэргээс болохгүй юм.

Эзэн хаан өөрийн суудлаа үр ач нартаа өвлүүлэн үлдээжээ, тэр үр хүүхэд, ач зээ нар нь улс орноо өвгө хаан шигээ сайн удирдан залж чадалгүй үеэс үед улам доройтуулжээ. Үүнтэй яг ижилхэн нөхцөл байдал. Хэрвээ шавийн дэс чадал улам бууraад байвал номын ёс цаашид

уламжлагдаж чадахгүйд хүрнэ. Тэгээд ч номын ёсны увдис дамжлага тээх хүн нь заавал Формоса хүн байх ёстой биш. Заавал нэгэн Формосагийн Төгс Гэгээрсэн Их Багшаас суралцана, Формоса хүн л жинхэнэ илтэд туулсан Бурханы хутагт хүрч чадна, гадаадын хүн чадахгүй гэж ярьж болохгүй. Заавал тийм байдаг биш юм. Хүн бүрийн бясалгалын нөхцөл байдал өөр, гэгээрэлд хүрсэн хүн орон бүхэнд заавал байдаг. Зөвхөн зарим нэг улсын хүн л гэгээрдэг тийм хязгаарлагдмал юм гэж байхгүй. Тиймээс түүхэнд гарсан, алдаршсан маш олон гэгээнтэн бүгд өөр өөр соёлын уламжлалтай, өөр өөр улс орны хүмүүс байсан.Тийм биш үү? (бүгд алга ташив)

Лууз, Күнз бүгд хятад хүн. Есүс Христ бол еврей хүн, Шагжамуни Будда бол энэтхэг хүн, Сократ бол грек хүн, тэд одоо ч маш алдартай. Бид зөвхөн тэдний төрсөн тухайн цаг үеийн талаар л уншсан төдий болохоос биш, илүү нухацтай бодоогүй байдаг. Төгс Гэгээрсэн Их Багш заавал манай нутгаас төрөх ёстой биш, бас заавал бидэнтэй нэгэн ижил үндэстэн байх ч ёстой биш. Энэ учрыг бид мэдэхгүй биш, мэднэ. Заримдаа хэн нэгэн хүн сануулбал бид сая сэргээн санана.

Багшийнх нь айлдсан ном яагаад та бүхний сэтгэлд нийцдэг вэ? гэвэл би ерөөсөө шинэ зүйл яриагүй. Миний ярьсан бүхнийг та нар бүгдийг мэднэ. Зөвхөн сануулан хэлж байгаа төдий. Тиймээс Багшийг яримагц та нар маш хурдан хүлээн зөвшөөрч байна. Учир нь та бүхний санал бодол Багшийнхтай адил, та бүхэн ч бас ижил хүсэл зорилготой байгаа хэрэг. Дотоодын билиг ухаан тань нэгэн ижил зүйлийг ойлгожээ. Та нар мэдэхгүй биш, бүгд мэднэ, зөвхөн мартсан төдий. Тийм ч учраас Багшийг яримагц зөвшөөрөн хүлээн авч байна. Учир нь та бүхний бодол Багшийнхтай ижил, сэтгэлдээ нэгэн ижил хүсэл тэмүүлэлтэй. Та бүхний билиг ухаан нэгэн ижил зүйлийг ойлгоно. Та бүхэн ойлгохгүй

биш, бүгд ойлгоно. Зөвхөн мартсан байна. Учир нь ижилхэн санаа бодолтой хүнтэй тааралдаагүй учраас өөрийхөө бодлыг буруу гэж бодож явжээ.

Дөнгөж сая тайзан дээр ахуй ойлголтоо ярьсан манай авшигтан Арьяабалын аргаар бясалгадаггүй байхдаа Буддад мөргөөд гэрэл харсан байна. Гэвч тэр гэрэл ямар учиртайг мэдэхгүй байсан гэнэ. Хэрвээ тэр үед Арьяабалын аргаар бясалгадаг байсан бол Багшаасаа асуугаад л мэдчих байлаа. Түүний гэрэл олж харсан нь нэгэн зүйлийн гэгээрлийн ахуй ойлголт юм. Жаахан гэгээрсэн гэсэн үг, Бурхан бодьсадвагийн адислалын хүч юм. Хэрвээ Арьяабалын аргаар бясалгадаггүй бол өөрийн мөн чанараа хөгжүүлж чадахгүй, тийм гэрлийг бас өдөр бүр харж чадахгүй, өдөр бүр Бурхны аялгууг сонсож чадахгүй. Тиймээс Арьяабалын бясалгалын арга нь гадны орноос ирсэн зүйл биш, бас Багш нь та нарт өгсөн зүйл ч биш. Та бүхэн угаасаа гэрэлтэй, угаасаа аялгуутай. Багш нь харин та бүхэнд хэрхэн хөгжүүлэх, яаж арчлах, Бурхан чанараа хөгжүүлж, гэгээрлийн хүчээ хадгалах, бүхнийг чадагч энэ их хүчийг яаж ашиглахыг л зааж өгнө. Бид өнчин ганцаардмал, тус дэмжлэггүй төрөлтөн байж болохгүй. Хүн бүхэн бүхнийг чадагч их хүчтэй, бурхан чанартай. Харин хэрхэн яаж ашиглахаа мэддэггүй бол мөнгө хөрөнгө ихтэй тэрбумтан байсан ч гуйлгачин шиг амьдрахтай ижилхэн юм.

Асуулт: Номын Багш сая “Баруун этгээдэд зорчсон нь” зохиолд Тансан лам ном залахаар явсан тухай, мөн Сүн Ү күний тухай ярилаа. Энэ бүхэн цөм уран сайхны дүр, үүнийг номын багш мэдэхгүй гэж үү?

Хариулт: Яагаад уран сайхны дүр гэж? Яагаад зохиомол гэж? Тансан лам байгаагүй хэрэг үү? (Байсан гэж нэгэн хүн хариулав) Та нар ойлгохгүй учраас замбараагүй юм асууж байна. Ү күн ч байна. Бажи ч байна. Шарой ч бас байна. Энэ бүхэн бүгд та бидний сэтгэлийн чанарууд юм. Энэ бол

Тансан лам ном залахаар явах үеийн түүний дотоод сэтгэлийн тэмцлүүд юм. Сүн Y күн нь түүний цэцэн сэргэлэн билиг ухаан, бүхнийг чадагч их хүчийг төлөөлж, тухай бүр Бурхан бодьсадвагаас тусламж, аврал эрж, асуудлыг шийдэж явдаг. Жу Бажи бол түүний залхуу хойрго зан чанарыг илэрхийлж, гоо үзэсгэлэнд автах, сайхан бүсгүйд сэтгэл татагдах, сайн хоолонд шимтэн дурлах зан чанарыг харуулна. Харин Шарой бол түүний тайван амгалан, тогтуун тэнцвэртэй, сайн, муугийн ялгалгүй болсон сэтгэлийн төлөв мөн. Та нар уншаад ойлгохгүй, тэгээд Багшаасаа ийм асуулт асууж зүрхэлнэ ээ?(Бүгд алга ташив.)

Дөрөвдүгээр бүлэг

“БАРУУН ЭТГЭЭДЭД ЗОРЧСОН НЬ” ЗОХИОЛЫН ДҮРҮҮД

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Хонгконгийн хоёр хоногийн даяан
1993 оны 10 дугаар сарын 1.(Эх нь хятад хэлээр)

Энэ “Баруун этгээдэд зорчсон нь” зохиолд бүхэлдээ бясалгалын дэс төвшин, бясалгалын урхи зангын тухай өгүүлдэг. “Баруун этгээдэд зорчсон нь” зохиолыг унших тусам энэ зохиогчийг би улам бишрэх болсон. Тэрээр хүмүүний амьдрал, бидний дотоод чанарыг дэндүү ойлгомжтой өгүүлж, бясалгалын замд тохиох олон янзын саад тотгорыг төрөл бүрийн зүйрлэлээр дүрслэн үзүүлсэн төдийгүй, тэдгээрийг давах бясалгалын аргуудыг ч бичжээ. Бид бясалгах тусмаа зохиолын утга санааг улам гүнзгий ойлгоно. Зөвхөн нэг үлгэрийн зохиол уншиж буй төдий зүйл биш. Энэ зохиолд жинхэнэ сайн, сургамжтай зүйлс бий. Арьяабалын аргаар бясалгаад уншвал бүр сайн ойлгоно.

Өөрийн жинхэнэ мөн чанараа үнэхээр үзнэ. Гэгээрнэ!

“Баруун этгээдэд зорчсон нь” зохиолд гарч буй Тансан лам бол сайхан сэтгэлтэй, хүндлэл хүлээсэн номын багш мөн. Харин түүний гурван шавь нь ямархуу улс вэ? Зүс царайгаар дорой, хүн ч хороож мэдэхээр. Жирийн хүмүүс тэр гурвыг харвал үнэхээр айж балмагдана. Гэвч Тансан лам айгаагүй төдийгүй, тэднийг өөрийн шавь болгодог. Тэр гурав Тансан ламыг нэгэн үзүүрт сэтгэлээр хамгаалан явж, бурхны маш олон судрыг амжилттай залж авчирдаг. Хэрэв энэ гурван муу шавь байгаагүй бол Тансан лам магадгүй баруун оронд хүрч чадахгүй байсан. Тэгэхээр юм бүхэнд өөрийн тус эрдэм бий. Хэрвээ бид орчлонгийн хуулийг ойлгож, бүтээгч эзний нууцлаг аргыг мэдвэл юуг ч хэрэгтэй зүйл болгон хувиргана. Хэрэгцээгүй зүйл нэгээхэн ч үгүй.

Сүн Y күн, Бажи, Шарой нарыг байдаггүй гэж бүү бод, тэд бол бидний дотоод олон чанарын төлөөлөл бөгөөд ном залах аяллын явцад Тансан ламын дотоод сэтгэлд өрнөж буй тэмцэлүүд юм. Сүн Y күн бол Тансан ламын цэцэн мэргэн билиг ухаан, бүхнийг чадагч их хүч чадлын төлөөлөл, тэр тохиол бүрт Бурхан бодьсадвагаас тусламж хүсч, асуудлыг дор бүр нь шийдэж явдаг. Харин Бажи бол түүний залхуу хойрго, гоо үзэсгэлэнд дурламтгай зан чанарын төлөөлөл болно. Заримдаа сайхан хүүхэн харвал сэтгэл догдолно, сайхан хоол таарвал баясан хүртэнэ. Шарой бол Тансан ламын амгалан тайван, тэнцвэртэй, сайн, муугийн ялгал үгүй болсон тэр төлөв юм.

Зохиолд Сүн Y күнийг цэцэн сэргэлэн нь дэндсэн, 72 янзаар хувилах шидтэй гэж гардаг. Гэгээрэхээсээ өмнө тэнгэрийн орныг түйвээж, өөрийгөө “Тэнгэртэй чацуу их богд” хэмээн өргөмжилж байжээ. Үүгээр бидний дотоод дахь тэмцэгч чанарыг харуулсан байна. Хэрвээ Тэнгэрийн хаантай эн зэрэгцэхээр агуу юм бол түүний орныг түйвээх хэрэг юу байна? Бид дотооддоо Эзэн Бурханы чанартай,

хамгийн дээд нь гэдгээ мэддэг ч Бурханы хутагт хараахан хүрээгүй учир өөртөө итгэхгүй, өнөөдөр итгэсэн ч маргааш нь эргэлзэнэ. Нөгөөдөр ахин итгэсэн ч дараа өдөр нь бас үгүйсгэнэ.

Бид тэр нэг өдөр гэгээрч, өөрийн хэн болохыг мэдэж, үнэхээр эрхэм ариун, тэнгэр газар, түмэн бодистой нэгдмэл нэг болохыг ойлгож мэдэрнэ. Гэвч энэ хорвоогийн амьдрал зовлонгоор дүүрэн, аль нэг өдөр бидэнд олон саад, их бэрхшээл тулгарвал эгэл хүний дэс рүү унадаг. Өөртөө эргэлзэж, дэндүү сул дорой, тус дэм болох юу ч үгүй, ямар ч хүч чадалгүй санагдана. Энэ үед их л бухимдаж, биднийг Бурхан, Дээд төрөлтөн гэж хэлсэн ч сонсохгүй. Өөртөө итгэх итгэл бүрмөсөн үгүй болдог.

Сүн Y күний тэр ахуй ойлголтууд Арьяабалын аргаар бясалгадаг хүмүүст ч бас бий. Тийм учраас бид өдөр бүр асуудал, тэмцэлтэй байдаг. Заримдаа гэгээрч, бурхан болмоор, заримдаа гэгээрмээргүй санагдана. Зарим өдөр бурхан болж чадна, зарим өдөр чадахгүй. Заримдаа бурхан, заримдаа чөтгөр болно. Ингэж янз бүр болж байгаа нь Тансан ламын дотоод сэтгэлийн тэмцэл юм. Зохиолч, бидний оюун бодлын тогтворгүй байдлыг сармагчинтай зүйрлэжээ. Гэвч энэ сармагчин үнэхээр цэцэн сэргэлэн, маш их ид шидтэй, хүссэн бүхнээ авдаг, хүссэн ертөнцдөө хүрдэг ч энэ нь зөвхөн сэтгэлийн хүрээнээс хэтрээгүй, гурван ертөнцийг даваагүй байдаг.

“Баруун этгээдэд зорчсон нь” зохиолыг уншихад Сүн Y күн Тансан ламыг дагаж баруун орноос ном залахаар яваа нь хамаг төрөлхтөнийг аварч гэтэлгэхийн төлөө байв. Гэтэл Бурхан, Бодьсадва нар тэдэн рүү үй олон чөтгөр шулам явуулж, үргэлж хорлоно. Есөн мянга есөн зуун наян нэгэн гамшиг бүхнийг бүгдийг Бурхан бодьсадва зохиосон байна. Энэ нь юуг илэрхийлж байна вэ? Учир нь сорилт шалгалтгүй бол бид өсөж хөгжихгүй. Яг л цэрэг хүн дасгал сургуулилт

хийхгүй бол сайн цэрэг болохгүй, сурагчид шалгалтгүй бол шамдан сурахгүйтэй адил. Тиймээс сорилт шалгалт бидэнд тун хэрэгтэй. Өөрийнхөө хэр дэвшиж хөгжсөнийг, итгэл сэтгэлээ ганхсан эсэхийг олж мэднэ.

Тэд Багш, шавь хэдүүлээ заримдаа цэцэг жимс, мод бутны сайханд татагдаж, эсвэл уул, усны эздэд хорлогдож байхыг бид зохиолоос унших даг. Энэ нь яг л Багш нь гадаад ертөнц та нарт аюултай, маш осолтой байдгийг сануулдаг шиг, бидний үзэж харах зүйл ихсэх тусам улам автаж, мөн чанараа мартдаг. Ийм үед тухайн зүйлд маш амархан автана. Яг л бид амьдардаг газраа дасвал өөр тийшээ явах хүсэлгүй болдог, очсон ч тэндээ амарч унтаж чаддаггүй шиг.

Үүнтэй адил, бясалгагч хүн зарим нэг очсон газар орондоо үлдмээр санагддаг. Уг нь Бурханы ном залж, Буддагийн хутагт хүрэх зорилготой боловч сүүлдээ тэр нутгийн сүрлэг сайхан уул ус, үзэсгэлэнтэй мод ургамал, дэлгэрч дэлбээлсэн цэцэг, жимсийг хараад найдангуйрч үлдэхээр шийдэн: “За за! Ер нь Бурхан болж юугаа хийх вэ? Энд сайхан уул ус, цэцэг ногоо харан баясаж, дуу шүлэг зохион уншиж сууя!” гэж бодно.

“Баруун этгээдэд зорчсон нь” зохиолд заримдаа модны савдаг, цэцгийн савдаг гарч ирээд Тансан ламыг уруу татдаг, тэр ч хариугүй автах дөхөхийг бид харна. Үнэндээ савдгууд уруу татаагүй, харин Тансан лам өөрөө байгалийн сайханд дурласан байдаг. Тэр өөрөө сэтгэл татагдах нь мод, цэцэгт хүлээслэгдэхтэй ялгаагүй. Тэгээд ч мод чулуу, цэцэг ногоо бүхэн сүнстэй. Хэрвээ бид тэднийг сонирхвол бидэнтэй холбогдоно. Таашаан сонирхох тусмаа бид улам хүлэгдэнэ. Ингээд бидний дэс тэдний төвшинд гацдаг юм.

Бидний бясалгал хаа нэгэн газар зогсонгишиж болохгүй, үргэлж дээшээ дэвшиж байх ёстой. Тиймээс гадаад ертөнцийг сонирхох нь аюултай гэдгийн учир нь энэ.

Сүн Үүн бол бидний нилээд хурц мэргэн оюун ухааны төлөөлөл. Хэдийгээр сэрэмж алдан Тансан ламын эгэл хүний дадал зуршлыг дагаад аюул гамшигт өртдөг ч тэр бол Сүн Үүн. Эрт орой хэзээ нэгэн цагт заавал мултран гардаг. Удаан живэхгүй. Хэрэв Бажи байсан бол живээд алга болно! (Багш инээв.)

Нэгэн удаа Бурхан бодьсадва маш үзэсгэлэнтэй гурван охин болон хувираад Бажи дээр ирдэг. Тэр мэдэлгүй, бүсгүйчүүдийн гоо үзэсгэлэнд автаж, занганд ордог. Хэдийгээр хорлогдож сүйд болоогүй ч нэг хэсэг л тэдэнтэй зууралдсан.

Хүлээс гэж чухам юу вэ? Хэдийгээр тухайн хүн үнэхээр үзэсгэлэнтэй, эсвэл Бурхан бодьсадвагийн жинхэнэ хувилгаан байсан ч түүнд дурлавал хайр сэтгэлийн урхинд бас л орно. Уг нь баруун оронд хүрч Бурханы ном залахаар яваа хүн шүү дээ. Гэтэл тэнд саатсан нь бүсгүй хүнийг хайрлахын төлөө байв. Энэ нь мэдээж чиний бясалгах цаг хугацааг удаашруулна. Тиймээс Бурхан бодьсадвагийн хувилгаан байсан ч бид тоох хэрэггүй. Энэ нь дээр. Бясалгалд сонор сэрэмж маш чухал. Тун сайн хүн, үнэхээр сайхан бүсгүй гэгчид, эсвэл ертөнцийн сайн сайхан ажил үйлд бүү хүлэгд!

Нэгэн удаа Тансан лам аалзны үүрэнд хашигддаг. Аалзнууд гэр дүүрэн хүүхэдтэй үзэсгэлэнт бүсгүй болон хувираад Тансан ламыг хүлээслэв. Үүгээр гэр бүлийн ойлголтыг харуулсан юм. Тэр үед Тансан лам: “Ерөөсөө гэр бүлтэй болъё, Бурханы ном залж ирэхийн төлөө ингэж зовж зүдрээд яахав, эхнэр авч, хэдэн “хөөрхөн үйлийн үр” төрүүлье, энэ ч бас зүгээр явдал” гэж бодсон байж магадгүй. (бүгд инээлдэв) Ийм санаа төрсөн тэр агшинд л тэнд хүлээслэгдэнэ. Үнэндээ хүлээслэх эхнэр, хүүхэд дэргэд чинь байхгүй ч энэ тухай бодохын зуурт аль хэдийнээ тэдэнд хүлэгдээд дэс чинь ч өөрчлөгддөг.

Тэгээд энэ бодолтойгоо хэр удаан зууралдана, тэр бүх хугацаанд ийм төвшинд л гацна гэсэн үг. Яг үнэндээ энэ нь том, жижиг аалзан чөтгөрүүдийн бэлдсэн урхи занга биш, харин тэр өөрийнхөө бодлын бүтээлд хүлэгдсэн юм. Бясалгал гэгээрлийн урт холын замд үүсэх сэтгэлийн янз бүрийн төлөв байдлаас зайлсхийх аргагүй. Зохиогч эдгээр түүхээр Тансан ламын сэтгэлийн үйлийг илэрхийлж, тэдгээр барцад саадыг давахын тулд түүний дотоодод болсон олон янзын өрнөлийг хүүрнэн өгүүлжээ.

Бас нэгэн араг ясан чөтгөр тун үзэсгэлэнтэй хүний дүрээр хувилан ирж, хүмүүсийг уруу татаж, тэдний цусыг сордог. Энэ араг ясан чөтгөр гэж хэн бэ? Энэ бол бидэнд байдаг чөтгөрлөг чанар, эмэгтэй хүний гоо зүсээр бусдыг уруу татдаг тэр чанар юм. Иймээс эртний бясалгагчид заримдаа өөрийн дур хүслийг хянахын тулд араг яс ажих бясалгалаар харсан хүн бүхнээ хувхай ясанд хувирган хардаг. Энэ ч бас буруугүй. Хэрэв чи сайхан эмэгтэй, сайхан залууг нэвт харвал түүний дотор бас хувхай яс, араг яс байхыг ойлгоно.

Арьяабал бодьсадва Сүн Y күнийг мэхэлж байгаад толгойд нь Алтан цагариг өмсгөхийг хараад бид: “Арьяабал бодьсадва яасан энэрэх сэтгэлгүй вэ?” гэж гайхаж магадгүй. Гэвч түүнийг хянах арга үүнээс өөр байхгүй, түүнд тусалж, сургаж хүмүүжүүлэхийн түлд заавал Алтан боодос өмсгөх хэрэгтэй. Ингэхгүй бол түүний ааш зан өөрчлөгдөхгүй, бясалгаж гэгээрч чадахгүй. Тиймээс Бурхан бодьсадва дандаа сайхан аашилж, чихэр жимс өгөөд байдаггүй юм. Ингэх нь чамайг эрхийн тэнэг болгож, тийз бэлгэлээд там руу нисгэснээс өөрцгүй!

Одоо энэ түүхэн зүйрлэлүүдийг ойлгов уу? Бидний дотор гахай, сармагчин чанар бий. Чи амьтдыг хар даа, тэд ч бас идэж ууна, үр төл төрүүлнэ, тэднийгээ асарч халамжилна. Бидэнтэй яг адил. Тиймээс хэрвээ бид бясалгадаггүй бол

амьтнаас ялгарах юмгүй. Азаар бид бясалгалтай, билиг ухааны хөгжилтэй. Амьтдад хүн шиг олон зүйлийг ойлгож мэдэх арга ухаан байхгүй. Тиймээс та бүхэн өөрийн гурван эрдэнийн газрыг сайтар нандигнаж (Багш билгийн мэлмийгээ заав.), энэрэн нигүүлсэх сэтгэлийн чанараа тэтгэн хөгжүүлээрэй. Өдөр тутмын амьдралаа өөрийн гахай, сармагчин чанараар удирдуулж, эрхэм ариун “гэр орон”-оо бүү бохирдуулаарай!

Тавдугаар бүлэг

БЯСАЛГАЛ БҮТЭЭЛИЙН ЗАМ ДАХЬ АД ЧӨТГӨРҮҮДЭЭС БОЛГООМЖИЛ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шихү ашрам. 1991 оны 8 дугаар сарын 1
(Эх нь хятад хэлээр)

Та нар хар даа, Тансан ламыг очсон газар бүрт түүний махыг идэхээр ад чөтгөрүүд дайрч байдаг. Үнэндээ түүний махыг хэсэглэж хэрчээд иднэ гэсэн үг биш, харин бидний оюун санааг хүчирхийлж, идэж ууж, унтаж амарч чадахгүй, тэсч тэвчихийн аргагүй болгож, улмаар бие махбодыг хүчгүй, сул дорой болгох нь махыг нь идсэнээс ялгаагүй гэсэн санаа юм. Учир нь хүний оюун санааг хүчирхийлэх нь бас нэг төрлийн хорлол мөн.

Зарим ад чөтгөр хүний амин эрчмийг сордог, хүн эерэг эрчим ихтэй байх тусам сөрөг эрчимт ад чөтгөрүүд улам дуртайяа сордог. Хэт их соруулснаас болж бидний

оюун ухаан самуурна. Зарим хүн харахад хүн ч гэлээ дотроо дүүрэн ад чөтгөртэй. “Баруун этгээдэд зорчсон нь” зохиолд гардаг цагаан араг яст чөтгөр, хүний амин эрчмийг ховх сорж үхүүлээд биеийг нь эзэлдэг. Дараа нь хүмүүсийг уруу татахаар гарч явна. Бид гаднаас нь хараад ялгахгүй.

Тиймээс ад чөтгөрт эзлэгдсэн хүмүүсийн бие нь хүн, доторх нь чөтгөр байдаг. Ийм хүнтэй бид ойр байвал хамаг бие суларч үлбийнэ. Тэгээд дараа нь бүх зүйл өөрчлөгдсөн байдаг. Хэрвээ бид түүнд хуурtвал өөрийн мөн чанарыг улам гээх болно. Миний анзаарснаар, адад эзлэгдсэн зарим хүн эргэж ирэхдээ маш их өөрчлөгдсөн байдаг. Гэмшсэн ч ялгаагүй. Тэд үнэхээр өөр болсон байдаг. Эргэж хэвэндээ ороход маш их хугацаа хэрэгтэй болно. Тэр өөрөө ч энэ бүхнээ мэдэхгүй байж магадгүй. Яг л унтсан хүн унтаж буйгаа мэдэхгүй, согтсон хүн согтуугаа мэдэхгүй, галзуурсан, эсвэл сэтгэцийн өвчтэй хүн ийм өвчтэйгээ мэдэхгүй байдаг шиг.

Заримдаа, энгийн хүн жаахан сэрэмж алдах, эсвэл муу муухай бодол хэт бодсон үедээ ад чөтгөрт амархан ашиглагдана. Махбодод нэвтэрч орсон ад чөтгөр хүний биеийн нэг хэсгийг харлуулан бохирлож, биднийг хүн, чөтгөрийн холимог болгодог. Ингээд бидний үйл хөдлөлийг этгээд гаж болгон санаа бодлыг хувирган өөрчилж, өмнөхөөс өөр үйлдлүүдийг хийж эхэлнэ. Үнэхээр аймшигтай! Тиймээс бид цаг үргэлж бие, хэл, сэтгэлээ цэвэр ариун байлгаж, элдэв муу зүйл бодохгүй байх хэрэгтэй. Хэрвээ хар санаа, муу бодол ихэсвэл удалгүй тун их яршиг төвөг гарна.

Учир нь бид бүгд чөлөөтэй байх эрхтэй. Багш нь та нарын бодол санааг үргэлж хянаж чадахгүй, юу бодох нь таны эрх, тиймээс өөрөө өөрийгөө сайтар анхаарч, хянуур байх хэрэгтэй. Надаас хамгаалалт хүссэн тэр үед л Багш нь та нарт тусалж чадна. Харин хүсээгүй бол би тусалж болохгүй. Та бүхэн тусламж хүсэхгүй байж болно, хамаагүй, харин Багшийг л эсэргүүцэхгүй байх хэрэгтэй. Хүмүүсийн юу

хүсэх нь чөлөөтэй байдаг. Хэрвээ тэд Багшийг эсэргүүцвэл Багш нь ч, Бурхан бодьсадва ч хөндлөнгөөс оролцох аргагүй болно. Орчлонгийн хууль нь ийм. Тийм учраас дэлхий ертөнц одоо ч эмх замбараагүй хэвээр байна. Хэрвээ Бурхан бодьсадва бидний оюун ухаанд хөндлөнгөөс бүрэн нөлөөлж болдог бол ямар ч асуудалгүй байх байсан. Гэвч ингэх нь бас ямар ч тоглолтгүй, зовлонгүй, жаргалгүй, ялгамжаатай дэс төвшингүй болгож, бид бүгд Төгс баясгалант оронд хүргэгдчихнэ!

Тиймээс бясалгалыг өөрөө л хийнэ, гэрлийг өөрөө л асаана, зам мөрийг өөрөө л туулна гэдгийг ойлгох хэрэгтэй. Харин өвдөж, явж чадахгүйд хүрвэл Багш нь мэдэж үүрч дүүрээд авч явна. Харин бид өөрөө эсэргүүцээд эсрэг зүгт явбал Багш нь чамайг дагаж явахаас цаашгүй. Явах тусмаа холдоно гэдгийг чинь мэдэж байдаг ч дагаад л явдаг. Та нарыг орхиж болохгүй, гэхдээ бас хөндлөнгөөс оролцож болохгүй.

Бясалгалд сонор сэрэмж хэрэгтэй, ад чөтгөр тун их шүү! Баруун орноос ном залахаар явахад л ад чөтгөр таардаг юм биш. Бид ч бас эндээ өдөр бүр баруун орноос ном залахаар явдаг. Зам нь Энэтхэг орохоос ч хол, бид тун их зүдэрч туулдаг. Хүн бүхэнд унах үе бий, гэхдээ эргэж босохоо мэдэж байвал зөвдөнө. Унахын цагтаа, биднийг дээш татсан тэр нэгэн хүнийг эсэргүүцэж болохгүй гэдгийг мэдэх хэрэгтэй. Ингэвэл бидэнд учрах аюул осол арай бага. Унасан ч тэндээ залхуураад суух хэрэггүй, бас зориуд өөрийгөө уруудуулж доройтуулаад би тун сайн гэх ч бас хэрэггүй.

Зургаадугаар бүлэг

ИД ШИД БА ИХ БИЛИГ УХААН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шинжү хот, Зам тээврийн их сургууль
1988 оны 4 дүгээр сарын 2. (Эх нь хятад хэлээр)

Ид шид бол балчир хүүхдийн нааддаг тоглоом наадгай

Өчигдөр нэг хүн Багшаас нь та бидэнд жаахан шид үзүүлж болох уу гэж асуусан. За, өнөөдөр шид үзэх хүн байна уу? (Байна гэж зарим нь хариулав) Үзэх нь гараа өргөөрэй? Гараа өргө гэхээр өргөж зүрхлэхгүй. Хэрвээ хүсэх хүн олон бол шид үзүүлж болно. Яг одоо гараа өргөсөн хүний тоо ердөө талд нь ч хүрэхгүй байна, тэгэхээр би больё доо. (бүгд инээлдэв)

Шид үзүүлэх асуудалгүй. Энэ бол ердөө л балчир хүүхдийн нааддаг тоглоом. Багш нь байнга шид үзүүлье гэж боддоггүй. Багш нь шидтэйг мэдэх хүн тун олон. Гэхдээ би энэ талаар хэзээ ч ярьж байгаагүй. Багш нь ямар нэгэн шид

хэрэглээгүй ч Багш шидгүй гэж хэлж бас болохгүй. Шидгүй байх нь хамгийн том шид мөн. (Бүгд алга ташив.)

Ийм байвал та нартай адилхан болох бус уу, та нар ч шидгүй шүү дээ. Ижил, гэхдээ бас ижилгүй. Хэдийгээр Багш нь шидгүй ч Багштай нь уулзахаар ирсэн ямар ч хүн хүссэнээ хүртээд сэтгэл хангалуун буцдаг. Харин та нартай уулзвал юу ч хүртэхгүй байж магадгүй. Ялгаа нь энэ. Гэхдээ Багш нь тэр хүнд зориуд юм өгөөгүй, тэр юу хүсэж ирсэн, түүнийгээ аяндаа хүртжээ. Багшид хамаг байдгаа бас ярих хэрэггүй.

Эртний Мэн Чанжүнийг тун өгөөмөр хүн гэж бид сонссон. Тэр их баян, олон дагалдагчтай, удирдагч хүн байв. Олон мянган хүнийг тэжээж байсан гэдэг. Хүмүүс бүгдээрээ тэднийд очиж хооллоно. Тэр хүмүүс хооллож дуусаад явна. Түүнд таархлаа илэрхийлэх ч хэрэггүй. Бас ирсэн явснаа ч хэлэх шаардлагагүй. Хэн хэн ирснийг тэр мэдэхүй. Учир нь их, бага түшмэд, ядуус, гуйранчид, баячууд гээд олон янзын хүн өдөр бүр орж гарна. Тэр хэнийг ч алаг үзэж ялгаварлахгүй, ирсэн бүхнийг хүлээн авна.

Бурханы хүч ч адилхан, ирсэн бүхэн хүртэх юмтай, гэхдээ Багш нь мэдэх шаардлагагүй, олж хүртсэн хүн ч Багшид нь дуулгах хэрэггүй. Зөвхөн Багшийг даган суралцвал олж хүртэнэ гэсэн үг бас биш. Багш нь ном айлдах бүрт заавал нэг хүн тайзан дээр гарч, ахуй ойлголтоо хуваалцдаг. Багшийн хувилгаан бие гэрт нь ирж, хэрхэн адисалсныг ярина. Өнөөдөр ахуй ойлголтоо ярьсан тэр хүн авшигтан биш. Миний бодлоор, ийм жижиг сажиг зүйлийг ярих хэрэггүй. Ийм түүх тун олон, яривал мөд дуусахгүй.

Багш нь яагаад ийм зүйлсийг ярих дургүй вэ? Учир нь, хүмүүс шидийн хүчээр өвчин анагаахын төлөө авшиг хүртэхийг би хүсэхгүй. Багш бол хамаг төрөлтнийг аварч, сүнсийг нь чөлөөлдөг. Харин махан биеийн тухайд бол

байгалийн жамаа дагах нь зөв. Эдгэх эсэх нь тухайн хүний буян, нүглээс хамаарна. Зарим нь хурдан, зарим нь маш удаан эдгэрнэ. Өөрийн дотоодод хурдан түргэн эдгэрэх хүсэл байгаа эсэхээс бас хамаарна.

Зарим хүний далд ухамсар нилээд хүчирхэг, эдгэрэх хүсэл нь бүхнээс хүчтэй бол өөрийгөө авардаг. Зарим нь далд ухамсрын хүч муутай, өөрөө ч эдгэх хүсэлгүй. Зарим нь эдгэх хүсэлгүйгээ өөрөө ч мэдэхгүй. Бүр үнэхээр өвдөх дуртай хүн ч бас байдаг. Өршөөгөөрэй, энэ бол үнэн байдал. Өвдвөл хүмүүс намайг тайтгаруулна, өрөвдөнө гэх мэтээр бодно. Гэхдээ энэ бүхэн бол шалихгүй зүйл, их яриад яахав.

Багш нь сая та нарт яагаад хүч чадлаа үзүүлсэнгүй вэ? Мэдэх хүн байна уу?(Үзүүлэх шаардлагагүй гэж зарим нь хариулав.) Тэд харахыг хүссэн тул заавал үзүүлэх хэрэгтэй. Гэхдээ Багш нь үзүүлж болохгүй. Учир нь эгэл хүний шунахай сэтгэл угаасаа маш хүнд, эд зүйлийн шунал ч бас яахав, ид шид горилсон шунал хамгийн аюултай.

Эрхэм ариун хүсэл мөрөөдөл хамгийн чухал

Сүн Ү күн далан хоёр янзын шидтэй, дээшээ диваажинд, доошоо тамд очдог. Бас олон зүйлийг хувилгаж чадна. Гэсэн ч Их Багш Тансанд тэр заавал үйлчлэх ёстой. Их Багш Тансан мөн Арьяабалын аргаар бясалгаж байжээ. Гэвч “Баруун этгээдэд зорчсон нь” зохиолд Тансан лам ид шидтэй байсан тухай дурдаагүй. Түүнд ад чөтгөр ч бурханаас ялгаагүй. Тиймээс Сүн Ү күн ад чөтгөрийг шийтгэх болгонд Тансан лам маш хурдан түүний толгойн боодсыг багасгах тарни уншиж өвтгөдөг. Учир нь тэр, Сүн Ү күнийг амь хөнөөхөд дургүй. Эгэл жирийн хүний амийг хөнөөв хэмээн бодно. Үнэндээ тэр нь хүн биш чөтгөр гэдгийг зөвхөн Сүн Ү күн л мэднэ. Гэвч багш нь мэдэхгүй учраас Сүн Ү күнийг

шийтгэдэг.

Сүн Y күн асар их шидтэй, тэнгэрийн мэлмий нь маш их нээгдсэн хэдий ч Тансан ламын шавь байх ёстой байжээ. Учир нь Тансан лам эрхэм дээд хүсэл зорилготой, маш чухал үүрэг даалгавартай хүн. Энэтхэг орноос билгүүн ухааны ном судар нэн ихийг залж, бурхны номыг дундад улс даяар ойлгож мэдэхэд туслах нь Тансан ламын эрхэм ариун үүрэг байсан юм.

Сүн Y күн ид шидтэй, хүч чадал ихтэй ч тун өчүүхэн зорилготой. Ердөө л үйлийн үрээ цэвэрлэж, чөлөөгдөж аврагдах хүсэлтэй төдий. Олон янзын шидээр наадаж чаддаг ч түүнд эрхэм ариун хүсэл зорилго байхгүй. Хүмүүсийн үнэ цэнийн ялгаа энд л байдаг. Эртнээс нааш бүхий л их бясалгагч хамаг амьтны төлөө өөрийгөө зориулах ёстой, бусдын төлөө өөрийгөө золиослохын хэрээр хүний чанар ариусаж байдгийг онцлон сургасаар иржээ. Бурханы шашинд үүнийг бодьсадвагийн замаар замнах гэнэ.

Гэхдээ энэ нь хүчээр хийдэг зүйл биш юм. Заавал дотооддоо тийм чанартай, гүн гүнзгий хүсэл эрмэлзлэлтэй байвал хийж чадна. Эс бөгөөс, хүчээр хийвэл жам бус, хиймэл явдал болно. Гэхдээ зүгээр, аажим аажмаар өөрийгөө дадуулж болно. Эхлээд жаахан хүчлэх боловч дахин давтан хийсээр байвал сүүлдээ ая зөнгөөрөө болох болно.

Тиймээс эрт дээр үеэс жинхэнэ хувраг хүнийг машид их хүндэлдэг байжээ. Ялангуяа хятадууд хувраг хүнийг бүр ч их хүндэлдгийг та нар мэднэ. Хуврагуудын зарим нь ямар ч бясалгалгүй, харахад тийм сүрлэг эрхэмсэг биш, яг л Багштай чинь ойролцоо (Бүгд инээлдэв.) иймэрхүү байсан ч хүндлэгдэнэ. Энэ нь та бүхэн их буянтай, сэтгэлийн гүндээ тэдэн шиг хүсэл эрмэлзлэлтэй, тэдэнтэй ижил алхам хийх гэсэн санаа бодолтойг харуулж байна. Тийм учраас ижил зүйлээ хараад сэтгэл ихэд баясдаг хэрэг. Ижил зүйл ижил

зүйлдээ татагддаг. Англи хэлэнд бас ингэж хэлдэг. Two great minds think alike (Хоёр агуу оюун ухаан адилхан сэтгэдэг).

Өнөөдөр яагаад хуврагийн тухай түүх ийм олныг ярьснаа би ойлгосонгүй. Магадгүй, сонсох хүсэлтэй хүмүүс байснаас тэгсэн байх. Хувраг хүн үнэхээр бясалгах дуртай байдаг. Тийм учраас гэрээс гардаг юм. Бүх холбоо хамаарлаа таслахыг хүсдэг. Энэ нь бясалгахад амар болгоно. Гэрээс гарах нь зөвхөн холбоо хамаарлаа таслахаас гадна хүсэл тачаал, уур хилэн, харанхуй мунхагийг ч тасална. Өөрөөр хэлбэл мөнгөнд шунахгүй, хувцсанд дурлахгүй, гэр бүлд хоргодохгүй, ер нь юунд ч татагдахгүй болно.

Гэвч энэ бас хангалтгүй, бясалгах хамгийн төгс дээд номын ёсгүй бол чөлөөгдөхгүй. Тиймээс дан ганц гэрээс гарах нь хангалтгүй юм. Иймээс Шагжамуни Будда өөрийн хамгийн хайртай шавь Анандад Арьяабалын аргаар бясалгахыг зөвлөсөн. Арьяабалын аргаар бясалгаагүй байх үедээ давж туулах шаардлагатай асуудлууд Анандад байсаар байжээ. Тиймээс Шагжамуни Будда түүнд хамгийн төгс дээд аргаар бясалгахыг зөвлөсөн байна. Тэгж Ананд гэгээрсэн. Хамгийн сүүлд Буддагийн залгамжлагч болсон билээ.

Анандад төвөг учирч, асуудалд ороогүй бол өнөөдөр “Баатар явагч их хөлгөн судар” гэж байхгүй, Арьяабалын бясалгал гэж юу болохыг бид мэдэх боломжгүй байх байсан. Шагжамуни Буддаг энэ дэлхийд залрахаас өмнө Арьяабалын бясалгалын арга аль хэдийнээ байсан нь мэдээж. Эс бөгөөс Шагжамуни Будда түүнийг хаанаас олж бясалгах вэ? Гэхдээ тэр бол тун ер бусын цаг үе байжээ. Зөвхөн дээд ангийн брахман хуврагаас бусад нь Арьяабалын бясалгалын арга гэж юу болохыг мэддэггүй байсан. Учир нь эрт дээр үед дээдийн номд суралцахад тун хэцүү байжээ. Үүнийг та бүхэн сайн мэднэ.

Эртний хятадад ч бас адилхан, нийтэд бараг ном уламжилдаггүй байсан. Нэгэн алдартай номын багшаас суралцахын тулд уул, усыг гаталж, бүх эд хөрөнгөө өргөл болгож, багштайгаа хамт амьдарч, тус дэм болж, олон жил шадарлан үйлчилнэ. Түүний дараа л багшаас шавьд ном уламжилна.

Та бүхэн Мял богдын түүхийг уншвал ойлгоно. Тэрээр өөрийн багшид долоон жил үйлчилсэн. Өдөр бүр зодуулна. Байшин барина. Барьсан байшингаа нураана, нурааснаа дахин барина. Ингэж олон жил соригдсоны эцэст багш нь номын авшиг хүртээсэн байна. Үүний өмнө Мял богд ном хулгайлахыг оролдоод бүтээгүй, багшийгаа мэхэлж түүний шавиас нууцаар ном сурахыг санаархаад чадаагүй. Түүний төлөвлөсөн бүхэн бүтэлгүйтэж байв. Багш нь ном уламжлахыг зөвшөөрөх хүртэл хүлээсний эцэст сая ном хүртэж чадсан байна. Авшиг хүртээд дараа нь үргэлжлүүлэн хүйтэн уул Хималайд хатуу бясалгал олон жил хийж, идэх хоол, өмсөх хувцасгүй, найз нөхөдгүй, эд зүйлээр дутуу гачуу нөхцөлд маш зүдэрч байжээ. Хэдий ингэж зүдрэн бясалгасан ч хожим нь Бурханы хутагт хүрч чадсан билээ.

Дамжлага нь тасарсан жинхэнэ ном

Тиймээс хэрвээ та бүхэн урьд нь яагаад Арьяабалын бясалгалын арга байгаагүйг, эсвэл Формосад энэ аргын талаар яагаад хэн ч ярьдаггүйг ойлгохгүй байвал энэ нь бас энгийн хэрэг. Зөвхөн Формосад ч биш, өөр олон улс оронд энэ аргын тухай огт сонсоогүй. Гэхдээ энэ нь Формосагийн хүмүүс хэзээ ч бясалгаж байгаагүй гэсэн үг биш. Бясалгаж байсан, гэхдээ тун цөөхөн. Иймээс бараг тасрах дөхөөд байжээ. Бумбын шашны бясалгах аргыг хараад би энэ номын ёс өнөөдрийг хүртэл уламжлагдахдаа зөвхөн багахан хэсэг, өчүүхэн жаахан нууц нь үлдсэнийг ойлгосон.

Судар номуудыг уншаад өмнө нь тэдний сургаалын эзэд болон их багш нар бүгд Арьяабалын аргаар бясалгаж байсныг бас мэдсэн. Одоо бол өчүүхэн бага баримт сэлт л үлдэж дээ. Хожмын хүмүүс яаж бясалгахаа мэдэхгүй байснаас бүгд буруу бясалгасан байна. Тэдний бясалгах байдлыг хараад надад инээх ихдэж, уйлах багадаж, харамсах сэтгэл төрсөн. Жинхэнэ номын дамжлага үнэхээр тасарсан нь харахад л ойлгомжтой байсан. Одоогийн шавь нар нь, шавийн шавь нар нь мухар сохроор бясалгаж байна. Үнэхээр харамсмаар. Үнэндээ тэдний гэгээрэх хүсэл эрмэлзлэл маш их, үнэхээр бясалгаж чөлөөлөгдөхийг чин сэтгэлээсээ хүсдэг. Зөвхөн бясалгалын арга л дутаж байна. Хэрвээ ийм өндөр төвшний гэгээрэх хүсэлтэй хүмүүс Арьяабалын аргыг олж бясалгавал маш хурдан Бурханы хутагт хүрч чадна.

Исламын шашинтнууд ч ялгаагүй, би тэдний мөргөлийн сүмд очиж мөргөл үйлдэх ёслолыг нь хараад, тэд ч бас Арьяабалын аргаар бясалгаж байсныг ойлгосон. Бясалгах байрлал нь л ялимгүй өөр. Хараад сэтгэл их өвдсөн. Гэсэн ч би тэдэнд хэлээгүй. Учир нь тэдий зүгээс надад номын айлтгал хүсээгүй бол ярьж болохгүй. Магадгүй цаг нь арай болоогүй байх. Тэгээд ч тохиромжтой газар биш байсан тул яриагүй, хэрвээ яривал зөвхөн буруу ойлголцол, өрсөлдөх бодол л үүсэх байв. Тэдэнд таагүй сэтгэгдэл төрүүлэхээс цаашгүй болох байсан. Гэхдээ би хааяа тийшээ очиж, ганц нэгэн зүйл ярьж байсан. Коран судар нэгийг авч яваад уншина. Багш нь тэднийг сургахыг хүсээгүйдээ биш, харин дэндүү гүнзгий төөрөлдсөнийг хараад яриад ч нэмэргүйг ойлгосон юм. Тэгэхдээ Багшид нь бас найдлага байна. Хэрвээ бид нийтийн дунд яривал заавал нэг хүн олж сонсоно. Тэгээд аяндаа өөрөө ирж, ном сурахыг хүснэ, тэр үед би авшиг хүртээх нь тодорхой. Тэр хүн хариад зөнч Мухаммед гэгээнтэндээ мөргөнө. Зөнч Мухамед бол түүний өмнөх сургаалын эзэн бөгөөд бид ч бас түүнийг биширмээр шүү.

Исламын шашинтан хүнийг заавал энд ирж, Багшид шавилахыг шаардахгүй. Би зөвхөн тэдэнд ном уламжлахад л болно. Тэд ямар нэгэн байдлаар надад үйлчлэх, миний төлөө ажиллах ямар ч шаардлагагүй. Надтай ямар нэгэн байдлаар холбоотой байх ч хэрэггүй. Хэрвээ Багштай нь гадаа тааралдаад танихгүй дүр үзүүлсэн ч надад асуудалгүй, зам дээр надтай мэндгүй зөрсөн ч хамаагүй. Учир нь Арьяабалын бясалгалын аргыг сэтгэлээс сэтгэлд нэг бүрчлэн нууцалж уламжлах тул гадны хүмүүст мэдэгдэхгүй. Хэрвээ мэдэгдвэл, тухайн шавийн нийгэмд эзлэх байр суурь, гэр бүлийн харилцаанд хохирол учирч болзошгүй. Тиймээс би, Багшийг даган суралцаж байгаа ямар ч хүнийг, хэнд ч мэдүүлдэггүй.

Бусад хүн мэдэхийг хүсэх нь тэдний асуудал. Багш нь ямар ч байсан хэн гэдэг том дарга, жижиг дарга, эсвэл ядуу хүн Багшийг даган суралцаж байна гэж сурталчлахгүй. Ингэх хэрэг огт байхгүй. Надад юу ч хэрэггүй. Миний хэдэн шавьтайг, хэр агуу хүн болохыг хэн ч мэдэх хэрэггүй. Өөрийгөө хичнээн агуу вэ гэж би хэзээ ч бодож байгаагүй. Бид бүгдээрээ агуу хүмүүс, зөвхөн ажил үүргээрээ л ялгаатай.

Эмч хүн маш чухал, гэхдээ хог новш цуглуулдаг хүн бүр ч чухал. Хэрвээ тэр байхгүй бол манай дэлхий хогоор дүүрч, маш муухай өмхий болох байсан. (бүгд алга ташив) Багш бол хог цуглуулагч. Бусдын муу үйлийн үрийг тусгайлан цуглуулна. Ийм үйлийн үр нь хог новшноос ч илүү өмхий, маш муухай. Тиймээс надад бардамнах юм ер үгүй. Сайхан номын хувцас өмссөн, харахад адилгүй болохоос би бол ердөө л нэг хог цуглуулагч. Хамаг төрөлтний үйлийн үрийг цуглуулах нь үнэхээр өмхий самхай.

Нуугдмал Бурханы хүч

Өчигдөр хариулж дуусаагүй нэг асуулт бол Багш нь яагаад та нарт хүч чадлаа үзүүлээгүй вэ? Үнэндээ бол ийм юм л даа, Багшийн хүч чадал зүгээр л аяндаа жамаараа байж байдаг, зориуд ид шид үзүүлнэ гэж байхгүй. Зарим нь түүнийг мэдэрнэ, зарим нь мэдрэхгүй. Энэ бол та нарын өөрсдийн асуудал.

Багш хүч чадалтай гэдгийг бид мэднэ гэж өчигдөр зарим нь хэлж байсан. Гэвч цөөн хэдхэн нь л мэднэ, бусад ихэнх нь мэдэхгүй. Энэ нь та нарын буруу биш, бас их доогуур дэстэй ч гэсэн үг биш. Өчигдөр Багш нь та нарыг Арьяабалын бясалгалын аргын хүч чадлыг таньж мэдэхээс өмнө жаахан дарамт шахалт үзүүлж “доош нь хийж”байгаад бардам сэтгэлийг чинь багасгасан.

Үнэндээ та нар тийм ч доогуур дэстэй биш, доогуур дэстэй хүн энд ирвэл юу ч ойлгохгүй, ирж ч чадахгүй. Ирсэн ч таван минутын дараа явмаар санагдана. Явахгүй байсан ч дороо хурхиран унтана. Гэтэл та нарыг харвал нүд нь гэрэлтээд зарим нь бүр төвлөрсөн царайтай, маш их сонирхон сонсож байгаа нь илт байна. Энэ бол тун өндөр дэстэйн шинж. Багшийн хүчийг авшиг хүртсэн шавь нар бүгд мэднэ. Авшиг хүртээгүй зарим хүн ч бас Багшаас цацрах гэрлийг шууд харж, Багшаас ирэх шидийг мэдэрнэ, мөн Бурхан бодьсадваг хардаг гэх мэтийн явдал ч байдаг. Тэр үед Багшийн бясалгал эгэл биш гэдгийг тэд ойлгодог.

Багш нь хаана ч: “Харцгаа! Би бол бурхан!” гэж сурталчлаагүй. Багш нь ингэж ярихгүй. Учир нь би өөрийгөө Бурхан гэж мэдэрдэггүй.

Формосад бол үсээ хусуулж, гэрэээс гарсан хуврагийг хүмүүс Багш хэмээн дууддаг. Энэ бол тун энгийн нэршил, том асуудал биш. Яагаад хүч чадлыг зарим нь мэдрээд зарим нь мэдрэхгүй байна вэ? Миний өвгө Багш дээр үед

нэгэн Будда энэ тоост хорвоод залрахад түүнийг мэдэх хүн байдаггүй нь үнэхээр хачирхалтай шүү гэж хэлж байсан. Хэрвээ нэгэн эмч ирвэл бид бүгдээрээ түүнийг танина. Учир тэр цагаан халаадтай. Ерөнхийлөгч ирвэл цэгцтэй сайхан хувцаслаж, дагуул олонтой явах тул бид түүнийг тэр дор нь танина. Эзэн хаан, эсвэл цагдаа ирвэл бид бас дор нь танина. Харин манайд Будда залран ирвэл хэн нэгэн хүн танилцуулахгүй л бол түүнийг таних арга бидэнд байхгүй. Тиймээс би олон газарт амьдарч байсан ч хэн ч мэдээгүй. Өчигдөр хар арьст америк авшигтан эмэгтэй дээдийн номыг хайсан өөрийн түүхээс ярьсан. Тэр бүсгүй тухайн үед Арьяабалын бясалгалын арга гэж байдгийг огт мэддэггүй байжээ. Нэг удаа тэрээр хүнд өвдөөд үхэж, төрөхийн сансрын хүрдэнд эргэлдэхийн зовлонг ухаарсан байна. Тэгээд Бурхан бодьсадвад хандан нэгэн Төгс Гэгээрсэн жинхэнэ Их Багшийг хайж олоход минь туслаач гэж ахин дахин гуйн залбирчээ. Түүний залбиралд Бурхан бодьсадва хариулсан байна. Эс бөгөөс тэр бүсгүй ч бас Багш гэж хэн болохыг мэдэхгүй байх байсан.

Хэрвээ бид чин ариун зүрх сэтгэлийн гүнээс залбиран даатгавал Бурхан бодьсадва бидэнд жинхэнэ Их Багшийг олоход тусална. Хэн нь жинхэнэ Их Багш вэ?, Хэн нь хуурамч Их Багш вэ? гэж багшаасаа бүү асуу. Жинхэнэ, хуурамч нь бидний чин сэтгэлтэй хамаатай. Чин сэтгэлтэй бол жинхэнэ Их Багштай уулзана. Чин сэтгэлгүй бол хуурамч Их Багштай уулзана. (Бүгд алга ташив.)

Есүс Христ Багш: And the sprit will make flesh and lives among man, but nobody knows Hirm" гэж хэлжээ. Утга нь, Сүнс биелэн бууж ирээд хүмүүсийн дунд амьдарна, гэвч хэн ч түүнийг танихгүй гэжээ.

Энэ үнэхээр хачирхалтай явдал. Бид өдөр бүр Эзэн Бурханаас, Бурхан Багшаас тусламж гуйн залбирдаг мөртлөө Бурхан залрахад Эзэн Бурханы хувилгаан бие бууж ирэхэд

Түүнийг таних ямар ч аргагүй байдаг. Нэгэн цэцгийг үнэрээр нь танина, алс холоос ч үнэрлээд мэднэ. Гэтэл Эзэн Бурханы хувилгаан дүр залрахад бид харин үнэрлэж ч чадахгүй.

Үзэгдэл хоосноос ялгаагүй, хоосон нь үзэгдэлээс өөрцгүй

Эрт дээр үед ч бас адил, даяаны судруудыг уншвал их бясалгагч, ихэд ангижирсан хүмүүн хаана ч очсон өөрийг нь таних өчүүхэн ч ул мөр үлдээдэггүй тухай бичсэн байдаг. Учир нь тэд бүрэн хоосорч, оршин буйг нь харах аргагүй болтол хоосорсон байдаг аж.

Хэрвээ нэгэн жинхэнэ сайн бясалгадаг нэгэн хүн энд ирж, ном айлдвал түүний бие нь хоосон, зөвхөн хэсэг гэрэл байхыг бид харна. Гэтэл зарим хүн зөвхөн дүрс л хардаг тул бие махбод заавал оршин байх хэрэгтэй. Тиймээс үзэгдэл хоосноос ялгаагүй, хоосон нь үзэгдлээс өөрцгүй гэдэг нь ийм учиртай. Их бясалгагч хүний бие энгийн нэгэн бие махбод биш. Учир нь түүний хэлбэлзэл дэндүү өндөр. Хэрвээ нэгэн мөчид бидний хэлбэлзэл тэдний хэлбэлзэлтэй ижил болбол бид ч бас тэдний махан биеийг харахгүй. Тэр үед, тэр үнэхээр хоосон, тэр бол махан бие биш болохыг ойлгоно.

Багадаа тоглодог байсан эргүүлгийг та нар санаж байна уу? Хэт хурдан эргэлдвэл дүрс нь харагдахгүй, яг юу ч үгүй юм шиг байдаг, тийм биз? Харин зогсвол дүрс нь харагдана. Үүнтэй ижил, хэрвээ нэгэн их бясалгагч хүний хэлбэлзэл дэндүү өндөр бол тэр оршихгүй мэт байна. Үнэндээ тэр оршин байгаа. Хамаг төрөлтнийг гэтэлгэхийн тулд заавал харагдах хэрэгтэй, тэдэнд түшиг болох хэн нэгэн байх хэрэгтэй учраас үзэгдэх бие махбодтой байх ёстой. Эс бөгөөс түүний оршин байгааг бид мэдрэхгүй билээ.

Би өмнө нь Нью-Йоркод жил гаруй амьдарсан. Тэр

үед нэг ч хүн ном гуйж ирээгүй. Харин нэгэн хар арьст авшигтан бүсгүй ирсэн. Түүний бясалгалд Багшийн дүр илэрч, улмаар дотор хүн нь энэ Багшийг олж уулз гэж түүнд хэлжээ. Эс бөгөөс, Багшийг нь хэн болохыг хэн ч мэдэхгүй байх байсан.

Тэр дандаа л намайг хайж ирдэг тул сүмийн хүн ихэд гайхаж: “Чи хэнийг хайгаа вэ?” гэхэд тэрээр: “Би Master Ching-г хайж байна” гэнэ. Master гэдэг нь хятад хэлээр Их Багш, номын Багш гэсэн утгатай. Тэд: “Чи амьдрах газар хайгаа юу” гэхэд тэрээр: “Үгүй үгүй, би нэг намхан биетэй гэлэнмааг хайж байна” гэжээ.

Тэр нэг жижигхэн гэлэнмааг номын багш гэж хэзээ ч тэд сонсоогүй учир маш их гайхсан гэнэ. Хожим нь ирэх хүн улам олширч, түүний найзууд нь хүртэл ирсэн. Ямар нэгэн зүйл мэдрээд эхэлмэгц нь Багш тэдэнд мэдүүлэхгүйн тулд өөр газар руу тун хурдан шилжин нүүсэн юм. Тэгээд тэндээ жил гаран амьдарсан. Тэр хэдэн хүн л Багшийнд нь ирнэ. Хамт амьдарч байсан бусад хүн Багшийг нь хэн болохыг огт мэдээгүй.

Өмнө нь Багш нь Формосагийн нэгэн сүмд бас жил гаран амьдарсан. Тэнд ч бас хэн ч, юу ч мэдрээгүй. Харин намайг даяан хийж байхад тэнд ганцаар амьдардаг нэгэн хүн ирж, хаалга тогшин асуусан. Надтай хамт амьдарч байсан хүмүүсээс хэн нь ч юу ч мэдрээгүй. Харин та нар ямар нэгэн зүйл олж үнэрлэсэн учраас энд ирж ном сонсож байна. Энэ үнэхээр хачин хэрэг шүү. Тиймээс нэгэн бясалгагч хүнтэй хамт амьдарвал заавал түүнийг танина гэсэн үг биш. Учир нь амжилтанд хүрсэн тэр хүмүүст би гэх юм хэдийнээ үгүй болдог. Тэр өөрийгөө ийм тийм хүн гэхгүй, түүнийг гуйранч гэвэл окэй гэнэ, зарц барлаг гэвэл тэр бас окэй л гэнэ. Яагаад тэр вэ? Учир нь тэр маргалдах мэтгэлцэх бодолгүй, хэнтэй ч тэмцэлдэхгүй, өөрийн дэсийг хэнд ч үзүүлэх хүсэлгүй байдаг. Түүний хувьд үнэхээрийн амин чухал ажил гэх юм

үгүй болдог. Түүнд юу ч хэрэггүй, бусдын магтаал бүр ч хэрэггүй. Түүний хувьд юм бүхэн ижил. Түүний хувьд ариун цэврийн өрөө цэвэрлэх, ном айлдах хоёр яг ижилхэн. Хамгийн чухал ажил хэрэг гэхээр зүйл түүнд байхгүй болдог. Учир нь түүний хувьд дэлхий ертөнц угаасаа асуудалгүй болсон бөгөөд хамаг амьтан хүсвэл гэтэлгэнэ, хүсвэл ном айлдана. Эс бөгөөс тэдний гэтлэх, гэтлэхгүй нь ч хамаагүй. Очих хүсэлгүй нь, хүсэлгүй гэсэн үг бас биш юм, ер нь юу ч хийсэн болно.

Төгс төгөлдөр их билгүүн ухаан

Өчигдрийн бас нэг асуулт бол яагаад бид заавал бясалгах ёстой вэ? “Махабарамид” гэдэг нь ямар утгатай вэ? Яагаад түүнийг олох хэрэгтэй вэ? Багш нь өчигдөр их товчхон хариулсан. Өнөөдөр арай гүнзгий тайлбарлая.

“Маха барамид” гэдэг нь самгарьд хэлний дуудлагаас орчуулсан үг. Самгарьдаар Maha Prajna paramita. Maha гэдэг нь их гэсэн утгатай. Энэтхэгийн Ганди–г та нар бүгд мэднэ. Түүнийг Mahatma Gandhi гэдэг. Энэ нь агуу их төрөлтөн гэсэн утгатай. Maha Atman нийлээд Mahatma болжээ. Энэ нь агуу сүнс гэсэн утгатай юм.

Энэтхэгт их бясалгагч хүнийг Mahatma гэх бөгөөд энэ нь Maha Atman -гаас хувирч иржээ. Maha гэдэг их гэсэн утгатай, Atman гэдэг нь сүнс, хамаг төрөлтөн гэсэн үг. Нийлээд их бясалгагч, их билиг ухаантан болно.

Maha Prajnaparamita-г салгаад тайлбарлая. Maha бол их, Prajna нь билиг ухаан, paramita нь төгс төгөлдөр гэсэн үг. Бид хятадаар Moheboleboremi, эсвэл Moheborebolomiduo гэдэг нь хамгийн дээд билиг билгүүн гэсэн утгатай. Бурханы билиг ухаан, Эзэн Бурханы төгс чадвар, бүхнийг чадагч их хүч бол хамгийн дээд билиг билгүүн мөн. Бид яагаад энэ их

хүчийг олох ёстой вэ? гэдгийг та бүхэнд хэлж өгье! Жишээ нь, зарим нэгэн гоц хүүхдүүд төрмөл авьяастай байдаг. Яг л Моцарт дөрвөн настайгаасаа төгөлдөр хуур тоглож чаддаг байсан шиг. Зөвхөн төгөлдөр хуур ч биш, өөрийн онгодоор орж ирсэн зүйлсийг тэмдэглэхийг аваасаа хүсэж, түүнийгээ аяз болгон бичиж байжээ.

Бетховен ч мөн багаасаа хосгүй их авьяастай байсан. Эртний хятад оронд ч гоц авьяастай хүүхдүүд байжээ. Гоц авьяастай маш олон хүүхэд байсан нь мэдээж. Одоо би нэрсийг нь хэлж мэдэхгүй. Тэд яагаад гоц явьяастай байдаг вэ? Учир нь тэд энэ чадвараа төрөл төрөлдөө хөгжүүлж, өөрийн энэ талын авьяасыг онцгой илрүүлэн гаргаж чадсан байдаг. Жишээ нь, нэгэн хүн шүлэг зохиохдоо тун сүрхий, яг л Ли Бай, Су Дунпо-той адил яруу сайхан бичдэг. Өмнөх олон төрөлдөө шүлэг зохиох авьяастай байсан нь түүнд нөлөөлжээ.

Яруу найрагч Жан Сүйкэ олон мянган шад алдартай шүлэг зохиосон:

Сар шингэсэн ч хэрээ гуагалж, тэнгэрт хүйтэн
жавар хуржээ.
Сүмийн ойролцоо, мөрний эрэг хавьд загасчны завин
дээр өчүүхэн гэрэл ёлтойн ахуйд
Санаа сэтгэл чилэн байвч унтах нойр хулжин оджээ.
Сужоу хотын гаднах Ханшан сүмийн хонхны дуу
үүр цүүрээр хөлөг дээр сонсогдном

гэж бичсэн байдаг. Энэ нь тэрээр олон төрөлдөө бичгийн чадвараа хөгжүүлж, дадуулсан учир зохиох бичихэд тун дадамгай болж, ийм сайхан шүлэг зохиожээ. Энэ нь яг нэгэн мужаан шиг. Нэг чадварыг хар багаасаа эзэмшвэл том болоод түүндээ улам мэргэшинэ. Сийлбэрчин ч ялгаагүй, өдөр бүр сийлээд байвал ур чадвар нь улам сайжирч алдаршина. Зарим хүн төрөл тутамдаа өөрийгөө тасралтгүй

хөгжүүлсэн тул ур чадвар нь улам сайжирч хамгийн шилдэг нь болдог.

Зарим эмч их алдартай, анагаах эрдэм нь маш торгон нарийн. Учир нь тэр урд төрөлдөө эмч байсан, энэ төрөлдөө ч бас эмч болсон тул бүх зүйл тун ойлгомжтой байна. Тиймээс бид зарим эмчийг хувилгаан эмч гэдэг. Жишээ нь; Хуа Түө, Биангэ нар одоо ч алдартай хэвээрээ. Одоо ч алдар цуутай эмч олон байна. Тэд өмнөх олон төрөлдөө эмчийн ажил хийж, анагаах ухааны мэдлэг чадвараа тасралтгүй хөгжүүлжээ. Тиймээс тэдний хувьд одоо энэ ажлыг хийхэд хялбар. Амархан ч хийнэ, сайн ч хийнэ. Дуу хөгжим, дуулах урлаг, уран зохиол, урлагийн салбарт авьяас нь тодорсон хүмүүс бүгд өмнөх төрлүүддээ хэдийнэ дадуулан хөгжүүлсэн байдаг.

Аль ч талын авьяас чадвараа хөгжүүлсэн энэ нь түүний доторх нэгхэн хэсэг төдий. Хэрвээ бид “Маха билиг барамид”-ийг олвол бүхнийг мэднэ. Мэс засал хийнэ, дуу хөгжим зохионо, зураг зурна, өвчин эмнэнэ. Энэ үнэхээр хачин хэрэг шүү!

Тиймээс Шагжамуни Будда: “Бид эхлээд Будда болох хэрэгтэй, тэгвэл юм бүхэнтэй болно” гэж онцолж байжээ. Тэрээр: “Бурханы билгүүн ухаан бол хамгийн төгс төгөлдөр нь. Тиймээс бид энэ төгс төгөлдөр билгүүн ухааныг олж авах хэрэгтэй” гэж айлдаж байв.

Есүс Христ ч мөн адил: “Seek you first the Kingdom of God, and all the things shall be added onto you”, (эхлээд өөрийн дотоодын диваажингаа олох хэрэгтэй, тэгвэл дараа нь бүхий л авьяас чадвар, бүхий л хэрэгцээтэй зүйл бүгд даган ирнэ) гэжээ. Өөрөөр хэлбэл чи бүхнийг аяндаа олж хүртэнэ, Эзэн Бурхан чамд өгнө гэсэн утгатай.

Шагжамуни Буддагийн шавь Модгалъяана /Молом

тойн/ маш их шидтэй, диваажинд ч хүрнэ, тамд ч очно, маш олон зүйлийг хувиргах чадалтай. Гэвч эцэстээ бусдад хорлогдсон. Учир нь тэрсүүдийн талын хүмүүс атаархсанаас илүү их хүчтэй шидээр түүнийг хорлодог. Шагжамуни Будда заларч байхдаа түүнд шид хэрэглэж болохгүй, шид ямар ч хэрэггүй гэж байнга сануулж байжээ. Гэсэн ч тэр гадны хүмүүстэй шидийн хүчээ тэнсэж, тэмцэлдсэн байна. Хэрвээ хэн нэгэн хүн надад ийм тийм шид буй гэвэл тэр бас надад буй гэнэ, хэрвээ хэн нэгэн хүн би ийм тийм зүйлийг хувиргаж чадна гэвэл тэр би ч бас хувиргаж чадна гэнэ. Өдөржингөө тэрсүүд нартай шидээр тэмцэлдэж, сүүлдээ тэднийг уурлуулсан тул нэгэн далимаар түүнийг хорложээ. Энэ бол үнэхээр харамсалтай явдал.

Модгалъяана бусдад шидийн хүчээр зодуулаад үхэх гэж байхад нь Шагжамуни Будда шавиа явуулж авчруулсан байна. Тэр бараг л үхэж байв. Түүнээс нэгэн хүн: “Та ийм их ид шидтэй байтал яагаад хэрэглэсэнгүй вэ?” гэж асуухад тэр: “Үйлийн үр ирэхийн цагт бүх шид мартагддаг” гэж хариулсан байдаг. (Бүгдээрээ алга ташив) Тиймээс хамгийн чухал нь өөрийн бурхан чанарыг хайж олох, бясалгал хийж, Будда болох явдал юм. Бусад нь аяндаа болж бүтнэ. Эс бөгөөс бид зөвхөн нэг л чадвараа хөгжүүлээд байвал төгс билиг ухааныг олж хүртэхгүй. Тиймээс Бурхны шашны бүхий л ном сударт: “Маха билиг барамид”-ийг, их билиг ухааныг онцгойлон дурддаг. Бурхны шашинтан хүн өглөөний уншлагадаа “Маха билиг барамид”-ыг уншдаг.

Библийн сударт мөн адил: “Эхлээд дотоодод буй тэнгэрийн орноо хайж ол, тэгвэл бусад зүйл аажим аажмаар аяндаа чам руу ирнэ, хэрэгтэй зүйлээ бүгдийг олно” гэж онцлон дурдсан байдаг. Үүнийг би урьд нь өөрийн биеэр мэдэрсэн тул баталж нотолно. Үнэхээр яг ийм байдаг. Эхлээд их билиг ухааныг олбол бүхнийг олно. Тиймээс та нар Багшийн хувилгаан бие авшигтанд мэс засал хийсэн

тухай сонсоод их цочдог байх. Багш нь энэ дэлхий дээр хэзээ ч мэс засал хийхийг сураагүй. Би эмч биш, гэхдээ миний аав, миний хуучин нөхөр, хүргэн ах, нагац ах, авга ах бүгд л эмч хүн байсан. Энэ дэлхий дээр өмнө нь би хэзээ ч анагаахын шинжлэх ухаанд суралцаагүй. Гэвч их билиг ухааныг олсноор бидний дотоод маань бүхнийг хийж чадна. Гэхдээ үүнийг гадна талд хэн ч мэдэхгүй, энэ бол дотоодын асуудал. Тиймээс та бүхэн Багшаас шид үзүүлэхийг шаардах хэрэггүй. Хэрвээ аяндаа харагдвал сайн хэрэг, эс бөгөөс тусгайлан гуйх хэрэггүй. Би хэзээ ч та нарт зориудаар шид үзүүлэхгүй. Бурхан бодьсадва ингэдэггүй. Хэрвээ Багш нь зориудаар шид үзүүлбэл орчлонгийн их хуулийг зөрчинө. Улс орон бүхэн өөрийн хуультай. Бясалгал гэгээрэл ч бас өөрийн хуультай. Орчлонд орчлонгийн хууль бий. Дурааараа дургиж огт болохгүй. Хэрвээ хууль зөрчвөл тун их яршиг төвөг үүснэ. Жишээ нь, Багш нь английн иргэн. Хэрвээ би Формосад ирвэл танай улсын ёс заншлыг хүндэтгэж, хууль дүрмийг сахих ёстой. Хууль зөрчиж болохгүй. Би бол Англи улсын иргэн, Формосагийн иргэн биш учраас юу дуртайгаа хийж болно гэж болохгүй. Үүнтэй адил, Бурхан бодьсадва маш их хүчтэй, гэхдээ энэ хүчээ зөвхөн шавь нартаа зориулан дотооддоо хэрэглэдэг. Гадны хүнд огт мэдэгдэхгүй. Хэрвээ тэд мэдвэл энэ нь ая зөндөө л болсон хэрэг. Хүмүүст мэдүүлэхийн тулд харин хэзээ ч зориуд хийхгүй. Та нар заавал Багшид итгэх албагүй, миний шавь болж, манай нийгэмлэгт элсэх ч хэрэггүй. Бидэнд ямар ч нэгдэл бүлгэм байхгүй. Миний шавь нарын дунд католик шашинтан, буддын шашинтан, исламын шашинтан, игуандаогийн шүтлэгтэн ч бий.

Багш нь аль ч шашныг ялгаварлахгүй. Тэднийг угийн шашин шүтлэгээ өөрчил гэхгүй. Миний хувьд, тэд сайн хүн байж, энэрэн нигүүлсэх сэтгэлтэй, гэгээрэх хүсэл эрмэлзлэлтэй байвал хамгийн сайн католик шашинтан, хамгийн сайн буддын шашинтан, хамгийн сайн игуандао

шүтлэгтэн мөн.

Би тэдний шашин шүтлэгийг өөрчлөхгүй. Хамгийн чухал нь өөрийн дотоодын хүчээ л олох явдал. Энэ дотоодын хүч биднийг ямар ч үед аварна. Ямар ч үед хамгаална. Бид түүнтэй заавал холбогдох хэрэгтэй. Харин үргэлж Багшид, Бурхан бодьсадвад, Эзэн Бурханд найдан тусламж гуйгаад өөрөө бясалгахгүй сууж болохгүй. Эзэн Бурхан бидний дотоодод байдаг, Есүс Христ: "Диваажин бидний дотор бий" гэсэн бол Бурхан Багш: "Будда сэтгэлд буй" гэжээ.

Та бүхэн угийн сайн католик шашинтан, сайн игуандао шүтлэгтэн, бумбын сайн сурталтан, күнзийн сайн сургаалтан хэвээрээ байж болно. Ер нь ямар ч шашинтан байсан хамаагүй, би зөвхөн хамгийн дээд хүсэл зорилгодоо хүрэхэд тань тусална. Жишээ нь, бид өөрсдийгөө бурхны шашинтан гэж боддог бол "Бурхан бидний сэтгэлд буй" гэдгийг мэдэх хэрэгтэй, дотоодод буй бурхнаа хайж олох хэрэгтэй. Чи өөрийн өвчнийг эмчилж чадах хүнийг олсон ч энэ нь түр зуурынх. Ийм хүмүүс Формосад маш олон.

Өвчнөө эдгээх чадвар бидний дотоодод бий. Хүнээр өвчнөө эмчлүүлж болно. Гэхдээ анагаан эдгээх өөрийн чадварыг нээж олох хэрэгтэй. Ингэвэл энэ нь үүрдийнх болно. Өвчин тусвал хүнээр эмчлүүлэх нь ерийн явдал, гэхдээ өвчнөөс аврах өөрийн мөнхийн чадварыг олох нь чухал. Учир нь бидний дотоодод юм бүхэн байдаг. Даанч түүнийгээ хэрэглэдэггүй нь үнэхээр харамсалтай, дэндүү гарзтай явдал мөн.

Дотоодын ахуй ойлголтгүй байж болохгүй

"Бурханы гэрэл мөнхөд гийгүүлнэ" гэж ярихыг бурхны шашинтай хүмүүс бүгд сонссон. "Мөнхөд гийгүүлнэ" гэдэг нь ямар утгатай вэ? Газар бүр гэрэлтэй,

хором бүхэн гэрэлтэй байдаг учраас "Бурханы гэрэл мөнхөд гийгүүлнэ" гэжээ. Ариун орны шүтээн Авид Бурхан бол цаглашгүй гэрэл мөн. Хэрвээ бид Авид Бурханы ариун оронд очихыг хүсвэл энэ мөнхөд гийгүүлэх Бурханы гэрлийг хаанаас хайж олохыг мэдэх хэрэгтэй. Хэрвээ Бурханы гэрэл мөнхөд гийгүүлдэг юм бол энэ нь цаглашгүй гэрэл байж таарна. Тэгэхээр тэр гэрэл газар бүхэнд байх учиртай, гэтэл яагаад бид харахгүй байна вэ?

Тиймээс энэ "Цаглашгүй гэрэл"-ийг хайж олоход Багш нь та нарт тусална. Учир нь энэ гэрэл цаглашгүй бөгөөд мөнхөд гийгүүлэх тул бид заавал харах ёстой. Бид заавал харна гэдгийг Багш нь амлая. Гэрлийг маш түргэн олох төдийгүй улам ихсэж, улам "мөнхөд гийгүүлж", улмаар "цаглашгүй гэрэл" болно. Бид өөрсдөө Авид Бурхан, цаглашгүй гэрэл болон хувирна. Ингэж байж сая жинхэнэ ариун оронтон, жинхэнэ бурхны шашинтан болно. Ойлгов уу? (бүгд алга ташив)

Авид Бурхан бол цаглашгүй гэрэл болохыг та нар мэдэх үү? Тэр бол мөнхийн гэрэл. Формосад маш олон хүн Авид Бурханыг шүтдэг. Гэвч тэд Авид Бурханыг харж чадаагүй байдаг. Бурхны шашинтнууд алгаа хавсран цаг үргэлж цаглашгүй гэрлийг дурсан уншдаг. Авид Бурханы утга нь цаглашгүй гэрэл. Гэвч тэд цаглашгүй гэрлийг олж хараагүй, зөвхөн амандаа уншихаас цаашгүй байна.

Багш нь цаглашгүй гэрлийг олоход чинь тусалж болно. Та нар тэр даруйдаа л олж харна. Учир нь тэр гэрэл оршихгүй газаргүй. Авид Бурханыг дурсан уншаад гэрэл хараагүй бол мухар сохроор уншсан хэрэг болно.

Хэрвээ католик шашинтан бол, Есүс Христ Багшийн: "I am tne lignt of the world, whoever follows me will walk in the light, and never walk in darkness" гэж хэлснийг ойлгох ёстой. Та нар ойлгосон уу? Багшийнхаа орчуулгыг ойлгов

уу? Есүс Христ: “Энд байгаа цагтаа би бол хорвоогийн гэрэл гэгээ мөн, хэн надад итгэнэ, тэр үүрд мөнх гэрлийн дунд явна. Хэзээ ч харанхуй газраар явахгүй” гэж айлджээ. Өөрөөр хэлбэл, хэзээ ч харанхуй газрыг үзэхгүй гэсэн үг.

Католик шашинтай хүн түүний энэ үгийг мэдэх ёстой. Тэгээд өдөр бүр гэрлийн дунд байж чадвал сая зөвдөнө. Гэвч католик шашинтан та бүхэн өдөр бүр гэрлийн дунд байж чадаж байна уу? Гэрэл харж байна уу? Та нарын дунд католик шашинтай хүн бараг алга уу? Заавал байгаа. Даанч та нар гэрэл харж чадахгүй, өдөр бүрийг түнэр харанхуйн дунд өнгөрөөж байна. Энэ нь таны жинхэнэ католик шашинтан болж чадаагүйг, Есүс Христ Багшийг жинхэнээсээ дагаж чадаагүйг харуулж байна.

Бурхны шашинтан хүний хувьд ч ялгаагүй, Бурханы гэрэл мөнхөд гийгүүлэхийг хараагүй, цаглашгүй гэрлийг ч үзээгүй бол та жинхэнэ буддист болж чадаагүй байна гэсэн үг. Тиймээс Багш нь та бүхнийг жинхэнэ буддист, жинхэнэ ариун орны шүтлэгтэн, жинхэнэ католик шашинтан, жинхэнэ христчин болоход чинь тусална. Та нарын бодол санаа Есүс Христийнхтэй ижил болж, Түүний сургаал номлолыг мэдэрч ойлгоно, Шагжамуни Буддагийн ярьсан үнэн ёсыг мэдэрч ойлгоно.

Хэрвээ исламын шашинтан бол Зөнч Мухаммед бясалгалдаа хэмнэлт гэрэл, гэрэлт аялгуу үзсэнийг мэдэж байгаа. Тэр бол нэг зүйлийн дотоодын аялгуу бөгөөд тэрээр сударгаа энэ тухай маш тодорхой өгүүлсэн. Хэрвээ өөрийгөө исламын шашинтан гэж үздэг, Зөнч Мухаммедыг дагаж, түүний сургаал номлолоос суралцахыг хүсдэг боловч яг Түүний дотооддоо үзсэн шиг ахуй ойлголтыг харж чадаагүй бол хэзээ ч Түүнтэй адил болохгүй. Жинхэнэ исламын шашинтан болж чадахгүй.

Аллах Бурханд залбирч буй Исламын шашинтан

хүнийг харахад байрлал нь Арьяабалын бясалгалын аргынхтай тун төстэй. Жаахан ялгаа бий. Энэ бол урьд нь жинхэнэ исламын шашинтай байсан хүмүүс Арьяабалын аргаар бясалгадаг байсныг харуулж байна. Күнзийн сурталтан хүн ч бас үүнийг мэдэж байх ёстой. Күнз нэгэн дотоодын аялгууг сонсоод түүндээ гурван сарын турш автан суужээ. Хэрвээ та түүнтэй ижил ахуй ойлголтгүй бол жинхэнэ Күнзийн сурталтан биш гэсэн үг.

Тиймээс бид ямар ч шашин шүтдэг, ямар ч ёс журамд суралцсан байж болно. Харин дотоодын ахуй ойлголтгүй л байж болохгүй. Хэрвээ ёс суртахуунд сайтар суралцсан, сургаал номыг сайн судалсан, дээрээс нь дотоод ахуй ойлголттой бол үнэхээр төгс болох юм. Тиймээс Багш нь та бүхнийг шашин шүтлэгээ өөрчлөх хэрэггүй гэдгийн учир энэ. Учир нь бүх сургаал номлол ижилхэн, зөвхөн дотоодын ахуй ойлголт л дутуу байдаг. Бүхий л шашны сургаалын эздийн ярьсан дотоодын ахуй ойлголтууд бүгд ижилхэн. Багш нь зөвхөн энэ дотоодын ахуй ойлголтыг олж хүртэхэд чинь та нарт тусална. Та бүхэн надад ямар ч өргүй, бас миний өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээх шаардлагагүй. Өөрт тань угаасаа байсан зүйлийг, хаана байдгийг нь хэлж өгөөд түүнийгээ гаргаж ашиглахад чинь би зөвхөн тусалсан төдий. Багш нь та нарт би ийм, тийм зүйл өгсөн гэж хэлж бас болохгүй. Жишээ нь, ээж, аав чинь их хөрөнгө зоорь өвлүүлжээ. Гэвч чи түлхүүрийг нь гээсэн, эсвэл ээж, аав чинь чамайг том болохоор нээж өгөөрэй гээд түлхүүрийг надад үлдээсэн бол би та нарт эд хөрөнгөө хаанаас олж авахыг хэлж, түлхүүрийг өгөх нь миний үүрэг. Энд миний ачлал гэхээр юм бараг үгүй, ойлгов уу? Би та нарт эд хөрөнгө өгөөгүй. Энэ бас миний ч эд хөрөнгө биш. Та нарынх. Та нарын өмнөөс харж хамгаалж байгаад цаг нь болохоор та нарт бэлэглэж буй хэрэг. (бүгд алга ташив) Тиймээс надад өртэй шүү гэж би та нарт хэлэх эрхгүй, бахархаж бардамнаж бүр ч болохгүй.

Хэрвээ та бүхэн Багшаас ирж суралцаад ямар нэгэн дэсийг олбол энэ нь бас л та бүгдийнх. Учир нь буян хишиг чинь боловсорч гүйцээд цаг нь болсон тул Багш нь та нарт тусалжээ. Багшийн хүчин дор та бүхэн нэгэн агшинд энэ ертөнцийг огоорч, элдэв бодлоо хаяж чадсан тул ийм ахуй ойлголтыг асар түргэн үзэж чадсан хэрэг. Ийм л юм болсон. (бүгд алга ташив) Тиймээс өөрөө л бясалгах ёстой шүү гэдгийг би та нарт үргэлж сануулдаг. Авшиг хүртэсний дараа ч мөн өөртөө л найдна. Багшид найдах хэрэггүй. Багш нь зөвхөн зааж чиглүүлнэ, тусалж дэмжинэ, урам зориг өгнө, асуултанд чинь хариулна. Гэвч бүх эд хөрөнгө, авьяас чадвар, бүхий л гэгээрэл, билгүүн ухаан бүгд та нарынх. Энэ бүхнээ гаргаж ашиглах хэрэгтэй.

Тиймээс өөр хэнд ч найдах хэрэггүй, зөвхөн өөртөө л найд. Гэхдээ яг хаанаа найдахыг, өөрийн чадвар яг хаана байдгийг, аль багш нь бидэнд тусалж чадах, хаанаас авч болохыг зааж чадах эсэхийг мэдэх хэрэгтэй. Авшгаар, Багш нь та нарт эд хөрөнгөө хаанаас авахыг, яаж мөнгөө өдөр бүхэн авч хэрэглэхийг зааж өгнө. Яг л би нэг хүнийг дагуулаад банкинд очиж, хүснэгт бөглөхийг зааж өгвөл тэр хүн аав, ээжийнхээ үлдээсэн мөнгийг авч чадна. Энд би зөвхөн тусалсан төдий. Түүний эд хөрөнгөтэй өчүүхэн ч хамааралгүй. Тиймээс хэн нэгэн хүн үүнээс өөр ёс журмыг танд сургаж байвал түүнийг би хууран мэхлэгч гэж үзнэ. Хүнийг сургавал шуудхан, чамд ийм ийм их эд баялаг бий, чи юм бүхэнтэй, үүнийгээ яаж ашиглахыг бас мэддэг байх хэрэгтэй гэж тодорхой сайн хэлж өгөх хэрэгтэй. Ингэж сургах нь хамгийн зөв. Тэрнээс, “Би чамд ид шид өгнө”, “Би чамайг идтэй шидтэй болгоно” гэх мэтээр бусдыг хуурч болохгүй. Хэн ч, хэнд ч юу ч өгөхгүй, бас юу ч заахгүй. Бид бүгдээрээ Бурхад. Зөвхөн Бурхан хаана байдгийг мэдэхгүй л яваа болохоос. Хэрвээ та бүхэн Бурхан хаана байдгийг мэдмээр байвал Багш нь дуртайяа хэлж өгнө. (Бүгд алга ташив.)

Долоодугаар бүлэг

ЦАГ ХУГАЦАА, ОРОН ЗАЙНААС ХЭТИЙДСЭН ТҮШМЭЛ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Тайчун хот.1988 оны 6 дугаар сарын 8
(Эх нь хятад хэлээр)

Мөр гэмээ нь мөр биш

Намайг “Хималайн нуруунаас ирсэн Их Багш” гэж танилцуулахыг сонсоод би айдаг. Багш нь ийм жижигхэн, та нар харж байгаа шүү дээ. Бид том биетэй, мах мариатай, сүрлэг эрхэмсэг Багшид дуртай. Гэтэл жижигхэн биетэй, ийм туранхай Их Багшийг олж харав. (Багш болоод бүгд инээлдэв.) Та бүхнийг гонсойлгосонд уучлаарай. Ийм байдал нь харин ч “мөр гэмээ нь мөр биш” болж, биднийг үнэхээр алмайруулав.

Бид бодохдоо авшиг уламжилж чадах хүн, эсвэл Их Багш гэгдэгч нь сүрлэг өндөр биетэй, зүс царай сайтай, өтгөн

хөмсөг, том нүдтэй байх ёстой. Гэтэл энэ зам мөр гэдэг чинь нилээд адармаатай. Тэр сонгох хүнээ л сонгоно, түүний царай зүс нь гоё сайхан, үзэсгэлэнтэй байх ер хамаагүй. Тиймээс зарим үед зөвхөн гадна үзэмжийг харвал дотоодыг нь дүгнэхэд амаргүй болно.

Найман аршийн нэг Ли Тиежан тун царай муутай. Арван найман архад бол Шагжамуни Буддагийн хамгийн гарамгай шавь нар. Тэд ч бас тийм царайлаг биш байжээ. Түүнээс гадна Гуан Чининь хуврагийг та нар сайн мэднэ. Тэр яг Багш шиг нь намхан, туранхай хүн байсан. Хачин хурдан алхдаг, нисэх мэт явах тул бид түүнийг гүйцэхгүй.

Та нар бүгд: “Багш аа! Танд ид шид байна уу?”, ”Та нисэж чадах уу?” гэж асуудаг. Би шидгүй гэвэл хэн ч итгэхгүй, иймээс өнөөдөр би машинаар ирсэн, баруун зүгийн орноос нисээд ирээгүй (бүгд инээлдэв) гэдгээ дахин онцолж хэлье. Машинд суувал миний толгой эргэж дотор муухайрдаг. Энэ бүхнээ тодорхой хэлбэл надаас та нар шид хүсэхээ болино. Хэрвээ шид сурах хүсэлтэй бол намайг дагах хэрэггүй. Би үнэнээ ил хэлнэ, хүнийг мэхлэхгүй. Би өдөрт заавал хооллоно. Өлсөхгүй ч идэх хэрэгтэй. Эс бөгөөс энэ бие махбод хэмээх машин доройтож муудна. Яг л машиндаа бензин хийхтэй адил, хичнээн чадварлаг жолоочтой байсан ч заавал бензин хийнэ. Учир нь машинд бензин хэрэгтэй. Үүнтэй жолооч хамаагүй. Тиймээс Багш нь ном айлдахаар явбал машинд сууна, нисээд очихгүй. Түүнээс гадна энэ бие тийм ч сайхан царайлаг, өндөр том, махлаг тарган биш. Сар шиг мэлтийсэн буянтай царай ч алга. Тиймээс өнөөдөр би энэ талаар нилээд бодлоо. Би ер нь энэ ажилд тохирохгүй ч юм шиг, энэ “бизнес” миний мэргэжил биш ч юм шиг, ер нь би тааруухан хийгээд байгаа ч юм шиг санагдав. Гэсэн ч шавь нар намайг үргэлж тайз руу түлхэн гаргадаг. Одоо ч бас ном айлдахаар явах гэж байна. Тэтгэвэрт гарах арга алга, гаръя гэсэн ч яаж гарахаа мэдэхгүй байна. Яг

л та нар шиг, заримдаа гэрлэх хүсэлгүй байдаг. Гэрлэвэл хүүхэдтэй болно. Хүүхэд өсгөж хүмүүжүүлэх тун амаргүй ажил. Өсгөхгүй байж болохгүй, заавал өсгөж хүмүүжүүлэх үүрэгтэй. Тэр үед дэндүү оройтсон байх тул нөхцөл байдлыг өөрчлөх аргагүй болдог.

Багш нь ч одоо бас ижилхэн байна. Аль хэдийнээ шавьтай болсон учраас тэднийг цаашид сургах хэрэгтэй. Сургах явцад шинэ хүмүүс нэмж ирнэ. Дахин эхнээс нь сургана. Жаахан юм сургаж байтал дахиад шинэ хүн ирнэ. Улам олуулаа болж, тасралтгүй үргэлжилнэ. Энэ бизнес зогсоход хэцүү бизнес. Алдагдалтай эсэхээс үл хамааран заавал үргэлжлэх ёстой. Та нарын бизнес хийдэгтэй яг ижилхэн.

Шагжамуни Будда гучин хоёр найраг төгс лагшинтай гэж сонссон. Багшид нь ганц ч найраг төгс лагшин алга. Түүний тэргүүн дээр нэгэн бөмбөгөр зүйл товойж гарсан гэж сонссон. Гэтэл Багшид нь байна уу, хар даа? Байхгүй юм шиг байна! Түүний магнайн голд гуравдагч мэлмий байдаг гэж сонссон. Багшид нь байна уу, үгүй юу, та нар сайн хараарай? Бас л байхгүй юм шиг байна! Ийм байхад Багшийг нь Будда гэж хэлэх хүн бас байх юм. Шагжамуни Буддагийн найраг төгс лагшин гэж юуг хэлнэ вэ? Үүнийг бид эгэл хүний нүдээр харахгүй. Багшид нь шид байгаа эсэхийг та бүхэн харж чадна. Гэвч шид бол гурван ертөнцийн доторх зүйл. Шидгүй бол харин сайн. Лууз: “Их билгүүн хүн тэнэгдүү харагддаг” гэжээ. Магадгүй Багш нь бас их билгүүн хүн байх. Учир нь мэдэх юм юу ч байхгүй, тиймээс их билгүүн гэсэн байх.

Нэгэн хүн хоёр ертөнцөд байхуй

Уг нь бид нэг л хүн, гэвч оюун ухаанаа жинхэнэ би

хэмээн эндүү бодсоноос хоёр хүн болчихоод байна. Нэг нь энэ дэлхийд ажиллана, хооллож ундална, машин барина, гэрлэнэ, хүүхэд төрүүлнэ, эх орноо хамгаална, биеэ засна, төрөө төвхнүүлнэ, хорвоо дэлхийг төвшитгөнө. Нөгөө нь өөр нэгэн дэсэд, өөр нэгэн төвшинд байж, маш их зүйлийг хийж бүтээх боловч хэн ч үүнийг нь мэдэхгүй, бид өөрсдөө ч бас мэдэхгүй. Тэр бол бидний жинхэнэ эзэн мөн. Жишээ нь, зарим хүн энэ дэлхийд эрхэм дээд алба хашна, эсвэл өөр олон ажил хийнэ. Гэтэл түүний нөгөө бие нь өөр ертөнцөд өөр ажил хийж байдаг.

Шагжамуни Будда амьд сэрүүндээ бодь модны дор, эсвэл өөр газарт ном айлдаж байхад өөр нэгэн бие нь Тушита тэнгэрийн оронд өндөр төвшний төрөлтнүүдийг сургаж байдаг байсан гэж сонссон. Түүнээс гадна, зарим нэг хүн энэ дэлхийд цагдаа, эсвэл энгийн иргэн байх атлаа тамын ертөнцөд шүүгч хийнэ, эсвэл өөр нэгэн ертөнцийн гэгээнтэн, хувилгаан байдаг тухай бид бас сонссон.

Вэй Жэн Лусын хааны толгойг авсан нь

Миний уншсан нэгэн номд, нэг луу хүний ертөнцийг түйвээж, олон хүмүүст яршиг төвөг тарьсан тухай бичсэнийг санаж байна. (Тан улсын Тайзун хааны үед бороо усыг хариуцсан лусын хаан Фэнхэ, Хурмастын хааны зарлигийг дагалгүй, энэ дэлхийд асар их бороо оруулж, олон ардыг хохироожээ). Тиймээс Хурмастын хаан, Вэй Жэн чансанг илгээж, Лусын хааны толгойг авч ирэхийг даалгав. Лусын хааны толгойг авах хүн заавал онцгой нэгэн байх хэрэгтэй. Лусын хаанаас илүү өндөр заяатай, илүү хүч чадалтай бол түүний толгойг цавчиж чадна. Лусын хаан бол энгийн нэгэн бодгаль биш, маш их сүнслэг төрөлтөн учраас жирийн хүн түүнийг хороож чадахгүй.

Лусын хаан үүнийг мэдээд Тан улсын Тайзун хаанд очиж, аврал гуйн мөргөжээ. Тэрээр: “Маргааш үдийн үед Вэй Жэн ирж, миний толгойг авна, гэвч би үхмээргүй байна, та надад туслаач, маргааш Вэй Жэнг энд бүү ирүүлээч” гэж гуйв. Тэрээр зүүдэндээ Тан улсын Тайзун хаанд ингэж хэлжээ.

Тан улсын Тайзун хаан, Лусын хаанд туслах арга сүвэгчилэв. Хоёр дахь өдрийн үдийн хоолны дараа Тайзун хаан, Вэй Жэнг урьж, шатар тогложээ. Зорилго нь шатар тоглоод үд өнгөрвөл Лусын хааны толгойг авахаар Вэй Жэн явахгүй. Тэгэхээр түүнд айх юмгүй болно гэж боджээ. Гэтэл яг тэр үед Вэй Жэн нам унтжээ. Тан улсын Тайзун хаан түүний унтсаныг хараад аюулгүй боллоо гэж бодоод орхин явжээ.

Вэй Жэн унтаж байхад түүний эзэн нь, өөрөөр хэлвэл сүнс нь гарч яваад Лусын хааныг хороосон байна. Буцаж ирэхдээ гар нь цусанд будагдсан байжээ. Тан улсын Тайзун хаан хараад жаахан эргэлзсэн ч өөртөө итгэсэнгүй. Учир нь хаан бясалгал хийдэггүй тул ихийг үл мэднэ. Тэр өдрийн орой Лусын хаан дахин зүүдэнд нь ирж ярив гэнэ. Тэр: “Би танаас туслахыг гуйсан, гэвч та тусалсангүй, би алагдав” гэжээ. Тан улсын Тайзун хаан: “Хэзээ тэр вэ?” гэж асуухад Лусын хаан: “Вэй Жэн унтаж байхдаа ирж намайг алсан” гэж хариулжээ.

Тиймээс бидний алхах, зогсох, суух, хэвтэх бүгд даяан. Зарим хүн унтаж байхдаа маш их зүйлийг хийдэг. Чин улсын үеийн Үйлан Их Багш зүгээр л унтах ажилтай байжээ. Гэвч тэр бүгдийг мэддэг. Бүгдийг ойлгодог. Тиймээс бид яг хоёр хүн шиг байдаг. Нэг нь эгэл жирийн энэ хүн. Нөгөө нэг нь бидний оюун ухаантай холбоогүй, бидэнд захирагдахгүй, юу хийхийг нь зааж болдоггүй, тэр бол бидний жинхэнэ эзэн юм.

Их Багш бол амин холбоог тусгайлан сэргээн засагч

Бидний эзэн угаасаа маш эрхэм дээд. Тэр тэнгэрийн элч, бодьсадва, хувилгаан арш болж болно, зарим нь газрын хувилгаан, зарим нь тэнгэрийн хувилгаан, зарим нь бодьсадва, зарим нь архад, зарим нь будда байдаг. Ийм нэг эгэл хүн бол биш.

Энэ эгэл хүн өөр нэг тэр хүнтэй холбоотой. Гэхдээ заримдаа энэ холбоо тасардаг. Цахилгааны утас шиг. Цахилгааны утас тасарвал микрофон дуугарахгүй, гэрэл асахгүй. Харин нэг хүн утас тасарсан тэр газрыг олж мэдээд бидэнд тусалж залгаж өгвөл ашиглах боломжтой болно. Бид өөрийн жинхэнэ эзэнтэй угаасаа холбоотой байдаг. Гэвч заримдаа дэндүү бүдүүлэг, элдэв муу үйл үйлдээд уг амин холбоог бид өөрсдөө тасалдаг. Ингээд дараа нь их хүч үгүй болж, ихэд ганцаардан сул дорой болно.

Их Багш энэ амин холбоог сэргээн засаж, жинхэнэ эзэнтэйгээ дахин холбогдоход бидэнд тусалдаг. Тэр хоёр дахь хүнтэйгээ холбогдвол бид эгэл жирийн хүний байр суурiас орчлонд өөрийн эзлэх ёстой жинхэнэ байр суурийг дахин олж авна. Хэрвээ бидний эзэн хувилгаан арш байсан бол холбогдох агшиндаа хувилгаан аршийн хутгийг мэднэ. Би хялбараар зүйрлэвэл, Их Багш бол тусгайлан хүмүүсийн амин холбоог сэргээн засагч юм. Жишээ нь, бид өмнөх төрөлдөө бясалгаад газрын хувилгааны төвшинд хүрсэн, эсвэл одоогийн төвшин нь газрын хувилгааны хутагт хүрсэн бол холбогдох үедээ буюу амин холбоо нь сэргэхдээ газрын хувилгаан болохоо гэнэт сэрж ухаарна. Хэрвээ бид угаасаа архад байсан бол холбогдсоныхоо дараа буюу амин холбоог сэргээсний дараа өөрийгөө архад болохыг гэнэт сэхээрнэ.

Мэднэ, гэхдээ энэ нь жирийн цэцэн мэргэн мэдлэгээр мэдэхтэй адилгүй. Мэднэ гэдэг нь өөр нэгэн мэдэлт, өөр нэгэн билиг ухаан юм. Оюун ухаанаар ойлгох биш, оюун ухаанаар илэрхийлчих биш, үг хэлээр тодорхой тайлбарлах биш юм. Зөвхөн гэгээрэх тэр агшиндаа бид хүлээж авна, ойлгоно, сэхээрнэ. Тиймээс “Даяанд үг хэл хэрэггүй”, “Мөр гэмээ нь мөр биш” гэж ярьдаг. Жишээ нь, бидний эзэн угаасаа Будда байж болно, яагаад болохгүй гэж? Шагжамуни Будда төрөлтөн бүхэн бурхан чанартай гэж айлдсан. Магадгүй бид угаасаа Будда. Зөвхөн бид мэдэхгүй л байгаа болохоос. Хэрвээ бидний эзэн угаасаа Будда бол сэргээн засахад, холбоход бид Будда гэдгээ сэрж сэхээрнэ. Энэ их амархан. Тийм учраас л даяаны багш нар “Агшин зуур гэгээрэх” нэгэн зүйлийн номын ёсны тухай ярьж, агшин зуур гэгээрч болно. Мөн чанараа үзэж бурхан болно. Агшин зуур Будда болж болно гэж ярьдаг юм. Энэ бол тэд тоглоом наадам хийсэн явдал огт биш. Бас тэд бидэнд худал ярьж, мэхлээгүй юм. Үүнийг бид өнөөдөр бас ахуй ойлголтоор ойлгож болно. Эртний хүмүүсийн ахуй ойлгож байсныг орчин үеийн хүмүүс бид ч бас ахуй ойлгож болно.

Эртний хүмүүс бидэнтэй яг адил амтай, хамартай, нүдтэй, чихтэй, бүх юмтай. Бидэнтэй яг адилхан алхана. Өнөөгийн биднээс ялгараад байх юм байсан уу? Байхгүй, хувцас нь л өөр байсан байх. Гэвч хувцас бол гадна талын зүйл, бидний уг хүнтэй хамаагүй. Тиймээс бид шар хувцастай ч гэгээрнэ. Хүрэн хувцастай ч гэгээрнэ. Жийнсэн өмдтэй ч гэгээрнэ. Учир нь бидний уг хүн хувцасгүй. Бидний уг хүн яг л хүүхэд шиг гэнэн итгэмтгий, ариун цагаан байдаг. (бүгд алга ташив) Тиймээс бид эртний бясалгагч хүмүүс ямар нэгэн хутагтын суурind хүрсэн, зарим нь хувилгаан болсон, зарим нь бодьсадва болсон, зарим нь хутагт болсон, зарим нь будда болсон тухай сонссон. Учир нь тэд өөрийн амин холбоог сэргээсэн хэрэг. Ийм л юм. Тэдэнд тусгай нэгэн хүн байдаг бөгөөд тасарсан амин холбоог нь сэргээн

засаж өгдөг. Цахилгааны утсыг мэргэжлийн хүн залгадагтай ижил.

Эртний хүмүүс гэгээрэх үедээ ямар нэгэн үрийн хутгийг олдог тухай бид сонссон. Жишээ нь, Шагжамуни Буддаг ном айлдсаны дараа хичнээн хүн бодьсадвагийн хутагт хүрсэн, хичнээн хүн архадын хутгийг олсон, хичнээн хүн шравакийн хутгийг олсон гэх мэт. Энэ бол нэг зүйлийн бясалгалын үрийн хутаг болно. Гэвч тэд үргэлж тэндээ зогсоод байхгүй. Хэрвээ хичээнгүйлэн сайн бясалгавал өөрийн билиг ухаан, өөрийн хүрэх хутагтын суурийг тасралтгүй дээшлүүлж болно.

Бид эдгээр ном судрыг уншаад ихэд баясаж, аз жаргалыг мэдэрч, сэтгэл хөдөлж, бид ч бас ижилхэн ахуй ойлголт үзэж чадах болов уу? гэж өөрөөсөө асуудаг. Тэгэхээр ном судар ч бас ач тустай юм. Бид ном судар уншихдаа зарим нэгэн төвшин нь дэлхийн байдлаас өөр болохыг олж хардаг. Зарим төвшин үнэхээр үзэсгэлэнтэй, найман эрдэнийн рашаантай, бяцхан шувуухайнууд нь хүний хэлээр ярьдаг, орд өргөө нь алт, биндэръяа, болор, мана, хув зэрэг найман эрдэнээр бүтсэн. Хүмүүс нь ~~нь~~ чөлөөтэй ниснэ, хүссэн газартаа агшин зуур хүрнэ, үг хэлний хэрэггүй, найз нөхөд бодлыг дор нь ойлгоно. Ийм дэсэд хүрвэл хичнээн сайхан бэ, эхнэр, нөхөртэйгөө тун хялбар ойлголцоно. Заримдаа бид үг хэлээрээ ойлголцож чаддаггүй, хэн хэн нь ярих тусам улам буруу ойлгодог. Тийм учраас ном судар унших нь бидэнд бас хэрэгтэй.

Бодь сэтгэл үүснэ, бясалгамаар санагдана, ижилхэн ахуй ойлголттой болохыг хүснэ. Энэ үед ном судар бидэнд тун их тустай. Зургадугаар үеийн Их Багш Хүй Нэн "Очир огтлогч судар"-ын ганц өгүүлбэрийг сонсоод гэгээрсэн гэдэг. Тэгээд Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олох хэрэгтэй, түүнтэй ижилхэн ахуй ойлголттой байх ёстой гэж ойлгосон байна. Энэ бол гэгээрсэн мөч мөн. Гэгээрээгүй

бол Их Багшийн дэргэд байсан ч ашиггүй, ойлгохгүй, бас гүтгэн муулах санаа агуулна. Ийм бол гэгээрээгүй хүн. Тэгэхээр номын айлдвар сонсоод бас гэгээрч болно, ном судар уншаад бас гэгээрч болно. Гэхдээ энэ бол өчүүхэн бага гэгээрэл. Зөвхөн бясалгах урам зориг төрсөн төдий. Эртний хүмүүс бясалгалаараа ямар хутагтын суурind хүрснийг мэдэх хүсэл төрөх төдийхөн. Гэхдээ л гэгээрсэнд тооцогдоно. Гэвч бидний ихэнх нь гэгээрэхийг маш агуу явдал гэж ойлгодог. Тийм ч учраас өөрийгөө голж, бас л гэгээрээгүй байна гэцгээдэг. Энэ нь илтэд туулсан хамгийн дээд төвшинд хүрээгүй байгаатай холбоотой юм.

Хүн гэгээрэх тусам илүү сэхээлэг болдог

Илтэд туулан гэгээрч, Бурханы хутагт хүрвэл, хутагтын суурind хүрвэл хэзээд алдахгүй, хэзээ ч уналд орохгүй. Бид нэгэн агшнаа гэгээрч болно, гэхдээ илтэд туулсан хутагтын суурind хүрээгүй бол гэгээрлийн тэр нэгэн дэсээ удалгүй мартаж, бодол санаа эгэл хүнийхээс ялгаагүй болно. Тиймээс заавал илтэд туулсан Бурханы хутагт хүрэх хэрэгтэй. Юуг илтэд туулах гэх вэ? Бид хутагтийн суурind хүрч, дотоодын ахуй ойлголтыг олж, диваажингийн төвшинд хүрч, Бурханы орны дэсэд хүрэхийг илтэд туулах гэнэ.

Бид илтэд туулах тусам улам гэгээрнэ, гэгээрэх тусам сэхээлэг болж, орчлон хаанаас үүсэлтэйг илүү тодорхой ойлгож, өөрөө анх хаанаас ирснээ, бас хаашаа одохоо мэдэх болно. Ном судар уншсан ч бясалгаж гэгээрэх бодь сэтгэл үүсэхгүй, дээд дэсийн ахуй ойлголтыг олох хүсэл эрмэлзлэл төрөхгүй бол судар уншаад ач тусгүй байна гэсэн үг. Хэрвээ судар уншаад бясалгаж гэгээрэх чин сэтгэл төрж, эртний хүмүүсийн адил ахуй ойлголттой болохыг хүсэж байвал судар уншсаны хэрэг гарна.

Зөвхөн эртний хүмүүс л ахуй ойлголттой байдаг гэж бүү бод, орчин үеийн хүмүүс ч ахуй ойлголттой болж чадна. Миний шавь нар ч эртний хүмүүстэй ижилхэн ахуй ойлголттой. Өчүүхэн ч ялгаагүй. Эртний хүмүүс баруун зүгийн Төгс бясгалант орныг хардаг байсан бол манай Арьяабалын аргаар бясалгаж буй шавь нар ч бас баруун зүгийн Төгс баясгалант орныг харж чадна. Зарим шавь такси жолоодож явахдаа л баруун зүгийн Төгс баясгалант орныг хардаг. Зарим нь газар хагалж байхдаа баруун зүгийн Төгс баясгалант орныг хардаг. Бүр цагдаагийн ажил дээрээ ч баруун орныг харсан хүн байна. Өндөр дээд албан тушаалтан, эгэл жирийн хүн аль нь ялгаагүй баруун зүгийн Төгс баясгалант орныг харж чаддаг. Ямар нэгэн ялгаварлал байх ёсгүй юм.

Шагжамуни Буддагийн шавь нар зөвхөн хуврагууд байгаагүй. Олонх нь гэрээс гараагүй бодьсадва нар байсан. Өнөөдөр гэртээ байгаа хүн ч бясалгаж болж байгаатай адилхан. Би та бүхэнд Арьяабалын бясалгалын арга үнэхээр их ач тустай гэдгийг илтгэн хэлье. Миний хэлж байгааг шавь нар маань бүгд мэднэ. Учир нь тэд өөрийн гэсэн ахуй ойлголттой, тэд мөн маш их талархдаг учраас Багшийг яримагц алга ташдаг.

Арьяабалын бясалгалын арга биднийг баруун зүгийн Төгс баясгалант оронд дагуулан хүргэж, Авид Бурхантай уулзуулна. Хэрвээ Есүс Христ Багшид дуртай бол тэр бас биднийг дагуулан тэнд хүрч, Есүс Христ Багштай уулзуулна. Хэрвээ бид Лууз Багшид дуртай бол тэр бас биднийг Лууз Багштай уулзуулж өгнө. Бид Күнз богд, Жидаан богд болон бусад бурхан бодьсадва, ер нь хэнд л дуртай байна, тэнд биднийг дагуулан хүргэнэ. Энэ “Зам мөр”-д ялгаварлал гэж үгүй.

Зам мөрд ялгаварлал үгүй

Хэрвээ нэгэн “Зам мөр” нь зөвхөн буддын шашинтнуудыг л гэтэлгэдэг бол тэр “Зам мөр”-д ялгаварлал байна гэсэн үг. Тиймээс эгэл хүмүүс бид энэ “Зам мөр” тийм явцуу, ийм хавчиг, баясгалангүй, манай бурхны шашин сайн, католик шашин муу гэж бодож болохгүй. Иймэрхүү шүүмжлэл нь бүгд бид “Зам мөр”-ийг үл ойшоосон, Эзэн Бурханыг үл ойшоосон, Бурхан бодьсадваг дорд үзсэн хэрэг мөн. Эгэл хүний сэтгэлээр Бурхан бодьсадвагийн сэтгэл зүрхийг хэмжиж, эгэл хүний сэтгэлээр тэнсэлгүй дээд энэрэл нигүүлсэл, цаглашгүй их хайрын хүчтэй Эзэн Бурханыг дэнслэхийг оролдож байна. Тиймээс бидний хэлэх үг логиктой байх ёстой. Тэгвэл хүмүүс хүндэлнэ. Замбараагүй зүйл ярих хэрэггүй. Бидний дэс тун доогуур болохыг хүмүүс мэдчихнэ.

Багшийнх нь ярьж буй Арьяабалын бясалгалын арга бол жинхэнэ “Зам мөр” мөн. Учир нь түүнд ялгаварлал байхгүй. Католик шашинтай хүн Багшаас нь сурахаар ирвэл Библийн сударт дурдсан ахуй ойлголтыг олж үзнэ, Игуандао шүтлэгтэн ирж суралцвал Ванму ээж, Жидаан богд, Хунлэ бурхан зэрэг өөрсдийн дуртай гэгээнтэнтэй уулзана, Буддын шашинтан хүн ирж Багшаас нь суралцвал Арьяабал бодьсадва, Авид Бурхан, Шагжамуни Буддатай уулзана, Лууз, Күнзийн сургаалтан ирвэл тэд бас өөрсдийн хайртай сургаалын эзэдтэй уулзаж чадна.Тиймээс би Арьяабалын бясалгалын арга нь баян хоосон, хөгшин залуу ялгалгүй бүх хүнийг ахуй ойлголттой болгодог ялгаварлалгүй номын ёс гэдэгт зуун хувь итгэсэн. Багшийнх нь хамгийн бага шавь таван настай, тэр бас “Эрхэт мэлмийгээр болгооч бодь сэтгэлтний тийн хувилгаанаар үзүүлсэн хотол зүйл” дэх ахуй ойлголтуудыг олж үзсэн юм. Тав, зургаан настай хүүхэд худлаа ярьж мэдэхгүй, тэр бас Арьяабал бодьсадваг харж, Махастхамапрапта бодьсадватай уулзжээ. Арьяабал

бодьсадва болон бусад бодьсадва бүгд тэдний найзууд. Хүүхдүүд бурхадтай тун ойрхон байдаг, танимхай байдаг. Хамгийн ахмад шавь 80 настай эмээ бий. Тэр ч бас ахуй ойлголттой, бас Бурхан бодьсадваг хардаг. Ганц тэр ч биш, ахмад настай өөр олон авшигтнууд бүгд ийм байдаг. Заримдаа ахмад настай хүмүүс Бурхан бодьсадваг амархан хардаг нь тэдний зүрх сэтгэл хоосроод энэ ертөнцийн жамыг гүн ойлгож, өчүүхэн ч хоргодох юм үгүй, амьдралын хором бүхэн үнэ цэнэтэй болж, амжихаа больсноо ухаарсан зүрх сэтгэл нь яарч, туйлын их хүсэн хүлээдэг зэрэг нь Бурхад бодьсадваг ихэд баярлуулжээ. Сайн ахуй ойлголттой настнууд олон байдаг. Залуучууд хүртэл атаархмаар. Гэхдээ залуу хүн сайн ахуй ойлголттой байх боломжгүй гэсэн хэрэг бас биш. Ерөөс, баян хүн, ядуу хүн, эр, эм, хөгшин, залуу ямар ч хүн өндөр дэсийн ахуй ойлголт болж болно.

Арьяабалын аргад үнэхээр өчүүхэн ч ялгаварлал байхгүй. Шашин шүтлэгээр ч ялгаварлахгүй, нас сүүдэр, баян ядуу, сайн муугаар ялгахгүй. Зарим нь насаараа амьтан алсан ч гэм нүглээ агшнаа ухаарвал ярганы хутгаа хөсөр хаяад тэр даруй маш сайн ахуй ойлголттой болж байжээ.

Арьяабалын бясалгалын арга нь их нигүүлсэнгүй, их энэрэнгүй, ихэд гэтэлгэгч номын цогц мөн. Учир нь ийм олон төрөлтөн ач тусыг нь хүртэж, ийм олон хүн сайн ахуй ойлголттой болсон учраас шавь нар маань Багшийг залж, газар бүхэнд ном айлдуулдаг. Хамаг төрөлтөнд ач тустай байгааг хараад Багш нь ч бас их баярладаг юм.

Бурханаас суралцах нь Бурханы хутагт хүрэхийн төлөө

Арьяабалын бясалгалын арга бол эгэл хүнийг Будда болгон хувиргадаг цорын ганц номын цогц гэдэг нь

баталгаатай үнэн. Энэ нь үнэхээр логикт нийцнэ. Бид үүнд итгэх хэрэгтэй. Бид бүгд угаасаа бурхан чанартай гэдгийг сонссоор ирсэн. Тэгвэл яагаад бид Будда болж чадахгүй байх вэ? Маш олон хүн Бурханаас суралцдаг. Гэвч хэн ч Бурханы хутагт хүрч зүрхэлдэггүй. Хэн нэгэн хүн Бурханы хутагт хүрсэн гэж сонсвол бид маш их эргэлзэж, өндөр дуугаар гүтгэн буруутгаж, адал явдалтай үйлдэл олныг гаргадаг. Бурханаас суралцаад бурхан болохгүй бол өөр юу болох вэ? Буг болох уу? Бурханаас суралцвал Бурханы хутагт заавал хүрэх ёстой!

Анагаахын шинжлэх ухаанд суралцвал эмч болно, хуулийн мэргэжил эзэмшвэл хуульч болно, таксины жолоочийн дамжаанд сурвал таксины жолооч болно, гэрлэвэл эхнэр, эсвэл нөхөр болно, тэгвэл Бурханаас суралцаад яагаад Бурхан болохгүй байх билээ? Гэвч өнөөдөр Бурханы номд суралцаж байгаа хүн нь өөрөө бурхан болж зүрхлэхгүй, бусдыг ч бурхан болно гэдэгт итгэхгүй, хэн нэгнийг Бурханы хутагт хүрсэн гэж сонсвол яг галд шатсан мэт дүрсхийн хүлээж авахгүй, итгэхгүй байдаг. Яагаад итгэхгүй байна вэ? Шагжамуни Будда: “Төрөлтөн бүхэн бурхан чанартай” гэжээ. Тэгвэл хүмүүс бид яагаад бясалгаад Бурхан болж болохгүй байх вэ? “Богдосын ном цагаан лянхуа судар”-т: “Лусын охин найман насандаа Бурханы хутагт хүрсэн” гэж бичсэн байдаг. Тэгвэл бид бол хүмүүн төрөлтөн, яагаад Бурханы хутагт хүрч чадахгүй байх билээ?

Хүн бол хамаг төрөлтний дээд. Орчлон дээрх хамгийн эрхэм дээд төрөлтөн бол хүн. Лусын охин найман насандаа Бурханы хутагт хүрч чадсан байна. Гэтэл бид ийм эрдэнэ мэт нандин, эрхэм ариун, нас сүүдэр өндөр, эрдэм ном ихтэй атал яагаад Бурханы хутагт хүрэх зориг зүрхгүй байна вэ? Энэ үнэхээр гайхмаар байна. Хэрвээ сайн номын ёс дутаж байвал түүнийг заавал эрж хайх хэрэгтэй. Бурханы номын ёсыг бясалгавал гарцаагүй Будда болно. Эндээс ч нэг,

тэндээс ч нэг юм сонсож явсаар, эцэст нь бид Будда болж чадахгүй юм байна гэж бодох хэрэггүй! Зөвхөн Шагжамуни Будда л бурхан болж чадна гэж ярих нь Шагжамуни Буддаг гүтгэсэн явдал мөн. Учир нь Тэрээр айлдахдаа, Бурхан энэ хорвоод мэндэлсэн нь хамаг төрөлтөнд Бурханы билгийг ойлгуулахын төлөө байдаг. Зөвхөн Бурхан л бурхны билгийг ойлгоно гэж айлджээ

Энэ нь бид Бурханы хутагт хүрч чадна гэдгийг илэрхийлж байна. Бурхан бууж ирсэн нь, биднийг Бурхан болгохын төлөө. Гэтэл бид өөрөө бурхан болж зүрхлэхгүй төдийгүй, бусдыг ч бурхан болж чадахгүй хэмээн газар сайгүй ярьж явдаг. Энэ нь Шагжамуни Буддаг гүтгэж, Түүний хэлсэн үгэнд итгэхгүй байна гэсэн үг. Би Шагжамуни Буддад зуун хувь итгэдэг. Бурханы хутагт хүрэх зориггүй хүн байвал эндээс явж болно. Харин Бурхан болох зоригтой хүн байвал бүгдээрээ хамтдаа бүтээе.

Эмч болгодог номын ёс байна, хуульч болгодог номын ёс байна, тэгэхээр бурхан болгодог номын ёс заавал байх ёстой. Гэрээс гарсан хувраг хүн сахил хүртвэл заавал Төгс Гэгээрсэн Их Багш, төгс сайн номын ёсыг хайх хэрэгтэй. Тэгж байж Бурханы хутагт хүрнэ. Зөвхөн сахил сахих нь хангалтгүй. Учир нь манай энэ дэлхийд сахилыг маш ариун сахихад тун хэцүү.

Ногоо идсэн ч амь хөнөөнө. Амьсгал авсан ч амь хорооно. Бурхан Багш: “Усанд наян дөрвөн мянга өт хорхой бий. (Эх зохиол: Нэгэн аяга усыг Бурханы нүдээр харвал наян дөрвөн мянган өт хорхой буй) Тарни уншихгүйгээр усыг уувал амь хөнөөсөн хэрэг болно” гэж айлджээ. Гэвч бид 24 цаг тарни уншиж чадахгүй. Заримдаа мартана, мартсан үедээ нүгэл хийнэ. Учир нь агаарт үй олон бичил биетэн байх тул амьсгалаараа олон амьтны амийг хөнөөж байдаг. Усанд ч мөн үй олон төрөлтөн байх тул ус уусан ч амь хөнөөнө. Ногоо тарихад бордоо цацвал бас л амь

хорооно. Иймээс энэ дэлхийд бид сахил санваарыг ариун сахиж чадахгүй.

Шагжамуни Будда хэдийгээр гэрээс гарсан ч, Будда болохын тулд заавал Арьяабалын аргаар бясалгах хэрэгтэй байсан. Арьяабалын аргаар бясалгавал Бурханы хутагт хүрнэ гэдгийг өөрийн хамгийн ойрын шавь Анандад захисан байна. Арван зүгийн гурван цагийн бүх бурхан энэ номоор бясалгаж, Бурханы хутагт хүрснийг хэлж өгсөн байна. Үүнээс бид Бурханы хутагт хүргэж чадах нэгэн номын цогц заавал байдгийг ойлгож болно. Тэр аргыг мэддэг хүнийг олж, түүгээр заалгавал бид Бурханы хутагт хүрч чадна. Энэ нь ердөө ч ер бусын нууцлаг явдал огт биш. Бид заавал эрж олох хэрэгтэй. Энэ нэгэн эрхэм нандин эрдэнэт хүний биеийг олоод хэргийг нь гаргалгүй, дэмий бүү гарздаарай.

Тиймээс Багш нь очсон газар бүртээ хүмүүст сайн мэдээ түгээж, хэрвээ итгэж байвал хамтдаа бясалгаж, энэ агуу боломжийг хамт эдлэхийг уриалж явдаг. Итгэхгүй байсан ч хамаагүй, гол нь гүтгэн буруутгах сэтгэлгүй байх хэрэгтэй. Эгэл хүний дэсэд байхдаа бид хэн нь хэн болохыг харж чадахгүй. Жишээ нь, Багш нь бурхан бол, жишээ нь шүү, та бүхэн гүтгэн буруутгавал их төвөгтэй. Тамд унаж, тэндээ тун их удах хэрэг гарна.

Наймдугаар бүлэг

БАГШ “УСАН ХӨВӨӨНИЙ ШАСДИР”-ЫН ТАЛААР

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Тайнан хот.1988 оны 4 дүгээр сарын 21
(Эх нь хятад хэлээр)

Хаан эзэн Тэнгэрийн Багшийг залав

“Усан хөвөөний шасдир”-т тэр үеийн хятад орон үлэмж их гамшигт өртөж, бороо хургүй удсанаас ган болж, олон хүн өлсөж үхсэн, мөн тэр үеийн их хаан (Сун Рэнзүн) олон ардад өглөг тарааж, тэнгэрээс гамшиг зовлонгүй болгохыг даатгаж гуйсан тухай өгүүлдэг.

Хэдийгээр эзэн хаан сайн үйл арвин ихийг үйлдсэн ч олигтой тус болсонгүй. Нэгэн хүн эзэн хаанд бумбын шашны арш, их бясалгагчийг танилцуулжээ. Арш гэдэг нь зөвхөн Күнз, Лууз-д итгэгчдийг хэлэхгүй, их бясалгагч гэсэн утгыг бас агуулдаг. Тэнгэр, газрын нуурад гүнзгий нэвтэрсэн,

эрхэм дээд ёс суртахуунтай, асар их шид, хувилгаан хүчтэй хүмүүсийг арш гэнэ.

Энэ арш бээр (Жи Жан Тэнгэрийн Багш бөгөөд Луут барс ууланд амьдарна.) Түүний хүч чадал сэтгэшгүй их, улс орондоо тусалж байгалийн гамшгийг шийдэж чадна. Сун Рэнзүн хаан ихэд баясаж, аршийг хааны ордонд залж, ард олноо гамшгаас аврахаар Хун Тайвэй-г томилон явуулав .

Хун Тайвэй Луут барс ууланд хүрвэл уулын бэлийн нэгэн сүмийг цэвэрлэж байв. Тэр сүмд олон хувраг бясалган суух ажээ. Хун Тайвэй тэднээс: Танай багш хаана байна? Би түүнд хааны ордонд морилж, ач буян үйлдэхэд нь туслах хааны зарлигийг сонсгоно гэхэд хуврагууд: “Өө! Түүнийг залах аргагүй дээ, тэр их өндөрлөг газарт суудаг. Түүний зан авир, амьдрах хэв маяг жирийн хүмүүстэй адилгүй. Хүмүүстэй холилдох дургүй. Бидэн шиг эгэл хүмүүс түүнийг залж дийлэхгүй гэхэд, Хун Тайвэй: “Энэ бол хааны зарлиг, залахгүй байж хэрхэвч болохгүй” гэхэд тэд: “Хааны зарлиг байсан ч нэмэргүй!” гэж хариулав.

Тэр хуврагууд бас тун даруухан хүмүүс байв. Тэд тайлбарлан: “Тэнгэрийн Багшийн бясалгал дэндүү хэтийдсэн учраас Түүний бодол санаа, хүч чадал жирийн хүнийхтэй адилгүй. Бид хүртэл түүнийг доош буулгаж, хамт амьдарч чадахгүй байна. Тэгэхээр та буцсан нь дээр” гэв. Гэвч Хун Тайвэй чин сэтгэлээсээ шийдсэн тул арга зам зааж өгөхийг хуврагуудаас ахин дахин шамдан гуйсны эцэст нэгэн арга зааж өгөөд: “За яахав! Хэрвээ та Их Багшийг залахыг чин сэтгэлээсээ хүсвэл хувцсаа эгэл борог хувцсаар солиод мах идэлгүй, мацаг хооллож, нэг хувин хүж бэлдээд уул руу ганцаараа явах хэрэгтэй. Таны чин сэтгэл түүний сэтгэлийг хөдөлгөвөл уулнаас бууж, хүмүүсийг аврахыг зөвшөөрч магадгүй” гэв.

Хун Тайвэй тэдний хэлснээр мацаг хоол идэж, усанд

орж, биеэ цэвэрлээд ордны түшмэлийн торгон хувцсаа хамгийн хямдхан энгийн ёрог даавуун хувцсаар сольж өмсөн даруу төлөв байдлыг илтгэж, нэгэн хувин хүж авч, ганцаар уул өөд Их Багшид бараалхахаар явжээ. Өөрийн туслагч, бараа бологчдоос ч дагуулсангүй.

Зорьсон газартаа хүрэхээс өмнө замын турш маш олон сорилттой тулгарч гэнэ. Замын хугаст хүрэхэд нэгэн бар үсрэн ирж, идэх шахав. Барнаас салаад удаагүй байтал том хорт могойд хазуулав. Жинхэнээсээ хатгаагүй ч харин түүнийг ихэд айлгажээ. Тайвэй уул руу өгсөхөө бараг больё гэж бодсон ч улс оронд нүүрлэсэн гамшиг арилаагүйг санахаар урагшлахаас өөр замгүй. Дараа нь тэрээр Тэнгэрийн Их Багштай уулзсан ч таньсангүй. Учир нь Их Багшийн бие жижиг, харахад яг л үхэр унаж, бишгүүр үлээх тугалчин хүү шиг харагдана. Хун Тайвэй Тэнгэрийн Багшаас зам асууж: “Их Багш хаана заларч байгаа бол?” гэхэд Их Багш: “Өө, би өнөөдөр түүнийг ийм ийм газар харсан, гэвч тэр одоо тогоруу унаад үүлэн дунд нисч яваа, энд байхгүй дээ” гэв.

Энэ түүх их урт. Багш нь яагаад энэ түүхийг ярьж байна гэвэл нэгт, гэгээрсэн Их Багшийг олж уулзах нь тун амаргүй гэж бид бүгд сонссон. Энэ нь үнэндээ Их Багшийн бардам ихэмсэгээс болоогүйг бид ойлгох хэрэгтэй. Шагжамуни Будда Бурханы хутагт хүрснийхээ дараа уулнаас буух мөн дургүй, хамаг төрөлтнийг гэтэлгэхгүй, ном уламжлахгүй, ер нь юу ч хийх хүсэлгүй байжээ.

Тэр зөвхөн нирваанд орохыг хүсэж байв. Нирваанд орох нь таалал төгсөх биш. Нирваан хоёр янз байдаг. Нэг нь бага нирваан, нөгөө нь их нирваан. Бага нирваан гэдэг нь өдөр бүр бясалгаж, самадид ороод бурхны оронд очиж, баяр жаргалыг эдлэн баясаж, бие, сэтгэлийн амар амгаланг эдлэх явдал юм. Үүнийг өдөр бүр хүртэж болно.

Их нирваан гэдэг нь бидний амьд явах хугацаа дуусч, энэ ертөнцөөс салан одохыг хэлнэ. Энэ бол жинхэнэ нирваан болно. Шагжамуни Будда нирваанд орно гэдэг нь тэр өдөр таалал болно гэсэн хэрэг биш. Ийм санаа биш шүү. (Бүгдээрээ инээв.)

“Усан хөвөөний шашдир”-т өөр нэгэн түүх гардаг. Лияо, Луо Жэнрэнийг хороосон тухай. Гадагш гартал нэгэн хүүхэд уйлж байжээ. Хүүхэд: “Та яагаад миний Багшийг хөнөөчихөв өө?” гэхэд Лияо өнөөх хүүхдийг бас хөнөөжээ.

Энэ хэсэг түүх юуг өгүүлнэ вэ? Эндээс хүмүүс бид хичнээн бүдүүлэг, бодлогогүйг харж болно. Луо Жэнрэн хэзээ ч харгис муу үйл хийгээгүй, тэр мацаг хоолтон байв. Ууланд олон жил бүгж, ертөнцийн явдалд үл оролцож, нэгэн үзүүрт сэтгэлээр бясалгал үйлдэхийг л бодож байжээ. Үнэндээ Лияо тэр хоёрт ямар ч холбоо сүлбээ байгаагүй. Луо Жэнрэн шавь нараа нам сэлүүн бясалгуулахын тулд уулнаас буулгахгүй, амьтны амь хөнөөлгөхгүй, ертөнцийн элдэв явдалд оролцуулдаггүй байв. Энэ нь зөв, ердөө ч буруу биш. Гэрээс гарсан хувраг хүн угаасаа амь хөнөөх ёсгүй. Үүнийг бүгд мэднэ. Гэвч хүмүүс маш бүдүүлэг, өөрийгөө байнга хянаж чаддаггүй. Энэ бол маш төвөгтэй явдал.

Их Бясалгагч хүмүүсийн ихэнх нь энэ ертөнцөд бууж ирэхийг зүрхэлдэггүй, хүмүүсийг гэтэлгэхийг зориглодоггүй нь үхэхээс айсан хэрэг биш юм. Хүмүүс Шагжамуни Буддаг хорлохыг оролдож байсныг бид мэднэ. Зургадугаар үеийн их өвгө Багш Хүй Нэнг ч бас хөнөөхөөр мөшгөж байсан. Есүс Христийг хүмүүс загалмайд цовдолж хөнөөсөн. Күнз, Луузыг тэр үед олон улс орон хүлээн авахаас татгалзаж, хөөж, сүрдүүлж, доог хийж байв. Гэвч тэд энэ бүхнээс эмээгээгүй. Харин хамаг төрөлтнийг гэтэлгэх нь хэцүү учраас айж байжээ.

Бид түүх уншвал ойлгоно. Ямар ч Их Багш гарч ирээд

ном айлдан хамаг төрөлтнийг гэтэлгэхэд үнэхээр амаргүй, бүгд тун их саад бэрхшээлтэй тулгардаг. Тийм учраас л гэгээрсэн Их Багшийг олох амаргүй гэж ярьдаг юм.

Зугтах аргагүй хувь заяаны үүрэг

Зарим хүн заавал ил гарч ном дэлгэрүүлэх үүрэгтэй байдаг. Түүний хувь тавилан ийм юм. Гарахгүй байж болохгүй. Багшийг нь даяан хийж байхад хэсэг хүн ирж, илчилсэн тухай түрүүн та нар сонссон. Үнэндээ энэ нь тэдний буруу биш, харин Арьяабал бодьсадвагийн буруу юм. Арьяабал бодьсадва газар орныг зааж өгсөн учраас тэд Багшийг нь олж чадсан. (Багшийн намтар хэсгээс уншиж болно) Бид зөвхөн хүний нүднээс л нуугдаж чадна, Бурхан бодьсадвагаас нуугдаж чадахгүй. Хаана ч нуугдсан тэд мэднэ. Хэрвээ Арьяабал бодьсадва хэлсэн бол би өөрийгөө ид шидийн хүчээр ч нууж чадахгүй. (бүгд алга ташив) Нилээд олон удаа ингэж илчлэгдсэний дараа гарч, ном дэлгэрүүлэхээс өөр аргагүй болсон. Дахиж нуугдаад ямар ч нэмэргүй болов. Заавал нэг асуудал гарна, ялгаа байхгүй. Яг л Луо Жэнрэнтэй адил. Тэрээр шавь нараа уулнаас бууж, Лиан Шанбо-гийн хүмүүст туслахыг зөвшөөрөөгүй. Эцэст нь бүдүүлэг Лияо-д алагддаг.

Гэвч та бүхэн санаа бүү зов. Луо Жэнрэн үхээгүй, тэрээр өөрийн биеийг хоёр хулуугаар орлуулж, нэг хулууг өөрийн бие, нөгөө хулууг шавийнхаа бие болгон хувилгасан. Тэгэхээр Лияо зөвхөн хоёр хулуу л цавчсан хэрэг. Лияо хэдийгээр Луо Жэнрэн–ийг алаагүй ч түүний сэтгэл дэндүү харгис, хэрвээ Луо Жэнрэн эрдэм чадлаар нэн өндөр, гэгээрэх сэтгэл нь маш гүн байгаагүй бол аль хэдийнээ алагдах байсан, тийм биз? (Бүгд алга ташив.)

Иймээс маш олон их бясалгагч, бумбын арш, Төгс Гэгээрсэн Их Багш, гэгээрсэн Их Багш цөм хүмүүсээс маш их эмээнэ. Хэтэрхий харгис хүний сэтгэлээс айна. Гэвч би

айхгүй, учир нь би бол Их Багш биш. Их Багш л айна. Бага багш айхгүй. Та нарыг харахад Багш нь өчүүхэн жижиг биетэй, тэгэхээр Их Багш биш. Тиймээс би айхгүй. Айхгүй учраас гарч хүмүүсийг сургана. Би ямар ч шинэ ёс журам заагаагүй. Шашин бүхэн нэгэн ижил зүйлийг заадаг. Сайн үйл хийж, бие биенээ хайрлахыг заадаг. Хэрвээ Их Багш нар гарч ном дэлгэрүүлээгүй, шашны судар ном бичигдэж үлдээгүй бол манай нийгэм ийм соёлжингуй, амар тайван, аюулгүй байж чадахгүй байх байсан.

Ёс суртахуунаар дутмаг нэгэн цаг үе

"Усан хөвөөний шашдир"-ыг уншихад тэр үе үнэхээр аймшигтай байжээ, тийм биш үү?(бүгд: тийм гэж хариулав) Шударга ёс байхгүй, их түшмэл нь бага түшмэлээ дээрэлхэнэ, бага түшмэл нь доод түшмэлээ дээрэлхэнэ, хамгийн бага түшмэл нь эгэл ядуу ардыг дарамтална. Дээр нь дайн байлдааны үймээн самуун их. Зарим хүн хүчээр дээрэмчин болж байжээ. Тэр үе үнэхээр самуун байсан. Гурван улсын үе ч бас их самуун байсан. (Нийтийн тооллын 220-280 он) Феодалын үеийн Хавар, Намарын улс ч бас самуун ихтэй байв. (Нийтийн тооллын өмнөх 770-403 он) Хамаг төрөлтнийг гэтэлгэхээр хэн ч гарч ирээгүй. Шагжамуни Будда гарч ном дэлгэрүүлсэн (Нийтийн тооллын өмнөх зургадугаар зуун) тэр үеэс энэ дэлхий арай дээрдэж, тийм аймшигтай байхаа больсон юм.

Бид өнөөдөр ургамал хоол идэхийг уриалж байна. Зарим хүн сүм хийд барьж, ёс суртахуунтай сайн үйл хийхийг уриалж байна. "Усан хөвөөний шасдир"-ын үед хүмүүс мах идэж, хүн хүнээ иднэ, цагаан ногоон хоол гэж ярихын ч аргагүй, хүн алаагүй нь хэдийнээ сайн хэрэг байв. Хэрвээ тэдэнд хүн алж болохгүйг сургаж чадвал ерөөсөө маш том алхам. Юун ургамал ногоон хоол, ёс суртахуунтай

үйл хийх тухай ярих? “Усан хөвөөний шасдир”-ыг уншихад тэр үеийн хүмүүс амьтан алж иддэг, идэх амьтан олдохгүй бол хүн алж иддэг байжээ. Тэр үед дээрэмчдийн ахлагч нь баатар эрд тооцогдоно. Тэд бүгд хүний мах иддэг, дайснаа барьж ирээд элэг, зүрх, бөөрийг нь сугалан иднэ. Үнэхээр аймшигтай, дотор муухайрмаар. Гэвч тухайн үедээ тэд бол хүмүүсийн хүндлэл нь байв. Хүн бүхэн тэднийг “ёс суртахуунтай” хэмээн магтана.

Бясалгагч хүмүүний сүр жавхлант байдал

Бясалгадаг хүн, бясалгадаггүй хүний ялгаа үнэхээр их. Бясалгадаггүй бол хүн түүнд яаж хандана, яг тийм хариу барина. Хүн сайн хандвал сайн хандана. Тэгэхдээ бас яг тийм биш. Заримдаа сайн хандсан хүндээ ч гомдох нь бий. Тийм үү, үгүй юу? Харин бясалгагч хүн бол өөр. Хүн бидэнд муухай хандсан ч бид түүнд сайнаар хандана. Есүс Христ загалмайд цовдлогдохдоо Эзэн Бурханаас түүнийг цовдолсон, түүний амийг хөнөөсөн, түүнээс урвасан, түүнийг гүтгэн буруутгасан хүмүүсийг өршөөн хэлтрүүлэхийг гуйж байсан. Тэрээр: “Эцэг минь, тэднийг өршөөж хайрла! Тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна.” гэж хэлж байжээ. Их бодьсадва хүн л ийм агуу өгөөмөр сэтгэлтэй байдаг. Есүс Христ бол Бурхан биш, түүний дэс маш доогуур, тэр бол бодьсадва биш гэх мэтээр зарим нь ярьдаг. Би үүнийг зөвшөөрөхгүй. Ийм агуу өгөөмөр чанар зөвхөн бодьсадва хүнд л байна. Тийм биш гэж үү?(Бүгдээрээ алга ташив.)

Тийм учраас бид энэ шашин сайн, тэр шашин муу гэж дурааараа шүүмжилж болохгүй. Нягт нямбай анзаарч ажиглах хэрэгтэй. Урьд үеийн их сургаалын эзэд, урьд үеийн гэгээрсэн Их Багш нарыг санаан зоргоор гүтгэж хэрхэвч болохгүй. Бид бол эгэл хүмүүс. Ойлгохгүй зүйлээ

хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Алгуур суралцаж, ойлгож мэдсэн цагтаа жинхэнэ дүгнэлтийг хийж болно. Маш олон хүн хэрэг явдлын үнэн мөнийг ололгүй шүүмжилснээс болж, шашин хоорондын ялгаа гарч, тэмцэл, тэр ч бүү хэл дайн самуун гардаг.

Багш нь хаана ч очсон хүмүүсийг ялгаварлахгүй байж, бие биенээ алж хөнөөхгүй, ёс суртахуунтай үйл хийхийг уриалдаг. Католик шашинтнууд эмнэлэг барьж, өглөг өргөж, олон нийтэд тусалдаг. Тэд ямар ч муу үйл хийгээгүй. Мэдээж католик шашинтнуудын дунд муу хүмүүс байгаа, манай буддын шашинтнуудын дотор ч бас муу хүн бий. Ганц нэг муу хүнээс болж, нийтээр нь харлуулж болохгүй. Игуандао шүтлэгтнүүдийг муу гэж олон хүн хэлдэг. Тэдний яагаад муу болсныг би ойлгодоггүй. Тэд амьтан алахгүй, хулгай хийхгүй, садар самуун явахгүй, чадлаараа сайн хүн байхыг хичээж байгаа нь нийгэмд хангалттай сайн нөлөөлдөг. Тэднийг шүүмжлэх ёсгүй. Хүний сайн, муу байх нь бидний хамаарах явдал биш юм.

Дэглий, дун хоёрын тэмцлээс загасчин хожсон нь

Дэлхийн хүмүүс хамтрах хэрэгтэй. Хамтдаа ёс суртахуунаа бэхжүүлж, нийгмийн амар тайвныг бататгаж, ах дүү, найз нөхдөө хамтдаа хүмүүжүүлж, тэднийг зоригжуулж, бясалгуулах хэрэгтэй байна. Яаж бясалгах нь тэдний хэрэг, тэд эрх чөлөөтэй. Хэрвээ тэр Арьяабалын аргаар бясалгахыг хүсвэл тэдэнд: “За, Чин Хай Багшийг даган суралцаарай” гэж хэлж болно. (Бүгд алга ташив.) Хэрвээ тэр католик шашинтнуудтай нөхөрлөхийг хүсвэл католик сүмд очиж, номлол сонсохыг зөвлөөрэй. Хэрвээ ариун орныг бясалгана гэвэл буддизмын ариун орны урсгалаас суралцахыг зөвлөнө. Ямар ч асуудалгүй, бүгд амар амгалан амьдарна. Бид тэмцэлдэх биш, хамтрах хэрэгтэй. Үнэхээр

тэмцмээр байвал чөтгөрийн эзний эсрэг тэмцэх хэрэгтэй. Бидний хамгийн том дайсан бол чөтгөрийн хүч. Найз нөхөд бидний дайсан биш, авшигтнууд бүр ч биш. Хүн өөр шашин шүтдэг бол тэднийг ад чөтгөр гэж болохгүй, ёс суртахуунгүй гэж бас болохгүй. Жишээ нь, буддын шашинтан католик шашинтантай таарахгүй, буддын шашны тэргүүнүүд католик шашны тэргүүнүүдтэй таарч нийлдэггүй бол бие биенийхээ давуу талаас суралцах боломжгүй болж, зөвхөн үгүйсгэнэ. Аяндаа мууг нь харахаас сайныг нь харах чадваргүй болно. Хоёр тал хамтрах хүсэлгүй, үргэлж мөргөлдөөн өдөөвөл шүтлэггүй хүмүүс бүр ч эсрэгээр нь ойлгоно. Тэд буддын шашинд ч итгэдэггүй, католик шашинд ч итгэдэггүй байсан бол одоо бүр хаашаа хандахаа мэдэхгүй болно. Нүдний нь өмнө хоёр шашин харилцан тэмцэлдээд байвал тэд ямар ч шашинд итгэхгүй болно.

Хятадад ийм нэгэн үлгэр байдаг. Нэгэн өдөр дун хясаагаа дэлгээд наранд ээж байжээ. Түүнийг харсан дэглий шувуу урт хошуугаа сунгаад дунг идэхийг завдахад тэр хясаагаа хумьж, дэглийн урт хошууг хавчиж гэнэ. Ингээд тэр хоёр тэмцэлдэж, нэг нь: “Би чамайг юм идүүлэхгүй. Тэгэхээр чи хэзээ нэгэн цагт өлсөж үхнэ” гэхэд нөгөөх нь: “Чи ч бас маргааш өлсөж үхнэ” гэв. Энэ үед тэдний хажуугаар өнгөрч явсан загасчин тэднийг хамтад нь шүүрч, торондоо хийн аваад харьжээ.

Хэрвээ бид үргэлж өөр хоорондоо тэмцэлдвэл ад чөтгөр үүнийг далимдуулж, харалган байдлыг нь ашиглан хоёуланг нь устгана. Ингээд бидний ажил Эзэн Бурхан, Бурхан Буддагийн ажил биш, эсрэг үйлдэл болж хувирна. Бурхан бодьсадва хэзээ ч бидэнд ялгаварлах, алагчлахыг заагаагүй. Есүс Христ, Лууз, Күнз, ер нь аль ч Их Багш бидэнд алагчлах, ялгаварлахыг заагаагүй. Бид үнэн ёсыг ойлгоогүй, үнэнийг ухаараагүй байна. Тиймээс өнөөдөр ч дэлхий хүмүүс энх тайвангүй, эвлэлдэн нэгдэж чадахгүй

байгаа юм. Хэн нэгэн хүн гарч ирээд хамтарч нэгдэхийг уриалбал түүнийг буруу номтон гэнэ, яг ингэдэг, тийм биз?

“Усан хөвөөний шашдир”–ын үед хамаг төрөлтнийг сургах Төгс Гэгээрсэн Их Багш гараагүй юм. Бүхэл бүтэн зохиолд хүмүүсийг сайн үйлд уриалсан, бясалгаж гэгээрэхийг хөхиүлэн дэмжсэн зүйл нэг ч байхгүй, бүгд л дайн тулаан, атаа жөтөө, дарамт шахалт, хээл хахууль, бусдын хөрөнгийг хүчээр булаасан явдлууд гардаг. Ёс суртахууны хувьд тун дорой байжээ. Тэр үед магадгүй манай улсад Төгс Гэгээрсэн Их Багш байгаагүй байх. Улс орон бүхэн Төгс Гэгээрсэн Их Багштай байдаг юм биш.

Их бясалгагч хүмүүн улс орон бүхэнд бий. Ёс суртахуунтай хүмүүс тодорхой хэмжээгээр заавал байдаг. “Усан хөвөөний шастир”-ын үед ч бас ёс суртахуунтай, бясалгалтай хүмүүс байсан. Гэвч тэд ил гарч, хүмүүсийг сургахгүй. Саяхан ярьсан тэр Луо Жэнрэн ууланд нуугдан бясалгаж байсан. Хүмүүс түүний шавь нарыг уулнаас буулгахыг хүсэхэд тэр явуулдаггүй байв. Цаг үе тун самуун байгааг тэр мэдэж байсан учраас бусад бүх хүнд биш, заавал цөөхөн хэдэн хүнд заадаг. Тиймээс ердөө хоёр, гуравхан шавьтай байжээ.

Улс орон бүхэн Төгс Гэгээрсэн Их Багштай биш. Төрөл тутамд Төгс Гэгээрсэн Их Багш тун цөөн байсан. Байхгүй биш байсан, гэвч маш цөөн. Байсан нэг нь нуугддаг, хамаг төрөлтөн ирж, хөнөөхөөс айна. Амь насаа алдахаас айсандаа нуугдсан хэрэг биш, харин зааж сургаж амжилгүй хөнөөгдөхөөс айна. Тэгэхээр сургаад хэрэггүй. Ямар ч нэмэр тусгүй! Хамаг төрөлтөн огт сонсохгүй, тиймээс тэд нуугддаг. Тэд амиа хайрласандаа биш. Тэд үй түмээр хувилж чадна. Тэгэхээр махан биед хоргодоод яах билээ? Гэвч зарим Их Багш үүрэг даалгавар маш багатай байдаг. Тэд өөр өөр үүрэг даалгавартай ирдэг. Зөвхөн хэдэн арван, эсвэл хэдхэн хүнд заагаад л болно. Тэд уултай устай, нам

гүм орчинд амар жимэр амьдрах тул доош бууж, хамаг амьтанд гүтгэгдэж дайруулж үгүйсгэгдээд яах вэ?

Хүний цаана хүн, тэнгэрийн цаана тэнгэр

Ийм нэгэн түүх байдаг. Зарим нь сонссон байх, гэхдээ би өнөөдөр дахиад ярья. Лууз-д нэгэн хүн бараалхаж, сургаал айлдана уу гэж хүсжээ. Лууз: "Та яагаад ийм олон хүн дагуулж ирэв?" гэхэд өнөөх хүн эргэж хараад: "Хэн ч байхгүй, би ганцаараа ирсэн" гэхэд Лууз толгой сэгсрээд: "Ийм олон хүн дагуулж яах нь вэ?" гэхэд өнөөх хүн дахин дахин эргэн харж, ихэд гайхан: "Нэг ч хүн алга, яагаад намайг олон хүн дагуулсан гэв?" гэж бодов. Лууз: "Тэр олон хүн таны тархи толгойд, оюун ухаанд байна" гэжээ.

Тэр хүн өмнө нь олон багшаас суралцсан аж. Лууз түүний энд, тэндгүй явж, багш нарыг цуглуулдаг, сургаал номыг цуглуулдаг атлаа бясалгах чин хүсэлгүйг нь тодотгон хэлсэн аж. Тэр зөвхөн сонирхож, ийш, тийш явдаг, хүмүүстэй өдөржингөө ном хаялцаж мэтгэлцэх л дуртай. Өөрийгөө тун сүрхий, хэнээс ч суралцах шаардлагагүй гэж боддог тул хаана ч очсон үнэн сэтгэлээсээ зам мөрийг үл хайна, зөвхөн маргаж мэтгэлцэхийг л боддог ажээ. Ам нээгээгүй ч толгой тархи нь тогтсон үзэл, ягшмал бодлоор дүүрэн байв. Тиймээс Лууз: "Олон хүн дагуулж ирэх хэрэггүй" гэж түүнд хэлсэн байна.

Багш нь ч бас олон ийм хүнтэй таарч байсан. Эхлээд ёс журмыг сахихыг ихэд хичээвч хэлмээргүй байсан үгээ тэднээс болж аргагүй хэлэхэд хүрнэ. "Та нарын бясалгал сайнгүй, билиг ухаан дутуу байна. Энд ирж жүжиглэх хэрэггүй" гэдэг. "Би өөрийгөө билиг ухаан ихтэй гэсэн хэрэг биш, харин та нар билиг ухаанаар үнэхээр дулимаг байна. Хэрвээ та бүхэн ямар нэг зүйлийг мэддэг гэвэл зарим

хүн та нараас ч ихийг мэддэг байж магадгүй" гэж хэлдэг. Хүний цаана хүн, тэнгэрийн цаана тэнгэр бий. Орчлонгийн билиг ухааныг сураад дуусахгүй, дэс төвшинд ч хязгаар гэж үгүй. Хүрч болох хамгийн дээд дэс байдаг гэж сонссон бол үнэндээ тийм зүйл байдаггүй. Нэг дэс нь нөгөө дэсээс дээш байдаг ч хамгийн дээд дэс гэж байхгүй. Яагаад вэ? Учир нь орчлонд ертөнц хэмжээ хязгааргүй. Их билиг ухааныг бид төсөөлшгүй. Бидний эгэл хүний оюун ухаан, эгэл хүний бүтцээр хэмжиж үл чадна.

Хэрвээ хүрч болох хамгийн дээд дэс бий гэвэл тэр нь Багш биднийг тайтгаруулж, "Хэзээ ч хүрч чадахгүйгээс хойш" гэж бодоод урагш дэвших хүсэлгүй болохоос аварсан хэрэг. Хэрвээ бид өөрийгөө хамгийн дээд дэсэд хүрчихлээ гэвэл тэр нь хамгийн дээд дэс биш. "Нэр гэмээ нь нэр биш, мөр гэмээ нь мөр биш" гэж бид сонсож байсан. Лууз-ын хэлсэн үг ийм утгатай. (бүгд алга ташив) Мөрийг олж гэгээрсэн ч "Би хамгийн дээд дэсэд хүрлээ" гэхийн аргагүй. Хэрвээ энэ дэлхийд: "Би хамгийн дээд дэсэд хүрсэн" гэвэл энэ нь хамгийн дээд дэс бас биш. Учир нь энэ дэлхийн хэл яриа, энэ дэлхийн оюун ухаан дээд ертөнцүүдийг ойлгоход хангалтгүй. Дээд төвшнийг үг хэлээр илэрхийлж, дүрсэлж, тайлбарлах ямар ч боломжгүй. Тиймээс аль нэгэн номын багшаас суралцах, Төгс Гэгээрсэн Их Багшийн билиг ухаанаас лавлах бодолтой бол үнэхээр жинхэнэ номхон даруу, чин сэтгэлтэй байх хэрэгтэй.

Бид Бурхад бодьсадва, Эзэн Бурхан, Ванму ээж, Арьяабал бодьсадваг яаж хүндэлдэг шигээ гэгээрсэн Их Багшийг тэгж хүндлэх шаардлагагүй. Ингэх хэрэггүй. Учир нь бид Төгс Гэгээрсэн Их Багш гэж хэн болохыг мэдээгүй байна. Бид бас нэг хүнийг тийм ихээр хүндэлж чадахгүй. Гэхдээ ядаж л өөдрөг гэгээлэг бодолтой, чин үнэн сэтгэлтэй, номхон даруу, харилцан илэн далангүй ярилцдаг байвал сая хүртэх олзтой байх юм. Бидний мэдэх зүйл хязгаартай,

орчлонгийн их, бага учир явдлыг сайн ойлгохгүй, тиймээс бардам байх хэрэггүй.

Хамаг төрөлтнийг гэтэлгэх хэцүү. Бүгд мэдлэгийн тоосонд дарагдсан байдаг. Сурсан мэдсэн нь дэндүү их, уншсан судалсан судар ном нь асар олон тул өөрийгөө бүхнийг мэддэг гэж бодно. Харин Төгс Гэгээрсэн Их Багштай уулзвал суралцах аян замаа огт эхлээгүй явснаа ухаарна. (Бүгд алга ташив) Төгс Гэгээрсэн Их Багштай уулзахаас өмнө бид өөрийгөө тун сүрхийд бодож явсан. Багштай уулзаад хичнээн доогуурын доогуур дэстэйгээ ойлгодог. Тэр үед зүрх сэтгэл жинхэнэ хоосорч, тулах цэггүй, зуурах барьцгүй болж, арчаагаа алдана. Эргэлзэж, яахаа мэдэхгүй болно. Тэгж зүрх сэтгэл балчир хүүхдийнх шиг хов хоосон, цэвэр цайлган болох тэр агшин бол ном сурах хамгийн сайн цаг мөн. Тиймээс эртний даяанч багш нар, Төгс Гэгээрсэн Их Багш нар шавийгаа маш хатуу сорьж шалгадаг байсан байна. Яагаад сорьж шалгадаг вэ? Учир нь сорилт шалгалтын явцад шавь өөрийн дутагдлыг олж харна. Хэр эрхэм дээд ёс суртахуунтайгаа мэднэ. Хэр их тэсвэр тэвчээртэйгээ танина. Тэсч тэвчихийн аргагүй хүнд нөхцөлийн дунд хэр их номч сэтгэлтэйгээ мэдэж авна.

Хүний хорвоод буусан тэнгэрийн од

“Усан хөвөөний шашдир” тун аймшигтай зохиол, гэвч тэндээс тусгаж авууштай зүйл бидэнд их бий. Аймшигт хэргүүдийн тухай уншаад хожим ийм явдал хэрхэвч үйлдэж болохгүйг ухаарна. Энэ нь бас нэг хичээл юм. “Усан хөвөөний шашдир”-т бичсэнээр Сун Жианбэнь бол долоон бурхан одны доторх хамгийн том од, бүх одын хаан, хамгийн том Тиан Куйсин од юм. Тэр уг нь агуу их тэнгэрийн төрөлтөн. Гэвч тийм ч сэтгэл сайтай байгаагүйгээс тэнгэрийн хаанд шийтгүүлсэн байна. Түүнийг

хүний хорвоод сайн хүн байхад суралцуулахаар илгээжээ. Гэвч тэрээр өөрийн жинхэнэ уг гарвалыг мэдэхгүй. Хэцүү бэрхтэй тулгарч, хүмүүст хөөгдөөд нэгэн сүмд нуугдаж байхад нь есөн тэнгэрийн нууцлаг бүсгүй илэрч, түүнийг авардаг. Тэгээд түүнд хандаж: “Та угаасаа энэ дэлхийн хүн биш, та бол оддын хаан, зарим нэг шалтгааны улмаас мөнх бусын энэ ертөнцөд илгээгдсэн. Сайтар бясалгаж байж л диваажин луугаа буцаж чадна” гэжээ. Есөн тэнгэрийн нууцлаг бүсгүйн хэлснийг Сун Жианбэнь сайн ойлгоогүй. Бүсгүй бясалгаж дадуулах тэнгэрийн гурван боть судрыг түүнд бэлэглэв. Энэ нь түүнд яг зүүд мэт санагджээ.

Гэвч энэ зүүд яг л жинхэнэ мэт, Сун Жианбэний сүнс, сүнсэн биеийг есөн тэнгэрийн нууцлаг охин дээш дагуулан явж, гамшгаас авраад дараа нь доош буулгав. Тэр махан биеэрээ яваагүй. Бясалгалтай хүн үүнийг ойлгоно. Сүнсэн бие чөлөөтэй ирж очдог. Явах, ирэх чөлөөтэй. Есөн тэнгэрийн нууцлаг бүсгүй яг л сүмийн арын хашаанд амьдардаг мэт тийм ойрхон. Гэвч дараа өдөр нь түүнийг хайгаад олсонгүй. Үүнээс хүний хорвоод ч диваажин байдаг, есөн тэнгэрийн нууцлаг бүсгүй хийдэд ойрхон байсан нь тодорхой. Гэвч эгэл хүний нүдэнд үл харагдана. Хэрвээ есөн тэнгэрийн нууцлаг бүсгүй өөрөө л хүмүүст харагдахыг хүсэхгүй бол хэн ч түүнийг олж харахгүй.

Энд диваажин ч бий, там ч бий, нирваан ч бий, баруун зүгийн Төгс баясгалант орон ч бий гэж сонссон. Гэвч эгэл хүний чадвар хязгаартай тул бид харж үл чадна. Хутагт хувилгаадын дэс биднээс үлэмж өндөр. Есөн тэнгэрийн нууцлаг бүсгүй, Рунжэн-д жинхэнэ хэн болохыг нь хэлж өгсөн ч тэр бас итгээгүй. Өдөржингөө дайн байлдаан хийгээд өөрийн агуу ихийг таньж чадаагүй. Цаг нь болоогүй бол бас ихийг мэдэж болохгүй. Хэн нэгэн нь эхлээд жаахан жаахан цухуйлгасан ч тэр өөр гэдгээ мэдрээгүй, би бол эгэл хүн гэж бодсоор байдаг. Учир нь түүнд төлж дуусаагүй үйлийн үр,

хийх ёстой ажил, сурах ёстой хичээл байсаар байгаа хэрэг.

Хималайн ууланд байдаг зарим хүн хэдэн мянган жилийн настай гэж сонссон, та нар сонссон уу? (сонссон гэж зарим хүн хариулав) Үүнд итгэж байна уу?(Итгэдэг гэж хариулав.) Нүдээр үзээгүй зүйлд итгэх нь мухар сохроор сүсэглэж буй хэрэг. Гэвч үнэхээр ийм явдал бий. Тэд бол агуу их бясалгагчид. Даогийн олон эрдэмд гүн нэвтэрсэн байдаг. Тэд бидэнтэй адилгүй. Махан биедээ түшиглэвэл урт наслахгүй. Зарим нь олон мянган жил амьдарч байгаа гэж сонссон. Хималайн ууланд очвол тэдэнтэй амархан уулзана гэж бид боддог. Гэвч үнэндээ, бид тэдний өмнө нь очсон ч харж чадахгүй. Учир нь тэдний бие махбод биднийхтэй адилгүй, маш нарийн хэлбэлзэлтэй. Эгэл бидний бүдүүн хэлбэлзлэлээс өөр. Хэрвээ тэдэнтэй уулзахыг хүсвэл бид өөрөө эгэл биш байх ёстой. Эсвэл тэд бидэнтэй уулзахыг хүссэн тохиолдолд бидэнд харагдана.

Есөн тэнгэрийн нууцлаг бүсгүй өөрөө харагдахыг хүссэн учраас Сун Жиан түүнийг харж чаджээ. Гэхдээ ганцхан удаа харсан. Сун Жианд саад тотгор учирсан тул түүнийг аюулаас аврах, далимаар нь гурван боть тэнгэрийн ном бэлэглэхийн тулд түүнтэй уулзсан байна. Эс бөгөөс Сун Жиан есөн тэнгэрийн нууцлаг бүсгүйг харж чадахгүй юм. Уг нь тэр хоёр найзууд байсан аж. Сун Жиан өндөр дэсээс унасан учир бүсгүй түүнд эртхэн гэртээ харихад нь туслахын тулд эгэлийн ертөнцөд ирж, Сун Жианийг халамжилсан юмсанж. Бид, Эзэн Бурхан, Бурхан бодьсадва, диваажингийн орныг ихэд санан дурсдаг гэж боддог, гэтэл Бурхан бодьсадва биднийг бүр ч их санан дурсдаг юм шүү. Эзэн Бурхан биднийг бүр хүчтэй санан дурсаж байдаг. Тиймээс Бурхан бодьсадва хувилгаан биеэрээ тоост хорвоод заларч, биднийг аварч, гэтэлгэдэг гэж үргэлж сонсож байдаг. Яагаад вэ? Бид чин сэтгэлээсээ залбирч даатгавал тэнгэр, газрыг уяраана, Бурхад бодьсадваг уяраана. Тиймээс

биднийг аврахаар хүмүүсээ илгээдэг байна.

Өөр өөр үүрэг хариуцлага

Багш нь сая "Усан хөвөөний шашдир"-т гардаг харгис хэрцгий Лияогийн тухай ярьсан. Тэр, Луо Рэнжэнийг цавчиж хоёр хэсэг болгохыг завддаг, та нар санаж байна уу? Луо Рэнжэн ч түүнийг эгэл хүн бишийг мэднэ. Тэрээр, Лияо бол төрөл аван бууж ирсэн тэнгэрийн алуурчин од бөгөөд тэнгэрийн хаан түүнийг хүн алуулахаар томилсон гэж ярьдаг байв. Учир нь дэлхийн хүмүүсийн ёс суртахуун доройтон муудаж, муу үйл дэндүү их үйлдэх болсон тул тэнгэрийн хаан хар хуй салхи Лияо-г эгэлийн ертөнц рүү илгээжээ. Хэдийгээр тэр маш харгис, хүмүүсийг үй олноор нь хүйс тэмтэрч байсан ч энэ нь түүний үүрэг байв.

Зарим хүн, хамаг амьтныг үй олноор хороох үүрэгтэй томилогдож ирдэг. Энэ бол бодит үнэн. Тэр хүмүүсийг Багш нь хэдийгээр магтан сайшааж дэмжээгүй ч энэ бол бүтээгч эзний ажиллагаа. Хүн алахгүй байх нь хамгийн сайн. Гэхдээ бид бас дэндүү их хутгалдан орж болохгүй. Зохиолд гарч буй хүн алах үйлдлүүдэд бид мэдээж дургүй, гэвч бид эдгээрийг шүүн тунгаагаад муу үйл хийж болохгүйг өөртөө сануулах хэрэгтэй. Ингэвэл ял шийтгэлтэй нөхцөл байдлаас зайлсхийж чадна.

Бид бас өдөржингөө бусдыг зэмлэн буруутгаад хэрэггүй. Өөрөө хэр сайн бясалгаж байгаагаа харах хэрэгтэй. Магадгүй өмнөх төрөлдөө сайн үйл хийгээгүй бол энэ төрөлдөө олигтой хувь заяатай байхгүй. Хэрвээ одоогийн хувь заяа чинь сайн байсан ч бас хичээн бясалгах хэрэгтэй. Тэгвэл энэ байдлаа үргэлжлүүлэн хадгална. Хэрвээ одоогийн байдал чинь тааруу бол илүү их хичээн бясалгах хэрэгтэй. Тэгвэл үйлийн үрээ өөрчилнө.

Лияо хүн алах тун дуртай, ах дүүгээ хамгаалахын төлөө ёс суртахуунтай сайн хүнийг ч ална. Үнэнч шудрага занг нь магтууштай ч, муу явдал нь түүнийг тамд унагах юм.Эгэл хүмүүс бүгд ийм л байдаг. Сайн, мууг ялгаж салгаж чадахгүй. Сэтгэлд нь нийцээгүй хэнийг ч замаасаа зайлуулна.

Дорнын хүмүүс зурхайд дуртай, хэрвээ зурхайч надад та өмнөх төрөлдөө тэнгэрийн хувилгаан, бодьсадва, тэнгэрийн элч, долоон бурхан од, өмнөдийн их од байсан бөгөөд одоо эгэлийн ертөнцөд бууж иржээ гэвэл бидэнд их л бахархалтай санагдана. Гэхдээ бид бодьсадва, тэнгэрийн элч байсан ч энэ төрөлдөө бясалгадаггүй бол бүдүүн хадуун, харгис хэрцгий, сайн, мууг ялгах билиг ухаанаар дутмаг, яг Лияо шиг сайн зүйлийг ч бас устгана. Тэр Луожэнтэй ямар нэгэн айхтар гүн өс хонзонгүй, гэвч зүгээр л ах, дүүгээ хамгаалж, нэгэн сайхан сэтгэлтэй, ёс суртахуунтай, хүч чадалтай сайн хүнийг хөнөөдөг. Бүр алаагүй ч түүний үйлдэл, бодол санаа нь дэндүү харгис. Тиймээс их бясалгагч хүмүүн түүнийг шоронд гурав хоног хорьж шийтгэжээ. Дараа нь тэр гэмшээд жаахан засарсан байна.

Хүн бүхэн бодьсадва мөн

Энэ зохиолоос бид хүн бүхэн бодьсадва гэдгийг ойлгож болно. Шагжамуни Будда: “Төрөлтөн бүхэн бурхан чанартай” гэсэн бол Есүс Христ: “Бид бүгд Эзэн Бурханы хүүхдүүд” гэжээ. Гэвч яагаад бид заримдаа уурлаж, их харгис догшин болдог вэ? Заримдаа ёс журамтай, ёс суртхуунтай болдог вэ? Энэ бүхэн ердөө л үнэн зөв, жинхэнэ номоор бясалгаагүй, өөрийгөө сайтар сургаагүй, чөтгөрлөг муу чанараа дарж, бурханлаг сайн чанараа хөгжүүлээгүйгээс болдог. Тиймээс зөвхөн сайн үйл хийвэл зөв, улс орноо хамгаалвал хангалттай, хорвоо дэлхийг төвшитгөвөл

хамгийн агуу нь биш юм.

Күнз: “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө төвшитгө, тэгвэл сая тэнгэрийн дор амгалан тогтоно” гэж сургасан.

Бид өдөр бүр “Мөр ёсны судар”, Күнзийн “Хэв дундыг сахихуйн ёсон” “Их суртахуун”-ыг уншиж судалж байдаг ч дагаж мөрдөж, хэрэгжүүлж чаддаггүйн гол шалтгаан нь бясалгадаггүй учраас “Зам мөр” гэж юу болохыг мэдэхгүй, энэ “Мөр гэмээ нь мөр биш”-ийг олж хүртээгүй, тиймээс ийм өнчин ганцаардмал, өөрийгөө хянах чадваргүй сул дорой байдаг. Хэрвээ хүн угаасаа төгс төгөлдөр байсан бол Лууз “Зам мөр”-ийг бясалга гэхгүй байсан. Күнз: “Өршөөл энэрэл, элбэрэл хайр, тахимдуу ёсон, ёслол журам, мэргэн ухаан, шударгуу ёсон”-ы тухай сургахгүй байсан, Шагжамуни Будда ч “Зургаан билиг барамид”-ыг чухалчлахгүй. Есүс Христ ч: “Арван сахил”-ыг заахгүй байсан юм. Библийн судраас бидний уншдаг Есүс Христийн “Уулан дээрх сургаал” нь буддын шашны бодьсадвын сахил, бодьсадвагийн явдал, бодьсадвагийн зам мөртэй ижилхэн.

Яагаад бид хэрэгжүүлж чаддаггүй вэ? Учир нь бид “Зам мөр”-ийг олоогүй, дотоодын диваажингаа олоогүй, бурхан чанараа таниагүй байна. Хэрвээ судар ном уншаад ёс суртахууны ном сургаал судлаад энэ бүхнийг олдог байсан бол Шагжамуни Будда өдөр бүр бясалгаж, самади агуулж, диваажинд хүрч, тамд очиж, хүмүүсийг аврах хэрэггүй байсан. Хэрвээ Библийн судар уншаад болчихдог бол Есүс Христ цөлд 40 хоног бясалгаж, 40 хоног мацаг барьж, их цөлийн дунд орь ганцаар өөрийгөө цэгцэлж, бие, хэл, сэтгэлээ ариусгаад дараа нь бусдыг гэтэлгэхээр явах шаардлагагүй байсан. Хэрвээ “Мөр ёс”-ны судрыг унших нь хангалттай юм бол өнөөдрийг хүртэл их бясалгагчид, их арш нар ууланд сууж бясалгах хэрэггүй юм. “Мөр ёс”-

ны судрыг уншихад л хангалттай байсан бол яагаад заавал өглөө нарыг ажиж, орой сарыг харах хэрэгтэй вэ? Үхэлгүй мөнхрөх дотоод хийг бясалгаж, эмийн ургамлын алхими судалж, хийн бясалгал хийж, гол хоёр судлыг нээх хэрэгтэй байдаг вэ? Тийм үү? Тиймээс бид нэг зүйлийг сайн ойлгох хэрэгтэй. Ном судар бол гаднах сургаал, бясалгал бол жинхэнэ дотоод сургаал мөн. Гадна, дотно тэнцэж байж "Зам мөр" бүтнэ. (Бүгд алга ташив.)

Шагжамуни Буддаг их нирваанд орсны дараа түүний шавь нар олон мянган ном судрыг нь эмхэтгэсэн. Гэтэл яагаад заавал Маха Кашиб ном уламжлах хэрэгтэй байв? Яагаад заавал Ананд авшиг дамжуулах ёстой байв? Бас яагаад заавал Бодьдармаа, зургадугаар үеийн Их Багш Хүй Нэн, Хуанпи, Байжан гэх зэрэг Их Багш нар авшиг уламжилж байв? Хэрвээ ном судар судлахад л хангалттай бол тэд тэгж өөртөө болон бусдад төвөг удах хэрэг байсан уу? Хүмүүсийг нэг алхамд нэг мөргүүлж, ууланд очиж, даган суралцахыг уриалах хэрэгтэй юу? Ойлгож байна уу? Үүнийг зөвшөөрч байна уу? (Бүгд алга ташив.) Тиймээс Багш нь шинэ зүйл огт заагаагүй. Багшийнх нь зааж буй бүхэн ном сударт бий. Багш нь зөвхөн, яагаад заавал нам сууж бясалгах хэрэгтэй вэ? Яагаад заавал билгүүн ухаанаа нээж гэгээрэх хэрэгтэй вэ? Яагаад заавал их билгүүн ухааныг олж авах ёстой вэ гэдгийг та бүхэнд тайлбарлаж байна.

Энэ "Дао-мөр"-ийг олвол буян бүхэн аяндаа ирнэ. Лууз хэлэхдээ: "Мөр" байхгүй үед буянт үйлийг бүтээх шаардлагатай. "Мөр" байвал бүх юм байж байдаг. ("Мөр ёсны судар" гучин есдүгээр бүлэг: "In the past, the sky will be clear, the earth will be peaceful, and the god will be spirit. When the valley is full, all things live by one, and Hou Wangdeyi thinks that the world is chaste".

Урьдын цагт Мөрийг олсон хүний ухаан нь саруул болог гэж Тэнгэр диваажин түүнийг олдог, амарч тайвшраг гэж газар

дэлхий түүнийг олдог, сүнстэй байг гэж бурхад түүнийг олдог, урган цэцэглэг гэж тал хөндий түүнийг олдог, амьдраг гэж эд зүйлс түүнийг олдог, хорвоо ертөнцийг мэргэн цэцэн болгох гэж хаад ноёд түүнийг олдог байжээ.

"Зам мөр" гэж юу вэ? "Зам мөр" гэдэг нь дотоодын гэгээрэл, дотоодын их билгүүн ухаан, бүхнийг чадагч дотоодын хүч юм. Хүн бүхэнд бүхнийг чадагч их хүч бий, гаргаж хэрэглэхгүй бол дэндүү хайран. Тэгж өөрийгөө өчүүхэн жижиг, сул дорой, ганцаардмал, арчаагүй, хүч чадалгүй болгодог. Шагжамуни Будда зам мөрийг олсон учраас тийм агуу их хүч чадалтай, агуу их шидтэй, үй түмэн хувилгаан биетэй, оршихгүй газаргүй, там, диваажинд зорчих нь бидний дэлгүүрээс ногоо авах шиг тийм амархан болсон юм.

Лууз "Зам мөр"-ийг олсон учраас одоо ч алдар цуутай. Олон улс оронд түүний "Мөр ёс"-ны судрыг судалж байна, гэхдээ дотоод нууцад нь нэвтэрч чадаагүй л байна. Учир нь тэд дотоод зам мөрөө олоогүй учраас "Мөр ёс"-ны сударт юу өгүүлснийг, Луузын жинхэнэ санаа юу болохыг ойлгохгүй байгаа нь аргагүй юм. Хэрвээ бид "Зам мөр"-ийг бясалгаж, "Зам мөр"-ийг олбол яг Луузтай адилхан өөрийн гэсэн "Мөр ёс"-ны судрыг бичиж чадна. Магадгүй бүр ч олон хүнийг татахаар бичих байх. Энэ нь бид Луузаас илүү гэсэн хэрэг биш, харин бид орчин үеийн хүмүүст илүү ойлгогдохоор бичих болно.

Есдүгээр бүлэг

ТҮҮХЭЭР БАГШЛУУЛАХУЙ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
АНУ-ын Калифорни муж, Лос-Анжелес хот
1996 оны 3 дугаар сарын 13.(Эх нь англи хэлээр)

Билиг ухааны эрдэнэсийн сангаа танихуй

Бясалгалын хүч маш олон зүйлийг өөрчилдөг, үүнийг хүн бүхэн мэднэ. Зарим лам нар бясалгалаар сайнгүй ч цаг агаарыг өөрчилж чаддаг. Бид тэгэх хэрэггүй, зөвхөн сайтар бясалгах нь чухал.

Аливаа зүйл бидний хүсэл эрмэлзлэлээр өөрчлөгдөж байвал тэр л хамгийн зөв. Калифорнийн хүмүүс Арьяабалын аргаар бясалгах болсноос хойш одоогийн байдлаар хамгийн олон авшигтантай газар болсон байна. Учир нь би энд байнга ирдэг байсан. Цаг агаар ч улам сайжирчээ. Тэгж таарсан ч байж магадгүй. Гэхдээ энэ тохиол тун дажгүй шүү! (Бүгд алга ташив) Тиймээс ийм байх нь надад маш зөв санагддаг. Бид газар бүхнийг өөрчилнө. Арьяабалын аргаар бясалгавал

юм бүхэн өөрчлөгдөнө. Үүнийг Багш нь батална.

Нэгэн Их Багшийн тухай түүх байдаг. Энэ Багш өөр өөр улс оронд очиж ном айлдаж, ном тайлж явдаг. Нэг шавь нь Багшийн аяллын замыг тэнгэрийн нүдээр шалгаад түүний очих газрыг мэджээ. Дараа нь тэр бусад шавь нартай нийлж нягтлаад Багшийн заларсан газар бүхэн бороотой байсныг мэдсэн байна. Тухайн орны цаг агаар их хуурай яг энэтхэг шиг, бороо хур дутмаг. Гэвч тэр Багшийн очсон газар бүхэнд бороо дагаж явсан байв. Түүний явах замыг борооны усаар угаах мэт. Үнэхээр гайхалтай! Тэр шавь “харсан”-ыхаа дараа тэндхийн авшигтнуудтай нийлж нягталвал үр дүн нь түүний үзсэнтэй өчүүхэн ч зөрөөгүй байжээ.

Арьяабалын бясалгалын арга үнэхээр сэтгэгдэшгүй! Энэ тэнсэлгүй дээд номын ёсоор бясалгасны ач тусыг ярьсан ч яриад барахгүй. Заримдаа би дэлхийн хүмүүсийг бүгдээрээ мэдээсэй гэж маш их хүсдэг. Гэвч бид заавал тэвчих хэрэгтэй. Хэрвээ та нарт миний тэвчээр хангалтгүй санагдвал үүний шалтгаан нь ийм гайхамшигтай номын ёсыг, бүхнийг чадагч ханьцашгүй их хүчийг хүмүүс үл хайхрах атлаа зовлонгийн далайд амьдарч, өдөр бүр Эзэн Бурханд залбирч, өчүүхэн жаахан буян гуйгаад өөрийн дотоодод юм бүхэн байгааг мэдэхгүй байгаа явдал болно.

Соёл иргэншлийн оргил ба давтагдсан дайн

Олон мянган жилийн өмнө гайхалтай сайхан зүйлс байсан тухай өгүүлэх нэгэн түүхийг ярья. Зөвхөн одоо ч биш, эрт дээр үед олон олон хөгжингүй соёл иргэншил оршин байсныг бид үүнээс мэдэж болно.

Эртний соёл иргэншлүүд нь дайн дажнаас болж устаж сүйрснийг бид түүхийн сурвалж бичиг болон судалгааны тайлангуудын тэмдэглэлээс мэднэ.

Магадгүй галактикийн их дайн, гараг хоорондын дайн, эсвэл дотоодын дайн, мөн нутаг нэгтнүүд бие биенээ барьж идэх зэргээс болжээ. Ямар ч соёл иргэншил оргилдоо хүртэл хөгждөг, хэрвээ тухайн нийгмийн хүмүүс дотоод хүчээ хямгадаагүй, болгоомж сэрэмжгүй, өөрийгөө барьж хязгаарлаагүй, эзэмшсэн шинжлэх ухааны мэдлэгээ илүү ухаалгаар ашиглаагүй бол төвөгтэй байдлууд үүсдэг. Шинэ технологийн төлөө өөр хоорондоо уралдаж, бусад улс үндэстэн, газар нутаг, гараг эрхсийг эрхшээлдээ оруулахыг санаархсанаас дайн дэгддэг. Харин дайн дуусахад бүх зүйл юу ч үгүй болно.

Хүн төрөлхтний асуудал үүнд л байна. Бид хэзээ ч суралцдаггүй. Бидний одоогийн энэ дэлхийг хар. Маш олон улс орон сургамж аваагүй л байна. Дайтах болгондоо улс орон нь дампуурч, ядуурч, урт хугацааны туршид сэхэж сэргэхгүй болдог. Орон бүхний удирдагчид дайны хор хохирлыг сайн мэддэг ч дур зоргоороо авирлаж, энх тайвныг үл эрэлхийлнэ. Заримдаа тэд бусад улс орныг зөвхөн айлган сүрдүүлэхийг санаархдаг. Гэвч төлөвлөгөө нь бүтэлгүйтвэл яах вэ? Зөвхөн бие биенээ буруугаар ойлгоно. Өчүүхэн явдал нь их гамшиг үүсгэж, зогсоох аргагүй болж хувирдаг. Дайны гал дүрэлзэж, хүн төрөлхтний соёл иргэншил бамбарын гол болдог байжээ. Яг л саяхан номхон далайн ёроолд живсэн эртний Атлантис хотыг илрүүлсэн, эсвэл эртний харь гарагийн хүн гэгч шиг.

Бид: Хөөх! Тэд тухайн үедээ ийм соёлжингуй байсан гэж үү гэх болно. Тийм ээ, тэд урьд нь соёлжингуй байсан. Магадгүй одоогийн биднээс ч илүү соёлжингуй байжээ. Библийн сударт Родын эхнэрт тохиолдсон явдлыг тэмдэглэсэн байна. Тэр эргэж очин харах үедээ давсан багана мэт болсон байна. Харахад яг л цөмийн бөмбөг маягийн зүйл дэлбэрсний үр дүн мэт. Нэгэн өндөр технологийн химийн зэвсэг хүнийг эхлээд химижүүлдэг. Дараа нь шатааж, үнс

нурам болгоно. Харахад яг давс шиг болчихдог.

Тийм учраас өмнө нь бас маш олон дайн болж байжээ. Мөн мэдээж олон шинэ нээлт хийж, олон зүйлийг олж илрүүлсэн байна. Тийм учраас бид одоо байгаа зүйлүүддээ хэт бардамнах хэрэггүй. Энэ мэт мөнх бус шинжлэх ухааны багаж хэрэгсэлд бас хэтэрхий найдах хэрэггүй. Гэвч хүмүүс үргэлж л ийм байсаар ирсэн. Шинэ нээлт хийх бүртээ өөрсдийгөө тун агуу хэмээн үнэлж, дараа нь устгаж болох бүхнийг устгана. Тэгээд дахиад л бүр эхнээс нь эхэлнэ.

Одоо би та бүхэнд баталгаа болгож нэгэн түүх уншиж өгье. Энэ явдал хятадад болсон бөгөөд одоогийн олон тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ихэнхийг хамгийн анх хятадууд зохиожээ. Мэдээж тэр үед нилээд болхидуу, хамгийн энгийн бүтэцтэй байсан байх. Хожим нь улам боловсронгуй болгосон, эсвэл европчууд болон америкчууд тэднээс санаа авч илүү сайжруулсан байна. Жишээ нь, хятадууд зохион бүтээсэн салютаа шинэ жилээр буудуулдаг. Энэ нь нэг талаараа баяр тэмдэглэж, хүмүүсийг баяр хөөртэй болгоно, нөгөө талаараа бол чөтгөр шуламсийг хөөж буй хэрэг аж. Жишээ нь, гэрлэх ёслолын үеэр гэх мэт. Гэхдээ та бүхэнд сануулж хэлэхэд хятад хүн юу ч болсон салют буудуулах тун дуртай. (Бүгд инээлдэв.)

Хүн нас барахад буудуулна, гэрлэхдээ буудуулна, сэтгэл санаа тавгүйтвэл буудуулна, баярлавал буудуулна. Төрсөн өдрөөрөө буудуулна. Чин Хайн өдрийг тэмдэглэхдээ бас буудуулна. (бүгд инээлдэв) Багшийн төрсөн өдөр, эсвэл Чин Хайн өдрөөр та нар зөндөө л сонссон. Тэдний гаргах элдэв янзын дуу авиа нь бидний чихийг дүлийрүүлэх шахдаг. Тэд үүндээ дуртай, цохиж нүднэ, салют буудуулна, бид ч одоо бүр дасчихжээ.

Салютыг хятадууд хэдэн мянган жилийн өмнө зохион бүтээсэн. Тэр цагт зөвхөн баярлан цэнгэлдэх үедээ

хэрэглэдэг байв. Хожим нь европчууд ирснээр салютыг хүн алахад хэрэглэх болжээ. Ингэж буу анх үүссэн түүхтэй. Хамгийн эртний буу шийдэм нь Хятадуудтай байлдахад зориулагдсан байв. Өмнө нь хятадад буу байгаагүй, хамгийн анх европчууд хятадуудын салютын дарь хийх аргыг мэдээд буцахдаа дарь худалдан авч явжээ. Тэгээд түүнийг өөрчлөн буу болгосон байна. Эргүүлээд түүнийгээ хятадуудад худалдав. Тэр үед хятад улс хамгийн анхны их буу, тэсрэх бөмбөг бүхий цэрэг армитай, хамгийн хүчирхэг байлдан дагуулагч орон болсон юм. Тиймээс яг үүн шиг, анх зохион бүтээгдэхдээ ямар ч аюулгүй, хүүхэд тоглоход зориулагдсан зүйл байснаа хожим уг зүйлийг хэн нэгэн нь хүмүүсийг хөнөөхөд ашиглах болсон байна.

Мөхөөлдсийг ч мөн хятадууд зохиосон. Өөр бас олон зүйл бий. Тиймээс европчууд анх хятадад ирээд юутай үзэсгэлэнтэй вэ? хэмээн дуу алдаж, яг л хүүхдийн зохиолд гардаг үлгэрийн орон оршин байна гэцгээж байв. Үзэсгэлэнт бүсгүй зэрлэг араатнууд дагуулан ирвэл маш их төвөг учирдаг шиг юмс үргэлж л ингэж өрнөнө. Тиймээс би үнэндээ та нарт яаж хэлэхээ бас мэдэхгүй байна, хэрвээ чи маш их гоо үзэсгэлэн, авьяас чадвар, эд мөнгөтэй байсан ч эсрэгээрээ энэ бүхэн чинь бусдын атаархлыг хөдөлгөж, улмаар чамайг зовоож, эсвэл чиний азгүйтэхийн эх үндэс болно. Тиймээс эгэл жирийн тарчигдуухан амьдралаар амьдарч, эд хөрөнгийг нэг их тоох хэрэггүй гэж би та бүхэнд заавал хэлэх хэрэгтэй юу? Тэгвэл та нарын амьдрал хожим нилээд тухгүй болно байх, ялангуяа америкт Хималайн ууланд байгаа мэт явган явбал чи өлсөж үхнэ. Учир нь хамгийн ойрын супермаркет хүртэл гурван цаг давхих хэрэгтэй байдаг. Энд бүх зүйл цагаар хэмжигдэнэ.

Хаанд өргөсөн бэлэг - хүн робот

Хятадад Жоу Мубан хэмээх нэгэн хаан байжээ. Ойролцоогоор хоёр мянган таван зуун жилийн өмнө оршиж байсан Байлдаант улсын үеийн нэг хаан юм. Тэр нэгэн удаа гөрөөлөхөөр явжээ. Ихэнх хаад уйдсан, эсвэл хийх ажилгүй үедээ ан хийдэг. Үнэхээр аймшигтай! Хүн алахгүй бол ан амьтан алдаг. Тэд цаг үргэлж өөрсдийгөө хэрхэн дайтахад бэлтгэнэ. Анхнаасаа л буруудсан хэрэг, тиймээс хятадын түүх ердөө л дан ганц дайны түүх мэт болсон байна. Өөрсдөө дотроо дайтахгүй бол хөрш оронтой дайтна, эсвэл ан амьтантай дайтна.

Энэ хаан ч бас адилхан. Тэрээр ууланд очиж ан агнав. Тэр уулыг Ян уул гэнэ. Ан авлаж дуусаад ордон руугаа буцах замд нь нэгэн хүн эд зүйл бус, харин төгс төгөлдөр ур чадвартай нэг мужааныг хаанд өргөл болгон өгчээ. Түүнийг мужаан Ян гэнэ. Хаан тэр мужааныг дуудаж ирүүлээд: За чи ямар ямар авьяас чадвартай вэ? хэмээн асуухад хаанд өргөл барьц болж ирсэн тэр мужаан ингэж хариулав. “Эрхэм дээдэс ээ, таны хий гэсэн бүхнийг би хичээнгүйлэн хийх болно. Гэхдээ би өмнө нь нэгэн төхөөрөмж зохион бүтээсэн. Тэр бол хүн-робот. Хэрвээ хаантан таалвал танд өргөл болгон мэлмийг тань баясгая, эрхэм дээдэс болгооно уу” гэв. Хаантан: Мэдээж, тэгэлгүй яахав, маргааш түүнийг надад үзүүлэхтүн гэв. Маргааш нь хаанд авчирч үзүүлэхэд хаан ихэд гайхан мужаанаас: Чиний ард яваа хүн хэн бэ? гэхэд мужаан, тэр бол миний зохион бүтээсэн хүн-робот гэжээ. Үнэхээр ялгахын аргагүй адилхан байсан тул хаан хүртэл хууртагдаж, ард нь хэн нэгэн хүн яваа мэтээр харжээ. Одоогийн хүн–робот ч бас тийм адилхан байж чаддаггүй шүү дээ. (Бүгд инээв.) Харьцуулшгүй!

“Гурав дахь төрлийн уулзалт” гэдэг кинонд гардаг хүн–робот яг гэрийн тоос сорогч шиг хавтгай байдаг, хүнтэй огтхон ч төсгүй тул биднийг хуурч дөнгөхгүй. Гэтэл энэ хүн

2500 жилийн өмнө хүнээс өчүүхэн ч ялгагдахгүй хүн-робот бүтээж байжээ. Мэдээж бусад гараг дээр ч бас ийм нээлтүүд түгээмэл байсныг би сонсож байсан.

Энэ хүн–робот үнэхээр хүнтэй адилхан, хаан эзэн ихэд гайхан цочирдож, тэр хүн-роботыг ширтсээр байв. Тэр алхана, гүйнэ. Бас яг л хаан болон их түшмэдэд бид мэхийн ёсолдог шиг хаанд мөн мэхийн ёслоно. Түүний үйл хөдлөл яг хүн шиг, жинхэнэ хүн шиг байв гэнэ.

Түүнийг зохион бүтээсэн мужааныг бид шинжлэх ухааны эрдэмтэн гэж бас болно. Мужаан, хүн - роботын эрүүнд хүрмэгц дуулж эхлэв. Дуу нь маш уянгалаг бөгөөд цэвэр тунгалаг. Мужаан түүний гарт хүрмэгц бүжиглэж эхэлжээ. Тэр нь их хэцүү хөдөлгөөнтэй, нарийн төвөгтэй бүжиг байлаа. Яг л бүжгийн урлагийг бүрэн эзэмшсэн бүжигчин мэт байжээ. Үүнээс гадна, тэр бас янз бүрийн хөгжмийн зэмсгээр тоглож үзүүлэв. Яг л арга барилыг нь бүрэн эзэмшсэн, авьяас билиг төгөлдөр, сайтар сургагдаж бэлтгэгдсэн хүн шиг байлаа. Хий гэсэн бүхнийг хийж гүйцэтгэж чадаж байв. Энэ хүн – робот ийм уран нарийн, чадвар төгс байсан нь хаан эзнийг үнэхээр цочирдуулж, жинхэнэ хүн хэмээн бодоход хүргэв.

Тэр үед хааны хамгийн хайртай бага хатан нь хамт үзэж байсан бөгөөд мөн тэнд байсан өөр олон хатан, татвар бүсгүй бүгд гайхсандаа ангайж хоцорчээ. Хүн-роботын үзүүлбэр дууссаны дараа бүгд нүд ирмэлцэж гэнэ. (бүгд инээлдэв) Тэр бас хааны хамгийн хайртай бага хатан луу нүд ирмэж, сэтгэлээ илэрхийлжээ. Ингээд асуудал эхэлж, хүн-робот яг жинхэнэ хүн шиг байсанд хаан ихэд уурлав. Учир нь залуус охид бүсгүйчүүд рүү нүд ирмэх мэт зан гаргасанд уурлаж, бас харджээ. Хаан түүнийг амьд хүн хэмээн бодож, түүнийг бүтээсэн мужаан болон хүн-робот хоёрыг алахыг хүсчээ.

Хаанд тэр үнэхээр жинхэнэ мэт харагджээ

Хүн–роботыг бүтээсэн мужаан ихэд айж, даруй сөгдөөд; Эрхэм дээдэс ээ! Та бүү хилэгнэ. Энд эндүүрэл гарчээ. Хүн-робот бол жинхэнэ хүн огт биш. Тэр хүн биш шүү. Би танд баталж үзүүлье! гээд хэдэн шураг сугалан автал хүн-робот газарт хөсөр унаад боссон ч үгүй, хөдөлсөн ч үгүй гэнэ. Дараа нь Ян мужаан хүн-роботын гар, хөл, гэдэс, чих гээд бүгдийг задалж, түүний бүх бие нь зөвхөн машин төдий, жинхэнэ хүн биш гэдгийг хаанд батлан харуулав. Дотор эрхтэн элэг, зүрх, бөөр бүгдийг модоор, төмрөөр хийгээд будгаар буджээ. Бүгдээрээ угсарсан эд анги байв. Гэсэн ч яг л жинхэнэ хүн шиг арьсан доор нь цусны эргэлтийн системийн артер, венийн судаснууд нь байгаа мэт харагдаж байлаа.

Мужаан хүн–роботын шүд, чих, нүдийг нэг нэгээр нь салгаад хаанд шалгуулав. Эцэст нь хаан жаахан итгэж гэнэ. Хаантан Ян мужааныг зүрхийг нь аваадах, юу болохыг харъя гэхэд хүн-роботын ам нь хамхигдаад дахиад юу ч дуугарахгүй болов гэнэ. Элгийг нь гаргаад ир гэхэд нүд нь анивчихгүй, юм харахгүй болжээ. Бөөрийг нь автал явж чадахгүй болов гэнэ. Хааны санаа нь амарч, нээрээ л хүн-робот төдий юм байна гэж бодоод итгэжээ. Хааны уур хилэн ч дарагдаж, атаархах сэтгэл нь алга болж, улмаар тэр хоёрыг өршөөн хэлтрүүлжээ. Гэсэн ч хаантан толгой сэгсрэн гайхширч: Чи үнэхээр Эзэн Бурханыг төлөөлмөөр байгаа хэрэг үү? Чи бүтээгчийн ажлыг хийж чадах уу, эсвэл түүнтэй өрсөлдмөөр байгаа юм уу гэх мэтчилэн бодов. Магадгүй л юм! Мэдээж зохион бүтээгч юу ч ойлгохгүй байх л даа. Тэр бол зөвхөн нэг агуу эрдэмтэн. Дараа нь хаантан шадар туслахдаа хандан энэ хоёрыг тэргээр гэрт нь хүргэж өг хэмээн тушаажээ.

Дэлхий дээр үнэхээр үнэхээр “шинэ” нээлт байдаг уу?

Хятадууд өмнө нь үүлэнд дээгүүр аялдаг төхөөрөмж зохион бүтээжээ. Үүлэн дээр гардаг учраас түүнийгээ үүлэн шат хэмээн нэрлэсэн байна. Энэ нь бараг хамгийн эртний онгоц юм. Тухайн үед ийм төхөөрөмж байсан нь үнэхээр гайхамшиг байв. Түүнийг өөр нэгэн хүн өөр нэгэн газар оронд зохион бүтээжээ. Бас нэг хүн нисдэг шувуутай төстэй зүйл бүтээсэн байна. Энэ нь магадгүй нэг төрлийн онгоц байх. Зохион бүтээсэн хүмүүс бүгд л өөрийгөө хамгийн сайн, дээд зэргийн зүйл бүтээлээ гэж бодно. Гэтэл хэн ч хүнээс ялгаагүй хүн-робот бүтээнэ гэж бодож төсөөлөөгүй байсан биз. Тиймээс тухайн үед хүн–робот бүтээсэн нь өмнө нь бүтээгдсэн нисдэг шувуу, үүлэн шат зэргийг бүдэгрүүлсэн аж. Магадгүй хятадууд өмнө нь харь гарагийн нисдэг биет, онгоц гэх мэт багажтай байсан байх. Харахад яг л тийм байсан мэт, тэр ч бүү хэл хүн–роботтой. Тэр нисдэг шувуу, үүлэн шат зэргийг зохион бүтээсэн хүн, хүн-робот гарсныг сонсоood амаа хамхиж, өөрийн бүтээлээ дахин шагшин магтаж зүрхлэхгүй болсон байх. Эд бүгд байлдаант улсын үеийн хүмүүс байжээ.

Байлдаант улсын үед хачирхалтай үйл явдал олон болдог байсан гэж би сонссон. Жишээ нь, тэр үед маш олон онцгой хүн байсан бөгөөд бараг л өөр гарагаас хүрч ирсэн, бидний ярьдаг харь гарагийн хүмүүс шиг, тэд олон зэр зэвсэгтэй байжээ. Өнөөдөр бидний сонссон харь гарагийн хүмүүсийн хэрэглэдэг зэвсгүүд, жишээ нь, лазер буу хүнийг мэдээгүй, хөдөлгөөнгүй болгоно. Тэр ч бүү хэл бүхнийг устгах чадалтай.

Байлдаант улсын үед ийм хүмүүсийг Му хүн гэдэг байсан бөгөөд тэдний үг, үйлдэл яг илбэ мэт байдаг. Дайснаа ялагдуулахын тулд агаарт хийсвэр зүйл тун олныг бий болгодог бөгөөд түүнийг нь задлах ямар ч боломжгүй.

Тэр үед бараг гараг хоорондын дайн болсон байх. Тиймээс гараг хоорондын дайн нь зохиомол зүйл биш юм. Нэг хэсэг нь бодитой болсон хэрэг. Эс бөгөөс гурван мянган жилийн өмнө алс холын хятад орон, тэр үед хятад, америк, европын хооронд ямар ч бодитой холбоо харилцаа байгаагүй. Тэгэхээр тэд яаж ижилхэн хэрэг явдал ярих билээ?

Тухайн үед тэд жирийн зэр зэвсэг хэрэглээгүй. Тэд буу, лазерын буу мэтийн маш хүчтэй устгах чадал бүхий зэвсэг хэрэглэж байсан тухай бичжээ. Хятадууд тэр үед тэднийг их хувилгаан, өндөр дээд ертөнц, диваажингаас ирэгсэд хэмээж байв. “Хаадыг хорьсон бамбар” кинонд гардаг шиг. Тэгэхээр энэ бол үнэн бодитой. Хятадын түүхэн сурвалжуудад ч бас эдгээрийн тухай тэмдэглэсэн байдаг. Төсөөлөл биш юм. Иймээс хүмүүс гурван мянган жилийн өмнө орчин үеийн багаж төхөөрөмжтэй байсан, бүр ч илүү дэвшилттэй байжээ.

Саяхан би сонинд гурван мянган жилийн өмнө цөмийн бөмбөг байсныг батлах эд зүйл олдсон тухай бичсэнийг уншсан. Археологчид, цөмийн бөмбөгөнд сүйрч, газарт булагдсан үлдэгдлийг малтлагаар илрүүлэхэд уг үлдэгдэл одоо ч цацраг идэвхт бодис ялгаруулсаар байгааг хэмжилтээр тогтоож, цөмийн бөмбөгийн үлдэгдэл гэж үзэж байна. Магадгүй Библид гардаг Родын эхнэрийн тухай түүх нь энэхүү гурван мянган жилийн өмнөх цөмийн бөмбөгийн үлдэгдэлтэй яв цав тохирно. Иймээс, манай гараг дээр ямар нэгэн улс төрийн шалтгаанаас, эсвэл улс төрийн өөр өөр тогтолцооноос болж, бид өөрөө өөрийгөө сүйрүүлсэн, эсвэл өөр гарагтай байлдаж сүйрсэн бололтой. Нарны дор цоо шинэ зүйл огтхон ч байхгүй. Тиймээс бид одоо мэдэж байгаа, эсвэл эзэмшсэн шинжлэх ухааны аливаа ололт амжилтандаа бардамнах хэрэггүй. Бидний өвгө дээдэс энэ бүхнийг хэдийнээ мэддэг байсан, бараг биднээс ч илүү сайн хийж байжээ. Гэвч тэд юунд ашиглаж байв? Бие биенээ

устгаж хөнөөх, доройтуулахад л ашигласан. Магадгүй санамсаргүй, эсвэл зогсоохын аргагүй дайны ажиллагаа байсан байх. Тиймээс та бүхэн хар! Сайн юм ер үгүй байна. Хүн алах арга, багаж хэрэгслийг зохион бүтээх нь хүн төрөлхтөнд ямар ч ач тусгүй. Гэвч хүн төрөлхтөн одоо ч үүнээс сургамж аваагүй хэвээрээ, бие биенээ алж хөнөөсөөр байна.

Дэлхийн бүх улсын удирдагч хятадын "Гурван улсын түүх", "Байлдаант улсын бодлого", "Хаадыг хорьсон бамбар" зохиолыг заавал унших хэрэгтэй. Тэд тэндээс нилээд зүйл сурч болох билээ, гэхдээ тэд: "Хөөх бас л хятадууд, тэдний төсөөлөх чадвар тун баялаг юм" гэж бодох байх. Зарим нь зохиолын бодит үйл явдлуудад үл итгэнэ, би "Байлдаант улсын бодлого" зохиолыг уншаад одоо бидэнд байгаа шиг гайхамшигтай зүйлс тэр үед их байсныг ойлгосон. Жишээ нь, уг зохиолд маш ухааалаг тэр хүмүүс дайснаа шидийн хүчээр дардаг байжээ. Мэдээ хүлээж авах аргатай байсан бөгөөд хэн нэг нь агуйд, эсвэл гэртээ бясалган сууж байхад гэнэт этгээд сонин салхи хажуугаар нь сэвэлзвэл эхлээд өнгөрөөнө, дараа нь салхийг атгаж аваад түүнд байгаа мэдээ юу болохыг үзнэ. Та нар уншвал ойлгоно. Уншаагүй бол заавал уншаарай. Тэр тун давгүй ном. Хятадын уран зохиолын эрдэнэсийн нэг. Би тун бага байхдаа уншиж байсан. Тэр үед би 7, 8 настай л байсан. Гэсэн ч би тэр номд үнэхээр дурлаж, өдөр шөнөгүй уншиж билээ. Тэр номны гайхамшигтай ер бусын ертөнцөөс аав намайг татан гаргах хүртэл (бүгд инээв) уншсан. Дараа нь би өөр газар хайж олоод үргэлжлүүлэн уншив. Эсвэл аавыг явсны дараа уншдаг болов. Үнэндээ маш их сэтгэл татаж байсан. Хятадын уран зохиолын оргил зохиолуудын нэг гэдгийг би тэр үед мэдээгүй ч гар тавихгүй уншиж дуусгасан.

Хятадын эртний уран зохиолуудыг би бараг нэгийг ч үлдээлгүй бүгдийг уншсан. Алдартай зохиол гэж сонсвол

шүүрч аваад уншина. Тэр үед би их жаахан байсан, бараг долоон настай л байсан байх. Хятадын бараг бүх хаант улсын ихэнхийх нь "учрыг олчихсон", бүгдийг нь "буулгаад авчихсан" байж билээ. (Багш болон нийтээрээ инээлдэж, алга ташив.)

Тиймээс та бүхэн анзаарвал, түүх тасралтгүй давтагддаг, энэ үг бидний амнаас байнга гардаг ч үнэндээ бид хэзээ ч бодит үнэнээр нь ойлгоогүй, түүхийг эрхшээх арга зам олохыг бодоогүй байдаг. Өнөөдөр олон орны эрх баригч түүхийг муу зүйлийн замч болгохыг санаархан цуст түүхийг давтахыг оролдож байна.

Дэлхийн хүмүүс бүгд сэрж сэхээрэх болтугай

Би, дэлхийн хүмүүс нэгэн өдөр бүгд сэрж сэхээрэн үнэнд ёсонд эргэн нэгдэж, Арьяабалын аргаар бясалгахгүй ч энх тайвнаар зэрэгцэн оршоосой хэмээн хүсдэг. Хүн бүхэн энх тайвны тухай ярьдаг. Засгийн газрууд ч бас: "Бидэнд эрх чөлөө, ардчилал хэрэгтэй. Ард түмний төлөө, улс орны хөгжил цэцэглэлтийн төлөө, эрх чөлөөний төлөө, тэгш эрхийн төлөө, түгээмэл хайрын төлөө..." гэж өндөр дуугаар уриалдаг. Гэтэл тэд улс орон, ард түмнийхээ төлөө яг юу хийсэн бэ? Үнэхээр инээдтэй шүү, тэд ийм зүйл ярьчихаад орой нь яаж амар тайван унтаж чаддаг юм бол гэж би их гайхдаг. Хар, цагаан, худал үгээр дүүрсэн, хийж буй юм нэг ч үгүй. Эсвэл тэд хэтэрхий хийрхэж, хаана алдаад байгаагаа харахгүй болжээ. Эсвэл тэд төрөлхөөсөө ийм чанартай байж магадгүй. Тийм учраас энэ бүхэн тэдний хувьд хэвийн үзэгдэл байх. Яг л загас усандаа, шувууд тэнгэртээ байх мэт хэвийн. Зарим хүн төрөлхийн алуурчин, угаасаа л хар санаатай, туйлын сөрөг, алж устгахдаа угийн сурамгай, бүр үй олноор хоморголон устгана. Хэрвээ чи энд хүн алах юм бол асуудалд орно. Харин дайны үед тэдний бууны ам

хэдэн зуун мянган ямар ч гэм зэмгүй энгийн ард, хүүхдүүд рүү чиглэдэг. Гэтэл тэднээс хүмүүсийн амийг нэхэх хэн ч байхгүй. Тэд зөвхөн: "Арай ч хэцүү юм боллоо. Дайнаас болж олон зуун хүний амь нас, гэр бүл хохирч сүйрлээ. Үр хүүхэд өнчирч, эд хөрөнгө шамшигдлаа..." гэцгээнэ. Гэвч энэ талаар хэн ч ярихгүй. Магадгүй үүний дараа тэд уучлал гуйх байх. Заримдаа бараг уучлал ч гуйхгүй дээ.

Хэрвээ тэд үнэхээр санаа зовж байгаа бол дайны галыг зогсоож, дахин дайн хэзээ ч дэгдээхгүй. Гэвч яагаад ийм олон удирдагч дайн дэгдээх дуртай байдаг вэ? Учир нь дайн тэдэнд ямар ч нөлөөгүй. Хичнээн хүн үхэж, хичнээн их улсын эд баялаг үрэгдсэн ч хамаагүй, тэд санаа зовох зүйлгүй, хүнс хоолонд санаа зовохгүй. Урьдын адил тансаг амьдарсаар байдаг. Үнэтэй тансаг машин хөлөглөн хувийн онгоцоор зугаална, хувийн бие хамгаалагчтай, хамгийн сүүлд улс орон нь бүрэн дампуурахад улсынхаа бүх эд хөрөнгийг хамж аваад хувийн онгоцондоо суугаад баяртай гэх болно. Тэд хаана ч очсон сайхан амьдарсаар байдаг. Өөр нэгэн газрын хаан болно, гэхдээ газар нутаггүй хаан.

Тиймээс маш олон удирдагч дайн ба энхийг үл тооно. Учир нь тэд бол жинхэнэ удирдагч биш. Зөвхөн алба тушаалаа ашиглан өөртөө эд баялаг хуримтлуулах зорилготой, эрх мэдэл, ганцаар ноёрхох хүсэлтэй. Тиймээс бид удирдагчаа сонгохдоо туйлын хянамгай байж, зөв хүнээ сонгох хэрэгтэй. Мэдээж бид төгс төгөлдөр, бидний санаанд бүрэн нийцэх нэгнийг олж чадахгүй ч ядаж л хамгийн сайныг нь, бусдыг шархлуулахгүй, гавьяа байгуулахгүй ч гай тарихгүй. Биднийг хамгаалж чадахгүй ч ядаж хорлохгүй. Хамгийн наад зах нь ийм хүнийг олж сонгох хэрэгтэй. Тэр юу ч ярьсан эхлээд бид үйлдлийг нь сайтар ажиглаж, ийм нэг ерөнхийлөгч, ийм нэг хаан бидэнд үнэхээр тус болж чадах уу гэдгийг мэддэг байх хэрэгтэй. Ерөнхийлөгчийг бол сольж болно, харин эрх баригч нь хаан бол сайтар

бодох хэрэгтэй. Хэрвээ чи хувьсгал хийвэл хамгийн түрүүн толгойгүй болно. Одоо бидэнд ганцаар эзлэн захирдаг хаант засаглал байхгүй нь үнэхээр зол юм. Өмнө нь хаан бол Эзэн Бурхан гэсэн үг. Хэн ч түүнийг эсэргүүцэж болохгүй. Амаа сайн хамхиж явахгүй бол даруй толгойгүй болно.

Чи юу ч хэлж чадахгүй. Эгцэлж харж ч болохгүй. Хаан эзэн гадагш аялах бүрд чи газарт сөгдөөд түүнд мөргөх ёстой. Хэрвээ толгой өргөн харваас толгойгүй болно. Хааны царайг харж амжилгүй толгой чинь өөр газар хэвтэж байж магадгүй. (Бүгд инээлдэв.)

Газар сайгүй маш чанд хатуу. Хичнээн хүн өлсөж даарахын зовлон эдэлж, халуунд халж хүйтэнд хөрч, байгалийн гамшигт нэрвэгдэж байсан ч хаан эзэн хамгийн тансаг амьдарч байдаг. Хатдын ордондоо гурван мянган гоо үзэсгэлэнттэй. Үй олон тайган. Тэдэнд ямар ч хүндрэл бэрхшээл байхгүй. Жинхэнэ зовлон гэж юу болохыг тэд хэзээ ч мэдэж байгаагүй юм.

Хайрын хичээл

Францийн хатан хаан Мари-гийн (Marie Antoinette) тухай алдартай түүхийг та бүхэн мэдэх үү? Тэр алтан халбага атгаж төржээ. Хүмүүс түүнд ард түмний амьдрал бэрх байна, идэх талх ч үгүй болов, өлсгөлөн нүүрлэв гэсэн санааг мэдээлэхэд талхгүй болсон бол бялуу идэхгүй юу (Хүмүүс инээлдэв.) гэж хариулжээ.

Талхгүй болно гэдэг нь идэх юм юу ч үгүй болсон гэсэн үг. Талх ч үгүй байхад бялуу яаж байх билээ дээ? Гэвч тэр ийм байдлыг ер ойлгохгүй, талх бол эгэл ардын хувьд бүх юм нь, өдрийн гурван хоол нь, амь амьдрал нь гэдгийг тэр мэдэхгүй. Хятад хүмүүс: Бид идэх будаагүй болсон! гэвэл энэ нь идэх юмгүй болж, өлсөж байна гэсэн санаа.

Будаа бол хоол хүнсний бэлгэдэлт хэлц. Яг л америкчууд, европчуудын талх шиг.

Мари хатан хаан магадгүй хэзээ ч өлсөж байгаагүй байх. Хазгай газар гишгэж үзээгүй, мөн өмнө нь ордноос гарч, ард түмний аж амьдралтай танилцаж байгаагүй байх. Түүний очсон газар бүхэнд хүмүүс хаацайлж халхлаад эсвэл ардын амьдралын үнэн байдлыг нуун дарагдуулдаг байсан, эсвэл түүнийг тойроод бас олон давхар хамгаалалттай болохоор юу ч харахгүй. Тэгэхээр ард түмний амьдралыг бүр ч харж чадахгүй. Магадгүй тэр тийм ч хүйтэн сэтгэлтэй хатан хаан байгаагүй байх. Гэвч түүний амьдрал дэндүү их хамгаалалт, дэндүү олон худал яриа, хэт чухал биш хүрээллээр дүүрсэн байжээ. Тиймээс зарим хаан, хатан хаан юу хийж байгаагаа мэдэхгүй. Үнэхээр хэцүү шүү!

Хүмүүс хувьсгал хийж, эзэн хаан, хатан хаанаа цаазын тавцанд гаргадаг нь бас аргагүй юм. Тэд дарангуйлал, дангаар ноёрхох улс төрийг өөрчилж, хүмүүсийн ахуй амьдралыг сайжруулахыг хүсдэг.

Эрт дээр үед бол чи хаан эзний өөдөөс дуугарах эрхгүй, буруутгаж бүр ч болохгүй. Одоо ч мөн адил болохгүй хэвээрээ л байна. Гэвч зарим нэгэн ерөнхийлөгчтэй бол ингэж ярьж болно. Ядаж л өмнөх үеийг бодвол арай эрх чөлөөтэй болж, жаахан ч гэсэн өөрчлөгджээ. Өмнө нь бид хааныг, засгийн газрыг шүүмжилсэн үг хэлж болохгүй, зөвхөн тэднийг үг дуугүй дагаж, хий гэснийг нь хийдэг байв.

Харин өнөөдөр та ерөнхийлөгчийг, засгийн газрыг шүүмжилж болно. Гэхдээ тэдний даалгасан ажлыг нь харин хийх ёстой. (Бүгд инээлдэв.) Ялгаа нь гэвэл бид үг хэлэх эрх чөлөөтэй болжээ. Та чөлөөтэй хэлж ярьж болно, гэхдээ ажлаа хийх хэрэгтэй. (Багш болоод хүмүүс бүгд инээлдэв.) Үнэндээ нэг их ялгаагүй. Гэвч хүмүүс шүүмжилвэл тэд

ядаж л жаахан цочроо авах юм даа. Би их эрх чөлөөтэй байна. Ядаж л санасан бодсоноо хэлчихнэ. Хэлсний дүнд дараа нь зарим буруу ойлголт арилна. Тиймээс хийх л хэрэгтэй. Гэхдээ хүмүүс тийм их дарамт мэдрэхгүй. Энэ бас нэг асуудал.

Би та нарт нэг орос онигоо ярьж өгсөн билүү? Нэгэн америк хүн орост ажлаар очжээ. Тэнд маш олон нууц цагдаатай, хүмүүс нь их айдастай, огт инээдэггүй болохыг олж харсан байна. (Одоо ямар болсныг би мэдэхгүй, энэ бол нилээд дээр үеийн явдал) Тиймээс тэр найзаасаа: Яасан, юу болов? Та нар юуны ч талаар ярьж зүрхэлдэггүй юм байна. Америкт бол хүмүүс засгийн газар, ерөнхийлөгчөө хэзээ ч, ямар ч цаг үед, ямар ч хэргээр шүүмжилж болно гэхэд орос найз нь: Тийм тийм, манай энд америкийн засгийн газар, ерөнхийлөгчийг хүссэн үедээ шүүмжилж болно гэж хэлжээ. (Багш болоод хүмүүс бүгд инээлдэж, алга ташив.)

Ирээдүй бидний гарт

Вьетнамд харь гарагийн нисдэг биет газардсан тухай би өмнө нь та бүхэнд ярьж байсан. Бараг дөрвөн мянган жилийн өмнөх явдал юм. Тухайн үед харь гарагийн тэр хүн Вьетнамыг аврахаар иржээ. Тун жижигхэн биетэй ч маш том, хүч чадалтай болон хувираад галт мориор тэнгэр рүү нисэн оджээ. Галт морь газарт буухад газарт дугуй нүх үүсэв. Тэр ямар төрлийн морь байсан бол? Яг л хөл бөмбөг шиг бөв бөөрөнхий байсан байх. За ямар янзтай ч байсан харахад жирийн морьтой адилгүй төдийгүй, төмрөөр хийсэн байжээ. Хоёр талаасаа галаар тургина, уг галын дөл хүрсэн газарт дайсан заавал устана. Тэр морь, түүнээс гарах галын дөлийг эсэргүүцэх ямар ч аргагүй. Сонсоход яг л галладаг буу, нисдэг биет зэрэг орчин үеийн төхөөрөмж шиг санагдана.

Манай энэ цаг үе бол хамгийн хөгжингүй үе, бүх зүйлийг бид бүтээсэн, маш их зүйлийг мэддэг гэж бид байнга боддог. Гэвч үнэн хэрэгтээ бид түүхийг дахин сайтар унших хэрэгтэй, даруу байхад суралцах хэрэгтэй. Урам зориггүй биш, харин хүсэл мөрөөдлөөр дүүрэн байвал зохино. Хэрвээ эртний хүмүүс ийм хөгжингүй дэвшилд хүрсэн юм бол бид ч бас ирээдүйд хүрч чадна. Гэвч бидний суралцах хичээл бол хүн төрөлхтний цэцэн мэргэн оюун ухааныг урвуулан ашиглаж болохгүй. Харин өөрийн дотоодыг дасгалжуулж, ёс зүй, зан суртахууны хэм хэмжээг бататгах төдийгүй, эрхэм дээд хүсэл мөрөөдөлтэй, асран нигүүлсэх хайр энэрэлтэй бол бид ямар ч машин техник зохион бүтээсэн, аюултай байсан ч түүнийг энхийн зорилгоор ашиглаж, хүн төрөлхтөнд үйлчилж, соёл иргэншлийн хөгжлийг хурдасгана. Харин харилцан биесээ хөнөөхгүй. Хүн бүхэн үүнд суралцаасай гэж би хүсдэг. (Бүгд алга ташив.)

Аравдугаар бүлэг

ХАТУУ ЗӨӨЛНИЙГ ХОСЛУУЛЖ ЧАДВАЛ ТӨГС ТӨГӨЛДӨР МӨН

Күнз болон түүний шавийн түүх

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Хонконг, Шатин, Тэндао ашрам
1994 оны 4 дүгээр сарын 6. (Эх нь хятад хэлээр)

Күнз болон түүний дөрвөн шавь

Күнз болон түүний дөрвөн шавийн тухай нэгэн түүхийг Лизи бичжээ. Нэгэн Зисиа нэрт хүн Күнзээс: Янхуй ямархуу хүн бэ? хэмээн асуужээ. Күнз маш олон шавьтай, тэдний нэгийг нь Янхуй гэдэг үү? (Тийм гэж нэг нь хариулав) Күнз: Янхуй надаас илүү шударга! гэв. Тэр үргэлжлүүлэн: За тэгвэл, Зихиен ямархуу хүн бэ? гэж асуухад Күнз: Зихиены мэтгэлцэх чадвар надаас илүү гэв. Зисиа дахин Күнзээс: За тэгвэл, Зилу ямар хүн бэ? гэхэд Күнз: Зилу надаас илүү эр зоригтой гэв. Зисиа дахиад л:

Зижан ямар хүн бэ? гэж асуухад Күнз: Тэр надаас илүү сүр жавхаатай гэлээ.

Дараа нь Зисиа босож зогсоод Күнзээс: Тэгвэл тэр дөрөв яагаад заавал таныг даган суралцахаар ирсэн юм бэ? гэж асуув. Дөрвүүлээ аль нэг талаараа Күнзээс илүү байтал яагаад заавал түүнээс суралцахаар ирэв гэсэн санаа, Күнз: Та суугтун! гэв. Түүний сэтгэл нь ихэд хөдөлснөөс босож зогссон аж. Та суу, суу, би танд хариулъя. Та мэдэхгүй байна гэж үү! Янхуй өршөөл энэрлийг мэднэ, гэвч ямар үед өршөөж энэрэхгүй байхыг үл мэднэ. Зихиен мэтгэлцэж чадна. Гэвч тэр ямар үед үл дуугарахыг мэдэхгүй. Хэдийд нь үл мэтгэлцэж, хэдийд нь дуугүй байхыг мэдэхгүй гэсэн үг. Юм бүхнийг мэддэг, цаг үргэлж мэтгэлцдэг байх хэрэггүй. Энэ нь хүмүүст төвөг уддаг! Тийм биз?

Күнз үргэлжлүүлэн: Зилу эр зоригийг мэднэ, харин яаж айдгийг мэдэхгүй. Айсан дүр эсгэж мэдэхгүй, айх ёстойг мэдсэн үедээ ч жинхэнээсээ “айж” мэдэхгүй. Утга нь зөөлөн аядуу байвал зохистой цагийг мэдэхгүй гэсэн үг.

Зижан маш сүр жавхаатай, гэвч найрсаг нийцтэй байх ёсыг үл мэднэ. Тэдний давуу талуудыг нийлүүлээд миний дутуу талтай солилцьё гэвэл би солихгүй. Тэд хичнээн сайн байсан ч тэдний Күнзээс илүү сайн талуудыг нийлүүлээд Күнзийн муу талуудтай сольё гэвэл Күнз солихгүй гэсэн санаа. Тиймээс тэр дөрөв Күнзийн шавь болж суралцахаар заавал ирэх хэрэгтэй байж. Хоёргүй сэтгэлээр гэдэг нь халширч няцахгүй, харамсаж гэмшихгүй гэсэн санаа.

Өршөөл энэрэлтэй байх хийгээд өршөөл энэрэлгүй байх

Энэ маш гайхамшигтай түүх! Өршөөл энэрэл нь юу гэсэн утгатайг та нар мэдэх үү? Нэгэн хүн хүн бүхнийг

хайрлана, сэтгэл нь маш өгөөмөр уужим, бусдыг сайн ойлгоно, амархан уучилна, хүнийг өчүүхэн ч зэмлэхгүй, үргэлж хайраар хандана. Энэ бол өршөөл энэрэл мөн. Хэн нэгэнд асуудал бэрхшээл тулгарсныг сонсвол түүнийг хайрлаж тусална. Хэрвээ хүн алдаа эндэл гаргавал уучилна. Бидэнд яагаад ийм зан чанар байж болохгүй билээ.

Бид яагаад үргэлж ингэж үйлдэж болохгүй билээ? Энэ нь нилээд сайн хэрэг биш үү? Гэтэл Күнз яагаад өршөөл энэрэлгүй байх цагийг бас мэддэг байх хэрэгтэй гэж хэлэв? Энэ нь юу гэсэн утгатай вэ?

Үүнийг мэдэх хүн байна уу? (Зарим хүн: Муу хүнтэй харилцвал гэж хариулав) (Зарим нэгэн хүн: Хүнийг хайрлаж болно, бас хайрлахгүй ч байж болно.., хайрлахгүй гэдэг нь хүнд өршөөл хайраар хандахгүй гэсэн үг. Аль алин нь байх хэрэгтэй.)

Зөв, аль алин нь байх хэрэгтэй. Арга, билгийн тэнцвэр хэрэгтэй. Өршөөх газраа өршөөнө, энэрэх газраа энэрнэ. Өршөөл энэрэл хэрэггүй газар өршөөл энэрлийг үзүүлэхгүй. Энэ жинхэнэ сайн. Миний санаа бас ийм. Ямар нөхцөлд өршөөл энэрэлтэй байх вэ? Ямар цаг үед өршөөж энэрэх вэ? Жишээ нь, нэгэн найз маань хүндрэл бэрхшээлтэй тулгарвал бид сайн найзын хувьд заавал туслах ёстой. Мөнгө санхүүгээр тусалбал бизнес эрхлээд удалгүй биеэ даана. Хэрвээ мөнгөтэй болбол тэр бас бидэнд эргээд тусална. Буцааж төлөхгүй байсан ч бид их тоохгүй. Хэрвээ бид маш их мөнгөтэй байгаад найз маань авч хэрэглэвэл бид бас нэг их тоохгүй, эсвэл ах дүү, хамаатан садан хүмүүс авч хэрэглэвэл бид бас тоохгүй.

Хэрвээ тэр хүн мөнгө аваад бизнес хийхгүй, муу явдал үйлдэж, мөрийтэй тоглож, архи тамхи хэрэглэж, элдэв муу хэрэг хийчихээд дараа нь биднээс дахин мөнгө нэхвэл тэр үед бид урьдын адил өршөөл энэрлээр хандаж

болохгүй! Хэрвээ түүнд муу хүн байхад нь тусалж, нэгэн бусдаас хараат, амиа аваад явж чаддаггүй хүн болоход нь тусалж болохгүй. Бид үргэлжлүүлэн түүнд өршөөл энэрлээр хандаад байвал улам хорлоно. Улам бие даан амьдрах хүсэл зориггүй, сул дорой, бэртэгчин, ямар ч хүн чанаргүй хүн болж хувирна. Ингэж бид нэгэн найзыгаа алдаад зогсохгүй, түүнийг хорлож, амьдралыг нь дампууруулж, эргэж сэргэж босох ямар ч чадваргүй болгоно.

Нэгэн эрдэмтний найздаа зориулсан элдэг бус тусламжийн түүх

Манай хятадад ийм нэгэн түүх байдаг. Хоёр найз хоёулаа бичгийн хүмүүс, сэхээтнүүд байжээ. Тэднийг Луйпин, Янли гэнэ. Нэг нь нилээд хичээл чармайлт сайтай тул эрдэмтний шалгалтанд тэнцэж, хааны ордонд түшмэл болов. Нөгөө найз нь идэж ууж, наргиж цэнгэх дуртай. Хэдийгээр авьяас чадвартай ч ихээхэн залхуу, сурлагаар муу тул шалгалтанд тэнцээгүй аж. Шалгалтанд тэнцээд түшмэл болсон найз нь сэтгэл санаа өөдрөг, бас найзыгаа үргэлж дурсана. Тэд сайн найз байсан болохоор найзыгаа мэдээж тийм ч сайнгүй л яваа даа гэж бодоод хүн явуулж авчруулжээ.

Найз нь ирэхэд өнөөх эрдэмтэн номын өргөөндөө тун завгүй байгаа мэт дүр эсгэж, түүнийг гаднаа удаан хүлээлгэв. Найз нь дахин асуулгахад зориуд нэгэн бага түшмэлийг явуулан угтуулж, хооллож ундлуулаад ядуус, доод тушаалын хүмүүст өгдөг шиг шальдар булдар эд хүргүүлж, эгэл борог зүйлсээр хооллоод олигтой сайхан хүлээж авсангүй гэнэ. Найз нь түүнтэй уулзахыг хүссэн ч завгүй дүр эсгэн дараа уулзъя гэсээр хэдэн өдрийг өнгөрөөжээ. Тэр нэгэн өдөр найз нь хүрч ирэхэд бас л өмнөх шигээ хандаж гэнэ, түшмэлийн шалгалтанд тэнцээгүй

өнөөх ядуу найз нь тун сэтгэл дундуур болж, ихэд үзэн ядаж, ичиж гутраад түшмэл найз дээрээ дахиж ирэхээргүй болов. Хариад өдөр бүхэн их л бухимдалтай байх болжээ. Тэрээр хамгийн их бухимдсан үедээ гэнэт үхмээр санагдаж, юу ч хийх хүсэлгүй болоод байтал нэгэн бүсгүйтэй таарч гэнэ. Тэр тун үзэсгэлэнтэй, ялдам эрхэмсэг хэдий ч өмссөн зүүсэн нь тун борогжуу бүсгүй байв.

Тэр бүсгүйтэй гэнэт таараад хоёулаа уулзан танилцжээ. Бүсгүй түүнийг ихэд урамшуулж, сэтгэл санааг нь ойлгож, найз нь хэрхэн гомдоосныг бас сонсчээ. Бүсгүй түүнийг тэжээж, зүгээр дээ, чи үргэлжлүүлэн сураарай, би даавуу нэхэж, өөр олон гар урлалын зүйл хийгээд чамд тусална. Бас чамд туслаарай гэж дотоодын багшдаа даатгана, чи санаа зовох хэрэггүй дээ гэв. (бүгд инээлдэв) Тэгээд өнөөх залуугийн санаа сэтгэл амарч, хичээл номдоо шамджээ. Залуу бас бүсгүйд сайн сурч, түшмэл болоод чамайг эхнэрээ болгож авна аа гэж амлав. Бүсгүй юу ч хэлсэнгүй, зөвхөн, за тэр үедээ л ярья! Одоо эхлээд сайн суралц! Энэ бол жижиг асуудал, дараа нь болъё гэв. Бүсгүй дандаа л ингэж хэлдэг байв. Залуу түүнтэй ямар нэгэн холбоо үүсгэхийг хичээвч ер бүтэхгүй. Бүсгүй түүнд хичээл номдоо л сайн шамд, хайр сэтгэлийн асуудлаас болж, анхаарлаа бүү сарниул, энэ асуудал хаа хол байна, эхлээд заавал эрдэмтний шалгалтанд тэнцэх хэрэгтэй гэж байнга хэлнэ. Тэгээд залууг амар тайван суралцуулж, харж хандсаар байлаа. Дараа нь залуу шалгалтандаа тэнцэж, эрдэмтэн болжээ.

Шалгалтанд тэнцээд хамгийн түрүүнд очиж уулзсан хүн бол түүний өнөөх уйтгартай, түүнээс урваж, түүнийг дорд үздэг түшмэл найз нь байлаа. Бас түүний урьдын найз юм. Тэр түүнтэй уулзахаар маш хурдан очжээ. Түшмэл болсноо харуулж, олон дагуултай очив. Өмнө нь надад яаж муухай хандсаныг нь хэлж, тэр муу найзыгаа нэг сайн загная гэж боджээ. Тэр удтал загнаж байтал өнөөх найз

нь доод түшмэлдээ хандан нэг зүйл аяархан хэлтэл гүйж гараад нэгэн бүсгүйг дагуулан орж ирэв. Шинэхэн түшмэл бүсгүйг хараад шууд танив, тэр бол гурван жилийн турш түүнийг харж хандаж, хичээл номд нь зоригжуулж байсан нөгөө бүсгүй мөн байлаа. Чи яагаад энд байгаа юм бэ? гэж асуухад хуучин түшмэл: Тэр бол миний эхнэр гэлээ. (Багш болоод хүмүүс инээлдэв.) Ойлгов уу? Найзынхаа төлөө эхнэрээ золиосолсон байна шүү дээ.

Эхнэрээ явуулж, найзыгаа харж хандуулан хичээл номд нь шамдуулжээ. Түүнийг унаж доройтуулахгүйн төлөө, нэгэн чадварлаг хүнийг гарздаж, авьяас чадварыг нь бөхөөхгүйн төлөө тэгжээ. Найз нь мэдээж ойлгоогүй байх, түшмэл найзынхаа сайхан сэтгэлийг ойлгоогүй. Түүнийг маш муухай хандсан гэж буруутган загнаж, өшөө авахыг л бодож байв. Хожим мэдээд өвдөг сөгдөн мөргөв. Тэр хоёр тэврэлдээд сэтгэл нь хөдөлж уйлцгаажээ. Энэ түүхийг та нар сайн мэдэх байх. Хятадын түүх, тийм үү? Энэ түүх Ау Лакт ч бас их алдартай. Эрдэмт хүмүүний өршөөл энэрэлгүй нь ч ийм байдаг аж. Өчүүхэн хүний өршөөл энэрэл заримдаа бусдад хор болох нь ч бий. Гэвч их хүмүүний өршөөл энэрэлгүй нь үнэхээр олон хүнд тусална, өөртөө тусална, бусдад тусална, энэ бол жинхэнэ өршөөл энэрэл мөн. Тиймээс бид ч бас зарим үед өршөөл энэрэлгүй байх гэдгийг мэддэг байх хэрэгтэй. Багшийнхаа санааг ойлгов уу?

Хатуу зөөлнийг хослуулж чадвал жинхэнэ сайн хүн мөн

Энэ түүхээр дамжуулан Күнзийн сургасан өршөөл энэрлийг мэдэж авна. Гэвч хэдийд өршөөл энэрэлгүй байх вэ? гэдгээ мэддэг байх хэрэгтэй, энэ нь хатуу, зөөлнийг хослуулж чадах гэсэн үг. Эс бөгөөс бид өршөөнгүй энэрэнгүй чанартаа баригдана. Хэрвээ бид үхтэл зууралдаад

үл огоорвол энэ нь муу. Зарим үед огоорч орхивол зохино.

Жишээ нь, дайн болбол бид өөрсдийн эрдэнэсийн санг тэврээд очир алмаас, алт, мана, хув зэргийг нийлүүлж боон нуруундаа үүрээд газарт тавихгүй авч явна. Хаана ч очсон үүрээд л явна. Аюул осолгүй газар олтлоо үүрнэ. Гэвч аюулгүй газарт хүрсэн бол буулгах хэрэгтэй. Эсвэл ах дүү, найз нөхөд өлсөж цангавал нэг хэсгээс нь зараад тэдэнд хоол хувцас авч өгнө. Алт эрдэнэсээ хадгалаад бусдыг тоохгүй байж болохгүй. Тиймээс өршөөл хайрыг ч, өршөөл хайргүйг ч хослуулна. Аргаа мэдвэл өршөөл хайргүй нь өршөөл болж болно. Аргаа үл мэдвээс өршөөл хайр нь ч өршөөл хайр биш, хор болж мэднэ.

Олон хүн энэрэл нигүүлсэл гэж их ярьдаг. Хүн энэрэл нигүүлслийн сэтгэл өвөрлөж, буй оршихуй нь энэрэл нигүүлслээр дүүрэх ёстой гэж боддог. Өдөржингөө мишээл дүүрэн царай гаргаж, хэн ч ирсэн: Сайн байна! Сайн байна! (Багш болоод хүмүүс инээлдэв) гэж сууна. Энэ бол тэнэг хэрэг, модон бурхан л ингэх байх. Хүн ийм байж болохгүй. Жинхэнэ эр хүн бол жин банг нь тааруулж, хатуу, зөөлний нь тохируулна. Энд Күнз хэлэхдээ: Би Янхуй шиг өршөөл энэрэлтэй биш гэсэн нь ийм учиртай. Учир нь заримдаа түүнд өршөөл энэрэл байхгүй. Заримдаа яг л өршөөл энэрлийг огоорсон мэт бусдад хайргүй хандах үе түүнд байдаг. Тийм учраас л тэрээр Янхуй-гийн өршөөн энэрэх сэтгэл надаас илүү гэж хэлжээ. Магадгүй Янхуй өдөржингөө өршөөл энэрлээр дүүрэн явна. Хэдийд “үгүй”, ”ойлгохгүй”, эсвэл “болохгүй” гэж хэлэхээ мэдэхгүй. Юм бүхэнд за за, болно, болно гэсэн хүн л явна. Энэ чинь өршөөл энэрэл биш ээ, харин нилээд тэнэгдүү л байдал юм.

Илүү өндөр төвшний өршөөл энэрэл

Тиймээс Янхуй маш өршөөл энэрэлтэй, хайрлангуй нэгэн боловч хайрлангуй бус байх тэр нэг хэсэг нь дутуу. Хайрлангуй сэтгэлээ ямар үед орхих хэрэгтэйг үл мэднэ. Тиймээс жинхэнэ хайранд суралцахын төлөө, илүү агуу их хайрлангуй сэтгэлд суралцахын тулд Янхуй, Күнзийн шавь болжээ. Тэрнээс Күнз өршөөл энэрэлгүй гэсэн үг биш. Харин түүний мэддэг өршөөл энэрэл бол нэн өндөр дэсийнх.

Тиймээс бид нэгэн Төгс Гэгээрсэн хүн энэрэл нигүүлсэлтэй гэх нь хүн төрөлхтөн бидний бодож төсөөлдөг тийм нэг энэрэл нигүүлсэл биш, түүний үйл хөдлөл, арга барил нь бидний төсөөлдөг ёс журам, ачлал энэрэл, ёслол, мэдлэг, итгэлийн хэм хэмжээнд биш байдаг. Тэр хэдийнээ чанадад хүрсэн. Тэр хэрвээ энэ хэм хэмжээндээ байхыг хүсвэл байна. Түүнээс давахыг хүсвэл давна. Түүний ирэх, очих чөлөөтэй. Харин бидний ихэнх нь энэ хэм хэмжээндээ л байдаг. Яаж давахаа ч мэдэхгүй, яаж ирэхээ ч мэдэхгүй. Тиймээс нилээд ялгаатай. Нилээд үхмэл хөшингө гэсэн үг. Яг л ганц урсгалтай зам шиг, явж чадна, ирж мэдэхгүй.

Яг үүн шиг Зицен маргаж мэтгэлцэхдээ гаргуун, тун хэлэмгий. Гэвч тэр хэдийд мэтгэлцэж болохгүй, зүгээр л энгийн хүн мэт байх ёстойг мэдэхгүй. Мэдэхгүй бол мэдэхгүй гэдгээ заавал хэлэх хэрэгтэй. Бүхнийг мэдэх ёстой биш. Харин мэдэх үедээ мэддэг. Мэдэх ёсгүйг мэдээд хэрэггүй. Мэдэхгүй бол: “Би мэдэхгүй ээ! Учир нь надад үүнийг мэдэх шаардлага байхгүй” гэж хэлнэ. Мэдэхгүйгээсээ болж, үхэх хэрэггүй. Би мэдэх ёстой, хийх ёстой зүйлээ л мэднэ. Мэдэх ёсгүй, хийх учиргүй зүйлтэй ороцолдохгүй.

Мэддэг гэх боловч заримдаа мэддэггүй шүү дээ. Зарим хүнээс чи юу ч асуусан бүгдэд нь хариулдаг. Хэн ч түүнийг дийлэхгүй. Эсвэл хүмүүс заримдаа хэт ядраад

маргалддаггүй л болохоос тэр бүгдийг мэддэг гэсэн үг биш. Тэр дэндүү сониуч, ялан дийлэх дуртай, бүхнийг мэдэхийг, ойлгохыг хүсэгч, ийм байх нь заримдаа үнэхээр ядаргаатай. Бууж өгөхгүй. Эгэл жирийн, гэнэн цайлган хүүхэд шиг байж чадахгүй. Маргаж мэтгэлцэж мэдэхгүй тул хүүхдэд хэн ялах нь хамаагүй байдаг.

“Төгс төгөлдөр”-ийн жинхэнэ утга

Өнөөдөр энэ түүхийг уншаад би өөрийгөө жаахан тайвшрууллаа. Заримдаа хэн нэгэнтэй мэтгэлцээд дийлэхгүй, цаад хүн маань тасралтгүй бөөн сонгодог, бөөн онол ярихад надад ч бас зөв санагдаад (Багш болон хүмүүс инээлдэв) тэгээд би ялагдчихаж байгаа юм. Гэртээ хариад бодох нь ээ, нээрээ Төгс Гэгээрсэн Их Багш байтлаа ингэж нүүрээ барах гэж. (Багш болон хүмүүс инээлдэв) Дараа нь дахиад л ай хөөрхий! За за, одоо нэгэнт нүүргүй болсон юм чинь, нүүрээ барсан талаар бодоод ч яахав дээ гэж бодно.

Өнөөдөр Күнзийн хэлснийг харахад заримдаа ярихдаа жаахан ээрч гацах хэрэгтэй гэжээ. Түүний санаа бол Зициен хэнтэй ч хэлэлцсэн дийлдэхгүй, мэтгэлцэх чадвар маш сайтай. Гэвч хэзээ жаахан ээрч гацах хэрэг болдгийг мэдэхгүй. Бид ээрч гацах нь юунд хэрэгтэй вэ? Энэ чинь мэтгэлцэх чадваргүйгээ л харуулна. Үнэндээ, хэн нэгэн хүн үргэлж хамгийн шилдэг нь байвал хүмүүс тэвчихгүй. Тэд өөрөө ч бас тэвчихгүй. Хааяа нэг гацдаг байх хэрэгтэйг ойлгохгүй, тийм байдалд дасаагүй, үргэлж ялдаг бол хэзээ нэг өдөр ялагдвал амиа хорлох байх. Дасаагүй болохоор тэвчихгүй. Ийм хүн дэндүү үхмэл. Тиймээс энэ ертөнц дээр дэндүү төгс төгөлдөр байж болохгүй. Тийм ч төгс төгөлдөр биш байх нь өөрөө төгс төгөлдөр мөн. Үүний санаа нь, хэдийд юу хийхээ мэддэг байх гэсэн үг. Хэдийд хэлэлцэх, хэдийд нь үл хэлэлцэхийг мэддэг байх. Бас хараагүй, сонсоогүй царайлах үе ч бас бий, энэ бол өөрийнхөөрөө амар тайван байгаа хэрэг. Цаг үргэлж сайн хүн байхыг

хичээж, сайн нэр төрөө хадгалах гэж хэн ч ярьсан чи үргэлж мэтгэлцэнэ. Дэндүү уйтгартай, дэндүү дургүй хүрэм, төгс биш, тэгээд ч сонирхолгүй. Багш инээв. Үргэлж нэг хэвийн байвал сонирхолгүй болно!

Их Багш нөхцөл байдалд нийцүүлэн даруухнаар зохицуулж байдаг

Күнз хэлэхдээ: Зилу надаас илүү зориг зүрхтэй гэв. Гэвч тэрээр хэдийд аядуу зөөлөн, хэдийд айж эмээсэн царай гаргах хэрэгтэйг үл мэднэ. Энэ нь заримдаа үнэхээр хэрэгтэй байдаг. Нээрээ үнэхээр шүү! Нилээд дээр та бүхэнд би хэлж байсан даа, бид нэгэн улсад Ау Лакын дүрвэгдсэдийн асуудалд тусалж байхад биднийг цэргийн хүчээр дарангуйлах байсан. Мэдээж бид маш олуулаа, бас ихээхэн сэтгэлийн хөөрөлтэй үе байв. Аль аль нь хатуурхсан бол зодолдохоор байсан. Та нар үүний үр дүнд юу болохыг мэдэрч байна уу? Мэдээж муу, тийм биз дээ? Нэгт, би бол зочин хүн. Тэгээд ч бусдын газар нутагт байна. Хоёрт, бид бол бясалгагчид, Гуравт, бид туслахаар ирсэн болохоос нөхцөл байдлыг улам хүндрүүлж, үл ойлголцлыг дэвэргэхээр очоогүй. Энэ нь хоёр талд алинд нь ч тусгүй.

Тиймээс тэр үед хэрвээ Багш нь зөөлрөлгүй, орхиж явалгүй, айсан дүр үзүүлэлгүй, бууж өгөхгүй байсан бол маш их төвөгтэй байдал үүсэх байсан. Ау Лакын дүрвэгдсэд ямар ч тус болохгүй байв. Бид яллаа гээд бас яах ч билээ? Удалгүй билет аваад буцах л болно. (бүгдээрээ инээлдэв) Тэгээд ч тэнд байнга оршин суухгүй.

Тиймээс одоо ч, урьд ч манай хятадын зэвсгийн эрдмийн багш, мастерууд зэвсгийн эрдмээ хамаагүй үзүүлж, гайхуулж үл болно гэж сургасаар иржээ. Үргэлж тэвчиж, хязгаарын туйл хүртэл тэсэх хэрэгтэй. Хамгаалахын тулд л довтолно. Дурааараа тулаанд дуудаж болохгүй. Хүн тулаанд дуудмагц даруйдаа өөрийн эрдмийг үзүүлэн тоглож

болохгүй. Ингэлээ гээд зориггүй, эрдэмгүй болчихгүй. Тэвчиж чадах нь харин жинхэнэ зэвсгийн эрдэм мөн. Хүн зодохгүй байх нь хамгийн сайн явдал.

Гарцаагүй нөхцөлд мэдээж ашиглана. Гэхдээ хүссэн үедээ үзүүлж, хүмүүст хэнээс ч айхгүй, зэвсгийн эрдмээр илүү, авьяас чадвартай, бид ийм их хүчтэй гэж ер болохгүй.

Тиймээс зарим үед Төгс Гэгээрсэн Их Багш энэ дэлхий дээр аливаа бүхнийг ая зөнд нь, нөхцөл байдалд нийцүүлэн даруухнаар шийдвэрлэж байдаг.

Шагжамуни Буддагийн ид шидийн хүч тийм их, хүмүүс Түүнтэй ид шидээ тэнсвэл дийлэхгүй. Есүс Христ ч мөн маш их ид шидийн хувилгаан хүчтэй. Түүнийг цовдлох хүн ийм хувь тавилантайг Тэрээр мэдэж байсан гэдэг. Цовдлогдсоноор хамаг төрөлтөн аврагдах байсан тул тэрээр цовдлогдсон байна. Түүнд зугтах боломж байсан, заавал ид шидийн хувилгаан хүч хэрэглэх ч шаардлагагүй. Тэрээр олон шавьтай байсан. Мөн урьтаж мэдээд зугтах боломж байсан. Заавал ид шидийн хувилгаан хүч хэрэглэх шаардлага байхгүй.

Арван нэгдүгээр бүлэг

БАО ШУЯА, ГУАНЖУН ХОЁРЫН ЗӨВ НАМБА ТӨРХ, СҮР ЖАВХЛАН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шихү ашрам.1996 оны 1 дүгээр сарын 7
(Эх нь хятад хэлээр)

Эртний хятадад мэргэн түшмэл тун олон байсан ч хүмүүс тэднээс суралцдаггүй нь үнэхээр харамсалтай! Жишээ нь, урьд Бао Шуяа, Гуанжуныг хэрхэн танилцуулсныг харахад Түүний үйлдэл үнэхээр гайхалтай.

Хавар, Намрын улсын самуун цагийн эрдэм төгс хос хүмүүн

Өмнө нь Гуанжун, Чи улсын Хуангуныг харваад хараахан аминд нь хүрээгүй аж. Хуангун үхсэн мэт дүр эсгэжээ. Дараа нь Хуангун Чи улсын хаан болоход Гуанжун өөр улс руу зугтсан байна. Гуанжун бол үнэхээр эрдэм төгс хүмүүн гэдгийг Бао Шуяа мэдэх тул түүнийг даруй эргүүлэн авчирч, Чи улсын Хуангунд чухал алба ажилд томилохыг

санал болгожээ. Гуанжун бол ард олны амгалан жаргаланг бүтээж чадах түшмэл мөн, Гуанжун байгаагүй бол тэр үеийн Дундад улсыг нэгтгэж чадахгүй, энх тайван тогтохгүй гэдгийг Бао Шуяа мэдэж байв. Тиймээс Бао Шуяа найзыгаа буцаан авчирч, аврах арга бүхнийг сүвэгчлэн түүнийг авчрахыг туслахууддаа тушаажээ.

Тэр үед Гуанжун Лу улсад хоргодож байжээ. Лу улсын нэгэн их түшмэл түүний эрдэм чадлыг олж хараад өөрийн хаанд хандан: Эрхэм дээдэс ээ, та энэ хүнийг суллаж болохгүй, хэрвээ та түүнийг ашиглахгүй бол алах нь зөв гэжээ. Лу улсын хаан, Гуанжуныг яагаад ашиглах хэрэгтэй, бас яагаад алах хэрэгтэй билээ гэж асуухад тэр мэргэн түшмэл: Гуанжун бол энэ хорвоогийн нэгэн их авьяас билигт хүмүүн болно, түүнийг одоо Чи улсын Хуангуны талд өгвөл түүнийг нэн чухал албанд томилох нь тодорхой. Тэгвэл та өнгөрнө! Хэрвээ та түүнийг ашиглахгүй бол алсан нь дээр. Бусдын гарт өгөх нь дэндүү аюултай! гэжээ. Улс төр үнэхээр харгис шүү, нэгэн авьяас төгөлдөр хүнийг олж авсан ч өөрөө ашиглахгүй бол өрөөлд өгч болно оо доо, яагаад болохгүй байх вэ? Магадгүй тэд Арьяабалын аргаар бясалгаагүй тул бусадтай хуваалцах сэтгэлгүй, эрхэм ариун хүсэл мөрөөдөлгүй учраас л ийм байна.

Лу улсын хаан мэргэн түшмэлийнхээ саналыг сонсоод эхэндээ Гуанжуныг хороох бодол агуулж байсан ч, Бао Шуяагийн нэн мэргэн ухаант шадар туслах нь: “Хэрвээ та энэ хүнийг алчихаад цогцосыг нь бидэнд өгвөл өгөөгүйтэй адил бөгөөд энэ нь та манай Чи улсыг дорд үзсэн хэрэг болно. Гуанжун өмнө нь манай Чи улсын хааныг харвасан бөлгөө, одоо ч тэр өсийг хаан хараахан аваагүй тул Чи улсын хаан үхэвч амар амгалангүй тул эрхэм дээдэс та түүнийг манай Чи улсад буцаан өгч шийдүүлэхгүй аваас манай хоёр улсын хооронд маргаан үүснэ” гэв. Лу улсын хаан сонсоод өөр аргагүй болохыг ухаарчээ. Түүний улс

нилээд ядуу буурай, тэгээд ч тэдний хүнийг алах шалтаг байхгүй, хэдийгээр өөрт нь тусгүй боловч өөр аргагүй тул хаан, түшмэл хоёр хүлцэн тэвчээд Гуанжуныг буцааж гэнэ.

Гуанжун ч бас тун дайчин түшмэл, түүний хойноос нэхэж, амийг нь хөнөөнө гэдгийг мэдэж байсан тул маш олон дуу зохиож гэнэ. Тэгээд гэмтнийг харгалзан яваа цэргүүд түүний зохиосон дуунуудийг нь замдаа дуулж явжээ. Зам ч тун хурдан хорогдож гэнэ. Лу улсын их түшмэл түүнийг хороохоор хойноос нь мөшгөсөн ч гүйцсэнгүй. Ямар сүрхий вэ! Хүмүүс бүгдээрээ ийм сүрхий! Хэрвээ бид бүгд ийм дайчин бол хичнээн сайн хэрэг вэ! Энд ийм мундаг хүн байна уу? Бараг л алга, цорын ганц мундаг нь би бололтой. (Багш болоод хүмүүс бүгд инээлдэв.)

Бао Шуяа найзыгаа амжилттай авчирч чаджээ. Гуанжун ч шоронгийн тэрэгнээс амь насаа самбаатай аврав. Шоронгийн тэрэг, Чи улсын хилд хүрээд зогсоход Гуанжун Чи улсад буцан ирснийг Бао Шуяа сонсоод даруй угтахаар очив. Тэрээр шоронгийн тэргийг онгойлгож, Гуанжуныг суллав. Гуанжун: Хараахан зарлиг хүлээж аваагүй байхад чи ийм хурдан хаалга нээж болохгүй гэхэд Бао Шуяа: Айх хэрэггүй ээ, би тун удахгүй чамайг Чи улсын хаанд танилцуулна гэв. Гуанжун нилээд номхон царайгаар: Миний жинхэнэ эзэн хэдийнээ үхжээ, би өөрийн эзнээ хамгаалж чадсангүй, би ямар нүүрээрээ дайсантайгаа шар булагт уулзах билээ? гэв.

Шууд хүлээн авахад түүнд хэцүү байсан тул бусад хүн ятган сэнхрүүлснээр сая зөвшөөрүүлжээ. Гэнэтхэн гарч ирээд л би түшмэл хийж чадна гэж болохгүй байсан хэрэг. Бао Шуяа ч мөн итгэсэн дүрээр: Зүгээр дээ, энэ бол өчүүхэн асуудал, эрдэм чадалтай хүнд улс орны их үйл хэрэг, дэлхий дахины амар амгалан л хамгийн чухал. Өчүүхэн жижиг асуудалтай, эсвэл аль хэдийн өнгөрсөн хүнтэй зууралдах хэрэггүй. Бид ганц хоёрхон хүнд бус, дэлхий ертөнцөд

үйлчлэх ёстой гэв. Гуанжун өөрийн үнэ цэнэ нэн ихийг ойлгоод үхэх хүсэлгүй болж гэнэ.

Тэр эхлээд магадгүй үхэх санаатай байсан биз, би сайн мэдэхгүй. Хэрвээ үнэхээр үхэхийг хүссэн бол яагаад харгалзагч хуягуудаар дуу дуулуулж, хурдлуулсан юм бол? (Бүгд инээлдэв.) Бүгдээрээ түүнд итгэцгээе дээ!

Баатар эрд их түшмэлийн дэм хэрэгтэй

Тэр хоёр ярьж тохироод дараа нь Бао Шуяа, Чи улсын Хуангун дээр очиж: Эрхэм хаанд айлтгах хоёр хэрэг буй хэмээгээд эхнийх нь, улсын их хэргийн төлөө та өөрийн садан төрлийн ачлал энэрлийг тэвчих хэрэгтэй, эл явдалд эзэн таныг би машид өрөвдөнө. Удаах нь, энэ дэлхийн хамгийн авьяаслаг хүмүүн Гуанжун хэдийнээ аврагдаад ирэв. Эзэн хаан танд өнөөдрөөс эхлэн таны эрдэмт туслагч болно гэв.

Чи улсын Хуангун: Тэр хүн намайг харвасан билээ. Энэ өсийг би яахин мартах буй, харвасан сум нь ч бас хадгалагдаж байна. Тэгэхээр яаж би түүнийг ашиглах билээ гэв. Би түүнийг буцаж ирмэгц нь хөнөөж, хүүрийг нь тарааж хаяна гэлээ.

Нэгэн улсын сүр жавхлант эзэн хаан атал өчүүхэн өсийг ч үргэлж санавал түүний тухай ганц сайн үг хэлэх хүн олдох уу, хэдий удаан санана, төдий чинээ муу хэлэгдэнэ. Ингээд гурван үе нь бүгд “гэтэлгэдэх” биз. (Гурван үеэрээ устгагдана), (Бүгд инээлдэв)

Ихэнх хаан ууч өгөөмөр чанар тун дутмаг тул дэргэд нь үргэлж мэргэн түшмэл, авьяаслаг хүмүүн, эрхэм дээд ёс зүйтэй хуврагууд зөвлөж байх хэрэгтэй. Олон тусмаа сайн. Гэвч ихэнх хувраг, эрхэм дээд ёс зүйтэй хүн түшмэл болох хүсэлгүй. Тэд юм бүхэн цөм жүжиг гэдгийг мэдэх тул тэнд очиж жүжиглэхгүй. Уйдсан үедээ л оролцдог. Гэхдээ тэр

мэргэдийн ихэнх нь ийм хэцүү бэрх газар очихгүй.

Харин ч Гуанжун, бас Бао Шуяа хоёр байгаа нь тун сайн хэрэг. Магадгүй түшмэл болж, эзэн хаанд туслах нь тэдний хувь тавилан байх, эс бөгөөс хаан эзэн юу ч хийж чадахгүй. Буян байвч ёс суртахуунаар дутмаг. Буяны үрээр хаан болсон ч ертөнцийн явдал, улсын хэргийг шийдэхэд билиг ухаан, ёс суртахуун нь үл хүрэлцэнэ. Тэр түшмэд харин ёс суртахуун сайтай ч хаан болох буянгүй. Зөвхөн түшмэл хийх л заяатай. Тэд түшмэл болох буянаараа улс орондоо тусладаг.

Яг үнэндээ бол тэд зөвхөн жүжигт оролцон тоглохооор бууж ирдэг төдий. Нэг нь улсын хаан, нөгөө нь түшмэл болно. Яг л кинон дээр нэг нь гол дүрд, нөгөө нь алдар нэртэй ч туслах дүрд тоглодог шиг. Авах мөнгө нь л арай бага байх. Тэр яахав! (Инээлдэв) Бараг ялгаагүй. туслах дүр байхгүй бол гол дүр жүжиглэх аргагүй. Гол дүр үгүй бол туслах дүр ч бас тоглох боломжгүй. Найруулагчийн хувьд бол бүр ярих ч юмгүй. Тиймээс та бид байхгүй бол Эзэн Бурхан ч бас хэрэггүй болно! Түүнээс айх хэрэггүй. (Алга ташицгаав).

Бао Шуяа хэлрүүн: Шудрага түшмэд нэгэн сэтгэлээр эзэн хааныхаа төлөө зүтгэнэ. Тухайн үед Гуанжун, Жиу гүнтэнд шадарлаж байсан бөгөөд Жиу гүнтэн, Дангүн хоёр ах дүү байсан ч хаан суурийн төлөө өрсөлдөж байжээ.

Жиу гүнтэн түүний эзэн нь байсан тул мэдээж эзнийхээ төлөө Дангүнийг харважээ. Та одоо түүнийг чухал албанд томилвол тэр таны төлөө л зүтгэнэ. Та энэ нэг сумаар тэнгэрийн доорх ардыг харватугай гэв. Ийм хүнийг олсондоо Чи улсын Дангун ихэд баярлав. Эцэст нь тэр ойлгож гэнэ. Хаан болох амархан, ерөнхийлөгч байх ч амархан, бусдын үгийг сонсдог байхад л болно. Цэцэн сэргэлэн, билиг ухаантай, авьяас төгөлдөр хүнээс үгийг

нь сонсдог, санааг нь авдаг байвал хаан ширээнд он удаан сууж, улс гүрнээ төвшитгөн захирч чадна.

Яг үүн шиг, бясалгач хүмүүс бид ч гэгээнтнүүдийн зааврыг үл дагаж, эртний хүмүүсийн мэргэн сургаалыг үл сонсох аваас өөрийн өчүүхэн хэргийг хэзээ гүйцэлдүүлж чадах вэ? Бид мэдэхгүй, тиймээс арай илүү билиг ухаантай, арай илүү мэддэг тэр хүмүүсийн сургаалыг сонсдог. Эртнээс нааш ямар ч их хааны дэргэд сайн зөвлөхүүд байсан бөгөөд тэд маш хурц ухаантай. Хаан эзэн төгс төгөлдөр билиг ухаантай, авьяас чадвартай байх шаардлагагүй. Харин цэцэн сэргэлэн, даруу төлөв, бусдын зөв сайн санаа бодлыг хүлээн авдаг байхад л болно. Тийм бол хаан байж болно. Хаан байх ийм амархан аж, та нар оролдоод үзэх үү? (Инээлдэв) Нижгээд ухаантныг цуглуулж чадвал хаан болж болно. Ер нь гэртээ л хаан болоход болно доо. Чи улсын Хуангун, Бао Шуяагийн хэлэхийг сонсоод Гуанжуныг өршөөн хэлтрүүлэв. Гэвч түүнийг дэргэдээ авах бодол байсангүй. Түүнийг үнэхээр авьяас чадвар төгс хүн гэдгийг Бао Шуяагаас сонссон хэдий ч түүний авьяас чадвар нь тэгээд хэдий хэр вэ гэдгийг ойлгохгүй л байв. Харин зөвхөн Бао Шуяад л хаан төрийн бүх их хэргийг хариуцуулах санаатай байжээ. Бао Шуяа: Хаан эзний их ивээлд талархлаа. Манай гэр бүл, ураг садны аж амьдрал элбэг хангалуун, сэтгэл дүүрэн тул танд тун талархалтай билээ. Улсын их хэргийг шийдэхэд өчүүхэн миний авьяас чадвар дутах тул би хариуцаж үл зүрхэлнэ гэж хэлжээ. Чи улсын Дангун түүнийг үргэлжлэн ятгасан ч тэр: Үнэхээр болохгүй, өчүүхэн би ёс журмыг ихэд эрхэмлэнэ, жаяг дүрмийг ойлгоно, хаан эзнээ хүндэтгэнэ. Гэвч төрийн хэргийг Гуанжун шиг сайн шийдэж үл чадна. Хэрвээ хаантан намайг хүчээр хийлгэвэл гавьяа багатай, гай ихтэй байх болно. Төрийн үйл хэрэг нэн тодорхой, дээдэс ноёд нь тэнгэрийн хөвгүүдэд ачтай тустай, доодос ард нь ноёд түшмэддээ тахимдуу байваас улс гүрэн тогтвортой байж, эзэн хаан улам алдаршин түмэн үедээ алдар нэр тань

мөнхрөх болно. Үүнийг гоц гойд нэгэн хүн хийж чадахаас жирийн хүмүүн яахин чадах буй гэв. Тэр өөрийгөө эгэл жирийн хүн, авьяас чадвар төгөлдөр биш нэгэн хэмээн үзэх ажээ. Хаан эзэнтэнд үнэхээр төр улсыг засах хүмүүн хэрэгтэй бол гагцхүү Гуанжун л байна. Түүнээс илүү сайн хүнийг би огт үзээгүй гэв. Бао Шуяа үнэхээр нүдтэй хүн, хэрвээ манай энд түүн шиг нэг хүн байвал хичнээн сайн бэ, хаа нэгтээ тийм хүн таарвал та нар бариад ирээрэй. (Инээлдэв.)

Нийтийн хэргийг шийдэхэд хувийн сэтгэлийг огоорох хэрэгтэй

Чи Дангун Бао Шуяад тун их итгэнэ. Бао Шуяа түүнтэй байнга хамт байсан бөгөөд яг л найз нөхөд, ураг садан мэт, сайн сайхан зүйл юу байна, түүнийгээ Бао Шуяад өгөхийг хүсэх ч Бао Шуяа татгалзана, түүнд үнэхээр бэрх байжээ. Тэр өөр хэнд ч итгэхгүй. Бид бүгд яг ийм байдаг. Хамт амьдарч, нилээд дассан хүмүүстэйгээ сэтгэл зүрхээрээ холбогдож, тэдэнд сэтгэлийн өртэй болсон тул аливааг хийхэд хэцүү болдог.

Бид юу ч хийсэн маш шударга байх хэрэгтэй. Хэнд авьяас чадвар байна, түүнийг гарган ирж, ажиллуулах хэрэгтэй. Ингэвэл олон түмэнд тустай. Тэрнээс биш, энэ миний сайн найз, тэр миний ураг садан, танил тал гээд давуу боломж олгох ёсгүй. Ингэвэл алдаа гаргана! Бид ер нь аливааг хийхдээ хувь хүний сэтгэл зүрхээр ханддагаас будлиан их хутгадаг. Маш олон хаан, ноён хайртай хатан, үзэсгэлэнт бүсгүйгээс болж, улс гүрнийхээ их хэргээр наадаж, эцэст нь улс орон нь мөхөж сүйрдэг. Эртнээс нааш үргэлж л ийм байсан. Бясалгагч хүмүүс бид үүнээс суралцахад гэмгүй, хараахан Бурханы хутагт хүрээгүй байгаа үедээ түр зуур энэ бүх байлдах зэвсгийг хэрэглэх нь

бас л тус ихтэй.

Бао Шуяа хэдийнээ олон зүйлийг тунгаан бодсон байв. Чи улсын Хуангун харин эргэлзсэн хэвээр, дараа нь: За за, тэгэхээр чи түүнийг дуудаж авчир! Би түүний хэр авьяас чадвартайг сорино гэлээ. Дангуны яасан ч яахав гэсэн тоомжиргүй царайг хараад Бао Шуяа ингэж болохгүй гэв. Хэрвээ нэгэн хүний байр суурь нэн дорд аваас баян хүнд нөлөөлж үл чадна. Аж ахуйн их эрх мэдэлгүй бол баян тансаг гэр бүлийн хэргийг шийдэж чадахгүй. Нэгэн дорд хүмүүн баян эрхмийн өөдөөс үг хэлж зүрхлэхгүй. Тэгэхээр яаж тэдэнд сонсгох билээ? Хэрвээ хаан эзэнд Гуанжун хэрэгтэй бол түүний далд хүч чадалд тааруулан түүнд түшмэлийн суудлыг өгөх хэрэгтэй. Түүнд ах дүү, аав ээж шигээ хандвал зохилтой гэжээ.

Та нар юу гэж бодож байна? Түүнд ах дүү, аав ээж шигээ хандвал тэр танд тусална. Та нар намайг Багш аа гэж дууддаг нь аргагүй юм байна. Би одоо л ойлголоо! (Инээлдэв) Өөрсдийн тусын тулд надад ямар ч нэр өгнө. Хий хоосон байр суурь өгөөд намайгаа үхтэл ажиллуулна. Энэ хөгшин үнэхээр тэнэг юм даа. Арга мэхэнд унажээ. Өнөөдөр эртний хүмүүний түүхийг уншаад мэхэнд унаад удсанаа сая ойлголоо. Үүнээс хойш би та бүхнийг Багш аа! гэж байя. (Инээлдэв) Хэдүүлээ ажлаа сольё доо. (Үгүй! Багш аа, гэцгээв!)

Өндөр дээд байр суурind байх тусмаа илүү даруу төлөв байх ёстой

Бао Шуяа үргэлжлүүлэн: Хэрвээ түүнийг түшмэл болгоё гэвэл нялх хүүхэд мэт, эсвэл нэгэн ямар ч нэр төргүй доодос мэт, эсвэл эгэл жирийн хар хүн мэт дуудан ирүүлж яаж болох вэ? Дэндүү дорд үзсэн, дэндүү хүндлэлгүй

хэрэг болно. Гуанжун бол нэгэн түмнээс төгөлдөр авьяас чадвартан. Хаантан минь та нэгэн баяр ёслолт өдрийг сонгож, өөрийн биеэр түүнийг залж ирэх нь зөв гэжээ. Нэгэн түшмэлийг яг ингэж залах хэрэгтэй. Хожим нь Чи улсын Хуангун дундад улсын хүчирхэг хаан болсон нь үнэхээр аргагүй юм байна. Тэгэх ч эрхтэй. Хаан эзэн ийм даруу байж чадсан нь тун сайн хэрэг.

Өнөөдөр энэ дэлхий дээр хичнээн хаан, улс төрч, улсын тэргүүн ийм эгэл даруу байж чадсан бэ? Магадгүй байгаа л байх, бид л мэдэхгүй болохоос, байгаа бол маш сайн байна, манай дэлхийд баяр хүргэе. Эгэл даруу эзэн хаад, ерөнхийлөгчтэй улс орнуудын өмнөөс бид баярлан талархаж байна. Ийм удирдагчид, хаад олон болбол манай дэлхий улам энх тайван, таатай сайхан болох болно.

Хаан хүн ийм л даруу төлөв байх хэрэгтэй. Байр суурь хичнээн өндөр байх тусмаа илүү даруу төлөв байх хэрэгтэй. Бид ч энэ дэлхий дээр нэг жаахан өргөст хэмх л шүү дээ, тэгсэн атлаа хичнээн даруухан байна даа. (Бүгд инээлдэв.) Би чинь Багш шүү дээ. Ихэнх Багш нар ийм байдаг, өөрөөр байвал Багш биш болно. Жүжиг, жүжиг бас ч гэж сонирхолтой шүү. Миний дотоод үнэхээр даруухан, та нар л харахгүй байгаа болохоос, гэхдээ итгэх хэрэгтэй. (Бүгд инээлдэв.)

Үнэнч шудрага, мэргэн ухаант Бао Шуяа

Бао Шуяа хааныг ятгасаар байв. Тэрээр: Хэрвээ хаантан Гуанжунд ийм хүндэтгэлтэй хандвал тэнгэрийн дор дөрвөн зүг, найман зовхисын хамаг олон бүгд бахархаж, хаантан таныг улам их хүндэтгэнэ. Учир нь хаантан та хувийн өс хонзонгоо умартсан төдийгүй, улс орныхоо төлөө дэлхийн мэргэн авьяастанд хүндлэл үзүүлж

байна. Хожим даян дэлхий таных болох нь гарцаагүй гэв. Түүний үг яг л тэнгэрийн бошго мэт байжээ. Хожим нь үнэхээр биелэгдсэн байна. Чи улсын Хуангун толгой дохин зөвшөөрөв. Чи улсын энэ хаан үнэхээр сайн хүн аж. Хожим нь тэрээр дундад гүрний жанжлагч их хаан болсон нь үнэхээр зүй ёсны хэрэг байжээ.

Үүнээс бид Бао Шуяа хичнээн агуу хүн болохыг мэдэж болно. Тэр ач гавьяандаа дулдуйдан алдар нэр, ашиг хонжоо хайсангүй, мэргэн авьяастныг нуун дарсангүй. Гуанжуныг нуугаад түүний тухай мууг өгүүлсэнгүй, харин ч арга бүхнийг сүвэгчлэн түүнийг аварч, эзэн хаантай золгуулжээ. Эрх мэдэлтэй хүн ингэж үйлдвэл энэ дэлхийн хамгийн шударга түшмэл мөн. Хүн ч бас ийм байвал тэр нь энэ дэлхийн хамгийн сод мэргэн хүн болно. Ийм найз бол энэ дэлхийн хамгийн сайн найз мөн. Манай дэлхийд ийм хүмүүс олон байвал хичнээн сайн бэ, бясалгагч хүмүүс бид ч бас ядаж юуг ч маш шударга үйлддэг хүн байх хэрэгтэй шүү хэмээн өөртөө сануулах хэрэгтэй. Хувийн өс хонзонгоор бусдыг нуун дарж, дээш дэвшүүлэхгүй байж болохгүй. Улс орноо, эх дэлхийгээ улам баян чинээлэг, энх амгалан болгох хэрэгтэй. Энэ цаг бол авьяас билиг төгөлдөр хүнд нилээд халгаатай үе. Ер нь олон олон цаг үед ийм л байсан. Гэхдээ тийм авьяастныг чухал албанд ажиллуулж чадах нэгэн байсан нь тун азтай хэрэг.

Хэдийгээр Бао Шуяа өөрийгөө улс гүрний чухал үйл хэргийг шийдэх авьяас чадваргүй гэх боловч миний бодлоор тэр үнэхээр сайн хүн. Өөрийгөө мэднэ гэдэг билиг ухаантайн шинж, өөрийгөө ч мэдээд өрөөлийг ч мэдвэл зуунтаа байлдавч зуунтаа ялна гэдэг үг бий. Хэрвээ тэр өөрийн алдаа дутагдлаа хэдийнээ мэддэг бол энэ нь түүний тун сайн хүн, төгс төгөлдөр хүн болохыг харуулна. Тэнд суугаад нүдээ нээсэн, эсвэл аньсан маягтай, юу ч болсон үл хөдлөх агаад сэтгэл хөдлөл огт үгүй, хүмүүстэй харилцахгүй,

найзалж нөхөрлөхгүй, хүн төрөлхтний сэтгэлийн үйл огт үйлддэггүй тийм хүнийг бид төгс төгөлдөр хүн хэмээн боддог. Төгс төгөлдөрийн тухай иймэрхүү ойлголт нь тун буруу. Тэгвэл тэнд нэг чулуу юмуу, мод тавьчихвал төгс төгөлдөр болох бус уу! (Инээлдэв.)

Төгс төгөлдөр хүн давуу талаа хөгжүүлж байдаг

Төгс төгөлдөр хүн өөрийн давуу болоод сул талаа мэднэ. Сул талаа дарж, эсвэл хойш тавина, эсвэл түүнийгээ хянаж чадна. Хэрэгтэй үед нь гаргаж ашиглана. Харин давуу талаа өөртөө болоод бусдад туслахын тулд үргэлж хөгжүүлж байдаг бол төгс төгөлдөр хүн мөн. Хэрвээ хэн нэгэн төгс төгөлдөр хүн арван хуруу тэгш өөлөх юмгүй боловч ямар ч сэтгэл зүрхгүй, амьдралын ямар ч хувиралгүй бол тун уйтгартай. Тиймээс би та нарыг хааяа хааяа зэмлэж, жаахан амтлагч нэмдэг. Та нар ч бас үүнд дуртай. (Инээлдэв) Хэрвээ дургүй бол би ч бас тоохгүй, яг л модон бурхан шиг байж чадна. Та нарыг ирэх бүрд чинь "Сайн хүү шүү!" гээд толгойг чинь илээд сууна. Үнэндээ ингэх нь надад ч амар, улам л таргална.(Инээлдэв)

Гэвч, энэ дэлхий дээр хариуцлагагүй ийм Их Багш тун олон байна. Бас сүм хийдэд маш олон модон бурхан байдаг, би бас дээр нь нэмэгдээд яахав. Одоо манай дэлхийд ихээхэн ажил хэрэгч, уян хатан Будда хэрэгтэй байна. (Алга ташив) Бясалгагч хүмүүс аливааг хийхдээ Бао Шуяа шиг ийм эгэл даруу, цэцэн сэргэлэн биш бол ичих хэрэгтэй. Хятадад ийм хүмүүс байсан учраас бусдаас бус, өөрийн өвгө дээдсээс суралцах хэрэгтэйг хүмүүст сануулж байдаг. Гэгээнтнүүд хэлэхдээ: Гурван хүн явж байвал тэдний дунд надад багшлах нэгэн заавал бий гэдэг. Магадгүй гурвуулаа ч байж болно, тэд бидэнд өөр өөр зүйлийг заах юм.

Бао Шуяа, Гуанжуныг бахдан магтдаг, та нар бодохдоо тэр Гуанжуныг бүр бишрэн шүтдэг гэх байх. Бас тийм биш! Тэр өгөөмөр уужим сэтгэлтэй хүн. Улс орныхоо төлөө бүхнийг хойш тавина. Гуанжун, хаан эзний хамт өглөөнөөс үдэш болтол найрлан цэнгэнэ. Хааны ордон бол тансаг жаргал, хээнцэр гоёмсогийн туйл. Гуанжун ч бас ийм орчинд байлаа. Бао Шуяа түүний энэ занд дургүй байсан юм. Тэгээд түүнд хандан: Хаан эзэн тансаг жаргалд ташуурч байхад түшмэл нь болсон чи, үүнийг аригла, түүнийг гамна гэж ятгахын оронд харин ч түүнтэй ижилсээд найрлан цэнгэж байгааг юу гэж ойлгох вэ? гэхэд Гуанжун хариуд нь: Чи улсын хаан олон жил тэмцсэн тул үнэхээр их зүдэрсэн байна. Одоо эцэст нь хаан ширээнд залраад жаахан амсхийж, жаргаж цэнгэх хэрэгтэй. Энэ асуудал биш! гэв. Бао Шуяа түүнд хариу хэлээгүй ч дотроо төдий л сайшаасангүй.

Бао Шуяа нилээд хуучинсаг үзэлтэй, тун энгийн даруу амьдралтай, баян тансаг эдлэлгүй, бас Гуанжун шиг сэргэлэн аргат хүн биш юм. Энэ бол түүний дутагдалтай тал. Тэгэхээр Гуанжун түшмэл хийж чадна, харин Бао Шуяа тохирохгүй. Өөрөө үүнийгээ мэдэх боловч хүний сэтгэл заавал нэг зүйлд татагдаж байдаг. Тийм биш бол хүн биш юм. Тиймээс тэр өөрийн найз Гуанжуныг хэтэрхий тансаг жаргалд ташуурамтгай, ганган хээнцэр баян тансагт бусад түшмэлийг уруу татдаг хэмээн байнга шүүмжилнэ. Зүгээр дээ! Улс гүрнийхээ их хэргийг шийдэж чадаж байгаа нь л маш сайн, олон ядуу хүн хүнд хэцүү амьдарч, улсын их хэргийг шийдэж чадахгүй, нийт дундад улсыг нэгтгэж чадахгүй, хүмүүс энх тайвнаар зэрэгцэн амьдарч чадахгүй байна. Хэдийгээр Чи Хуангун жаахан жаахан тансаглан цэнгэдэг ч чадвартай хүнийг зөв ашиглаж байвал, тэгээд л боллоо! Тэгэхээр нэг их хамаатай биш шүү дээ гэв. Бүхэл хятад даяар ганцхан тэр тансаглан жаргахад улс гүрэн нэг их хотойхгүй. Бас хаан өөрийн бүх хөрөнгийг улсдаа тушаасан ч улс түүнээс болж илүү сайхан хөгжинө гэж бас байхгүй.

Нэгэн үеийн жанжлагч их хаан Чань Чихуан

Гуанжун, Бао Шуяа хоёр тийм сайн найзууд байсан ч тэдэнд үзэл бодлын ялгаа байсан. Манай дэлхийд найз нөхдийн дунд заримдаа бага зэрэг зөрчилдөөн гардгийг ойлгох хэрэгтэй. Энэ бол асуудал биш. Хүн бүхэнд өөрийн гэсэн үзэл бодол, өөрийн гэсэн сэтгэлгээ байдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Найзууд бүгдээрээ нэг хэвэнд цутгасан мэт ижил байх ёсгүй, тийм бол дэндүү уйтгартай. Ганцаараа байхад л болно, найзаар яахав? (Инээлдэв) Нэг их хэрэгцээ байхгүй юм. Ихэнх зүйл дээр найзууд хоорондоо санаа нийлж байхад л болно. Гуанжун аливаа зүйлийн чухал, чухал бусийг сайн мэднэ, юмсыг тов тодорхой харж чаддаг. Нилээд тансаглах дуртай эзэн хаанаа зэмлэж, зовоож байсангүй.

Чань Чихуан ч дэндүү илэн далангүй хаан, Гуанжунтай анх уулзаад л улс гүрний их үйл хэргийг шууд ярилцаж байжээ. Цэрэг дайчдыг хэрхэн хөдөлгөх гэх мэт, Гуанжун ч асуултанд оновчтой, урсам сайхан хариулж байв. Гуанжуны тухайд бол зөвхөн Бао Шуяа танилцуулснаас ч болоогүй, хаан өөрөө Гуанжуныг үнэхээр чадвар төгс хүн болохыг мэдээд түшмэлийн албанд томилохыг зөвшөөрсөн байна. Бас түүнийг өндөр аав хэмээн авгайлж, хаан эзний төрсөн эцэг мэт их л хүндэтгэлтэй хандана. Хаан, Гуанжуныг их л бахдаж, түүнтэй тун ч илэн далангүй ярилцдаг байв. Тэрээр Гуанжунд хандан: Хаанд нь нэг дутагдал байна. Бүсгүй хүний үзэсгэлэн гоог нилээд таална. Энэ зан улс гүрэнд хор хохирол болох уу гэж асуухад Гуанжун: Бүсгүй хүний гоо үзэсгэлэнд дурлах нь улс гүрэнд хор хөнөөл авчрахгүй. Харин мэргэн түшмэдийн үгийг үл сонсох нь улс гүрэнд ч, дэлхий дахинд ч тун их хор хөнөөлтэй гэжээ. Тэр үнэн хэлсэн. Хэрвээ хаан ямар ч алдаа дутагдалгүй бол түүнд сайн хүний хэрэггүй, хаан өөрөө бүхнийг чаддаг бол хүмүүст хийх ажил олдохгүй болно. Хэрэв нэгэн хүн дэндүү төгс

төгөлдөр бол санаа сэтгэл нь бачимдаж чивчирээд хэрэг явдлыг тодорхой сайн ухаарч ойлгохгүй болно. Бао Шуяа, Гуанжун шиг ухаалаг сэргэлэн биш. Учир нь Бао Шуяа хэтэрхий ёс суртахуунлаг, дэндүү шударга, их төв чигч, сайны туйл, төгс төгөлдөрийн биелэл болсон хүн байв.

Хувиа үл бодогч, би гэх үзлээ үл баримтлагч Гуанжун

Гуанжун бол өөр. Яаж хийвэл төгс болохыг тэр мэддэг, гэхдээ түүнд бас баригдахгүй. Тэр юу хийх хэрэгтэй байна, тэрийг л хийнэ. Олны ашиг тусын төлөө бол өөрийн төгс төгөлдөр байхыг ч үл тооно, төгс төгөлдөрт үл хайрцаглагдана. Улс орондоо үйлчлэхийн тулд олон янзын дүрэм журмыг огоорч, хэтэрхий явцуу тэдгээрт үл уягдана. Ялгаа нь энд байдаг.

Хаан эзэн ч мөн ялгаагүй, зөвхөн улсын хэргийг шийдээд хорин дөрвөн цаг тасралтгүй ажиллаж, охид бүсгүйчүүдтэй уулзахгүй, ховор тансаг идээ унд хүртэхгүй, архи дарс ч амсахгүй, ер нь юу ч үгүй байвал хэд хоног тэсэх вэ? Хамгийн ихдээ л гурав хоног. Тэр үхэж магадгүй. Эсвэл сэтгэл санаа нь самуурч бачимдаад хэвийн биш, тэнцвэргүй болж, ямар ч хэрэг явдлыг ойлгохгүй болно. Учир нь нэг зүйлд хэт их төвлөрвөл өргөн хүрээнд харах чадваргүй болдог. Яг л маргааш шалгалттай бол өмнөх өдөр нь хүүхдүүд юу ч хийхгүй тайвшран амардаг шиг. Суларч тайвшрах нь хамгийн зөв. Оюун санаа тайвширвал бодол цэгцэрнэ. Оюун бодол хэт ачаалалтай бол аливаа явдлыг сайтар тунгааж чадах уу? (Чадахгүй! гэцгээв.)

Тиймээс бясалгах арга нь логикт нийцдэг. Бид өдөржингөө завгүй, билиг ухаан, оюун санаа, мэдрэхүйн эрхтэн бүгдээ нэг зүйлд хандуулвал хэтэрхий явцуурч шийдэл олохгүй. Ямарваа зүйлийг хэт ойроос харвал тодорхой харагдах уу? (Багш нэг зүйлийг нүдний өмнө

тулгаж авчрав) Чадах уу? (Чадахгүй гэцгээв) Тодорхой зайд, орон зай, цаг хугацаатай байвал бид олон зүйлийг шийдэж чадна.

Бясалгагч хүмүүс бид ч ялгаагүй, өмнө нь би ийм олон шавьтай байгаагүй, бүгдээрээ майхан бариад би нэг талд нь, шавь нар нөгөө талд нь амьдардаг байв. Намайг цайлж суухыг нэг нь харвал бас шүүмжилж эргэлзэн: “Сонин юм даа! Гэгээрсэн Багш хүн яагаад яриа өрнүүлж, цайлж суудаг юм бол” гэж бодно. Гэгээрсэн бол цайлж, ярилцах хэрэгтэй. (Инээлдэв) Гэгээрээгүй бол цайлж, ярилцаж зүрхлэхгүй. Би аль хэдийн гэгээрсэн, яагаад энэ бүхнийг хийж болохгүй байх вэ? (Алга ташицгаав) Багш хүн гадагш гарч бөмбөг тоглоно, хөл бөмбөг өшиглөнө, гольф тоглоно, машин барьж зугаална. Учир нь тэр хэдийнээ сургуулиа төгсчихжээ. Тэр бүгдийг мэдэх болсон байна. Хэрвээ түүнд мэдэхгүй зүйл үлдсэн бол зугуухан суралцана. Асуудалгүй! Сурагчид л шалгалтанд бэлдэх хэрэгтэй, гэрийн даалгавраа чармайн хийнэ. Багш бол харин цагаа зохицуулж болно. Сурагчид шиг тэгж их чармайх хэрэггүй. Багшид ч бас хичээх үе байдаг. Орой ном уншиж, маргааш заах хичээлийн сэдвийг бэлдэнэ. Гэхдээ сурагчид шиг тэгж их чармайх хэрэггүй. Цагаа хэрхэн зохицуулахаа тэр мэдэж байдаг. Харин сурагчид шалгалт болон цагийн хязгаараас болж, дураараа зохицуулж болохгүй.

Тайвширч тайтгарвал учрыг ухаарна

Сурч боловсроход дэндүү их зүдрэх хэрэггүй. Тиймээс бид бясалгахдаа, долоо хоногийн даяан хийхдээ ч шорлог шарж, дуулж бүжиглэж, тоглолт хийдэг. Баярын үеэр гоё ганган хувцаслаад наадан цэнгэнэ. Гэсэн ч бясалгал ялгаагүй л сайн байдаг. Нөлөөлөгдсөн хүн байна уу? Гараа өргөөд надад харуулаарай. Улам сайжирсан, тийм

үү? Дэвшсэн үү? (Дэвшсэн гэж хариулцгаав) Хааяа нэг амарч тайвширч бололгүй яахав. Эргэж ирэхээ л санаж байвал тэгээд болчихно! Адуу, үхэр ч бас ядарч зүдрэхийг тэвчихгүй, тэгэхээр хүнийг бүр ч ярилтгүй, тийм биз? Үхэр малыг өдөржин хорин дөрвөн цаг газар хагалуулбал тэсэх үү? Тэсэхгүй! Үхчихнэ шүү дээ! Машин тэрэг ч мөн адил. Онгоц, машин ч засаж сэлбэх хугацаатай байх ёстой.

Америкийн нэгэн ерөнхийлөгч төрийн ажил хэрэг хэтэрхий их ачаалалтай байвал нэг, хоёр хоног амрахаар явдаг байжээ. Бүгдийг орхиод явна. Үнэндээ амарч байхдаа тэр илүү бүтээмжтэй сайн ажилладаг байж. Жирийн үед асуудал гарвал бид үргэлж бодож өөрийгөө хүчилж байдаг. Амжиж хурдан хийхийг, шийдвэрлэхийг хичээдэг. Эцэст нь олигтой хийж чадахгүй. Тэгснээс шууд орхиод унтаж амрах, эсвэл зурагт үзсэн нь дээр. Гэхдээ тэр үед бидний далд ухамсар зурагт үзэхгүй, сүнс, билиг ухаан ажилласаар байдаг. Тэгээд зав гармагц тэр бидэнд тухайн ажлыг хэрхэн шийдэхийг алгуурхнаар хэлж өгдөг байна. Тиймээс зурагт үзсэний дараа яаж хийх ээ мэдчихсэн байна. Би байнга ингэдэг. (алга ташицгаав) Ихэнх ажил хэргийг Багш нь орон дээрээ л шийддэг. Яг одоо ийм ажил хэрэгч, гоёмсог хувцас өмссөн үедээ бол тийм ч олон ажил амжуулж чадахгүй. Харин завтай үедээ маш олон ажил хэргийг жинхэнэ шийднэ. Учир нь тэр үед завтай, бас нилээд нам тайван байдаг юм. Энэ нь энэ дэлхийн хэрэг явдлуудыг хэлж байгаа хэрэг. Харин нүдэнд үл үзэгдэх төвшний ажил хэргийг би цаг үргэлж шийдэж байдаг. (Алга ташицгаав.)

Арванхоёрдугаар бүлэг

ТӨРӨӨ ТӨВШИТГӨЖ, ТЭНГЭРИЙН ДОР АМАР АМГАЛАНГ ТОГТООХ НЬ БЯСАЛГАЛ МӨН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шихү ашрам.1995 оны 9 дүгээр сарын 10
(Эх нь хятад хэлээр)

Билгүүн ухаантан үл туйлширна

Гадаад байдал бидний дотоод дэсийг илэрхийлж чадахгүй. Хамгийн гол нь бид сэтгэл зүрхээ ганхсан эсэх, цэвэр ариун байгаа эсэхээ мэдэх нь юунаас ч чухал. Тийм биз? Тиймээс Лууз: Дэндүү цагаан бол нилээд бүүдгэр харагдана, хэтэрхий ёс суртахуунтай хүн дутагдалтай мэт харагдана. Ёс суртахуунтай хүнийг хараад бид танихгүй байж магадгүй. Заримдаа юм хэтрэхээрээ тийм ч сайнгүй. Жишээ нь, эрт үед олон хүний эзэн хаандаа үнэнч, эх орондоо хайртай сэтгэл нь мухар сохор байснаас эцэст нь өөрөө хохирдог, эсвэл эрдэнэт амиа алддаг байжээ. Учир нь алдар нэр, чигч шударга зан, ёс суртахуун, нэр цэвэр

байдалд дэндүү шүтсэнээс заримдаа хэт туйлширч, улмаар өөрийгөө хорлодог байна. Ингээд улсдаа ч, нийгэмдээ ч бүтээсэн гавьяагүй болно.

Поы, Ши Чи хоёр юуны төлөө өлбөрч үхсэн бэ? Ердөө л өөрөө нэр цэвэр гарахын төлөө. Шуюан далайн ус руу юуны тул үсрэв? Ердөө л нэг мунхаг түшмэлд үнэнчээ харуулахын төлөө. Хэрвээ түшмэл нь мэргэн бол түүнд үнэнч байж хамгаалж, мэргэн зөвлөгөө өгч, үнэнч сэтгэлээ илчлэх нь зөв. Харин мулгуу түшмэлд үнэнч байгаа бол мунхаг тэнэг хүн! Үнэнч сэтгэлтэй мунхаг тэнэг.

Бясалгагч хүмүүс бид хэт туйлширч, хэт үхээнц байж болохгүй. Уян хатан, нөхцөл байдалд тохируулан билиг ухаанаар дүгнэж цэгнээд яахыг шийднэ, заримдаа нэр алдарт хэтэрхий дурласнаас ёс суртахууны нэгээхэн хэсэгт хүлэгдсэн, эсвэл амьдралын ямар нэгэн хэв маягт баригдсан бол бясалгагч ч биш, билиг ухаантайд ч тооцогдохгүй. Ямар ч дүрэм журам, нэр алдар, ёс суртахуун цөм хүнийг хамгаалахын тулд л байдаг. Тэрнээс нэр алдрыг хүн хамгаалах ёстой биш юм. Багшийнхаа санааг ойлгов уу? (Ойлголоо гэж хариулцгаав.)

Олон хүн Байыи, Шуюан, Ши Чи зэрэг эзэн хаандаа үнэнч, эх орноо хайрладаг хүмүүсийг бахдан магтдаг. Гэвч миний бодлоор тэд тийм ч хангалттай сайн байгаагүй. Учир нь тэдэнд билиг ухаан байхгүй. Хэрвээ шаардлагагүй бол өөргөө тэгж хохироох хэрэггүй. Ганц хаан, ганц мунхаг түшмэл бол бүхэл бүтэн нийгэм биш шүү дээ, бид зөвхөн түүгээр амьдралыхаа зорилгыг хязгаарлаж болохгүй. Өөрийгөө дэндүү чухалд тооцсон нь ийм байдалд хүргэсэн байна. Мунхаг түшмэл өөрийг нь сонсохгүй бол дагахаа л больчих хэрэгтэй. Эсвэл дагаж буй мэт дүр эсгээд хэсэг хугацааны дараа сэтгэлийг нь эзэмдэх хэрэгтэй. Эсвэл бас далдуур сэм тусалж болно, заавал нэг их ёс суртахуунтай хүнээр тодрох шаардлагагүй. Чамайг хүлээн зөвшөөрөх

хүн байх уу? Нэр хүндгүй эзэн хаан чинь нэр төртэй чамд дуртай байх уу? (Инээлдэв) Тэр хаан чиний үгийг сонсох уу? Чамайг өршөөх үү? Өршөөсөн ч хажуудаа байлгахгүй. Хажуудаа байлгасан ч чамайг сонсохгүй. Тиймээс та бүхэн энэ дэлхийд туслая, аврая гэвэл хаана ч, юунд ч хүлэгдэж уягдах хэрэггүй. Бид нөхцөл байдлыг ажиглаад юугаар тусалж чадахаар байна, түүнийгээ чимээгүйхэн хийнэ.

Улс гүрнээ төвшитгөж, дэлхий дахиныг тохинуулагч мэргэн сайд Гуанжун

Чи улсын Гуанжун бол маш их алдартэй түшмэл. Чи улсын мунхаг хаан Дангунтай явдал мөр ялгаагүй байж, хааны хийсэн бүхнийг хийнэ, хаан мунхаг зан гаргавал адилхан мунхаг царайлна. Өөрийн ёс суртахууныг хаанд өчүүхэн ч мэдэгдэхгүй. Хаан эзнээс илүү нэгэн гэж огт бодогдуулахгүй. Тэр ингэж чадсан учраас улс орноо төвшитгөж, тэнгэрийн дор амар амгаланг тогтоож чаджээ. Ийм учраас мунхаг хаанд ч тусалж чадсан, ард түмэндээ ч тусалж чадсан байна. Учир нь хаан биш, ард түмэн хамгийн чухал. Чи түүнийг ашиглаж чадвал ашиглана, хороовол харин нэр төрд халтай, тиймээс түүнийг дэргэдээ байлгаж, түүнийг даган тоглолт хийнэ. Тэгвэл удалгүй түүнд юуг, яаж хийхийг заах болно. Учир нь хаан хэдийнээ чамд итгэсэн, одоо зөвхөн чиний үгийг л сонсдог болсон.

Эзэн хаанд чи одоо өөрөөс нь огт ялгаагүй, ижилхэн санагдах болсон аж. Хоёулаа мунхаг, (Багш болон бүгд инээлдэв) сэтгэл зүрхний анд найзууд болжээ. Хоёулаа яг ижил ойлгов уу? Чи Дангун архи уувал Гуанжун түүнээс ч ихийг ууж буй мэт аяглана. Чи Дангун элдэв янзын ааш гаргавал түшмэл ч түүнээс ч дутуугүй элдэвлэнэ. Тэр одоо хааныг нэвт шувт мэддэг болсон төдийгүй сэтгэлдээ ч сайн ойлгох болсон байна. Өөрийгөө ч мэддэг, өрөөлийг

ч ойлгодог хүн зуун удаа байлдвал зуун удаа ялдаг ажээ. Гуанжун өөрийн ёс суртахууныг илэрхийлж, авьяас чадварыг гайхуулалгүйгээр улс орны хэрэг явдлыг шийдэх ажлаа чимээгүй хийж байв. Тэр үед Чи Дангун биш, харин Гуанжун хаанчилж байсан юм. Энэ нь илүү сайн. (Алга ташицгаав.)

Хэдийгээр хаан сууринд Чи Дангун сууж байсан ч улсыг Гуанжун удирдаж, тэнгэрийн дор амар амгаланг Гуанжун тогтоож байв. Учир нь тэр их уян хатан, муу хүнийг ч ашиглана. Мулгуу түшмэдийг ч өршөөнө. Харин Бао Шуяад тийм уян хатан чанар дутмаг тул сайн түшмэл болж чадахгүй. Бао Шуяа бол үнэхээр сайн, дэндүү сайн, бүр сайны туйл. Сайн хүнийг тэр туйлын их хайрлана, муу хүнийг алсан ч сэтгэл нь амрахгүй тийм л хүн. (Багш болоод хүмүүс инээлдэв) Тэр бол хүн хөнөөхөд нүдээ ч цавчихгүй байж чадах хүн. Тиймээс Гуанжун шиг улс гүрнийг засаглан удирдаж чадахгүй юм. Бао Шуяа хэдийгээр нэгэн үнэнч шударга, чигч шулуун түшмэл боловч улс орондоо тийм ч их тусалж чадахгүй. Гуанжун зугаа цэнгэл, найр хурим, архи дарс, гоо үзэсгэлэн алинаас нь ч буцахгүй. Хаан эзнээс ер дутахгүй замбараагүй. Гэхдээ тэр улс гүрэндээ хамгийн их тусалсан, хамгийн шилдэг баатар байжээ.

Бид бурханы сургаал, Их Багшийн айлдварыг уншвал тустай төдийгүй түүхээс мөн зарим зүйлийг суралцаж болно. Хэрвээ бид билиг ухаантай бол үзсэн харсан бүхнээсээ суралцана. Улс орноо тохинуулж, дэлхий дахиныг төвшитгөж буй хүнээс хэрхэн яаж засаглахыг суралцана. Улсыг удирдаж, дэлхийг төвшитгөх нь яг л бясалгал хийж, хамаг төрөлтнийг гэтэлгэхтэй ижилхэн. Ялгаа байхгүй. Арга нь ижил. Тактик нь ижил. Баримтлах үзэл санаа нь ижилхэн.

Нэгэн эгэл жирийн түшмэл улс гүрэн, ард түмнийхээ төлөө өөрийн нэр төрийг золиослож чадвал жинхэнэ эзэн

хаандаа үнэнч, эх орондоо хайртай хүнд тооцогдоно. Энэ бол жинхэнэ чин шударга сэтгэл мөн. Гуанжун байгаагүй бол Чи улс аль эрт хавсарга улс болох байв, Чи Дангун ч хаан болж, зааж зааварлахгүй, хөгжил дэвшил, баян тансагийг эдлэн жаргахгүй байсан. Тиймээс Гуанжун бол жинхэнэ үнэнч түшмэл байжээ. Тэр өдөржингөө зааж тушаагаад эсвэл хаан эзнээ шүүмжилж, зэмлэж зовоодоггүй үнэнч түшмэл байжээ. Ажлаа чимээгүйхэн хийж байсан байна.

Жинхэнэ хүн ил гардаггүй

Улсаа удирдъя, ард түмэндээ туслая гэвэл өөрийн нэр төрийг ч тоох хэрэггүй. Хүмүүст өөрийн шударга зан, билиг ухаан, улсыг удирдаж, төрийг төвхнүүлэх төгс чадвараа ч мэдүүлэх шаардлагагүй, зөвхөн өөрөө хийх нь чухал. Тайлбарлах шаардлагагүй, жүжиглэх хэрэггүй, энэ нь эсрэгээрээ заримдаа хамгийн зөв байдаг. Хүмүүс хэтэрхий ихийг мэдвэл магтаад салахгүй, хэрвээ чиний ёс суртахуун жаахан дутвал жишээ нь, чиний ёс суртахуун 80 хувьтай байхад хүмүүс чамайг 120 хувьтай төгс хүн болгон магтана. Ингэвэл чамд тавгүй байна. Хүмүүс чамаас илүү ихийг хүсэн хүлээнэ. Өөр нэгэн нь чамайг 150 хувьтай болгон магтвал чи үүнээс нь нэг дахин доогуур болон хувирна. Энэ үед чамд асуудал үүсч сандран юу ч хийсэн туйлын хянамгай байж, биеэ барьж эхэлнэ. Учир нь чи хүмүүсийн хүсэн хүлээсэн нэр төрөө хамгаалах хэрэгтэй болно. Ингээд ажил хийхэд хэцүү болж эхэлдэг. Эрх чөлөөтэй тааваараа ажиллах нь машид таатай, учир нь хүмүүс чамаас юу ч хүсэн хүлээхгүй. “Энэ хүн угаасаа ийм л хүн, тэрнээс их юм хүлээх хэрэггүй, тийм ч сүрхий хүн биш, хэн ч тоохоргүй, их залхуу, хэтэрхий борог, идэж ууж, наргиж цэнгэхээс цаашгүй, тусаар бага, анхааараад дэмий, өрсөлдөх чадваргүй хүн” гэцгээнэ. Харин би бол ёс суртахуунтай, хүмүүс надад дуртай байх нь гарцаагүй, харин тэр хэн ч биш гэж бодоцгооно. Ийм байх

нь ямар ч өрсөлдөгчгүй, чамаас юу ч хүлээхгүй, тэгэхээр юу ч хийсэн амар хялбар байна. Аливааг нам гүм, чимээ шуугиангүй хий, нүүрний багийн ард инээмсэглэхийг хэн ч харахгүйтэй адил. Тийм баг харж байсан уу? Хэв дарж бүтээгээд зөвхөн хоёр нүд л харагдана, чи ард нь инээсэн ч, уйлсан ч хэн ч харахгүй. Үүн шиг бид үнэхээр энэ дэлхийд, бусдад туслая гэвэл хэн, юу гэж бодохыг тоох хэрэггүй.

Үнэхээр нэр төр ольё гэвэл тун амархан, сурталчилгаа сайтай, бусдын нүдэнд өртөх аргатай байхад л болно. Олон жил замаа зассаны дараа бүгд чиний сайныг мэднэ. Жишээ нь, ерөнхийлөгч болъё гэвэл тун амархан. Хэрвээ үнэхээр ерөнхийлөгч болъё гэвэл эхлээд замаа зас, яг сонгогдохгүй мэт эхлээд замаа засаж, хүн бүхэнтэй мэндэлж, сүм бүхэнд мөргөж, дуган бүхэнд гороолж, хүмүүстэй уулзах гэх мэтээр үйлд, удалгүй хүмүүс чамайг урин зална. Улсаараа чамайг хамгийн ёс зүйтэй хүн, хамгийн сайн бясалгагчийн шинжтэй гэцгээнэ. Дараа нь чи: Үгүй, үгүй! Санаа зовж байна! гэнэ. (инээлдэж, алга ташив) Хүмүүс уриад л байвал чи: За за! Эвгүй юм даа. Үнэхээр санаа зовчихлоо! гэнэ. Энэ бүхэн цөм хуурамч ёс суртахуун, хуурамч нэр хүнд. Жинхэнэ ёс суртахуунтай, жинхэнэ нэр хүндтэй хүн ихэнхдээ үл анзаарагдана. Жинхэнэ хүн ил гардаггүй ээ гэж!

Улс орноо жинхэнэ ёсоор хайрлахад нэр хүндээ ч алдаж болно

Жоу Вэнван тухайн үеийн эзэн хааныг бодвол хүний төлөө хүн байжээ. Хаан их дорой, шунахай сэтгэлтэй, харин Жоу Вэнван тун өгөөмөр хүн байв. Хожим нь тэр хаан ширээнд сууж улсын эзэн болжээ. Учир нь түүний хийсэн бүхэн хаан эзнээс илүү байсан юм. Тиймээс хүмүүс түүнийг хожим хаан ширээнд залсан байна. Гуанжун сайн хүн байхыг хүссэн бол Чи Дангуны хаан ширээг булаах байсан.

Учир нь тэр үед Чи Дангун нэр хүндээ ихэд алдсан байв. Гэвч Гуанжун тийм үйлдэл хийгээгүй. Бусдын хаан ширээг булаах дургүй хүн. Тэр зөвхөн улсдаа л туслах хүсэлтэй, жинхэнэ эх оронч байснаас нэр төрд дурлагч биш байжээ. Тийм ч учраас нэр хүндээ ч алдахад хүрсэн юм.

Эх орныхоо тусын тулд элдэвтэй, олиггүй хүний дүр эсгэж явснаар хаан эзнийхээ эргэлзээг тайлж, алдар нэрээ ч хаан эзнээс дээш гарахааргүй болгосон ажээ. Ингэж л тэр эх орондоо туслах боломжтой болсон юм. Тэр үед тийм нэг хаантай таарсан болохоор түүнд өөр арга байгаагүй. Хааныг хороовол нэр нүүргүй болно. Өөр хүнээр соливол улам дордуулахаар байв. Гуанжун хааныхаа итгэлийг олоод аргыг аргаар хариулж, нөхцөл байдалд нийцүүлэн ажиллаж байжээ.

Тэр үед Гуанжун байсны ачаар Чи улсад энх тайван тогтож, улмаар дундад улсын жанжлагч гүрэн болж чаджээ. Чи Дангун үнэндээ хэн ч биш байв. Харин Гуанжуныг дэргэдээ ажиллуулсан нь түүний хийсэн хамгийн том гавьяа болсон байна. Гуанжуны хувьд тэр нэг мунхаг хааныг ашиглаж чадсан нь бас хамгийн сайн явдал болсон. (Инээлдэв) Тэрээр мунхаг хааныг сайн ашиглаад зогсохгүй, бусад зальхай түшмэдийг ч сайтар ашиглаж чадсан. Тэр хэнийг ч голдоггүй. Ингэж байж л тэр ажлаа хийж чадна. Гуанжун үнэхээр шилдэг, мэргэний туйл байв. Бясалгач бид ч бас Гуанжунаас суралцвал тун зүгээр. Тэр маш өгөөмөр сэтгэлтэй, үнэхээр сайн хүн, жаахан царай муутай, гэхдээ дотоод нь муу гэсэн үг биш. Бусдад өөрийгөө дэндүү сайн сайхнаар бодуулахгүй, харин өөрөө ямар ч хүнийг сэтгэлдээ багтаадаг. Тийм учраас тэр хүн улсыг засаглаж, дэлхийг төвшитгөж чадаж байжээ.

Би Гуанжуныг тун сайн гэж боддог. Бид заримдаа эртний түүх уншиж, тэндээс жаахан ч гэсэн суралцаж болно. Тиймээс хэн нэгнийг дүгнэж цэгнэх, таньж мэдэхэд бидэнд

билиг ухаан заавал хэрэгтэй. Тэр ямар төрлийн хүн болохыг гүнзгий мэдье гэвэл зөвхөн гаднах байдлыг нь харах биш, харин түүний ажил хэргийн үр дүн, үг, үйлдлийнх нь үр нөлөөг нь харах хэрэгтэй. Зөвхөн үг, үйлдлийг биш. Түүний гадна байдлыг харах хэрэггүй, зан байдал, дадал зуршил, хийх аргыг харна. Гаднах байдал биднийг заримдаа хууран мэхэлдэг. Түүний хийсэн ажлынх нь үр дүн сайн бол сайн гэсэн үг.

Түүхэнд Гуанжуны талаарх үнэлэлт дүгнэлт тийм ч сайнгүй. Түүний үр хойч ямар ч алдар нэр эдлээгүй. Гуанжуны эрх мэдэл, өв хөрөнгийн ашиг тусыг хүртээгүй. Тэр буй бүхнээ ард түмнийхээ төлөө зориулж байснаас биш, хожим дурсагдах нэр алдрын төлөө яваагүй юм. Тиймээс түүний үр удам ямар ч сайн алдар нэр олж аваагүй. Тэр үр хүүхдэдээ ямар ч байр суурь үлдээгээгүй, эрх мэдэл, эд хөрөнгө ч өвлүүлээгүй. Хожмын хүмүүс Гуанжуны үр удмыг тийм ч сайн хүндлээгүй, хэн ч тэднийг тоогоогүй. Учир нь Гуанжуныг амьд ахуйд нь түүний сайн талыг хүмүүс маш бага олж харжээ. Зөвхөн идэж ууж, наадан цэнгэж, хаан эзэнтэй эгээ адил явсныг нь л мэддэг. Хаан эзний нэр төр угаасаа муу, тиймээс түүнийх бүр дор байх нь аргагүй юм. (Инээлдэв)

Гадна талын багийг нэвтэлж, эх орноо гэсэн түүний халуун сэтгэл, шударга түшмэлийн жинхэнэ чанарыг мэдэж хэн чадах вэ? Ертөнцийн хүмүүс харалган, түүн шиг сайн хүн тун ховор тул ойлгох, хүндлэх, хайрлах хүнгүй байжээ. Зөвхөн хаан эзнийг аялдан дагагч, зусарч долдой, алдар нэр, ашиг хонжооны төлөө мунхаг хаантай хамт дурааараа аашлагч гэж хардаг байв. (Инээлдэв) Түүний улс эх орноо удирдан залах чадварыг, мөн дотоодынх нь эх оронч, шударга түшмэлийн жинхэнэ цэвэр ариун, сайхан зүрх сэтгэлийг нь нандигнаж чадах хүн байхгүй байжээ.

Ау Лакын мандан бадралт

Ау Лакт бас Гуанжун шиг тийм нэгэн сайд байжээ. Нэр төр нь ч бас сайнгүй, түүнийг Чэн Шоуду гэнэ. Та нар бараг мэдэхгүй байх. Тэр их алдартай байсан. Амьд сэрүүнд нь хүмүүс мөн ч их харааж зүхсэн дээ. Түүхэнд ч сайнаар бичигдээгүй. Тухайн үед балчир хүүхэд хаан сууринд суусан тул эрх мэдэл нь мэдээж сайдад шилжинэ. Тэрээр талийгч хааны нэг хатантай гэрлэсэн юм. Хаан нас барж, түүний хатантай гэрлэсэн нь хайр сэтгэлээс болсон уу, эсвэл хаан төрийн бүх эрх мэдлийг хянахын төлөө байсан уу гэдгийг мэдэхгүй.

Яг үнэндээ тэр, бүгдийг захирч байв. Эзэн хаан ихийг үл мэдэх тул сайд бүхнийг шийднэ.

Энэ сайд бас их зөрүүд хүн тул түүхэнд сайнаар бичигдээгүй, эзэрхэг, нялх хааныг сүрдүүлэгч, хаан төрийн эрхийг буруугаар ашиглагч зэрэг нэг их олон ялт нэртэй. Гэвч бид түүхийг нарийн сайн анхаарч уншвал түүнийг агуу их хувьсгалч, ардчилагч хүн байсныг олж мэднэ. Одоо бидний ерөнхийлөгч, ерөнхий сайдтай ийм тогтолцоог үндсэн хуульт ерөнхийлөгчийн засаглал гэдэг. Тийм үү? Гэвч ерөнхийлөгч тийм ч их эрх мэдэлгүй, харин ерөнхий сайд маш их эрх мэдэлтэй. Тэр үед үндсэн хуульт хаант засаглалын тогтолцоотой байсан бөгөөд манай Ау Лак хүмүүс үүнд сайн дасаагүй байсан. Бидний хувьд хаан бол тэнгэрийн хөвгүүн, хаан эзний зарлиг л бол зарлиг, олон ноёд түшмэд зөвхөн толгой бөхийн: “За дээдэс ээ! Үгүй ээ дээдэс ээ!” гэхээс цаашгүй. Тиймээс бид ч дасахгүй, ноёд ч бас дасахгүй байв. Түүний эрх мэдэл дэндүү их, бүх зүйлийг тэр ганцаараа шийднэ. Нялх хаантны хувьд хэлж яриад байх юмгүй. Нөгөө талаас нь харвал эзэн хаан нас бага, ухаан суугаагүй, хэрвээ тэр сайд байгаагүй бол манай Ау Лак тэр үед тийм ч амар амгалан байж чадахааргүй байсан. Тэгээд ч Ау Лак олон талаар хөгжил дэвшилгүй байсан юм.

Гэвч бүгд л түүнийг эзэрхэг түрэмгий, хүчирхийлэгч, эзэн хааныг дарамтлагч гэх зэрэг их олон ялт нэртэй болгосон. Ер нь тэгээд түүнд ямар ч олигтой нэр өгөөгүй нь тодорхой. Түүхэн бичигт ч түүнийг сайнаар тэмдэглээгүй. Гэвч тэр үед манай Ау Лак олон талаар чөлөөтэй хөгжиж чадсан. Хэрвээ юу ч ойлгохгүй нялх хааны үгээр явсан бол яаж улсаа удирдах вэ? Хааны үгээр явсан бол тэгээд л дуусах байсан. Зарим үед хаан зөвшөөрөөгүй ч сайд бас тамга дардаг байжээ. (Инээлдэв.) Өөрөө тамгалчихдаг тул хүмүүс түүнд тун дургүй.

Үнэндээ тэр маш сайн хүн. Хэрвээ тэр үнэхээр муу хүн байсан бол хааны хатныг авсан, бүх эрх мэдэл бараг түүний гарт байсан тул хааны суудалд өөрөө ч сууж болох байв. Тэр үед хүмүүс байнга л ингэдэг байсан. (инээлдэв) Энэ нь бүр хандлага болсон байв. Ялангуяа хятадад бүр ч нийтлэг байсан, тийм биш үү? (Тийм гэж хариулав) Хаан нь жаахан сул дорой, харин чи өчүүхэн эрх мэдэлтэй бол шууд л хаан сууринд сууна. Тэгээд төр эргүүлнэ. Уг нь Ли номын эгч байснаа шууд Ван номын ах болж хувирна. (Инээлдэв.) Тиймээс Шоуду хэрвээ хаан болохыг хүссэн, эрх мэдэл хэрэгтэй байсан бол тун амархан олж болох байлаа. Хаан эзэн балчир бага, эрх мэдэл өөрт нь байсан, мөн өмнөх хааны залгамжлагч сайд байсан тул эрх мэдэл маш ихтэй. Өмнөх эзэн хаан бүх эрх мэдлийг түүнд атгуулж, балчир хаан, хаан төрийг даатгасан байжээ.

Билиг ухаанаар түүхийг дахин үзэхүй

Иймээс бид Гуанжун үнэхээр нэр төрийн төлөө байгаагүйг мэдэж болно. Учир нь ингэсэн бол түүний нэр төр улам дордоно. Гэвч хаан эзэндээ ойр шадарлаж, бүх үйл хэргийг өөрөө хийж байжээ. Хүмүүс бүгд түүнийг үзэн ядна. Үнэндээ тэр бол маш мундаг улс төрч байсныг ажлынх нь

үр дүнгээр мэдэж болно. Түүхэнд бичигдсэн маш олон түүх, арвин их үнэлэлт дүгнэлт нь хойч үеийн хүмүүст хэн нь сайн, хэн нь муу, аль нь ёс суртахуунтай, аль нь шударга түшмэл, эх орноо хайрлагч вэ гэдгийг ойлгуулдаг. Тиймээс бид ахин дахин уншиж, бодит байдал дээр түүхэнд бичигдсэн шиг байсан эсэхийг сайтар тунгаан бодох хэрэгтэй. Түүнээс гадна түүхийг хэн бичсэн бэ? Аль ч түүхч түшмэл байсан тэр нь бас л хүн шүү дээ, өөрийн гэсэн үзэл бодолтой, билиг ухаан дутмаг, тогтсон үзлээр, мэдрэмжээр, хувийн өс хонзон, ачлал тусын үүднээс түүхийг бичнэ. Заримдаа бид уншсан төдийгөөр хялбархан итгэдэг. Тиймээс бид өөрийн билиг ухаанаар тунгаах хэрэгтэй. Үнэхээр түүхээс суралцахыг хүсвэл өөрөө задлан шинжлэх хэрэгтэй. Тэгвэл жинхэнэ сайн хүн мөн үү, суралцууштай хүн мөн үү гэдгийг мэднэ.

Арвангуравдугаар бүлэг

ГЭГЭЭНТНИЙ ӨВЧИН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шиху ашрам.1996 оны 2 дугаар сарын 6
(Эх нь хятад хэлээр)

За өнөөдөр нэгэн гэгээнтэн хүний түүхийг ярья. (Алга ташицгаав.) Энд өөрийгөө гэгээнтэн гэдгээ мэддэггүй нэгэн хүний тухай өгүүлдэг. Та нар шиг хүн бүр гэгээнтэн гэдгээ мэдчихсэн хүмүүсээс өөр. (Инээлдэв) Тэр өөрийгөө гэгээнтэн гэж мэдэхгүй, харин “үлдэж” хоцорсон тийм хүн гэж боддог аж. (Инээлдэв.) Нэрийг нь Луншу гэнэ.

Тэрээр Вэн-Ы эмч дээр очжээ. Тэр нь бараг Хавар, Намрын байлдаант улсын үед амьдарч байсан байх, маш их алдар нэртэй, ямар ч өвчнийг эмчилдэг хүн байжээ. Вэн-Ы эмч байлдаант улсын үеийн Чи улсын Вэнван хааныг эмчилсэн гэдэг. Вэнван хаан ямар өвчин туссанаа мэдэхгүй Вэн-Ы эмчийг дуудаж эмчлүүлжээ. Вэн-Ы эмч Вэнван хаанд ямар ч эм хэрэглэсэнгүй, зөвхөн түүнийг уурлуулаад л эдгээсэн байна. Та нар энэ түүхийг мэдэх үү? (Мэдэхгүй

гэж хариулцгаав.)

Нэн ховор тохиолдох нэгэн сонин өвчин

Луншу, Вэн-Ы ы эмч дээр очиж: “Таны эмнэх эрдэм үнэхээр төгс гэдгийг тэнгэрийн дор арван зүгтээ мэднэ. Би нэг хачин өвчин тусаад байна. Миний энэ өвчнийг эдгээж туслаач” гэв. Вэн-Ы эмч: “Болно болно” гэж хариулав. Гэхдээ, та ямар өвчин туссаныг би мэдэх хэрэгтэй байна, энэ талаараа надад ярина уу гэв. Луншу: “Энэ өвчний нэрийг нь ч, юунаас болсныг нь ч мэдэхгүй. Бас яг хаана өвдөөд байгааг нь ч олохгүй байна” гэв. Хэрэг явдал ийм юм, би тосгонд олон жил амьдарсан ч хэнтэй нь ч тийм дотно биш, улам л өөрийгөө этгээд сонин үл таних хүн мэт бодох болов. Жишээ нь, тосгоны хүмүүс намайг магтан сайшаахад надад ямар ч бахархал төрөхгүй. Өөр тосгоны зарим хүн намайг муу хэлж доромжилсон ч гутарч гунихгүй, хичнээн үнэтэй алт эрдэнэстэй болсон ч баярлахгүй, аа бас зарим нэг зүйл алга болоход сэтгэл шаналж, харуусахгүй, надад үхэж, төрөх ялгаагүй санагдаж, маргааш үхсэн ч болно. Баян, ядуу хоёрт ямар ч ялгаа алга, хамгийн муухай нь би хүнийг яг гахай мэт харах болсон. (инээлдэв) Би өөрөө ч яг тэдэнтэй адилхан бас гахай аж. (бүгд инээлдэв) Өөрийн гэрт амьдардаг ч яг л дэн буудалд байх шиг санагдана. Өөрийн тосгонд байгаа ч харь оронд байх шиг, миний төрөлх нутаг биш юм шиг санагдана. Энэ бүх этгээд хачин дадал зуршил, бодол санаанаас гадна надад өөр маш олон дутагдал байна. Жишээ нь, эрх мэдэл, алдар нэр, хааны ордонд амьдрах, өндөр хэргэмтэй алба хаших аль нь ч надад чухал биш, энгийн зүйл мэт бодогддог. Бас ямар ч ял шийтгэл, үхэж төрөх, сайн муу аль нь ч миний сэтгэлийг ганхуулахаа болив. Тиймээс би улс орондоо ч тусалж чадахгүй, хаандаа ч үнэнч биш, эзэндээ ч шадарлан үйлчилж чадахгүй болов. Найз нөхөд, ураг садантайгаа ойр дотно биш, үр хүүхэд, хань ижлээ захирч хүмүүжүүлж, тэдэнтэй нэгдмэл, нэг ижил санаа сэтгэлтэй биш болсон

нь хамт амьдрахад бэрх болгов. Түүгээр ч үл барам гэрийн зарц боолуудаа ч захирч чадахгүй байна. Би үнэхээр гайхаж байна! Энэ ямар төрлийн өвчин бэ? Та намайг эмчилж чадах уу? гэв. Вэн-Ы эмч Луншугийн биеийг эргүүлж тойруулан арай гэгээтэй газарт нарны гэрэлд зогсоон ажиглаж, тэнгэрийн мэлмийгээр тольдоод их дуугаар: Аа! Харлаа, харлаа!” гэж хашхирав. “Та юу үзэв?” гэж Луншу асуухад: ”Чиний зүрхийг харлаа” гэв. “Миний зүрх ямар байна?” гэхэд тэрээр: “Зүрх тань дөв дөрвөлжин өргөн, том, дотоод нь хов хоосон, яг л гэгээнтэн хүний зүрх шиг. Тэдгээрийн дотроос зургаан үүд нь нээгдэж, одоо нээгдээгүй ганц үүд л үлдэж. Магадгүй тэр үүд нээгдээгүй учраас өөрт туссан өвчнөө та мэдэхгүй байгаа байх. Хэрвээ тэр үүд нээгдвэл өвчнийхөө учрыг та маш тодорхой ойлгоно” гэж хэлжээ. Луншу: “Энэ одоо ямар өвчин бэ?” гэхэд Вэн-Ы эмч: “Энэ цаг үед гэгээнтэн хүний билиг ухаан, ах дүүдээ бол нэг төрлийн өвчин мэт үзэгдэх болжээ. Магадгүй энэ бол чиний өвчин. Хэрвээ чи гэгээнтний тийм өвчин туссан бол миний эмнэх чадвар нэмэр болохгүй” гэв.

Та нар ойлгож байна уу? (Ойлголоо! Алга ташицгаав) Түүнд ямар өвчин туссаныг би бас ойлгохгүй байна. Гэвч та нар ойлгож байвал сайн хэрэг. Та нар яг ингэж ойлгов уу! Үнэхээр ойлгосон уу? Хөөх! Яаж ойлгов оо? Та нар чинь бараг түүнтэй ижилхэн бус уу? Гэгээнтнүүд байна шүү дээ. Тиймээс л ижил нь ижилдээ татагджээ. Ер нь тийм л боллоо. Гэвч та нарыг эхнэр, хүүхдээ орхиод энд ирж, Багшдаа ном дэлгэрүүлэхэд тусал гэвэл, би амжихгүй нь ээ! гэнэ дээ. Энэ нь бараг түүнээс ч хэтийдсэнийг харуулах бус уу? Тэр ах дүү, найз нөхөдтэйгээ холбоотой байж чадахгүй байна. Харин та нар түүнээс нэг алхам түрүүлсэн тул ах дүүтэйгээ холбоотой, тэднийгээ огоорч чадахгүй байна. Хэлэхэд амар ч хийхэд хэцүү. Бодоод үз дээ, бид ч бараг ойролцоо бололтой. Олон хүнд ийм дутагдал бий, би бас ийм дутагдалтай. Гэвч би гэгээнтэн биш учир бусдаас л халдсан байх.

Гэгээнтэн биш ч би бас тийм гэгээнтний өвчтэй бололтой. Хэн надад халдаасныг мэдэхгүй. Гараа өргөөд надад харуул даа. (инээлдэв) Энэ өвчнийг хэн надад халдаасан бэ, гараа өргөж надад харуулаарай! Та нар ч өөрсдийн дутагдлаа мэдэх байх, мэдэхгүй царайлах хэрэггүй шүү, байна уу? (инээлдэв) Яагаад гэвэл би та нартай л уулздаг, өөр хаашаа ч явдаггүй, хэнтэй ч холбоогүй. Тиймээс би ямар нэгэн өвчин туссан бол та нараас л болсон хэрэг, хэн бэ? Одоо өвчний тухай сонсоод хэргээ хүлээхгүй болчихов уу? (Багш болон бүгд инээлдэв.)

Аливаа бүхэн ая зөнгөөрөө, хүчлэх хэрэггүй

Та нар халдаасан нь бүр тодорхой байна! Эс бөгөөс би юунд ийм болох вэ? Өмнө нь би дэлгүүр хэсэх, юм хум худалдаж авах, дуулж бүжиглэх дуртай байсан. Үгүй бол ганцаардаж өнчрөх байлаа. Одоо бол өдөржингөө унтсан ч уйдахгүй, хэрвээ та нар ирэхгүй бол унтаад л байна, өлсвөл сэрж нэг, хоёр, гурав хооллоно. Идмээр бол иднэ, ихэнхдээ идэх дургүй. Бараг ийм өвчин туссан байх. Ах дүү, найз нөхөд гэж нэг их сүйд болохгүй. Би тэдэнд хайргүй биш. Миний тэднийг хайрлах нь та нарыг хайрлахтай яг ижил, хайрлавал хайрлана, үгүй бол үгүй. Хүрч ирвэл хайрлана, явж одвол даруй мартана, мартахад маргаашийг хүлээх хэрэггүй. Түүнийг эргээд ирэхэд би ч бас эргэнэ. (Инээлдэв.) Сэтгэл зүрх эргэнэ, хайр сэтгэл ч эргэнэ. Сонин шүү! (Алга ташицгаав.) Ер нь л энэ “Гэгээнтний өвчин” гээчийг туссан бололтой! Халдсан байх, би ер нь Вэн-Ы эмчтэй очиж уулзья, байз!

Луншу жаахан бясалгалтай байсан байх! Бид бясалгаснаас хойш ийм болсон юм болов уу? Бараг л тийм бололтой! Жаахан ч гэсэн тийм үү? (тийм гэцгээв) Аа, тэгэхээр та нар л надад халдаасан байна. Одоо л та нар

хүлээн зөвшөөрлөө. Өмнө нь би ер ийм байгаагүй, байсан ч тун бага байсан. Гэвч одоо явах тутам ихсэв. Жишээ нь, уг нь дургүй байснаа, одоо дургүйцэхээ больж, яасан ч яахав гэх маягтай. Ирэх дуртай нь ирэг, явахыг хүссэн нь яваг, ер шаналахгүй болсон. Та нар шаналсан ч хоёр, гурван өдөр шаналах төдий, тийм үү? (Тийм гэж хариулав.) Тэгж их удаан шаналахгүй. Бид өмнө нь ямар нэг юмаа алдвал, жишээ нь, наймаа арилжаа бүтэлгүйтвэл шаналдаг байсан. Одоо ер хамаагүй болжээ. Хүнийг ч, тэнгэрийг ч буруушаахгүй, өөрөө дахин хичээнэ.

Аль эрт байлдаант улсын үед гэгээнтнүүд байсан байна. Тэрнээс саяхан энэ Миаолид гэгээнтнүүд төрсөн хэрэг биш аж. (инээлдэв) Та бүхэн өөрсдийгөө дундад улсын цорын ганц гэгээнтэн гэх хэрэггүй. Өмнө нь байсан байна шүү. Бясалгах арга төрөл тутамд байсан гэж би та нарт хэлдэг. Та нар Гэгээрсэн Их Багштай уулзах барилдлагатай эсэхээ харна. Ямар Их Багштай барилдлагатай байна, тэр Багшаасаа суралцана. Луншу магадгүй өмнөх төрөлдөө бясалгаж байсан байх, тэгээд энэ төрөлд ирэхдээ жаахан бясалгалтай төдий, жишээ нь, түүний бясалгал дөрөвдүгээр ертөнц хүрсэн бол одоо тун жаахан хичээх л үлджээ.

Үл уягдах, үл таалагдах хоёрын ялгаа

Вэн-Ы эмч түүнд гэгээрсэн багшийг эрж ол гэсэн бол сайн байсан юм. Үлдсэн тэр үүдээ нээлгээд агшин зуур гэгээрэх байв. Тэгвэл өөрийгөө өвчтэй гэж бодохоо болино. Тэр өөрийгөө өвчтэй гэж бодохгүй бол хүмүүстэй харилцаж, холбоотой байна. Хүн бүхэн түүнийг: “Чи яагаад ийм хачин этгээд, хайр сэтгэлгүй, хүйтэн хөндий юм бэ?” гэнэ. Энэ сэтгэлгүй, хөндий хүйтэн байдал нь хүмүүс бидэнд таалагдахгүй байдагтай адилгүй. Өнөөдөр энэ түүхийг сонсоод хүмүүстэй хүйтэн хөндий харилцах хэрэггүй.

(инээлдэв) Дараа нь тэд энэ бол гэгээнтний “мөс мэт чанар” гэцгээнэ. (Багш болон хүмүүс инээлдэв.) (Учир нь хятад хэлний мөс гэх үг, чанар гэх үгтэй төстэй дуудагддаг).

Зарим хүн надад тийм нэг мөс мэт цэвдэг хүйтэн чанартай санагддаг. Үг яриа нь бусдыг үл тоосон, хүн юм асуувал ойлгоогүй царайлна, мэдсэн ч хариулахгүй, эсвэл үгээ зөөж ядна, хүний асуултанд бүүр хойно сая нэг юм хариулах аядана. (Инээлдэв.) Энэ чинь хүнийг их зовооно, ойлгов уу? (Ойлголоо гэцгээв.) Тэгээд ч хүмүүс завгүй, амжуулах ажил өчнөөн олон тул чиний хойгуур, урдуур гүйгээд байж амжихгүй.

Ийм хүн өөрийгөө өөрчлөх хэрэгтэй. Энэ бол би гэх үзлийн өвчин, хүнийг хүндрүүлэх, хүнээр гуйлгах, үргэлж бусдын анхааралд байх хүсэлтэй учраас зориуд сунжруулж, хариулахгүй удна, эсвэл үгээ зөөнө, өөрийгөө маш агуу, эрхэмсэг сайхнаар сэтгэнэ. Энэ бол сүрхий явдал огт биш, тэнэг бядуугийн шинж. Ганц, хоёр удаа бол магадгүй, бас ч уучилж, эелдэг хандаж, чамд найдаад ирж очно. Яваандаа цаад хүний л хожил болно. Энэ дэлхий дээр ийм олон хүн байхад заавал үгээ зөөсөн, хүйтэн цэвдэг, бядуу чамайг эрэх шаардлагатай байна уу? Багшийнхаа санааг ойлгов уу? (Ойлголоо гэцгээв.) Тиймээс бидний энэ дэлхийд үл хүлэгдэх, энэ дэлхийг үл таашаах хоёр их ялгаатай. Луншу үнэхээр өвчин туссан юм биш, ердөө л найз нөхөд, ах дүү, нутаг ус, эх орондоо үл хүлэгдсэн хүн. Гэвч тэр тийм ч хүйтэн хөндий биш, сэтгэлдээ бол тун энгийн хүн. Зориуд хүнийг хүндрүүлж, эсвэл өөрийгөө гайхуулж, гэгээнтэн болохоо хүмүүст мэдүүлэх гэсэн хэрэг огт биш. Эсвэл тэр маш хүйтэн хөндий, үг хэл нь удаан, нэг мөч өнгөрсөн ч хэлэх үг нь дуусахгүй, эсвэл хүн уулзахаар ирэхэд зориуд дуугарахгүй, та юу хийж байна вэ? Би туслах уу? гэхэд хариулахгүй. Хүнд даруйхан халуун сэтгэлээр туслахын оронд үгээ зөөж ядан, аа... аа... гээд яг л хоолойд нь юм тээглэсэн шиг өдрийн хугас

болох жишээтэй, бараг үйлийн үр нь хоолойд нь тээглэсэн биз. (Инээлдэв.) Эсвэл хүйтэн уулнаас саяхан бууж ирсэн цаст уулын багш байх. (Инээлдэв.) Тэндхийн хүйтэн жавар ямар байдгийг мэдрүүлэх санаатай байх! Би тийм хүйтэн хөндий, мөс мэт харилцаанаас айдаг. Тийм ядсан, зориуд бусдын анхаарлыг татах гэсэн хүнээс айдаг. Тэр бол маш хүнд би гэх үзлийн өвчин, өөрийгөө голох өвчин. Өөртөө итгэлтэй хүнээс ийм байдал гарахгүй,тэд маш төв чигч, найрсаг халуун сэтгэлтэй, тэгж дүлэгнээд байхгүй. Эсвэл тэр өмнө нь боож үхсэн байх, тэр дурсамж нь энэ амьдралд нь байсаар өнөөх олс шидэмс хүзүүг нь боомилсноос хоолойгоор нь үг давахгүй болжээ. (Инээлдэв.)

Мэдвэл даруй зас

Хүмүүс бид дутагдал ихтэй, заримдаа өвчтэйгөө ч мэддэггүй. Луншу өөрийгөө өвчтэй гэх боловч үнэндээ тэр ямар ч өвчингүй. Бидний олонх нь өөрийгөө өвчингүй гэж боддог ч үнэн хэрэгтээ бүгд өвчтэй байдаг. Ямар өвчтэйгээ өөрөө мэдэх хэрэгтэй. Хүн бидэнд нэг удаа, хоёр удаа, гурван удаа засаж өгнө. Хаана өвдсөнөө мэдвэл даруй өөрийгөө аврах хэрэгтэй. Аварч эс чадвал ном унш, бусдаас тусламж хүс. Тэндээ зогсонгиших хэрэггүй.

Хэрвээ бид алдаа дутагдлаа засахгүй бол дараа дахиад төрөл авна. Их Багшийг дагасан, дагаагүй ялгаагүй буцаж ирнэ. Учир нь бид тэр нэг зүйлтэйгээ зууралдаад тавьж явуулахгүй, түүнийгээ зэвсэг болгон ашиглаж, бусдыг хүндрүүлж, хүмүүсийн анхаарлыг татаад байвал энэ бүх нөхцөл байдал биднийг буцааж ирүүлнэ. Энэ дэлхийн хууль маш шударга, юу хүснэ, түүнийгээ авдаг. Их Багш ч мөн адилхан. Чамайг чөлөөлөгд гэж ятгахгүй, харин чи өөрөө хүссэн бол өөр хэрэг. Эмч ч адил. Тэр чамд хүчээр эм уулгахгүй, хүчээр хагалгаа хийхгүй, өөрөө л хүсэхгүй

бол. Тийм биз? (Тийм гэж хариулцгаав) Чи өөрийн алдаа дутагдалтайгаа эвлэрч зууралдвал дахин энэ дэлхийд төрөл авна. Гэхдээ Их Багштай уулзаж чадах эсэхийг мэдэхгүй. Тэр үед чи яг Луншу шиг зургаан үүд нь нээгдчихсэн сэтгэлээ тээгээд хаа сайгүй тэнэнэ, өвчнөө хаана байгааг мэдэхгүй. Тэгээд ч долоо дахь үүдээ нээе гэсэн ч их хэцүү. Ямар дутагдал байна, түүнийгээ даруй засах хэрэгтэй, учир нь одоо засахгүй бол маргааш зас, нөгөөдөр зас, эс бөгөөс хойшлуулах тусам төвөгтэй болж, хүү нь нэмэгдэнэ. Дараа нь тэр нэг муу дадал улам бэхжиж, илүү бат бэх болж, засахад бүр хэцүү болно.

Арвандөрөв дүгээр бүлэг

ГЭГЭЭНТЭН ХИЙГЭЭД ЭГЭЛ ХҮНИЙ ЯЛГАА

"Жуанз" Тэжээхүй ухаан бүлгийн тайлбар

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
АНУ, Вашигтон муж, Сиэтл
1993 оны 4 дүгээр сарын 8.(Эх нь англи хэлээр)

Хязгаргүй мэдлэгийг сурч яаж барах вэ?

"Жуанз"-ын дотоод бүлэг, гуравдугаар хэсэг (Тэжээхүй ухаан бүлэг)-т өмнө нь "Хүний нас хязгаартай, эрдэм мэдлэг оройгүй. Хүний энэхэн хязгаартай амьдралаар оройгүй их мэдлэгийн хойноос хөөцөлдвөл ялагдах нь гарцаагүй" гэж дурджээ.

Амь нас нэн хязгаарлагдмал, гэвч эрдэм мэдлэгт эцэс төгсгөл гэж үгүй! гэдгийг мэдэх хэрэгтэй. Учир нь амь нас мөнх бус, тиймээс бид энийг ч, тэрийг ч сурч, энэ дэлхийн бүх мэдлэгийг эзэмшихэд бүх амьдралаа зориулж чадахгүй.

Энэ бол боломжгүй зүйл. Жишээ нь, бид анагаах ухааны эрдэмтэн болсон бол программ хангамжийн инженер болох нь юу л бол. Нэг бүрчлэн тасралтгүй суралцсан ч ертөнцийн бүх мэдлэгийг сураад дуусахгүй. Хэрвээ бид энэ насныхаа бүхий л эрч хүчээр ертөнцийн эрдэм мэдлэгээс ч илүү өргөн дэлгэр билиг ухааныг сурна гэвэл бүр дуусахгүй. Бурханы хутагт хүрэх эсэх нь хичнээн олон судар уншсанаас үл хамаарна, энэ хорвоогийн ямар нэгэн багажинд түшиглээд бас хүрэхгүй, харин өөрийн дотоодод угаас байдаг үлэмж баялаг мэдлэгийн их сан хөмрөгөө дахин нээж олох хэрэгтэй. Тэр үед бид аяндаа бүхнийг ойлгоно. Ертөнцийн мэдлэгийг ч бас мэдэх болно.

Тиймээс та бүхэн өөр өөрийн жаахан туршлагад үндэслээд ойлгож чадна. Өмнө нь ойлгодоггүй байсан олон зүйл, хийж яагаад ч чаддаггүй байсан ажлууд, авшиг хүртэж, хэсэг бясалгаад дотоодын мөн чанараа олвол бүх зүйлийг ойлгох болно, тийм биз? (Тийм гэж хариулцгаав.) Бидэнд бүгдэд маань ийм ахуй ойлголт байна, надад ч бас яг ийм ахуй ойлголт байна. Жишээ нь, хөгжим зохиох, төгөлдөр хуур тоглох гэх мэт. Хүмүүс намайг маш олон жил хөгжмөөр хичээллэсэн, суралцсан гэж боддог, үнэндээ тийм биш. Тогломоор санагдсан үедээ л тоглодог, бэлтгэл хэрэггүй. Зураг зурах, дотоод засал төлөвлөх, хувцасны загвар зохион бүтээхэд ч бас адилхан надад бэлтгэх шаардлага байхгүй, гэхдээ би энэ бүх мэргэжлээр ямар ч сургуульд суралцаагүй билээ.

Энэ ертөнцийн эрдэм мэдлэг ч бидний дотоодод хэдийнээ байж байдаг. Бид зөвхөн их үүдээ нээчихвэл тэнд байгаа мэдлэг бүхэн тов тодорхой болно. Жишээ нь, би хэзээ ч анагаахын сургуульд сурч байгаагүй, гэвч олон хүн өвдөх үедээ, хагалгаанд орохдоо Багш нь очиж туслахыг харсан байна. Тэгээд удалгүй өвчин нь эдгэрсэн гэдэг. Жирийн эм тарианаас хамаагүй илүү үр дүнтэй, энэ бол Багшийнх нь

дотоодод байдаг гайхамшигтай анагаах мэдлэг юм.

Маш олон хүн энэ дэлхийд үй түмэн жил амьдарсан байдаг. Бид олон янзын ажил хийж байсан. Тэр бүхэн бидний ой санамжинд хадгалагдан үлддэг байна. Тиймээс бид өөрийн билиг ухааны их санг нээвэл тэнд мэдлэг бүхэн байгааг олж харах болно. Бид аль эрт суралцсан болохоор дахин суралцах шаардлага байхгүй! Бүхнийг сурчихсан бол илүү өндөр төвшинд дэвшин суралцах эрхтэй болох юм. Энэ бол гэгээнтэн болох, Будда болох явдал мөн.

Үнэндээ, орчлон ертөнцөд хамаг төрөлтөн бүрэлдэн бий болохоос өмнө билиг ухааны үр түмэн бодист хэдийнээ суулгагдсан байдаг. Харин бид одоо нэгээхэн өнцгөөс юм бүхнийг сурахыг оролдож байгаа нь зүгээр л цаг заваа үрсэн хэрэг. Хүмүүс бүгдээрээ Будда бол эмч хэмээн магтдаг. Энэ нь анагаах ухаан хийгээд бусад бүх салбарын хамгийн дээд нь гэсэн утгатай. Учир нь Буддад мэдэхгүй юм байхгүй. Будда хэзээ ч ид шид сураагүй, гэвч шидтэй, Будда хэзээ ч анагаах ухаанд суралцаагүй, гэвч өвчин бүхнийг эмчилж чадна.

Билиг ухааны эрдэнэсийн сангаа нээвэл бүхэнд нэвтэрнэ

Манай нийгэмлэг ч мөн адил, та нар бүгдээрээ л Их Багшийн ид шид, хувилгаан чадал тун их, өвчин эмнэнэ, бусдын бодлыг уншина, хамгийн хэцүү үед биднийг ирж авардаг гэцгээдэг. Гэтэл үнэндээ энэ бүхэн тийм ч сүртэй зүйл биш. Бүх мэдлэг бидний билиг ухааны их санд хадгалагдаж байдаг. Чи өдөр бүр бясалгах бүрдээ тал бүрийн мэдлэгийг өөрийн мэдэлгүй сэргээн санаж байдаг. Энэ нь та бүхнийг аль ч талаар маш оюунлаг болгох бөгөөд дараа нь чи: "Итгэмээргүй юм? Би хэзээ ч үүнийг сурч байгаагүй, би

яаж мэдээд байна вэ?” гэж бодно. Маш онцгой гүн гүнзгий, тусгай мэдлэг шаардсан нөхцөлд ч хийж чадаж байгаагаа та гэнэт олж харна. Хэрвээ үнэхээр хийж чадахгүй бол дотоодын багшдаа даатгаж, тусламж гуйхад л болно. Энэ тал дээр ч та нар мэргэжилтнүүд шүү. Та нар хийхийг хүссэн бүхэндээ үргэлж л Багш аа туслаарай гэцгээдэг. Үнэндээ та бүхний дотоодод жинхэнэ их хүч оршин байдаг! Хэрвээ чи суралцах шатандаа явж байгаа, эсвэл өөрийн билиг ухааныг бүрэн ашиглаж чадахгүй бол мэдээж дотоодын багшаасаа тусламж хүснэ. Тийм учраас Багш хэрэгтэй байдаг юм. Гэвч хожим нь чи бүхнийг өөрөө хийж чаддаг болно. Жишээ нь, чи мужааны багшид шавь оржээ. Зарим зүйлийг хийхэд хэцүү, мөн яаж хийхээ мэдэхгүй бол багшаасаа тусламж хүсвэл багш чинь даруй ирж тусална. Хожим нь чи яаж хийхээ мэддэг болно.

Хэрвээ бид энэ дэлхийн юм бүхнийг сурахыг хүсвэл цаг хугацаа хүрэхгүй. Тиймээс өөрийн билиг ухааны их санг нээх нь хамгийн зөв явдал. Тэнд мэдлэг бүхэн бий. Хэрвээ чи өөрт буй агуу зүйлээр бахархъя гэвэл энэ бол жинхэнэ бахархууштай зүйл мөн. Хэрвээ өөрийгөө маш агуу гэж бодвол зөв ойлголттой байж, өөрөө жинхэнэ агуу болохоо мэдэх хэрэгтэй. Эхлээд та бүхэн гэгээр, дараа нь аялгууны бясалгалаар олон зүйл дагалдан ирдэг. Маш олон ойлголт, их мэдлэг, олон хариулт ундран гарна. Энэ бол бидний шууд суралцах зам, дэргэдээ багштай байх шаадлагагүй, учир нь бид дотоодоороо холбогддог, тэр үед чи жинхэнэ сургаал гэж юу болохыг ойлгоно. Тиймээс аман айлдварууд, ном тайлах зэрэг нь миний сургаалын өчүүхэн хэсэг бөгөөд зууны гучин хувийг л эзлэх төдий. Харин үлдсэн далан хувь нь нам сэлүүн үед, бясалгаж байхад чинь, эсвэл нойрон дунд чинь чамайг өндөр дэсийн сургуульд хүргэж, тэнд сургаж байдаг. Тиймээс заримдаа та бүхэн бясалгалын ахуй ойлголт багатай байдаг ч билиг ухаан чинь 10 дахин, 20 дахин, 100 дахин өссөн байдаг. Үүнээс гадна энэрэн нигүүлсэх сэтгэл

болон тал бүрээр дэс чинь дээшилдэг. Энэ бүхэн бол үггүй сургаалын үр дүн юм.

Гэгээрсэн хийгээд гэгээрээгүй хоёрын ялгаа

Өөрийн шавийг үг хэлээр гэгээрүүлсэн ямар ч Багш байхгүй. Үг хэлээр сургаал айлдаж, шавийг сургадаг ч энэ нь бүх сургаал биш. Бидний дотоодод холбоо үүсмэгц сургалт тасралтгүй шууд явагдаж эхэлдэг юм. Тиймээс та бүхэн улам билиг ухаантай болж, аль ч талын мэдлэгтэй, юу ч тохиолдсон шийдэх арга замаа бүгд мэдэж байдаг. Өмнө нь чиний хариу үйлдэл тун удаан байсан бол одоо маш хурц болсон. Энэ нь чи бясалгалаараа, нойрондоо, эсвэл энгийн амьдрал дундаа өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн Их Багш нартай байнга холбогдож суралцсанаас болжээ. Чи хорин дөрвөн цагийн турш адислагдаж байдаг. Энэ бол гэгээрсэн хийгээд гэгээрээгүй хоёрын ялгаа. Авшиг хүртсэн хийгээд хүртээгүй хоёрын ялгаа юм.

Заримдаа ялгаатай энэ талыг би өөрөө ч бас мартдаг. Гэхдээ санах боломж надад бий. Харин та нар бол үргэлж мэдэх боломжтой. Учир нь та бүхэн намайг бодвол ертөнцийн хүмүүстэй илүү ойр. Зарим хүн мэргэжлийн хүрээндээ маш сайн мэдлэг эзэмшсэн, маш ухаалаг, авьяаслаг, нийгэмд эзлэх байр суурь өндөртэй ч яг харилцаад үзвэл ялгаа байгааг та бүхэн мэдэх болно. Та нар мэдсэн ч цаад хүн магадгүй мэдэхгүй байх. Тиймээс буддын сургаалд: “Буддаг зөвхөн будда л ойлгоно” гэдэг. Хэдийгээр та бүхэн дотооддоо нуугдах бурхан чанараа бүрэн нээгээгүй ч ядаж л бурхны орон тийш нэвтрэх зам дээр яваагаа бүгд мэдэж байгаа шүү дээ. Доор гацсан, эсвэл гадна талын хүмүүстэй харьцуулвал та бүхэн бясалгалаар, Арьяабалын аргыг дадуулаад хүчнээн их ач тусыг олсноо өөрсдөө мэдэж байгаа. Эс бөгөөс хичнээн их эрдэм мэдлэг, лекц яриа, номын айлдвар байгаад ч нэгэн хүнийг гэгээнтэн болгож, гэгээрүүлж чадахгүй юм. Үнэхээр тэнгэр, газар шиг ялгаатай. Жишээ нь, бид одоо хэдийнээ

нас биед хүрсэн ч, хүүхэд багачуудыг дагуулан наадахдаа зориуд баярлан хөөрсөн царай гаргадаг. Мэдээж, бид өөрсдөө тоглож наадаад баясаж болно л доо, энэ нь хүүхдүүдээ энхрийлэн хайрласнаас тэдэнтэйгээ хамт баярлан хөөрөхийг хүссэн хэрэг. Бид тэдэнтэй наадвал тэд ч аз жаргалтай, бид ч бас аз жаргалтай болдог. Магадгүй бид бага насаа дурсаад хэдэн хором хөөрөн баясна. Гэвч ямар ч том хүн тоглоом наадгайд хүүхэд шиг автахгүй нь тодорхой. Үүний нэгэн адил Арьяабалын аргаар бясалгаж гэгээрсэн хүн харахад жирийн хүнээс ялгагдахгүй, заримдаа хүний нь араншин илэрч уурлаж, мохож шантарна, гэвч хэзээ ч хүний энэ дэсэд удаан живэхгүй, өөрийн сэтгэл хөдлөлийг мэдэж байдаг тул үргэлжлэн живээд байхгүй. Яг л бид балчир хүүхэдтэй хамт наадвал тэдэн шиг тоглоом наадгайдаа автахгүйтэй адил, учир нь бид бол хэдийнээ өсөж том болсон хүмүүс.

Үүнтэй адил, манай нийгэмлэгийнхний доторх гэгээрсэн нэгнийг харвал эгэл хүнтэй адилхан. Гэхдээ тэд хэрхэвч эгэл хүн биш. Та бүхэн үүнийг маш сайн мэднэ, тийм биз? (Тийм гэж хариулцгаав.) Мэдэж байгаад чинь би маш их талархаж байна. Зарим үед та нар надад сануулдаг. Миний хувьд бүх хүн Будда. Заримдаа л: “Өө, тийм шүү дээ! Тэд хэдийгээр Будда ч гэлээ мунхаг Будда!” гэдгийг санадаг. Яг л балчир хүүхэд өсөж томроод бадриун өндөр болсон нь алсаас, эсвэл гаднаас нь харвал том хүн байна гэж боддог шиг. Тэгээд ярилцаж үзээд: “Өө! Дөнгөж арван тавтай хүүхэд байна” гэдгийг нь мэднэ.

Дэлхийн хүмүүс заримдаа харахад тун их ухаалаг ч энэ нь гэгээрэл биш, ухаарал нь ч гүн биш байдаг. Хэсэгхэн хором ярилцвал бидний хооронд ялгаа байгааг олж мэднэ. Иймээс та бүхэн өөрийн ухаарал, гэгээрлийн дэсэд эргэлзэж байвал бусад хүнтэй ярилцаад үзээрэй. Заавал үргэлж гэгээнтнүүдтэй уулзуулаач гэж залбирах хэрэггүй, эгэл хүнтэй уулзсан ч чамд тустай. Ингэж өөрийн дэвшил хэр

байгааг мэдэж болно. Харыг цагаантай харьцуулвал илүү тодордог. Хэрвээ энэ дэлхийн бүх зүйл цагаан бол хэн ч цагаан өнгийг ялгахгүй. Ийм байх нь зүй ёсны хэрэг. Гэвч харыг цагаантай харьцуулвал цагаан өнгийг бид тодорхой мэдэж авна. Яг үүн шиг хэн нэгэнтэй уулзаагүй бол бид тийм ч их итгэлтэй биш байна. Тиймээс хүмүүстэй ойр байх нь тун сайн.

Ямар ч нөхцөл байдал байсан бүхнийг хүлээн авч, тэндээс суралц, эс бөгөөс чи яаж мэдэж чадах вэ? Та нар гэгээнтнүүдийн дунд байгаа учраас ач тусыг нь аль хэдийн мартсан байдаг. Хэдийгээр дотор болон гадна байхын ялгаа, орох үүдэнд өчүүхэн жаахан гэрэлтэй ч тийшээ нэг л алхан орсон бол бид үүрд өөрчлөгдөнө. Үүд хавьд байна уу, өндөр дэсэд байна уу? гэдгээс үл хамааран хаалганы гадна байсан үетэй харьцуулшгүй өөр болсон байдаг. Бүрмөсөн адилгүй! Мэдээж, бид улам урагшилж, бүр ихийг нээн илрүүлнэ. Ингэж л бидний амь амьдрал хувирдаг юм!

ЭХ СУРВАЛЖИЙН ЛАВЛАГАА

Та бүхнийг энэ дэлхийд залран буй Төгс Гэгээрсэн Их Багшийн айлдваруудын эх хувилбарыг сонсож, илүү их адислал хүртэхийг урьж байна.

12 дугаар хуудас

Арьяабалын аргаар бясалгаж байсан Найман арш

1988 оны 4-р сарын 8-нд Формосагийн Тайнанд хятад хэлээр айлджээ. (аудио CE5B, дугаарлаагүй аудио). Эх сэдэв нь: Найман арш ч мөн Арьяабалын аргаар бясалгасан. Өмнө нь Ау лак хэлээрх "Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр" номын 14 дүгээр ботид хэвлэгдсэн.

29 дүгээр хуудас

Нүйва чулуу хайлуулж, тэнгэрийн цоорхойг нөхөв

1988 оны 5-р сарын 11-нд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Формосагийн Каошиун хотод хятад хэлээр айлджээ. (аудио CE6B, дугаарлаагүй аудио)

Эх сэдэв нь: Бурханы хутагт хүрсний байдал, Ау лак хэлээрх "Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр" номын 13 дугаар ботид хэвлэгдсэн.

42 дугаар хуудас

Ан Зи-гийн билиг ухаан

1988 оны 5-р сарын 12-нд Формосагийн Пиндүнд хятад хэлээр айлджээ. (аудио CE7A, дугаарлаагүй аудио). Эх сэдэв нь: Арьяабалын алдрыг уншихын жинхэнэ утга. Ау лак хэлээрх "Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр" номын 13 дугаар ботид хэвлэгдсэн.

57 дугаар хуудас

"Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл" зохиолын дүрүүд

1993 оны 10-р сарын 1-нд Хонконгийн Шатины Тэндао сүмд хятад хэлээр айлджээ.(видео # 381)

Хонконгийн хоёр өдрийн даяан, намрын ургацын баярын айлдвар, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шинэ мэдээний сэтгүүлийн 97 дахь дугаарын "Сайн номын тэмдэглэл" тусгай буланд хэвлэгдсэн.

64 дүгээр хуудас

Бясалгалын замд тохиолдох ад чөтгөрүүдээс болгоомжил

1991 оны 8-р сарын 1-нд Формосагийн Шиху ашрамд хятад хэлээр айлджээ. (видео #190) Эх сэдэв нь: Яагаад нийтээрээ бясалгадаг вэ? Аливаа бүхэн сэтгэлээс үүдэлтэй, Урт наслах нууц, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шинэ мэдээний сэтгүүлийн 97 дахь дугаарын "Сайн номын тэмдэглэл" тусгай буланд хэвлэгдсэн.

67 дугаар хуудас

Ид шид ба Их билиг ухаан

1988 оны 4-р сарын 20-нд Формосагийн Шинжу-д хятад хэлээр айлдав. (видео#6) Эх сэдэв нь: Их Багшийн ид шид ба Их билиг ухаан, Ау лак хэлээрх "Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр" номын 14 дүгээр ботид хэвлэгдсэн.

89 дүгээр хуудас

Цаг хугацаа, орон зайнаас хэтийдсэн түшмэл

1988 оны 6-р сарын 8-нд Формосагийн Тайжун хотод хятад хэлээр айлдав. (аудио CE8A. дугаарлагдаагүй). Эх сэдэв нь:

Төгс Гэгээрсэн Их Багш бол заяа тавилангийн засварчин юм. (1,2). Ау лак хэлээрх " Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр" номын 14 дүгээр ботид хэвлэгдсэн.

104 дүгээр хуудас

Их Багш "Усан хөвөөний шасдир" зохиолын тухай

1988 оны 4-р сарын 21-нд Формосагийн Тайнан хотод хятад хэлээр айлдав. (видео # CE6A, дугаарлаагүй). Эх сэдэв нь: "Усан хөвөөний шасдир" зохиолын түүхүүд ба сүнслэг бясалгал. Ау лак хэлээрх "Агшин зуур Гэгээрэхийн түлхүүр" номын 13 дугаар ботид хэвлэгсдэн.

124 дүгээр хуудас

Түүхээр багшлуулахуй

1996 оны 3-р сарын 14-нд Америкийн Калифорни, Лос Анжелест англи хэлээр айлдав. (видео#537). Эх сэдэв нь: Ухаалаг чадвараа болгоомжтой ашигла (1,2) Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шинэ мэдээний сэтгүүлийн 128 дугаарт "Их Багшийн айлдвар" тусгай буланд хэвлэгдсэн.

141 дүгээр хуудас

Хатуу, зөөлнийг хослуулж чадвал төгс төгөлдөр мөн - Күнз болон түүний шавь нарын түүх

1994 оны 4-р сарын 6-нд Хонконгийн Шатины Тэндао ашрамд хятад хэлээр айлдав. (видео# 415) Эх сэдэв нь: Үнэнч сэтгэлийн төлөөс

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шинэ мэдээ сэтгүүлийн 38 дугаарын Их Багшийн айлдвар тусгай буланд хэвлэгдсэн.

152 дугаар хуудас

Бао Шуяа, Гуанжун хоёрын зөв зан төрх

1996 оны 1-р сарын 7-нд Формосагийн Шихү ашрамд хятад хэлээр айлдав. (видео # 522) Эх сэдэв нь: Мэргэдийн түүх (Гуанжун ба Бао Шуяа), Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шинэ мэдээний сэтгүүлийн 55 дахь дугаарын "Их Багшийн айлдвар" буланд хэвлэгдсэн.

168 дугаар хуудас

Төрөө засаглаж, тэнгэрийн дор амгаланг тогтоох нь бясалгал мөн

1995 оны 9-р сарын 10-нд Формосагийн Шихү ашрамд хятад хэлээр айлдав.

Шинэ мэдээ сэтгүүлийн 51 дэх дугаарын "Их Багшийн айлдвар" тусгай буланд хэвлэгдсэн.

179 дүгээр хуудас

Гэгээнтний өвчин

1996 оны 2-р сарын 4-нд Формосагийн Шихү ашрамд хятад хэлээр айлдав. (видио#522). Эх сэдэв нь: Гэгээнтэн мэргэдийн түүх (Гуанжун ба Бао Шуяа) Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шинэ мэдээний сэтгүүлийн 56 дахь дугаарын "Их Багшийн айлдвар" тусгай буланд хэвлэгдсэн.

187 дугаар хуудас

Гэгээнтэн хийгээд эгэл хүмүүний ялгаа. "Жуанз" Тэжээхүй ухаан бүлгийн тайлбар

1993 оны 4-р сарын 8-нд Америкийн Вашингтон мужийн Сиэтл хотод англи хэлээр айлдав. (видио# 349) Эх сэдэв нь: Үггүй сургаал, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шинэ мэдээний сэтгүүлийн 99 дэх дугаарын "Их Багшийн айлдвар" тусгай буланд хэвлэгдсэн.

ДЭЛГЭРҮҮЛЭН УНШИХ

Дао бүхий л орчлонг тэжээн тэтгэж байдаг – Бэрх хэцүү нөхцөлд гэгээрэх сэтгэл улам хүчирхэг болно

1993 оны 3-р сарын 2-нд Индонезийн Сишуйд хятад хэлээр айлдав. (видео хуурцаг# 322)

Гол агуулга нь: Их Багш "Луузын мөр ёсны судар"–ын 41 дүгээр бүлгээс гэгээрлийн төлөөх гурван шинжийг тайлбарласан. Сэтгэлийн дадлыг хэрхэн ялах вэ? Цэвэр ариун сэтгэл бол мөр юм.

"Багш нь зөвхөн ном айлдаж, та нарыг сургадаггүй, дотоодод чинь ч чимээгүйгээр сургаж байдаг. Номын айлдвар бол оюун ухаанд зориулагдсан зүйл. Сүнсийг биш, тархи толгойг сургаж байгаа төдий. Сүнсэнд, билиг ухаанд хандвал ганц ч үг, өгүүлбэр ярих шаардлагагүй ..."

Амьдралын талаарх дундаж зам мөрийн үзэл

1993 оны 3-р сарын 4-нд Индонезид хятад хэлээр айлдав. (видео хуурцаг#323)

Гол агуулга: "Жуанз" – Дотоод бүлэг - Тэжээхүй ухаан. "Жуанз хэлэхдээ: Хүний амь нас хязгаартай, харин билгүүн ухаан хязгааргүй. Хязгаарлагдмал зүйлээр хязгааргүйн хойноос хөөцөлдөх нь цагийн гарз болно..."

Хүмүүст хандах арга

1993 оны 3-р сарын 19-нд Австралийн Брисвэн хотод англи хэлээр айлдав. (видео хуурцаг #323)

Гол агуулга : Их Багш барууны шавь нартаа зориулан "Жуанз" –дотоод бүлэг – хүний ертөнцийн дөрөв дэх, Янхэ (Хавар, Намарын Лу ханлиг улсын мэргэн хүмүүн), Вэй улсын Лин хунтайжийн номын багш болжээ, явахын өмнө Ку бою (Вэй улсын мэргэн эмч)–тэй онцгойлон ярилцав. Тэр хоёрын гайхамшигтай сайхан хөөрөлдөөнийг уншиж шимийг нь хүртээрэй.

"Жуанз" энэ зохиолд бичсэн бүхэн билиг ухаан, ёс суртахуунаар дүүрэн тул олон түмэнд маш тустай. Жуанз алдартай ёгт үлгэрүүдийг тун чадамгай ашигладаг. Тэрээр ёгт үлгэрүүдээр дамжуулан шавь нар, тухай үеийн хүмүүст биеэ хэрхэн авч явах, их билиг ухаанд яаж суралцах, түүнийг яаж ойлгож ухаарах, хөгжүүлэхийг заан сургаж байжээ.

Хамгийн дээд дэсийн нөхөрлөл

1993 оны 3 сарын 23 нд Австралийн Брисвэнд англи хэлээр айлдав. (видео хуурцаг # 339)

Гол агуулгын товч: Их Багш "Жуанз, их мастер"–ыг айлдав. Зи Санху, Мэн Зифан, Зи Чинжан хэмээх гурван хүний уулзаж нөхөрлөсөн түүх бөгөөд өндөр дэсийн бясалгагчдын дунд болсон явдал юм. Тэд үхэл амьдрал нь цаг улирал өөрчлөгдөх, дээл хувцас солихтой нэгэн адил болохыг нэвт харсан хүмүүс. Магадгүй тэдний дэс бүгд ижил төвшинд хүрсэн байх. Тиймээс хамтдаа тун аз жаргалтай байжээ. Өндөр дэсийн сүнснүүд хамт байх үедээ хамт. Тусдаа үедээ тусдаа. Тэдний амьдрал маш энгийн, бүх зүйлд мэдрэмжээр хандана. Ямар ч нөхцөлд маш хөнгөн сэлүүн, эрх чөлөөтэй, хамт байвал бие биенийхээ оршин буйг үл мэдэрнэ. Хэн нэгнийхээ анхаарлыг сарниулахгүй, харилцаанд ч нэгнээ эзэрхийлэхгүй..."

Лаожуан ба диваажингийн аялгуу – Энэ ертөнцийн хамгийн сайн бясалгалын бүлгэм (1,2)

1993 оны 2-р сарын 28-нд Формасагийн Тайбэйд хятад хэлээр айлдав. (видео хуурцаг #320).

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шинэ мэдээний сэтгүүлийн 28 дахь дугаарын Их Багшийн айлдвар тусгай буланд хэвлэгдсэн. Мөн хятад хэлээрх "Агшин зуур гэгээрэхийн түлхүүр" номын 7 дугаар ботид орсон.

Гол агуулга: "Бид "Жуанз" зохиолыг уншихад нэгэн удаа тэрээр Луузыг их луу мэт хэмээн дүрслэн хэлсэн. Тийм биз? Тэр хэлэхдээ: Лууз тэнд яг л нэгэн үхдэл мэт өчүүхэн ч хөдлөхгүй сууна. Харин бидэнд тэр яг л нэгэн луу шиг харагдаж байв. Дараа нь маш эрхэм ариун, нам гүм төвшнөөс аянга цахих мэт их дуу гарах нь тэнгэрээс буух мэт, эсвэл газрын маш гүнээс оргилох мэт, эсвэл тэнгэр, газар нийлэн энэ дууг бүтээсэн мэт сонсогдоно... "

Эзэн Бурханы тааллыг хүндэтгэн дагахуй

1994 оны 4-р сарын 19-нд Хонкогт хятад хэлээр айлдав. (видео хуурцаг #420)

Гол агуулга: Их Багш "Жуанз-намрын ус" бүлгээс тайлав. Хуйз Лиан улсад түшмэлийн алба хаших болжээ. Жуанз түүнийг эргэхээр очив. Цуу яриа дэгдэж, Хуйзийн түшмэлийн албыг авахаар Жуанз иржээ, үүнд Хуйз ихэд балмагдав гэцгээв. Хожим нь Жуанз Хуйзтай очиж уулзаад түүнд нэгэн сэтгэл хөдөлгөм зүйрлэлийг ярьжээ...

Дөхөм аргыг дураараа зааж болохгүй

1994 оны 5-р сарын 21-нд Формосагийн Тайбэйд хятад

хэлээр айлдав. (видео хуурцаг #431)

Формосагийн 7 хоногийн олон улсын даяан. Даян дэлхийн хүний эрх, энх тайвны төлөөх даатгал (5)

Гол агуулга: Их Багш, Лаожуаны үггүйгээр засаглах тухай айлдав. Эртний мэргэн түшмэд улсыг засаглахдаа өөрийн оршин буйг үл мэдүүлнэ. Учир нь тэд ард түмнээ эрх чөлөөтэй байлгадаг. Хэнд ч энд нэг хаан, нэг ерөнхийлөгч байна. Би бол хамгийн том нь гэх мэт мэдүүлэхгүй. Лаожуаны зохиолоос, ард түмэн зөвхөн өөрт хамгийн ойр байдаг цагдаа, орон нутгийн жижиг түшмэдийг л мэдэхээс хаан байдаг эсэхийг мэдэхгүй. Мэргэн түшмэд ийм байх ёстой. Маш эгэл даруу, өөрөө ард түмний ажилчин төдий болохоо мэдэж байдаг... "

Алдар нэр үл горилох

1995 оны 10-р сарын 27-нд Формосагийн Шихү ашрамд англи хэлээр айлдав. (видео хуурцаг #505)

Их Багш Чин Хайн өдөрт зориулсан олон улсын долоо хоногийн даяан (2)

Гол агуулга: Их Багш, Мэнз, Яанз, Гуанжун, Бо-Ы, Шучи зэрэг дээдсийн үлгэр дуурайлалт түүхээс тайбарлан ярив. "Бясалгагч бид заримдаа эртний их билиг ухаан, бусад хүнтэй харилцах, ертөнцийн явдлыг шийдэх, эд зүйлд хандах арга барилаас ач тус хүртэж байдаг. Учир нь ард түнийхээ төлөө амь биеэ жинхэнэ зориулсан, аливаа бүхнээ өргөсөн тэр хүмүүс тийм ч алдар хүндтэй, тав тухтай байгаагүйг бид маш сайн ойлгодог ..."

Лизи салхи сөрөн алхсан нь, амьдралын тухай Яанзын үзэл

1995 оны 9-р сарын 17-нд Формосагийн Шихү ашрамд хятад хэлээр айлдав. (видео хуурцаг#500)

Гол агуулга: “Яанзын үзлээр хүн төрөлхтнийг амар тайван байлгадаггүй дөрвөн зүйл байдаг ажээ. Үүнд эхнийх нь мөнхрөх шунал, удаах нь алдар нэрийн шунал, гутгаар нь идээ ундааны шунал, дөтгөөр нь хөрөнгө мөнгөний шунал...”

Арьяабалын бясалгалд орохын өмнөх бясалгалын арга

1988 оны 12-р сарын 16-нд Формосагийн Каошиун хотод хятад хэлээр айлдав. (видео хуурцаг #26)

Гол агуулга: Их Багш Мози-гийн түүхийг ярив. “<<Мози>> зохиолд нэгэн түүхийг өгүүлдэг. Тэр хэлэхдээ бүх зүйл дадлаас өөр юу ч биш. Зарим хүн сайн үлгэр дуурайлал үзүүлсэн учраас хойч үеийн хүмүүс мөн тийн үйлдсээр иржээ. Үүн шиг, яагаад бидэнд Их Багш хэрэгтэй вэ? Учир нь тэр бидэнд үлгэр дуурайлал үзүүлдэг. Тэрээр бясалгах нь тун амархан, баяр жаргалтай, эрх чөлөөтэй, тийм ч хэцүү биш болохыг ойлгуулна. Тэр аль хэдийнээ энэ замаар замнасан тул ямар ямар саад бэрхшээл байдаг, хаана нь агуй, хаана нь нуур, хаана нь цөөрөм байдгийг бүгдийг мэднэ. Тиймээс тэр биднийг замчилбал нилээд хурдан, арай хялбар, илүү асуудалгүй байна ...”

Хятадын гүн ухаанаас Күнзийн сургаалын тухай ярилцья

1989 оны 3-р сарын 1-нд Формосагийн Тайнан хотод хятад хэлээр айлдав. (видео хуурцаг #51)

Гол агуулга: “Эртнээс нааш, Хятадууд улс гүрэн нь хамгийн их мандан бадарч, хамгийн хүчирхэг байсан тэр үед тэнгэрийн дор хамгийн эв найртай, энх амгалан байжээ.

Бүх ванлиг нэгдэж, хамгийн ууч өгөөмөр, бусдын тусын төлөө ажиллаж чадах тийм нэгэн оюунлаг удирдагчийг хамтдаа сонгож, түүгээр бүх улсаа захируулж, хамтдаа хөдөлмөрлөж, суралцаж, хөгжин дэвшиж, жарган цэнгэж байжээ. Тэр бол улсын сүр хүч хамгийн ихээр мандан бадарч байсан үе юм...”

Күнз ч мөн бясалгагч хүн

1989 оны 3-р сарын 20-нд Формосагийн Тайнанд хятад хэлээр айлдав. (видео хуурцаг #52, аудио CL7A)

Гол агуулга: “Өнөөдөр би Күнзийн тухай ярина. Учир нь Күнзийн талаар буруу ойлголттой хүн маш их байна. Түүнийг жирийн нэг сурган хүмүүжүүлэгч байсан мэтээр ярьдаг. Хүмүүст ёс суртахуун, өршөөл энэрлийн тухай заадаг төдий, дотоод бясалгалын хүчгүй байсан гэцгээдэг. Үүнд миний уур тун их хүрч байна. (Багш уурласан дүр гаргав). Энэ хүмүүсийн үзэл бодлын алдааг залруулах эрх надад байгаа хэмээн бодно. Учир нь Күнз дэндүү алдартай. Түүний үзэл бодол маш олон хүнд нөлөөлсөн. Түүний богд гэгээнтний байр суурийг дордуулвал бидний бясалгалд ч бас нөлөөлнө. Тиймээс бид түүнд хүртэх ёстой байр суурийг нь эргүүлэн өгөх нь зохистой...”

Сүнсний дэвшил

1993 оны 12-р сарын 22-нд Америкийн Хавай аралд англи хэлээр айлдав. (видео хуурцаг #383)

Хавайн олон улсын 4 хоногийн даяан (1)

Гол агуулга: Их Багш "Жуанз–ын Тэжээхүй ухаан бүлэг"-ээс тайлбарлав. Лууз наснаас нөгчих үед түүний найз Чин Ши гашуудан их дуугаар хэдэнтээ хашгиран уйлаад явж одоход Лаодан–ы шавь нар ихэд гайхав. "Үхэл, оршуулга бол хүмүүсийг хамгийн их айлгадаг, амьдралын хамгийн ер бусын нуцлаг явдал юм. Энэ гарагийн маш олон хүний хувьд ийм байдаг. Гэвч манай авшигтнууд авшиг хүртсэнээс хойш хэсэг хугацаанд маш хичээнгүй сайн бясалгаад үхэл хэмээгчээс огт айхгүй болсноо илэрхийлдэг... ".

Үзэл ойлголтын сэхээрэл

1996 оны 2-р сарын 21-нд Формосагийн Шихү ашрамд хятад хэлээр айлдав. (видео хуурцаг #525)

Олон улсын Чин Хайн өдөрт зориулсан 4 хоногийн даяан (1)

Гол агуулга: Хавар, Намрын байлдаант улсын үеийн алдарт эмч Чи Юэ жен-ий түүх. "Чин Юэ жен тэрхүү настан (Жан сан мэргэн)-ы царай зүс нь эгэл бус, өөртэй нь оровч, гаравч хамт байдаг бусад эрхмээс ялгаатайг олж харжээ. Тэгээд түүнд өргөл хүндлэлийг онцгойлон үзүүлж, найрсаг дотноор дайлав. Түүний энэ найрсаг дайллага өр зүрхний нь гүнээс ундран гарсан бөгөөд хариу ер горилоогүй ажээ. Жан сан мэргэн ихэд талархаж, явахын өмнө түүнд нэгэн тан бариад: Энэ танг хүртвэл бусдын үзэж үл чадахыг үзэх чадлыг олно хэмээжээ. Үнэхээр Чин Юэ жен тан хүртээд билгийн мэлмий нь нээгдсэн гэнэ... "

Лизи-гийн түүх

1995 оны 10-р сарын 29-нд Формосагийн Шихү ашрамд англи хэлээр айлдав. (видео хуурцаг #507)

Их Багш Чин Хайн өдөрт зориулсан олон улсын 7 хоногийн даяан (4)

Гол агуулга: "Лизи нэгэн мунхаг тэнэг хүнд: Би хаана ч очиж, дүүфүү авсан ч бүгд миний мөнгийг авахгүй байна. Арван газраас дүүфүү авахад тав нь надаас мөнгө авсангүй. Арваас тав нь аваагүй тул сэтгэлд айдас төрж, гэртээ харив" гэж хэлжээ.

Гэгээн эмч

1995 оны 10-р сарын 30-нд Формосагийн Шихү ашрамд англи хэлээр айлдав. (видео хуурцаг #508)

Их Багш Чин Хайн өдөрт зориулсан олон улсын 7 хоногийн даяан (5)

Гол агуулга: Их Багш, Биангэ эмч хоёр ноёнд зүрх солих мэс засал хийсэн тухай ярив. "Байлдаант улсын үеийн алдарт эмч Биангэ хоёр ноёнд нэгэн төрлийн маш хүчтэй тан уулгаж, тэднийг гурван өдөр, гурван шөнө ухаан алдуулсан гэнэ. Тэр хооронд тэдний цээжийг нээж зүрхийг аваад харилцан солиод тавьсан гэнэ. Ингээд гурав хоногийн дараа мэс засал дуусжээ..."

Үүрд мөнх орь залуугаараа

1995 оны 6-р сарын 27-нд Формосагийн Шихү ашрамд англи хэлээр айлдав. (видео хуурцаг #482)

Гол агуулга: Их Багш “Гурван улсын түүх” зохиолын Жүгэ овогт Кун мины залбирал яагаад бүтэлгүйтсэн түүхээс тайлбарлав. “Кун мин бол эртний цэргийн хамгийн агуу жанжин бөгөөд хүмүүс түүнийг хамгийн сайн цэргийн зөвлөх, стратегич гэж магтдаг байв. Тэрээр цус маш бага урсгах маш ухаалаг аргаар бусдыг ялдаг байжээ. Тиймээс хятадад болоод дэлхий даяар ялангуяа дорно зүгт, азид маш их алдартай байсан...”

Өндөр дээд дэсийн төгс төгөлдөр би - бясалгал бол хутагтын байр суурины төлөөх өрсөлдөөн биш

1990 оны 9-р сарын 28-нд Формосагийн Шихү ашрамд англи хэлээр айлдав. (видео хуурцаг #131)

Шихү-гийн намрын улирлын 7 хоногийн тусгай даяаны айлдвар (1)

Гол агуулга: Их Багш: “Гурван улсын үлгэр” зохиолын Жанфэй гүүр эвдсэн түүхийг өгүүлэв. “Хүмүүсийн ихэнх нь нилээд бясалгавал бас ийм болдог. Мэдсэн багахан зүйлдээ өчүүхэн түшиглэнэ. Үүнээс хэтийдэх ёстойг, төгс төгөлдөр их билиг ухааныг хараахан хүртээгүй байгаагаа мэддэггүй. Учир нь бидний билиг ухаан өөрөө нээгддэггүй. Гэвч бид Төгс Гэгээрсэн Их Багшийн гадаад байдлаас л суралцдаг. Хүмүүсийн ихэнх нь зөвхөн гадаад байдлаас суралцах төдий байдаг...”

Хэн бидний төлөө яардаг вэ?

1989 оны 4-р сарын 12-нд Формосагийн Пиндүнд хятад хэлээр айлдав. (видео хуурцаг #69)

Гол агуулга: Их Багш “Усан хөвөөний шастир” зохиолын нэгэн түүхээс өгүүлэв. “Ямар ч хүн: Та яагаад ийм энгийн дүрэм ч үгүй байдаг вэ? Тэд амраад зөвхөн ганц

хоёр хундага архи ууя л гэсэн. Яагаад болохгүй гэж хэлнэ. Гэвч тэр жанжин багаасаа энэ хавиар нутагласан учир хаана хамгийн аюултай болохыг мэднэ. ...Харин тэр шадар хүмүүс дэндүү мунхаг, бас түүнтэй хэрэлдэнэ. Эцэст нь өөрсдийгөө л хохироожээ. Яг үүн шиг, Бурхан бодьсадва энэ дэлхийд ирж, хамаг төрөлтнийг сургах нь үнэхээр түмэн бэрх мянган зовлонтой аж...”

Нэгэн төрөлдөө туулан ангижрахын ач тус

1988 оны 4-р сарын 23-нд Формосагийн Тайнанд хятад хэлээр айлдав. (аудио CE6A)

Ау лак хэлээрх “Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр” номын 13 дугаар ботид хэвлэгдсэн.

Гол агуулга: Их Багш “Усан хөвөөний шастир” зохиолоос нэгэн түүх өгүүлэв. “Усан хөвөөний шастир” зохиолд Сунжиан өөрийн биеэр их цэргийг удирдан Жужиа балгадыг довтолгов. Гэвч амжилтгүй болжээ. Учир нь Жужиа балгадын нутаг мод ургамлаар битүү бүрхэгдсэн, одох зам нь нарийн төвөгтэй, тойрсоор тойрсоор эргээд анхны газартаа ирнэ. ...Гарах замыг зөвхөн тосгоны хүн л мэднэ. Гадны хүн мэдэх аргагүй. Хожим нь туршуул илгээж, цагаан хус харвал зам эргэх ёстойг мэджээ. Энэ нуцыг мэдээд Лиан Шанбогийн дээрэмчид Жужиа балгадыг амжилттай эзлэв. Энэ ертөнцөд 84000 номын ёс байдаг гэж сонссон. Яагаад бид одоо ч бас энд эргэлдсээр байна вэ?...”

АВШИГ ХҮРТЭХҮЙ – АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, Арьяабалын бясалгалын аргыг үнэн ёсыг танин мэдэхийг чин сэтгэлээсээ хүссэн хүмүүст авшгаар дамжуулан уламжилдаг. “Аялгуу ажих” гэдэг нь Хятадаар амарлин сууж, аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэ бясалгалын арга нь дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажихаас бүрддэг. Эртнээс нааш дэлхийн шашин шүтлэг, сүнслэг бясалгалын ном судруудад дотоодын ахуй ойлголтын талаар олонтоо дурдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан” гэжээ. (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг). Энэ аялгуугаар дотоодын аялгууг заажээ. Мөн “Бурханы хэл”, “Shabd”, “Дао”, “Аялгууны урсгал”, “Ум”, “Тэнгэрийн хөгжим” хэмээн нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэр бол түмэн бодисын дотор хэлбэлзэж, бүхий л орчлон ертөнцийг тэжээн тэтгэдэг. Энэ дотоодын хэмнэл аливаа шархыг эмнэнэ, хүсэл эрмэлзэл бүхнийг хангана, эгэл ертөнцийн элдэв хүсэл шуналыг намжаана. Тэр бол бүхнийг чадагч бөгөөд хайр энэрлээр бялхан байдаг. Бид энэ аялгуунаас үүссэн учраас түүн лүгээ холбогдвоос сэтгэл ханаж амарлидаг. Энэ аялгууг сонсмогц бид бүхэлдээ хувирч, амь амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.” хэмээн айлджээ.

“Гэгээрэх” гэдэг үг нь дотоодын гэрэл - “Эзэн Бурханы гэрэл”-ийг заана. Энэ гэрлийн хүч нь өчүүхэн багаас тоо томшгүй, үй олон нарны гэрэл мэт хурц тод байдаг. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэднэ.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх,

сэтгэлийн авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэх, эсвэл шинэ шашинд орж буй хэрэг огт биш. Сэтгэлийн авшиг хүртэх үед гэрэл болон аялгуу ажих бясалгал хийхэд онцгойлон анхаарах зүйлсийг заана. Хамгийн анхны ариун ахуй ойлголт анир чимээгүйд бууж ирдэг байна.

Арьяабалын бясалгалын аргын хамгийн охь дээж нь авшиг уламжлах явдал. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн ач ивээл үгүй бол эдгээр арга нь дангаараа ямар ч ач тус хүргэж чадахгүй. Авшиг хүртэх тэр даруйдаа та өөрийн дотоодын аялгууг сонсож, өөрийн дотоодын гэрлийг харна. Үүнийг “Агшнаа гэгээрэх”, эсвэл “Агшин зуур билиг нээгдэх” гэж хэлдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

- Авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.
- Нас туршдаа веган хоолтон байх нь сэтгэлийн авшиг хүртэх зайлшгүй нөхцөл юм.
- Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага болно .

Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал сэтгэлийн авшгаар нээгдсэн билиг ухаан тань улам тэлэн

тэлсээр эцэстээ хамгийн дээд ухамсрыг олж, Будда болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын төвшинд эргэж очдог.

Өөрөө сүнслэг дадал бясалгал хийж, төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болно. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө дадуулан бясалгана. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь элсүүлэхгүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж хугацаат татвар хураахгүй. Их Багш Чин Хайд сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй. Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод сүнслэг дадал бясалгалдаа өөрийгөө дэвшүүлэн богд гэгээнтэн болохыг хүсэх тэрхүү чин сэтгэлийг чинь л хүлээж авах болно.

ТАВАН САХИЛ

1.Аливаа амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ.*

2.Үнэн бус зүйл ярихыг цээрлэнэ.

3.Өөрийн бус зүйл авахыг цээрлэнэ.

4.Бэлгийн зүй бус харилцааг цээрлэнэ.

5.Согтуурулах, мансууруулах бодис болон хорт зүйл хэрэглэхийг хориглоно.**

*Энэ сахил нь веган хоолны дэглэмийг хатуу мөрдөхийг шаардана. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, шувууны мах, өндөг (өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, жигнэмэг, зайрмаг) гэх мэт амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

**Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи, тамхи, хар тамхи, мөрийтэй тоглоом, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг, уран зохиол, цахим тоглоом тоглох зэрэг аливаа хортой зүйлээс зайлсхийх явдал багтана.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр

Англи (1-5), Ау Лак (1-15), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-10), Польш (1-2), Солонгос (1-11), Португал (1-2), Тай (1-6), Түвд (1), Унгар (1), Фин (1), Франц (1-2), Хятад (1-10), Швед (1), Япон (1-4)

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт , Хариулт

Англи (1-2), Ау Лак (1-4), Болгар (1), Герман (1), Индонез (1-3), Орос (1), Польш (1), Португал (1), Солонгос (1-4), Унгар (1), Франц (1), Хятад (1-3), Чех (1), Япон (1) Монгол (1-2)

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багш шавийн хоорондын захиа

Англи (1), Ау Лак (1-2), Испани (1), Хятад (1-3)

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд

Ау Лак (1-2), Хятад (1-2)

1992 онд Сан Ди Мун-д болсон 7 хоногийн даяан бясалгал / тусгай хэвлэл

Англи (1), Ау Лак (1)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1993 онд Дэлхий даяар ном дэлгэрүүлсэн аялал

Англи (1-6), Хятад (1-6)

Багш үлгэр ярьж байна

Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)

Эзэн Бурхан ба хүн төрөлхтний үлгэр - Библийн үлгэрүүдийг ухаарахуй

Англи, Ау Лак, Хятад

Эзэн Бурхантай шууд холбогдох - Энх тайванд хүрэх зам

Англи, Ау Лак, Хятад

Амьдралаа солонгоруулъя

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Эрүүл мэндээ ухаарахуй, Жам ёсны зөв амьдралын хэв маягт эргэн орохуй

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд - Бурхан бүхнийг зохицуулдаг

Англи, Ау Лак, Монгол, Солонгос, Хятад, Франц, Япон

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү уйтан байна!

Англи/Хятад (ном + CD)

Онч мэргэн үг (1)

Англи (1), Хятад (1), Испани/Португал, Франц/Герман,

Англи/Солонгос, Англи/Япон

Онч мэргэн үг (2)

Англи (1), Хятад (1)

Тэнгэрлэг зоог - Олон улсын ургамал хоолны гал тогоо

Англи/Хятад, Ау Лак, Япон

Тэнгэрлэг зоог – Гэрийн хоолны амтат сонголт

Англи/Хятад

Диваажингийн урлаг

Англи, Ау Лак, **Монгол**, Хятад

Жинхэнэ хайр

Англи, Хятад, DVD, MP4

Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй (тусгай хэвлэл)

Англи/Ау Лак/ Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлиг

Англи/Ау Лак/Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлиг

-Уран зургийн цувралууд

Англи (1), Хятад (1)

Тэнгэрийн хувцас

Англи/Хятад

Шувууд миний амьдралд

Англи, Ау Лак, Араб, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц, Хятад

Эрхэм ариун амьтад

Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад

Аниргүй нулимс

Англи, Ау Лак, Хятад, Герман, Франц, Испани, Португал, Солонгос, Монгол, Филиппин

Уузи шүлгүүд

Англи, Ау Лак, Хятад

Мартагдсан дурсамж

Англи, Ау Лак, Хятад

Хайрга ба Алт

Англи, Ау Лак, Хятад

Эрвээхэйн зүүд

Англи, Ау Лак, Хятад

Өмнөх амьдралын зам мөр

Англи, Ау Лак, Хятад

Хуучин цаг

Англи, Ау Лак, Хятад

Эрин зууны хайр

Англи, Ау Лак, Хятад

Аниргүй нулимсыг хайрлахуй

Англи, Хятад, CD, DVD, MP4

Амьдрал болоод ухамсрын тухай бодрол:

Доктор Жанезын бичсэн ном, Хятад хэлээр

Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган хүнс

http://crisis2peace.org хаягаар олон хэлээр үнэ төлбөргүй унших

болон татаж авна уу.

Дээрх номууд үргэлжлэн хэвлэгдсээр байна.

Бусад айлдвар болон дууны DVD, MP3, MP4, CD-ны цувралууд Араб, Армен, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Болгар, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Непал, Норвег, Перс, Филлипин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланк, Словени, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэлээр хэвлэгджээ.

БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?

Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса (шуудангийн код 36899)
Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе, Калифорни 95173-0247, АНУ
*Суприм Мастер Телевиз
И-мэйл: Peace@SupremeMasterTV.com
Утас: 1-626-444-4385,
Факс: 1-626-444-4386

*Ном орчуулгын групп:
И-мэйл: divine@godsdirectcontact.org
(Та Их Багшийн номыг олон хэлээр орчуулах ажилд оролцож болно.)
*Мэдээний групп:
И-мэйл: lovenews@godsdirectcontact.org

S.M. Celestial Co., Ltd:
И-мэйл: smclothes123@gmail.com;
Vegann@@hotmail.com
Утас: 886-3-4601391, Факс: 886-3-4602857
Веб сайт: http://www.sm-celestial.com

Бясалгалын холбогдолтой асуултанд хариулах баг:
И-мэйл: lovewish@godsdirectcontact.org

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн ХХК
И-мэйл: smchbooks@godsdirectcontact.org
Утас: 886-2-23759688 Факс: 886-2-23757689 http://www.smchbooks.com

*Цахим дэлгүүр
Celestial Shop: http://www.theCelestialShop.com (Англи)
Eden: http://www.EdenRules.com/ (Англи, Хятад)
Цэвэр веган бүтээгдэхүүний цахим дэлгүүр http://www.lovingfood.com.tw

*"Loving Hut" Олон Улсын Веган Хоолны Сүлжээ ресторан
И-мэйл: service@lovinghut.com
Утас: 886-3-4683345
Факс: 886-3-4681581
Веб сайт: http://www.lovinghut.com/tw/
*Гуан Инь веб сайтууд:
Бурхантай шууд холбогдох - Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг: http://www.godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm
Энэ хаягаар дэлхийн олон хэлээрх Гуан Инь вэб хаягуудыг олж авахаас гадна 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон Урлагийн Ертөнцөөр Аялахуй нэвтрүүлгийг үзэх боломжтой.
Мөн олон орны хэлээр "Агшин зуур Гэгээрэхийн түлхүүр" үлгэр дэвтрийг татаж авч болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэдээ сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах, унших боломжтой.
*Суприм Мастер Телевиз
Суприм Мастер Телевиз нь бүтээлч хөтөлбөрүүдийг нэвтрүүлдэг суваг бөгөөд танд сүнслэг дэвшлийг авчирч, амьдралд тань цоо шинэ өнгө төрхийг бэлэглэх болно.
Суприм Мастер Телевизийг 24 цагийн турш онлайнаар үзэх хаяг: http://supremmastertv.com/mn1/
Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр (үлгэр дэвтэр)-ийг олон хэлээр үнэ төлбөргүй татаж авах хаяг (80 орны хэлээр) http://sb.godsdirectcontact.net

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр-10

Хятадын эртний үлгэр домог дахь сүнслэг бясалгалын агуулга
Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Хэвлэсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн ХХК
Хаяг: Тайбэй хот, Жүнзэн дүүргийн баруун замын I хэсэг, 72-8-16
Утас: 886-2-23759688
Факс: 886-2-23757689
http: www.smchbooks.com
И-мэйл : smchbooks@Godsdirectcontact.org http://www.smchbooks.com
Шуудангийн дугаар: 19259438
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1987~2016
Зохиогчийн эрх: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Энэ номын агуулгыг хэвлэлийн компаниас зөвшөөрөл авсны дараа хуулбарлаж болно.
Анхны хэвлэл: 2007 оны 1 дүгээр сар
Гурав дахь хэвлэл: 2011 оны 5 дугаар сар
Хялбаршуулсан хятад хэлээр бичсэн I хэвлэл: 2009 оны 1 дүгээр сар
Хялбаршуулсан хятад хэлээр бичсэн II хэвлэл: 2010 оны 5 дугаар сар
Кирилл үсгээр бичсэн товчилсон хувилбар: 2015 оны 7 дугаар сар
Энэ хувилбарыг монгол хэлнээ орчуулсан 2023 оны 2 дугаар сар
Цахим хувилбар:http//www.gegeerel.mn/ 2023 оны 4 дүгээр сар

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр /Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай. дахин хэвлэл

Тайбэй хот: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын Нийгэмлэг, 2004 он (Min 93)

1 дүгээр боть; 13x19 см

ISBN 978-986 -6895 -01-2 (10 дугаар боть : Хатуу хавтастай)

1. Сүнслэг дадал бясалгал 2. Оюун санааны амьдрал

192.1 93018084